

DDC
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 5.8 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2023.05.30

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Д.Бямбахүү

ISBN 978-99962-8882-2-7

2023 №2 (35)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор **Бө.Бат-Эрдэнэ**

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) **Г.Бямбадорж**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

*Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 80199007
мэйл хаяг: ganbaatarbyamba88@gmail.com*

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2023 №2)

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

А.Лхамсүрэн Мөрдөн шалгах нууц ажиллагаанд тулгамдаж буй эрх зүйн зохицуулалтын асуудал.....4

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Батцэрэн Мөнгө угаах гэмт хэргийн олон улсын эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судлал.....7

Б.Баярболд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон улсын туршлага, эрх зүйн орчин 12

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

П.Эрдэнэбаатар Хулгайлах гэмт хэрэгт нотолбол зохих байдал, мөрдөн шалгах арга зүй.....25

Н.Бадраа Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, анхаарах асуудал.....33

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Ганболд Тоон ул мөр илрүүлэх, бэхжүүлэхэд анхаарах зарим нэг асуудал40

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Хулан, Д.Булган Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, түүнд үнэлгээ хийхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын шинжилгээ.....45

Д.Бямбахүү Хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт онцлог..... 53

Б.Наргулан Монгол улсын Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудын уялдаа холбооны уламжлал.....67

ЦАГДААГИЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Э.Дашгаадан Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын асуудал.....79

Т.Туяа Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх сургалтад танхимын болон зайн сургалтыг ашиглах онцлог шинж.....86

Д.Нямдорж Сургалтын технологийн хөгжилд багшийн үүрэг.....90

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Н.Пүрэвдорж Монгол улсын жолоодох эрхийн үнэмлэхийн загвар ба эрх зүйн чадамжийг нэмэгдүүлэх нь..... 98

Э.Хандармаа Тээврийн хэрэгслийн насжилт, түүнд тулгамдаж буй асуудал..... 105

ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Х.Уянга Хүний эрх: эрүүл, аюулгүй орчныг тодорхойлох амьдрах эрхийн хүлцэх түвшин..... 109

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ш.Эвсанаа Аюулгүй байдлын дүн шинжилгээнд системийн бүтцийн ашиглалт ба хязгаарлалт..... 114

МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ
ЭРХ ЗҮЙ ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ
АКТУАЛЬНЫЕ ВОПРОСЫ КОНФЕДИНЦИАЛЬНОГО
СЛЕДСТВЕННОГО ДЕЙСТВИЯ

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Гүйцэтгэх ажлын тэнхимийн дэд профессор
доктор, цагдаагийн дэд хурандаа
А.Лхамсүрэн
Заместитель начальника кафедры ОРД
Института полиции УВД Монголии
доктор право /Ph.D./, подполковник полиции
А.Лхамсүрэн

Товч агуулга: Монгол улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд УИХ-аас Зөрчлийн тухай, Эрүүгийн, Төрийн албаны тухай зэрэг олон хуулиудыг шинэчлэн найруулж баталсанаар тэдгээрийн эрх зүйн зохицуулалтын үйлчлэх хүрээ тэлж үүнийг дагасан хууль зүйн нэр томьёо, үйл ажиллагаа нэмэгдсэн. Үүний нэг тод жишээ нь ЭХХШТХуулинд тусгагдсан мөрдөн шалгах нууц ажиллагаа юм. Энэхүү илтгэлээр Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж чухам юуг ойлгох, энэ нь гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан арга, ажиллагаа мөн эсэх, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий этгээд нь хэн байх зэрэг асуудлаар санал бодлоо илэрхийлэхийг зорилоо.

Краткое содержание: В рамках правовой реформы были приняты Государственным великим хуралом Закон о правонарушениях, Уголовный кодекс, Закон о государственной службе, в результате которых расширились сфера правового регулирования введены новые понятия, термины. Один из ярких примеров является институции негласного следственного действия. В данной статье автор старался дать определение негласному следственному действию, как понять, является ли оно оперативно-розыскным мероприятием, уполномоченный детектив сотрудник какой службы и т.д.

Түлхүүр үг: Мөрдөн шалгах ажиллагаа, нууцлал, Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа, нэр томьёо, зэрэглэл,

Ключевые слова: Следственное действие, оперативно-розыскная деятельность, негласное следственное действие, термины, категория.

Үндсэн хэсэг. Монгол улсын Их хурлаас баталж 2018 оны 09 дүгээр сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Эрүүгийн Хэрэг Хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг хуулиар хүлээсэн /Цагдаагийн байгууллага/ байгууллагаас явуулах гэмт хэргийг шалгах, нотлох ажиллагаа буюу эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа гэх нэр томьёог өөрчилж мөрдөн шалгах ажиллагаа гэсэн нэршилтэй болгон хуульчилж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхээс бусад ажиллагааг энэ нэр томьёонд хамааруулан ойлгохоор заажээ. Гагцхүү энэ мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулж болох тухай мөн хуульд бас давхар тусгасан нь судлаачийн хувьд энэ сэдвийг сонгох болсон шалтгаан юм.

Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан ажиллагаа гэж хуульчилжээ.¹ Тэгвэл энэ нууц гэдэг ойлголтыг ямар ухагдахуунаар хүлээн авах ёстой вэ? Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн болон Албаны нууцын тухай хуулийн төрийн нууцад эсхүл албаны нууцын алинд хамааруулах вэ?

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13 ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ад зөвхөн Гүйцэтгэх ажил түүний үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, мэдээллийг Төрийн нууцын

¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.10 //Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

ангилалд “Онц чухал нууц”, “Маш нууц” –ын зэрэглэлтэйгээр оруулсан байх ба мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлын арга, хэрэгслийг ашиглан явуулж байгаа бие даасан үйл ажиллагаа юу, эсвэл гүйцэтгэх ажлын илрэн гарах нэг хэлбэр үү гэдгээс шууд хамааралтайгаар нууцын ангилал, зэрэглэл нь тодорхойлогдох болж байна.

Гүйцэтгэх ажлын илрэн гарч буй хэлбэр талаас нь мөрдөн шалгах нууц ажиллагааг авч үзвэл:

1. Уг ажиллагааг явуулах эрх бүхий этгээд гэж хэн бэ? Мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий Тагнуул, Авилгатай тэмцэх газар болон Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий мөрдөгч нар бүгд, үгүй бол эрх бүхий байгууллагуудын дарга нараас мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тусгайлсан эрхийг авсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий мөрдөгч нарын тодорхой хэсэг үү, эсхүл дээрхи байгууллагуудын гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий мөрдөгч нар мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах уу гэдэг нь тодорхойгүй байна.²

Уг эрх нь ямар хэлбэрээр баталгаажих вэ? гэдэг нь мөн шийдвэрлэгдээгүй байна. Тухайн байгууллагын даргын бүрэн эрхийн хүрээнд тусгайлан мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх олгосон тушаал байх, үгүй бол ахлах мөрдөгч, чиглэлийн ахлах мөрдөгч гэх мэт тодорхой албан тушаал, ажлын байрны тодорхойлолтоор мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрхийг баталгаажуулж өгөх шаардлагатай эсэхийг шийдвэрлэх.

2. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах мөрдөгчийн эрхтэй холбоотой асуудал тодорхойгүй байгаагаас үүдэн тухайн этгээдийн үүрэг, хариуцлага өөрөөр хэлбэл нууцын ямар төрөл, зэрэглэлтэй мэдээлэл, үйл ажиллагаатай харьцах нь зохицуулагдаагүй, үүнээс үүдэн гарах хор уршиг, эрсдэл, нууцын хадгалалт, хамгаалалтын асуудал давхар хөндөгдөж байна.

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журамд заасан зарим төрлийн ажиллагааг тухайлбал нууц ажиглалт, нууц үзлэг зэрэг арга хэмжээнүүд нь ихээхэн хэмжээний хүн хүч, хөрөнгө шаардах тул санхүүжилт, зардлын асуудал шийдвэрлэгдээгүй.

4. Мөрдөн шалгах нууц ажиллагааны нууц ажиглалт, үзлэгийг нууцаар хийх зэрэг аргыг хэрэгжүүлэх үүргийг одоогоор хэрэгжүүлж байгаа гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албад, нэгжийн алба хаагчдыг мөрдөгч нэр томьёонд хамруулан ойлгож болох эсэх. Дээрх алба хаагчид нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах үүрэг хүлээхгүй бөгөөд эдгээр алба хаагчдын явуулсан арга хэмжээ нь гүйцэтгэх ажлын арга хэмжээ юу, мөрдөн шалгах нууц ажиллагаа юу гэдгийг ялган зааглах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл мөрдөн шалгах нууц ажиллагааны журамд заасан уг ажиллагааг захиалгын дагуу явуулах эрх бүхий нэгж мөн эсэх нь эргэлзээтэй байна.

Моны мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлын хэрэгслийг ашиглан ижил төстэй аргаар явуулж байгаа бие даасан үйл ажиллагаа гэж үзэх хууль зүйн дараах үндэслэлүүд байна. Тухайлбал:

1. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан бус зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах ажиллагааг мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж ойлгохоор хуульчилагдсан.³

Гүйцэтгэх ажлын тухай хуульд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд урьдчилан бичгээр өгсөн прокурорын зөвшөөрөлтэйгээр хэрэгжүүлэх харилцаа холбооны сүлжээнд хяналт тавих, шуудан харилцааг хянах, орон байр, барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, ачаа, тээш, эд зүйлд нууц үзлэг хийх, нууцаар ажиглалт явуулах, хяналтын худалдан авалт, нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглах зургаан ажиллагааг хуульчилсан⁴ байдаг бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд үзлэгийг нууцаар хийх, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах ажиллагаа, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, орон байранд нэвтэрч хяналт

² Улсын Ерөнхий прокурор, Тагнуулын Ерөнхий Газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 19 ны өдрийн А/84, А/57 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам” –н 2.1.5, 9.1

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4.10 //Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

⁴ Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 23.3 //Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

тогтоох, орон байрнаас бусад газарт нэвтэрч хяналт тогтоох, тээврийн хэрэгсэлд нэвтэрч хяналт тогтоох, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт гэсэн арван хоёр ажиллагааг хуульчилжээ.⁵

Өөрөөр хэлбэл Гүйцэтгэх ажлын хуульд тусгагдаагүй ажиллагаануудыг өөртөө багтааснаараа мөрдөн шалгах нууц ажиллагаа нь бие даасан ажиллагаа мөн.

2. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явагдах үндэслэл, дараалал, явуулах эрх бүхий субъект, төрөл, хэлбэр, нь хуульчилагдсан буюу өөрийн гэсэн зохицуулах зүйл, зохицуулалтын аргатай учир мөрдөн шалгах нууц ажиллагаа нь бие даасан шинжийг өөртөө агуулж байна.

3. Прокурорын тухай хуулийн 25-р зүйлд “ Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих” талаар тусгасан нь мөрдөн шалгах нууц ажиллагаа нь гүйцэтгэх ажлаас тусдаа бие даасан, түүний явагдах үндэслэл, хэрэгжих явц, үр дүнд нь прокурор хяналт тавихаар ойлгогдож байна.

Шинээр батлагдан хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаа нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий байгууллагын мөрдөгч нараас тухайн хэргийн оролцогч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр тухайн мөрдөгчөөс бие даан хэрэгжүүлж буй ажиллагаа юм. Тухайн хэргийн оролцогч нар буюу хэргийн сэжигтэн, хохирогч, гэрч, шинжээч, өмгөөлөгч нарт мэдэгдэхгүйгээр прокурорын зөвшөөрлөөр мөрдөгч өөрөө биечлэн гүйцэтгэж байгаа нь нууц гэсэн ойлголтыг илэрхийлж байна.

Дүгнэлт. Мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэгч субъектын хувьд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч нь өөрөө байх ба энэ ажиллагаанд Гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албад болон нууц гүйцэтгэх ажилтан, гүйцэтгэх ажлын туслах хүчийг татан оролцуулахгүй байх явдал нь төрийн нууцыг хамгаалах нэг хэлбэр юм.

Нөгөө талаас мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах зардлын талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь гүйцэтгэх ажлын эрх бүхий байгууллагын тусгай албадаас явуулдаг гүйцэтгэх ажлын арга ажиллагаанаас тусад нь авч үзэх нэг үндэслэл юм. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлэх явцад гүйцэтгэх ажлын зардлыг ашиглах тухай болон гүйцэтгэх ажлын тухай хуульд мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад гүйцэтгэх ажлын зардал ашиглах талаар ямар нэгэн заалт эрх зүйн зохицуулалт байхгүй.

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Гүйцэтгэх ажлын тухай хууль
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Сэтгүүл:

4. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №8
5. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23
6. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1998 он, №3

Бусад материал

7. Улсын Ерөнхий прокурор, Тагнуулын Ерөнхий Газрын даргын 2017 оны 07 дугаар сарын 19 ны өдрийн А/84, А/57 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам”

⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1.3//Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ХАРЬЦУУЛСАН СУДЛАЛ

Б.Батцэрэн

Цагдаагийн сургуулийн эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч

Battseren.B

Associate Professor of the Department of Criminal
Law and Criminology of the University of Internal
Affairs of Mongolia, Police major.

Товч агуулга: 2002 оны Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамааруулж заасан байсныг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Эдийн засгийн гэмт хэргийн бүлгийн 18.6 дугаар зүйлд “мөнгө угаах” гэмт хэрэгт хамаарах үйлдлүүд гэж үзсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцид заасан агуулгаар гэмт хэргийн шинжийг тодорхойлсон нь тухайн гэмт хэргийн ойголт, зүйлчлэлийн талаар нэг мөр ойлгох хэрэгцээ шаадлага гарсан.

Abstract: Article 155 of the Criminal Code of 2002 states that the crime of "acquiring or selling property obtained by committing a crime" is a crime against the right to property seen.

Түлхүүр үг: Венийн конвенци, FATE, Палермогийн Конвенц

Key words: Vienna Convention, Convention of Palermo

Нэг. Олон улсын эрх зүйн зохицуулалт

1988 оны НҮБ-ын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”. (Венийн конвенц)-н 3дугаар зүйлийн 1.b.i-д хамаарах гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл гэмт үйлдэлд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг халхавчлах, нуун дарагдуулах болон гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавараас нь зайлсхийхэд ньтуслах зорилгоор уг хөрөнгийг хувиргах, шилжүүлэх 1.b.ii-д гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон, эсхүл тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотойжинхэнэ эрх эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах нь мөнгө угаалт байна гэж үзсэн⁶.

Венийн конвенцид мөнгө угаах гэмт хэргийг ийнхүү тусгах болсон хэд хэдэн үндэслэлтэй байсан. Энэ нь:

а. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээс бий болсон хөрөнгийн хөдөлгөөнийг хянах үед энэ нь мөнгө угаах гэмт хэрэг болон өөрчлөгдөж байгаа нь тогтоогдсон.

б. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтээс бий болсон орлого нь хээл хахууль хэлбэрээр нийгмийн бүх салбар луу нэвчин орж байсан нь тогтоогдсон.

⁶ НҮБ. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц. 1988, 3-р зүйл.

с. Нэгэнт нийгмийн бүх хэсэгт орсон хууль бус хөрөнгийн урсгал ямар нэгхэлбэрээр буцаад эдийн засгийн нэг эргэлтээс нөгөөд хөрвөхдөө хууль ёсны хөрөнгө болж хувирч байсан. Энэхүү урсгалд хатуу хяналт хууль, эрх зүйн орчин нэн шаардлагатай болсон⁷.

1989 оны Их долоогийн уулзалтаас гаргасан “Мөнгө угаахын эсрэг санхүүгийн аргаар тэмцэх олон улсын байгууллагын 40 зөвлөмж”

Олон улсын нэршлээрээ FATF гэж нэрлэгддэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсынбайгууллага 1989 онд их долоо гэгдэх нөлөө бүхий дэлхийн улс орнуудын санаачилгаар байгуулагдаж “40 Recommendations” буюу зөвлөмжийг гаргасан.

Энэхүү зөвлөмж нь 1988 оны НҮБ-ын “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”-н 3 дугаар зүйлийг гол эх сурвалж болгож боловсруулагдсан. “FATF-ын 40 зөвлөмж” нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг улс, орон бүрт нэг түвшинд хүргэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд улс хоорондын хамтын ажиллагаанд учирч болох хүндрэлүүдийг даван туулах зорилгоор гаргасан стандарт юм.

Энэ зөвлөмжинд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөх, шалгах, хууль бус гүйлгээ, орлогыг түдгэлзүүлэх, хураан авах эрх зүйн орчныг бүрдүүлэх, энэ ажлаар мэргэшсэн, төв байгууллагатай болох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг банк, санхүүгийн байгууллагаар авахуулах, сэжиг бүхий гүйлгээний талаар эрх бүхий байгууллагад мэдээлэх зэрэг цогц арга хэмжээ бүхий тогтолцоог бүрдүүлэхийг улс орнуудад зөвлөдөг.

2000 оны НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенц” (Палермогийн Конвенц)-ийн 6 дугаар зүйлд:

- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл эрх зүйн үндсэн зөрчлийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд нь туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;

- Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;

- Тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах;

- Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх гэж тодорхойлсон байдаг.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенцийн 2 дугаар зүйлд “... үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, биет эсхүл биет бус бүх төрлийн хөрөнгө хамаарах болон тэдгээр эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг нотлох хууль зүйн баримт бичиг хэрэгсэл ...” гэж тодорхойлжээ.

Олон улсын түвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Конвенцид зааснаар өргөн хүрээнд хэрэглэдэг бөгөөд гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томъёоллыг ашигладаг.

2003 оны НҮБ-ын “Авилгын эсрэг конвенц”

Конвенцийн хүрээнд 2 дугаар зүйлд гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж гэдгийг дараах байдлаар ойлгоно.

2.е-д “гэмт хэргээс олсон орлого гэдэг нь гэмт хэрэгүйдэх замаар шууд ба шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийгхэлнэ”

⁷ Robin Booth. Money Laundering Law and Regulation: A Practical Guide.2011,Oxford, p4-6.

2.н-д “ суурь гэмт хэрэг гэдэг нь Авилгын эсрэг НҮБ-ын конвенцийн 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн зүйл болж болох орлогыг бий болгосон гэмт хэргийг хэлнэ” гэж заасан.

Дээрх “гэмт хэргийн улмаас” гэдэг томъёолол нь авлига, албан тушаалын гэмт хэргийг тодорхойлж байгаа болохоос албан тушаалын шинжгүй, ахуйн хүрээний гэмт хэргийн илэрхийлдэггүй гэдгийг ойлговол зохино гэсэн байна.

Энэ хүрээнд FATF “40 зөвлөмж”-д суурь гэмт хэрэгт ямар гэмт хэргүүд хамаарах талаар нэмэлт оруулсан. Нийтдээ хориод төрлийн гэмт хэргийг үүнд хамааруулсан байна. Тухайн зөвлөмж нь 1996 онд мөнгө угаах чиг хандлага, арга зам өөрчлөгдсөнтэй холбогдуулж анх удаа шинэчлэгдсэн бөгөөд 130 гаруй улс хүлээн зөвшөөрснөөр олон улсын мөнгө угаахтай тэмцэх стандарт болж чадсан.

Зөвлөмжид мөнгө угаах гэмт хэргийн хамрах хүрээнд улс орнууд мөнгө угаах үйл ажиллагааг НҮБ-ын Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенци (Венийн конвенц), НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг 2000 оны конвенц (Палермогийн конвенц)-н дагуу гэмт хэрэгт тооцох шаардлагатайг зөвлөсөн бөгөөд нэмэлт тайлбарт мөнгө угаах гэмт хэрэгт аль болох өргөн хүрээнд суурь гэмт хэргүүдийг хамруулах шаардлагатайг зөвлөсөн ба дараах хэлбэрүүдээс сонгож болно. Үүнд:

- бүх гэмт хэргийг хамруулах
- “хязгаар” тогтоон тодорхой гэмт хэргийн төрөлтэй холбох
- суурь гэмт хэргийн ялын хугацаанаас хамааруулах (“хязгаарын арга”)
- суурь гэмт хэргийн жагсаалт гаргах
- энэ бүгдийг хослуулан хэрэглэж болно⁸.

АНУ-ын эрүүгийн хуулинд:

а) Хууль бус үйл ажиллагаа гэдгийг мэдсээр байж санхүүгийн гүйлгээ /financial transaction/ ашиглан санхүүжүүлсэн, эх үүсвэр, байршил, этгээдийг нуун дарагдуулсан үйлдэл. Энд дараах хууль бус үйлдлүүдийг ойлгоно.

- Хууль бус санхүүгийн гүйлгээ хийх зорилгоор тухайн хөрөнгө мөнгийг шилжүүлсэн, хууль бус орлогыг нуун дарагдуулах зорилгоор хийсэн үйл ажиллагаа, хууль бус үйл ажиллагаанаас орж ирсэн орлогын эзэн, эх үүсвэр, байршлыг нуун дарагдуулах, эсхүл хийгдэж байгаа хууль бус гүйлгээний зарим хэсгийг эсхүл бүхлээр нь хувиргах, өөрчлөх зорилгоор хийсэн үйлдэл, хууль бус гүйлгээний тухай мэдээллийг муж улсын болон холбооны хуулийн дагуу мэдээлэхээс зайлсхийсэн үйлдлийг,

б) Хууль бус үйл ажиллагаа гэдгийг мэдсээр байж АНУ-аас гадагш болон АНУ-руу хууль бус санхүүгийн үйл ажиллагааг мөнгөн хэрэгсэл /monetary instrument/ ашиглан хөрөнгийг шилжүүлсэн, өөрчилсөн, санхүүгийн гүйлгээний мэдээллийг илгээхээс зайлсхийсэн үйлдэл. Энд дараах хууль бус үйлдлүүдийг ойлгоно.

- Хууль бус санхүүгийн гүйлгээ хийх зорилгоор тухайн хөрөнгө мөнгийг шилжүүлсэн үйлдэл, хууль бус хөрөнгийг зөөвөрлөсөн, шилжүүлсэн, тээвэрлэсэн нь хууль бус мөнгөн хэрэгсэл ашигласан үйл ажиллагаа байсан гэдгийг мэдсээр байж тухайн хөрөнгийг зөөвөрлөсөн, шилжүүлсэн, тээвэрлэсэн үйлдэл, хууль бус үйл ажиллагаанаас орж ирсэн орлогын эзэн, эх үүсвэр, байршлыг нуун дарагдуулах, эсхүл хийгдэж байгаа хууль бус гүйлгээний зарим хэсгийг эсхүл бүхлээр нь хувиргах, өөрчлөх зорилгоор хийсэн үйлдэл, хууль бус гүйлгээний тухай мэдээллийг муж улсын болон холбооны хуулийн дагуу мэдээлэхээс зайлсхийсэн үйлдлүүд байна.

с) Хэн нэгэн этгээд хууль бус үйл ажиллагааг нуун дарагдуулсан, хуульд тусгайлан заасан хууль бус үйлдлээс бий болсон хөрөнгийг нуусан үйлдэл. Энд дараах хууль бус үйлдлүүдийг ойлгоно.

- Тусгайлан хориглосон хууль бус үйл ажиллагааг явуулах зорилгоор хийсэн үйлдэл, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогын эх үүсвэр, эзэн, байршлыг нуун дарагдуулсан, эсхүл

⁸ THE FATF RECOMMENDATIONS. 2012, p-34.

өнгөлөн далдалсан үйлдэл, хууль бус гүйлгээний тухай мэдээллийг муж улсын болон холбооны хуулийн дагуу мэдээлэхээс зайлсхийсэн үйлдлүүд байна⁹.

Англи улсын эрүүгийн хуулинд:

Гэмт хэргийн хөрөнгө гэдгийг мэдсэн хэрнээ түүнийг нуун дарагдуулсан, хувиргасан, өнгөлөн далдалсан, шилжүүлсэн, Их Британи улсын нутаг дэвсгэрээс гадагш зөөвөрлөсөн, хууль бус хөрөнгийг ашигласан, үр шимийг нь хүртсэн, өөртөө эзэмшсэн үйлдлийг мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинж байхаар хуульчилсан байна¹⁰.

Япон улсын эрүүгийн хуулинд:

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн хөрөнгийг авсан, хадгалсан, ашигласан, гэмт хэргийн хөрөнгийг хувиргасан, өөрчилсөн, өөрчилсөн мөнгийг хүлээн авсан үйлдэл нь мөнгө угаах гэмт хэргийн шинж болж байна¹¹.

ОХУ-ын эрүүгийн хуулинд:

Мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж нь мөнгөн сан болон бусад хөрөнгүүд нь бусдынхууль бус үйл ажиллагаанаас бий болсон гэдгийг мэдсээр байж хууль ёсны хөрөнгө болгох зорилгоор санхүүгийн хууль бус үйл ажиллагаа явуулсан,хувь этгээд нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас бий болгосон мөнгөн сан болон бусад хууль бус хөрөнгийг хууль ёсны хөрөнгө болгох зорилгоор санхүүгийн хууль бус үйл ажиллагаа явуулсан, хууль бусаар олж авсан хөрөнгө гэдгийг мэдсээр байж тухайн хөрөнгийг худалдан авсан үйлдэл байна¹².

БНХАУ-ын эрүүгийн хуулинд:

Мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бодисоос үүсэлтэй мөнгө хөрөнгийг мэдсээр байж авсан, ашигласан бол мөнгө угаах гэмт хэрэгт тооцно гэж заасан бөгөөд хууль бус орлогоороо:

- төрөл бүрийн сан байгуулсан,
- биет хөрөнгө болон санхүүгийн хөрвөх чадвартай хөрөнгө бийболгоход ашигласан,
- хөрөнгийг хувиргасан,
- гадаад орон руу шилжүүлсэн,
- ямар нэгэн байдлаар үнэнийг нуун дарагдуулсан үйлдэл байна¹³.

Мөнгө угаах гэмт хэргийн субъектын хувьд улс орнууд тодорхой бие хүн, хуулийн этгээд байхаар хуульчилсан байна. Мөнгө угаах гэмт хэрэг нь олон улс оронд “цагаан захтнуудын гэмт хэрэг” гэж нэрлэгддэг бөгөөд энэхүү гэмт хэргийг дурын хэн нэгэн бус зайлшгүй банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, тухайн салбарыг маш сайн мэддэг, өөрийн үйлдлийн хор хохиролыг ухамсарлаж, мэдэж байгаа аливаа этгээд байдаг онцлогтой.

Дүгнэлт

Терроризм, үндэстэн дамнасан гэмт хэрэг, авлига, албан тушаалын гэмт хэрэг, олон улсын байгууллага, банк, гадны хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй сан, буяны байгууллага, татвар төлхөөс зайлсхийх, хар зах зээл дэх бэлэн мөнгөний эргэлтийг зогсоох, мансууруулах бодис, галт зэвсгийн худалдаа, хүний наймаа, хууль бус эсхүл халхавчилсан үнэт цаасны арилжаа зэрэг зохион байгуулалттай үйлдэгддэг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх арга нь дээрх гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх бөгөөд энэ бүх нахцөлийг харгалзаж Монгол улс эрх зүйн орчиндоо мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоо олон улсын эрх зүйн хэм хэмжээн нийцүүлэн оновчтой тодорхойлох шаардлагатай байна.

Санал

-Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг нэгдэн орсон олон улсын гэрээ конвенци, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцид заасан агуулгаар нийцүүлэх

⁹ 18 U.S. Code § 1956 - Laundering of monetary instruments.

¹⁰ Proceeds of Crime Act2002.UK.,

¹¹ Act on Prevention of Transfer of Criminal Proceeds.Act No. 22, Japan, 2007.

¹² The Criminal Code Of The Russian Federation. 1996.

¹³ Criminal Law of the People's Republic of China. 1997.

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18,6 дугаар зүйлд суурь гэмт хэрэгтэй байхаар өөрчлөн найруулах / Практикт гэмт хэргийн хамт оролцох хэлбэрийг мөнгө угаах гэмт хэргээр зүйлчилж байгааг засах /

-Мөнгө угаах гэмт хэргийн талаар хуулийн байгууллагын нэгдмэл ойлголттой болгон нэмэгдэл эд хөрөнгө хураах ялыг оногдуулах

Ашигласан материал

Хууль, эрх зүйн акт:

- 1) Монгол улсын эрүүгийн хууль, 2015 он
- 2) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он
- 3) 1988 оны НҮБ-ын “Мансууруулах болон сэтгэгцэд нөлөөлөх эм, бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”
- 4) 200 оны НҮБ-ын “Авилгын эсрэг конвенц”
- 5) 2000 оны “Палермогийн конвенци”
- 6) Монгол банк, сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлага, УБ хот, 2020 он
- 7) Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт ФАТФ-ын зөвлөмж, 2019 он

Монгол эх сурвалж:

- 8) МХХ, Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, 2017 он
- 9) СЗХ, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх нь, 2020 он
- 10) ТЕГ, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх зарим асуудал, 2020 он
- 11) Жанцан С. Монгол улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий ба тусгай анги. УБ., 2012, 414дэх тал.

Гадаад эх сурвалж:

- 12) Robin Booth. Money Laundering Law and Regulation: A Practical Guide. 2011, Oxford, p4-6.
- 13) U.S. Code § 1956 - Laundering of monetary instruments
- 14) Proceeds of Crime Act 2002. UK.,
- 15) Act on Prevention of Transfer of Criminal Proceeds. Act No. 22, Japan, 2007.
- 16) The Criminal Code Of The Russian Federation. 1996.
- 17) Criminal Law of the People's Republic of China. 1997.

Цахим эх сурвалж:

- 1) <https://www.google.com/amp/s/shuftipro.com/blog/40-surprising-facts-and-statistics-about-money-laundering-2021-update/>
- 2) https://ec.europa.eu/info/business-economy-euro/banking-and-finance/financial-supervision-and-risk-management/anti-money-laundering-and-counteracting-financing-terrorism_en
- 3) <https://www.knowyourcountry.com/mongolia1111>

--o0o--

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ОРЧИН
PREVENTION OF DOMESTIC VIOLENCE,
INTERNATIONAL EXPERIENCE AND LEGAL ENVIRONMENT**

Б. Баярболд

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч,
/хууль зүйн магистр/

Bayarbold B.

Police School at University of Internal Affairs,
Department of Public Law,
lecturer police senior lieutenant,
/master of law/

Хураангуй: Дэлхийн улс гүрнүүд болон Монгол улс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлогыг ямар түвшинд, хэрхэн тодорхойлж буйг харьцуулан судалж, гадаад улс орны зарим нэг сайн туршлагыг Монгол улсын нөхцөл байдалд уялдуулан хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой тулгамдсан асуудлын шийдлийг олохыг эрмэлзэж, судалсан болно.

Abstract: A comparative study of the extent to which the world powers and Mongolia define domestic violence policy, and whether there are opportunities to implement some of the best international practices in the context of Mongolia, and seeks solutions to problems related to domestic violence.

Түлхүүр үг: Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, олон улсын гэрээ, конвенц, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт, гэмт хэрэг, олон улсын туршлага, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, гэрлэлт, жендер, тэгш эрх

Keywords: Constitution, Criminal Law, Law on Violations, International Treaties, Conventions, Domestic Violence, Divorce, Crime, International Experience, Rights of Children and Women, Marriage, Gender and Equality.

Оршил. Монгол улсад гэр бүлийн хүчирхийллийн гаралт өндөр, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд, эмэгтэйчүүд амь насаа алдах, бэртэж гэмтэх явдал буурахгүй байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллээс үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, таслан зогсооход хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд болон хүн бүрийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх явдал тулгамдсан асуудал болоод байна. Гэр бүлийн хүчирхийлэл бол эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хамгийн ноцтой хэлбэр юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь хохирогчид айдас түгшүүр, сэтгэлийн шаналал, өөртөө итгэх итгэлээ алдах зэрэг олон сөрөг үр дагаврыг авчрахын зэрэгцээ хохирогчийн эрх чөлөөтэй, аюулгүй байх эрхийг боогдуулан, хүсэл эрмэлзлийг унтрааж эмзэг, сул дорой байдалд оруулж, ирээдүйд итгэх итгэлээ алдахад хүргэдэг. Үүгээр зогсохгүй хохирогч болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал, эрүүл мэнд болон нийгмийн олон талт асуудлыг хөнддөг.¹⁴

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хүүхэд хамгааллын тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль, бусад холбогдох дүрэм журмын хүрээнд зохицуулсан байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 оны 12-р сард батлагдаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр УИХ-аас эхлээд хувь хүний үүрэг оролцоо хуульчлагдсан. Түүнчлэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны

¹⁴ Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүн цагдаагийн ажилтны гарын авлага. УБ., 2016 он. 2 дэх тал

харьяа агентлаг болох гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газар нь гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд амжилттай ажиллаж байна.

Үндсэн хэсэг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй гэж тус тус заасны дагуу төр нь гэр бүл, хүүхдийг хамгаалах үүрэг хүлээдэг билээ.¹⁵ Сүүлийн таван жилийн байдлаар улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 3211 иргэн хохирсны 2870 буюу 89.3 хувь нь эмэгтэйчүүд, 2708 хүн хөнгөн, хүнд хэлбэрийн гэмтэл авсан, 69 хүн амь насаа алдсан, гэмт учирчээ. Өөрөөр хэлбэл жилд хэргийн улмаас 1266.5 сая төгрөгийн эд хөрөнгө дунджаар 545, сард 45, өдөрт 1-2 гэмт хэрэг үйлдэгдэж байна. Зөвхөн 2015 онд 1229 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 365 хэргээр буюу 42.2 хувиар өссөн.

Олон улсын зохицуулалтуудаас үзэхэд гэр бүлийн хүчирхийллийг үндсэндээ жендэрт суурилсан эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалт гэж үзэх хандлага олон улсын түвшинд илүү өргөн дэлгэрсэн байдаг байна. Ер нь дэлхий даяар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг ажээ. Манай улсын хувьд ч гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь ихэвчлэн эмэгтэйчүүд байдаг талаар эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын бүх хэлбэрийг устгах тухай Конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол улсын ээлжит найм есдүгээр илтгэлд дурдсан байна. Гэвч дэлхийн улс орнуудад гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн охид эмэгтэйчүүд, хүүхдүүдээр хязгаарлахгүй, насанд хүрсэн эрэгтэйчүүд болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүчирхийлэлд өртсөн тохиолдлуудыг гэр бүлийн хүчирхийлэлд тооцох зохицуулалтууд бий болж байна. Жишээлбэл Европын холбооны зөвлөлийн Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх тухай конвенцод "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг бөгөөд эрэгтэй хүмүүс мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч байх боломжтой болохыг хүлээн зөвшөөрөн" гэж заасан байна. Гэр бүлийн хүчирхийллийг охид, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хүчирхийлэл гэж ойлгож, тодорхойлох нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болох нийгмийн зарим бүлгийн хүмүүсийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих үйл ажиллагаанд хамруулахгүй орхигдуулах эрсдэлийг үүсгэх аюултай юм.

Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд:

Монгол Улсын Үндсэн хуульд иргэний халдашгүй байдлыг хамгаалах талаар "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэний өмнө хариуцна"; 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д "Монгол Улсын иргэн амьд явах эрхтэй.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг ялын дээд хэмжээ уйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно"; "Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй", "Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" ; 16 дугаар халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй": 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13-т "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"; 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д: "Засгийн газар төрийн хуулийг биелүүлж хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэж тус тус заасан хэм хэмжээнүүд нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа төдийгүй тусгайлсан эрх бий болгоход

¹⁵ Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (2011).

чиглэгдсэн хуний эдлэх эрхийн үндэс, хохирогчийн эрхийг хангах, аюулгүй байдлыг хамгаалах асуудлыг зохицуулах эрх зүйн үндэслэл болох юм¹⁶.

Гэр бүлийн тухай хуулийн 4.1-д: "Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ" гэж гэр бүлийн харилцааны үндсэн зарчмыг тодорхойлсон. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль¹⁷ нь гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, цаг алдахгүй, шуурхай таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх болон урьдчилан сэргийлэх 42 тогтолцоо, үйл ажиллагааны эрхзүйн үндсийг тогтоосон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар:

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм
- Хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын салбар дундын зохицуулалт
- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, хугацааг нарийвчлан тодорхойлсон.

1. Хуулийн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлоход чиглэгдсэн байсныг өөрчилж, хохирогч, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилтыг шинээр нэмсэн.

2. Хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөж, хамгаалалтын гадна үлдэж байсан хохирогчдыг энэ хуулийн зохицуулалтад хамааруулах боломжийг бүрдүүлсэн.

3. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас хамааралтай эмзэг байдлыг харгалзан хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг нэг бүлэг болгон шинээр оруулсан.

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа салангид, зарим яамны чиг үүрэг орхигдсон байгааг өөрчилж, байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, салбар дундын зохицуулалт, тэргүүлэн гүйцэтгэгч хэн байхыг тодорхой болгосон.

5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээсэн байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн.

Эрүүгийн хуульд: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгч хариуцлагаас мултрахгүй байх, салбар хоорондын хамтын ажиллагааг нийцүүлэх, иргэд олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх, дагалдах хуулиудад зохих нэмэлт, өөрчлөлт оруулж хууль хоорондын хийдэл, зөрчилдөөнт байдлыг арилгах үүднээс 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэр бүл дэх хүчирхийлэл нь эрүүгийн гэмт хэрэг болохыг хуульчилж, "Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" 11.7 дугаар зүйлийг нэмж оруулсан.

Уг гэмт хэргийн объектив шинжийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах гэж тодорхойлсон. Ийнхүү тодорхойлсон нь практикт түгээмэл үйлдэгддэг эхнэр, нөхрөө хардаж зодох, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох байдлаар бие махбодын, сэтгэл санааны зовуурь шаналал байнга учруулдаг, тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоох боломж бүрдсэн юм. Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг зодох үйлдлийг бие махбодын сэтгэл санааны зовуурь шаналал байнга учруулсан бол үндсэн бүрэлдэхүүнээр зүйлчлэхээр заасан.

¹⁶ Т.Оюунчимэг. Гэрч. УБ., 2013 он. 119 дэх тал

¹⁷ [Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль бүрэн эхээрээ \(khs.gov.mn\)](#)

Зөрчлийн тухай хуульд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчих" зөрчлийг тусгаж, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх хуулиар хүлээсэн үүрэгтэй этгээд гэр бүлийн хүчирхийллийн талаар холбогдох байгууллагад мэдээлээгүй, түр хамгаалах байрны журмыг зөрчиж нэвтэрсэн, уг байрны зориулалтыг өөрчилсөн, өөр зориулалтаар ашигласан бол захиргааны шийтгэл ногдуулахаар болсон байна.¹⁸

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт: "жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг"; 4.1.2 дахь хэсэгт: "жендэрийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг"; 4.1.3. дахь хэсэгт: "жендэрийн хэвшмэл үзэл" гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг; 4.1.7. "бэлгийн дарамт" гэж бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл хурьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхүйг, эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавихыг; 4.1.8. "жендэрт суурилсан хүчирхийлэл" гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодийн, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйг; ойлгоно хэмээн тус тус зааж өгсөн байна.

Монгол Улсын гэр бүлийн хүчирхийллийн эсрэг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц:

Нийгмийн сөрөг үзэгдэл болсон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх уйл ажиллагаа нь дараах Монгол Улсын нэгдэн олон улсын гэрээ конвенц болон дотоодын хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна. Тухайлбал: Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд: Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан хүний эрхийн олон улсын гэрээ, конвенциудын дотроос судлан буй сэдвийн хамааралтай баримт бичгүүдийг судлан авч үзвэл:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал: "Гэр бул бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй", "Гэрлэгсэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлах үед тэгш эрхийг эдэлнэ" ¹⁹ гэж гэр бүлийн харилцааны суурь зарчмуудыг тунхаглан баталгаажуулсан байх бөгөөд эдгээр хэм хэмжээнүүд нь улс орон болон нийгмийн гишүүн бүрийн, гэр бүлийн гишүүдийн, хүн бүрийн чандлан сахих ёстой нийтлэг стандарт болон тогтжээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Фактад²⁰ гэр бүлийн харилцааны тухайд: "Харилцан бүрэн зөвшилцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно. Оролцогч улс бүр гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авах, хүүхдийг яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйн хувьд шаардлагатай бүхий хамгаалалт эдлэх эрхтэй" болохыг болон гэрлэлт цуцлах тохиолдолд аливаа хүүхдийг хамгаалах талаар шаардлагатай заалт гаргах ёстойг анхааруулжээ.

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай олон улсын фактын 10-р зүйлд: Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр бүлд, ялангуяа түүний үүсэх үед, бие дааж амжаагүй хүүхдийг халамжлах хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хирээр халамжлан хамгаалж

¹⁸ Зөрчлийн тухай хууль. 5.4 дүгээр зүйл.

¹⁹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. /<https://www.legalinfo.mn/law/details/1271>

²⁰ Иргэн болон олон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. /<https://www.legalinfo.mn/law/details/1257>

тусална. "Гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрсөний үндсэн дээр гэрлэнэ"²¹ гэсэн хэм хэмжээнүүд тусгагдсан.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид²². "Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх гэдэг нь эмэгтэйчүүдэд бие махбод, бэлгийн буюу сэтгэл санааны гэм хор, зовлон шаналал учруулсан буюу учруулж мэдэх, бэлгийн харьцааны шинжтэй үндэслэлээр үйлдэгдсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн ийм үйлдэл хийхийг албадсан, нийгмийн буюу хувийн амьдрал дахь эрх, эрх чөлөөг дур мэдэн хасах явдал мөн"²³ " гэж тодорхойлжээ.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцид²⁴: "Эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах"-ыг үүрэг болгосон нь хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай шууд заасан онцгой ач холбогдолтой.

НҮБ-аас улс орнууд үндэсний хууль тогтоомжоо сайжруулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлсан хууль боловсруулахад зориулан хүйсийн өвөрмөц байдлыг тусгасан, хүчирхийлэлтэй холбоотой бүх асуудлыг багтаасан зөвлөмж болгон гэр бүлийн гишүүд буюу ойр дотны харьцаатай хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн бол гэр бүл дэх хүчирхийлэл гэж үзэх, дээрх нэр заасан хүмүүсийг хүчирхийлэхийг хориглосон, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалсан, хүчирхийлэл дахин гарахгүй байхад чиглэгдсэн хууль тогтоомж боловсруулан гаргахыг уриалж 1993 онд "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" загвар хууль боловсруулан гаргасан юм.

Гэр бүл дэх хүчирхийллийн шинжтэй үйлдлүүдийг "бие махбод, сэтгэл зүйн болоод бэлгийн харьцааны шинжтэй хэл амаар доромжлох, айлган заналхийлэхээс эхлээд бие махбодод хүнд гэмтэл учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, албадах, мөрдөн мөшгөх, хэл амаар доромжлох, орон байранд хүчээр буюу хууль бусаар нэвтрэн орох, өмч хөрөнгө устгах, бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэр бүл болох, төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлгэ эрхтэнг бэртээж гэмтээх, биеийг нь үнэлэхтэй холбоотой хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэл хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг "гэр бүл дэх хүчирхийлэл" гэж үзэх ёстой гэжээ.

Манай орны тухайд олон улсын гэрээ конвенц, НҮБ-аас гаргасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль зөвлөмжийн дагуу олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар гэр бүлийн хүчирхийлэл манай улсад бодитойгоор оршин байгааг бүх нийтэд дэлгэн харуулж бодлого, шийдвэр гаргадаг, хуулийг хэрэгжүүлдэг албан тушаалтнуудад хүчирхийллийг ойлгуулснаар 2004 оны 5 дугаар сарын 13-д Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиа, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалан байрлуулах, утсаар зөвлөгөө өгөх болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн билээ.

Гадаадын зарим улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага:

Гадаадын ардчилсан орнуудад гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг дуугүй өнгөрөөхөө болж төрийн түвшинд авч хэлэлцэх асуудлын тоонд оруулах үйл явц нь 1970-аад онд феминистууд, олон нийтийн идэвхтнүүд, гэр бүлийн хүчирхийлэлд хохирогч болсон эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь хамтын үйл ажиллагаа, чармайлтын үр дүнд бий болсон байна. 1990-ээд оноос бүх дэлхийн улс

²¹ <https://www.legalinfo.mn/law/details/1284>

²² <https://www.legalinfo.mn/law/details/1285>

²³ Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенц . НҮБ. 1993

²⁴ " Хүүхдийн эрхийн тухай конвенц . /<https://www.legalinfo.mn/law/details/1276>

орнуудын засгийн газрууд гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн ноцтой асуудал хэмээн үзэж түүнийг шийдвэрлэх арга зам, гарцыг хайж эхэлсэн.

Хүчирхийлэл бол "бусад хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны гэмтэл учруулах эрсдэлтэй байдлаар биеийн хүч юм уу эрх мэдлийг санаатайгаар ашиглах юм уу ашиглахаар заналхийлэх үйлдэл"²⁵ гэж тодорхойлдог. Дэлхийн улс орнуудад гэр бүлийн хүчирхийллийн талаар явуулсан судалгаа, эмэгтэйчүүд баримтаас үзвэл тоо ихээхэн тохиолдолд хүчирхийллийн хохирогч болдог гэдгийг баталсан байна.

Залуучуудын үйлдсэн хүчирхийллээс үүдэлтэй дарамт ачааллыг бага, дунд орлоготой улс орнуудад илүүтэй үүрдэг ч урьдчилан сэргийлэх бодлого, хотолбөрийн үр нөлөөг судалсан судалгаа, үнэлгээнүүд бараг бүгд Австрали, Их Британи, Баруун Европын хэдэн улс, АНУ зэрэг өндөр орлоготой улс оронд хийгдсэн байна. Хувь хүн, ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлсэд анхаарсан бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлсэн судалгаанууд цөөнгүй байдаг бол орон нутгийн ба нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсэд нөлөөлөх бодлого, стратегийн үр нөлөөг судалсан нь бага байна.

Урьдчилан сэргийлэх стратегиуд нь бага наснаас анхаарч эхэлж байгаа нь сайшаалтай ч бага насанд үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэг нь есөж том болохын хэрээр өсвөр болон залуу насанд хүчирхийллээс хамгаалж чадаж байгаа эсэхийг авч үзсэн урт хугацааны судалгаа цөөн байна²⁶.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд: Гэр бүлийн хүчирхийлэл нь улс орон, тэдгээрийн хөгжил, хүмүүсийн амьдралын ялгаатай нөхцөл байдлыг үл харгалзан дэлхийн бүх улс орнуудад гарсаар, үүнийг зарим улсад хүний эрхийн зөрчлийн нэг хүнд хэлбэр, нөгөө хэсэг нь гэмт хэрэгт тооцон "эрүүжуулж" тодорхой арга хэмжээнүүдийг авсаар байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой олон улсын дараах гэрээ конвенц хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт (1966) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын факт (1966) Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979), энэхүү конвенцын нэмэлт протокол (1999) Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989) Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол (2000).

Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц Хүний эрхийн тухай 1993 оны Венын конвенц Хүн амын хөгжлийн асуудлаарх 1994 оны Кайрын конвенц. Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжингийн бага хурлуудын шийдвэрүүдэд тусгагдсан гэр бүлийн гишүүн бүр аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг хангахад чиглэгдэхээс гадна үндэсний хууль тогтоомжид тусгагдсан байдаг. Дээрх олон улсын баримт бичигт хүний эрх, эрх чөлөө, аливаа хүчирхийллийн талаар дараах байдлаар тусгасан байна.

Үүнд: Хүний эрхийн түгээмэл тунхаглал: Нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий ассамблейн 217 тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалж, нэгдэн орсон бүх улсуудын засгийн газарт хүний эдлүүлэх ёстой эрхүүдийг зааж, хүчирхийллээс хамгаалахыг үүрэг болгосон байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3-р зүйлд: "Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй", 2-р зүйлд: "Хүн бүр энэхүү тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьсны өнгө, үндэс угсаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой" хэмээн заасан хүний жам ёсны эрхээс гадна хүний хамрагдах, сурч боловсрох, бага сургуулийн төлбөрийг үнэ төлбөргүй заавал олгох соёлын амьдралд оролцох, шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг аж амьдралдаа ашиглах зэрэг хүний олон эрхүүд тусгагдсан байна. Түүнчлэн 7 дугаар зүйлд: "... гэр бүлийн гишүүдэд хангалуун амьдрах боломж олгох", 10 дугаар зүйлд: "Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр булд, ялангуяа түүнийг үүсэх үед бие дааж амжаагүй хүүхдийг халамжлах,

²⁵ Krug E, Dahlberg L, Mercy J, Zwi A, Lozano R. World report on violence and health. Geneva: World Health Organization; 2002.

²⁶ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь : нотлох баримтын тойм . УБ. 2017. 10 дахь тал.

хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хэрээр халамжлан хамгаалж тусална" хэмээн тодорхойлжээ.

Оросын холбооны улсын туршлага.

ОХУ-ын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй гэж үздэг 10 аргыг онцлон авч үзлээ. Үүнд:

1. Боловсролтой байх боломжийг бүрдүүлэх. Гэр бүлийн хүчирхийлэл нь боловсролтой гэр бүлд ч үйлдэгддэг, гэхдээ боловсролтой хохирогч хэрэв том хүн бол гэрээсээ явж чадна, өөртөө ажил олж хийж өөрөө аваад явчих чадвартай байна. Энэтхэг улсын эмэгтэйчүүд санхүүгийн боломжгүй байдлаасаа сурч боловсорч чаддаггүй гэх шалтгаанаар гэр бүлийн хүчирхийлэлтэй эвлэрэхээс өөр аргагүй байдалд байдаг байна. Гэр бүлийн хүчирхийлэлээс хамгаалах нэг арга хэрэгсэл бол боловсролтой байх.

2. Мэдээлэл түгээх. Ихэнх хүмүүс боловсролтой эсэхээс үл хамраан тухайн тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эсэхээ ойлгодоггүй, хэрэв хохирсон бол тусламж авах эрхтэй гэдгээ мэддэггүй. Хүмүүст гэр бүлийн хүчирхийллийн шинж тэмдэг, хор аюулын талаар байнга мэдээлж байх: сургууль, их дээд сургууль, албан газар, төв, орон нутагт энэ чиглэлээр сургалт явуулах, хичээл заах, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах.

3. Сөрөн босож, асуудлуудыг хэлэлц. Хохирогчийг дуугүй байлгахгүйн тулд түүний даван туулсан хүчирхийллийн тухай яриулах, хүмүүст энэ тухайгаа ярих нь шившиг биш гэдгийг, тусламж авах эрхтэйг нь ойлгуулах, үүнд олон нийтийн сошиал ертөнцийг ашиглаж болох юм.

4. Олон нийтийн байгууллагуудын хүч тусалцааг авах. Засгийн газар хойрго хандах, авлигад идэгдсэн байх зэрэг тохиолдолд олон нийтийн байгууллага том тусалцаа үзүүлж чадна. Төрийн бус байгууллагуудын талаарх мэдээллийг сайн түгээх, тэднээс тусламж хүсэж болохыг ойлгуулах.

5. Хохирогчийг дэмжих. Тухайн хүний, айл гэрийн хувийн асуудал мэтээр харах нь хохирогчид туслахгүй байхаас гадна энэ талаар ямар ч арга хэмжээ авах хүч чармайлт гаргахгүй байна гэсэн үг юм. Харин эсрэг үйлдэл нь хохирогчид найдлага төрүүлж, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд нь тусална. Үл оролцоо нь хохирогчид бус хүчирхийлэл үйлдэгчид ашигтай тусна.

6. Хариултыг нь өг. Энэ нь аюулгүй хувилбар биш ч гэсэн, тухайн хүчирхийлэл таны амь нас, эрүүл мэндэд аюултай байдлыг үүсгэж байгаа бол хэрэглээд үзэхэд (хариултыг нь хүчтэйхэн өг) гэмгүй гэдгийг ойлгуулах. Өөрийгөө хамгаалах нь хүчирхийлэлд тооцогдохгүй. (Манай улсын хувьд хэтрүүлбэл гэмт хэрэгт тооцогдоно).

7. Дур зургаа өөрчлөх. Бидний өмнөх нийгмийн үед гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа ярьсан эмэгтэйг худалч, соёлгүй, харин эрэгтэйг нь шоолж, "сул дорой амьтан" гэдэг байжээ. Одоо цагт гэр бүлийн хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрийг ямар ч нөхцөлд зөвтгөх ёсгүй, гэмт хэрэг болохыг ойлгож, хохирогчийг шоололгүй, туслах ёстой.

8. Хүүхдүүдээ зөв хүмүүжүүлэх. Гэр бүлийн хүчирхийллийн хамгийн том хүмүүжилийг олгох. Судалгаагаар гэр бүлийн шалтгаан бол буруу хүчирхийлэлд өртөж байсан эрэгтэй хүүхэд гэр бүлийн хүчирхийлэгч болох, эмэгтэй хүүхэд ГБХ-ийг байх ёстой зүйл гэж хүлээн авах магадлал өндөр байдаг²⁷.

Америкийн нэгдсэн улсын туршлага

1994 онд АНУ-ын Конгресс эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хууль (орос. Закон о насилии против женщин, англ. Violence Against Women Act (VAWA) батлан гаргасан, одоо уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил явагдаж байгаа юм байна²⁸. АНУ-д 1960-70-д оны үед иргэдэд хууль зүйн тусалцаа тусалцаа үзүүлэх өмгөөлөл / ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх хуулийн сургуулиудад нэгэн зэрэг хуулийн оюутнуудыг оролцуулах ажлыг эхлүүлсэн нь америкийн хуулийн боловсролд томоохон байр суурь эзэлсэн, 50 гаран жилийн

²⁷ <http://ugolovnyi-expert.com/domashnee-nasilie/>

²⁸ <http://ru.myattorneyusa.com/zakon-o-nasii-protiv-zhenshchin-v-ssha>

түүхтэй туршлага байна. Вашингтоны Хуулийн сургуулийн "Клиник сургалт " бол хамгийн сонирхолтой, бас хамгийн их үр өгөөжтэй, оюутнууд жинхэнэ утгаараа дадлагажиж чаддаг. Энэ сургууль Клиник сургалтаа явуулахдаа 1 семестрт 12-14 оюутныг саналаар нь элсүүлэн авч бэлддэг. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой уулзаж, хохирогчид үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зэргээр оюутан практик дээр сурч боловсорч, хичээл дээр үзсэн мэдлэгээ бататгаж, чадавхаждаг, мөн ГБХ-ийг олон нийтэд таниулах урьдчилан сэргийлэх ажилд оролцдог байна.

АНУ-д гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид "Эрх хязгаарлах" арга хэмжээг шүүхээс авдаг. Сургуулийн захиргаанаас "Хуулийн сургуулийн Клиник сургалтын оюутнууд үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө өгч, өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна" гэсэн утгатай зарыг шүүхийн байгууллагад байрлуулж, иргэдэд сургалтаа сурталчилдаг, үүний дагуу олон хохирогч нар ирж үйлчлүүлдэг байна. Энэ сургууль нь Клиник сургалтын танхим, оюутнуудын ажиллах өрөөтэй, суралцах, ажиллах орчныг бүрдүүлсэн, эрх зүйн туслалцаа авсан иргэдийн материалыг нууцалж хадгалдаг онцлогтой.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх Прокуроруудын нийгэмлэг (The Prosecutors' Resource on Violence Against Women) AEQUITAS гэдэг сургалтын байгууллагаас төлбөрийн чадваргүй хүмүүст өмгөөлөгч олж өгөх, өмгөөлөгчдийг сургах, хохирогчийг хамгаалж, шүүх хурал дээр хохирогч нэг асуудлаа олон дахин ярих хүндрэлээс сэргийлсэн арга хэмжээ авахад анхаардаг.

АНУ-ын Төрийн Департаментын Хар тамхи, хууль сахиулах олон улсын товчоо (INL) нь АНУ-ын прокурор, шүүх, цагдаа болон төрийн ба төрийн бус бүх байгууллагатай хамтран ажилладаг, цагдаагийн хандлагыг сайжруулах үүднээс стандартчилах ажил хийсэн, мөн ГБХ хэрэг дээр нотлох баримтад үндэслэсэн цагдаагийн үйл ажиллагаанд илүү анхаарч, "Hi point model "-ийг хэрэгжүүлдэг.

ГБХ-ийн хэрэгтэй тэмцэх хууль сахиулах ажилтнуудыг бэлтгэх, сургах (The National Sheriffs association) байгууллага нь цагдаагийн алба хаагчдад гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг хэрхэн хамгаалах талаар болон хэрхэн зөв харьцах, туслалцаа үзүүлэх 12 цагийн сургалт явуулдаг:

1. Гэр бүлийн хүчирхийлэл гэж юуг хэлдэг талаар, гэр бүлийн хүчирхийллийг хэрхэн таних, мэдүүлэг авах, ярилцлага хийх, ямар аюултай вэ гэдгийг ойлгуулах, мэдрэмжтэй хандах
2. Гэр бүлийн хүчирхийллийн газарт очоод юу болж байгааг ойлгох, бид та нарт тусалж чадна гэдгийг итгүүлэх (хохирогч нарт чи ганцаараа биш гэсэн мэдээлэл тараадаг), хохирогч нарт мэдээллээ бүрэн өгөх арга тактик, ярилцлага хийх, гэр бүлийн хүчирхийлэл өртөөгүй, хохирогч биш хүмүүст яаж хандах вэ, тэд нарын асуудлыг яаж журамлах
3. Боомилонт болон мөрдөн мөшгөх хүчирхийллийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээс мэдүүлэг авах, галт зэвсгийг хураан авах, хүчирхийлэгчийг баривчлах зэрэгт ямар тактик ашиглах
4. Нотлох баримт цуглуулах, 2 талын хүмүүсийг сонсож бүх талын мэдээллийг авах, аль болох "том" зургаар ГБХ хэргийг олж харах боломжийг бүрдүүлэх, яаж дурмээ зөрчихгүй ажиллах алхмыг зааж өгөх
5. Гэрт нь очихгүй, утсаар ярихгүйгээр яаж хохирогчийг хамгаалах, цэцэг өгөх мэтээр өрөвдүүлэх сэтгэл төрүүлэх үйлдлийг хэрхэн зогсоох, эд хөрөнгө эвдэх, улсын өмчид халдахаас хэрхэн сэргийлэх
6. Улсын хууль, мужийн хуулиуд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид хэрхэн үйлчлэх талаар /Муж дамжин хүчирхийлэл үйлдсэн тохиолдлыг хэрхэн шалгаж шийдвэрлэх, хохирогчийг хамгаалах шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд хохирогч яаж хамгаалах вэ г.м алхам бүрийг заадаг.

Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч хохирогчийг бус, цагдаагийн алба хаагчид буруу өгөхөд чиглүүлсэн сургалт, зөвлөгөө өгдөг, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн сургалтыг зохион байгуулдаг байна. Тухайлбал, хүүхдүүдэд гэр бүлийн эрүүл харилцааны талаар, хэрхэн хүчирхийлэлд өртөхгүй байх талаар г.м.

Probation officer- Шүүхийн шийдвэрээр томилогддог (хохирогчийг хамгаалах шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд ажилладаг нэмэлт ажилтан) ШШГБ-ын ажилтан болох хянагч байцаагч ажиллуулдаг туршлага сонирхолтой байна. Хянагч байцаагч нь хүчирхийлэгчид хяналт тавьдаг,

түүнд мэдээлэл өгөх, тэр буруу зүйл хийж байна уу гэдгийг нь хэлж ойлгуулдаг. Шүүх хурал хүртэл цагдан хоригдож байгаа хүчирхийлэл үйлдсэн этгээд нь тэндээс маш олон дуудлага хийж хүмүүстэй ярьдаг, тэр яриаг нь бичлэг хийж баримтжуулан, шүүх хурал дээр шүүгчид нь өгөх асуудлыг хариуцдаг.

"Doorways" түр хамгаалах байрны ажилтнууд хамгаалалтад авагдсан хохирогчид хамгаалалтад байх хугацаандаа чөлөөтэй ажилдаа явж, хөдөлмөр эрхэлж, хүүхэд бол сургууль цэцэрлэгтээ хамрагдахад нь тусалж, хохирогчдыг ажил, сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах ажлыг зохион байгуулдаг.

Болгар улсын "Ажиглалтын хөтөлбөр". 2005 онд анх удаа шүүхийн Ажиглалтын хөтөлбөрийг Болгарт бий болгожээ. Хохирогч эмэгтэйчүүдэд зориулсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн өмнө тэдний хамгийн чухал асуудлуудад анхаарал тавих чиглэлээр уг ажиглалтын хөтөлбөрийг бэлтгэн явуулдаг байна. Бэлтгэл ажлыг сайтар бэлтгэж, шүүгч, цагдаа, прокурор, өмгөөлөгчидтэй ажил хэргийн харилцаа тогтоосны дараа уг хөтөлбөрийг эхлүүлдэг. Бэлтгэл ажлын алхмууд:

1. Хууль хяналтын тогтолцоог судлах: Гэр бүлийн хүчирхийлэлд хэрэглэгддэг хуулийг ойлгох, хэргийг яаж хянан шийдвэрлэдэг, хуулийн байгууллагын үүрэг оролцооны талаар сайтар мэддэг байх.

2. Эхний зорилтуудаа тодорхойлох: Хяналтын бүлэг ямар ажил хийх, үүний тулд ямар эх үүсвэрийг зарцуулахаа эхлээд тодорхойлох. Дараа нь ажиглах хэргүүдийг сонгохдоо ямар шалгуур үзүүлэлт баримтлахаа тодорхойлох.

3. Урьдчилсан ярилцлага хийх: Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг шийдвэрлэхэд тухайн байгууллагад болж байгаа болон болохгүй байгаа зүйлийн талаар хууль хяналтын (хууль сахиулах) байгууллагын ажилтнуудаас ярилцлага авах

4. Нөөц бололцоонд үнэлгээ гаргах: Хяналтын ажлын далайц хэмжээ нь тухайн байгууллагад байгаа хүний болон санхүүгийн нөөц бололцооноос хамаарна.

5. Эргэн мэдээлэх: Олон нийтийн бух давхаргын оролцоо, дэмжлэгийг авах естой. Хууль хяналтын байгууллагын ажилтнуудаас ал хүсэлт авч, тэдний зовниж явдаг зүйлийн талаар мэдээлэл авах нь ажиллагааг өргөжүүлэхээс гадна төслийн тогтвортой ажиллагаа амжилтад ихээхэн тустай байдаг.

Голландын хүчирхийлэл үйлдэгч нарт чиглэсэн хөтөлбөр. Голландад гэмт этгээдүүдэд зориулсан хөтөлбөрийг Utrecht хотын цагдаагийн газар De Waag-н эмнэлэгтэй хамтран явуулдаг ба хөтөлбөрийг Dr.Hoeven-ы сан гэр бүлийн хүчирхийллийн гэмт этгээдүүдэд зориулан санхүүжүүлдэг. Хөтөлбөр нь дараах зарчмаар явагддаг: Эмэгтэйтэй цагдаагийн байгууллагаар дамжуулж холбоо барих ба нөхөртэй нь сэтгэл мэдрэлийн эмч байлцуулан 3 удаа ярилцлага хийж, түүний дараа хүчирхийллийг таслан зогсооход чиглэгдсэн биеэ авч явах дасгал хийгддэг. Энэ хөтөлбөр нь түрэмгий, олны дунд хүчирхийлэл үйлддэг гэмт этгээдэд тохиромжгүй юм.

Германд "Эрэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг" төсөл: 1984 онд анх үүссэн ба санаачлагч нь дээд сургуулийн багш, урд нь эхнэрийнхээ эсрэг түрэмгийлэгч гэмт этгээд байжээ. Зөвлөгөө өгөх байгууллага нь үнэгүй ба хөтөлбөрт сайн дураар хамрагдахад илүү анхаардаг. Нийт үйлчлүүлэгчдийн 60%-г биеийн хүчирхийлэл үйлдэгчид эзлэх ба тэднээс 10% нь хамтран амьдрагчаасаа гадна хүүхдүүдээ дарлан зовоодог, бэлгийн хүчирхийлэл үйлдэгч болон насанд хүрээгүй гэмт этгээдүүд 12-13%-г эзэлдэг. Хамгийн залуу хэрэг үйлдэгч нь 8 настай ба ээж рүүгээ хутга барин дайрчээ.

Гэмт этгээдүүдийн ихэнх нь архичид биш бөгөөд эдгээр тохиолдолд түрэмгийлэл адилхан үйлдэгддэг хэмээн төслийн ажилтнууд нотолж байна. Хуримтлагдсан сэтгэлийн зовлон, урам хугарлаа гадагш гаргах, өөрийгөө төгс эр хэмээх бодол нь аюулд орсон мэт сэтгэгдэл төрөх үед хүчирхийлэл гардаг. Хүчирхийлэгч өөрчлөгдөхөд нэг жил зургаан сараас хоёр жил мэргэжлийн тусламж хэрэгтэй болдог. Зөвлөгөө өгөх үйл ажиллагаанд хамрагдаж эхлэхэд сайн дурын шийдвэр, өнөөдөрт чиглэсэн бодит үзэл, эрчүүд зөвхөн эрчүүдтэйгээ ажилладаг зарчмыг ойлгох сэтгэлтэй байх нөхцөлийг шаарддаг. Хөтөлбөр нь маш сайн үр дүнтэй байсан ба Германаас гадна Австри,

Швейцар улсуудад хоорондоо холбоотой нийт 20 зөвлөгөө өгөх төвүүд үйл ажиллагаа явуулдаг байна.

Финляндад "Эрчүүд хүчирхийллийн эсрэг холбоо" энэ төслийг хэрэгжүүлдэг. Түрэмгий байдлаас нь өөрчлөхөд чиглэгдсэн олон хөтөлбөрүүдийн зохиогчдын үзэж байгаагаар сайн тодорхойлсон зорилго, гэмт этгээдийн талаарх сайн судалгаа, сайн тодорхойлсон нөхцөлүүд, хөтөлбөрийг хуулийн системтэй хэрхэн уялдуулсан зэргээс амжилт нь шалтгаална. Хувь хүний хүчирхийллийг таслан зогсооход нийгмийн хяналт, шүүмжлэл зайлшгүй шаардлагатай. Бүх хөтөлбөрүүд нь ихэнхдээ нь танин мэдэхүй, зан байдлын онолын зарчмаар ажилладаг байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нь тэдэнд хүч өгөх амьдралын болон сэтгэл санааны дэмжлэгийг шаарддаг тул эхний ээлжид тэдэнд чиглэсэн нийгмийн ажилд анхаарал хандуулдаг.

Амьдралын буюу бодит тусламж нь аюулгүй амьдрах орчноор хангах, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгаалалд зөвлөгөө өгөх байгууллагын үйлчилгээнд чиглэгдэх ёстой (мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын, тусгай утасны, хохирогчтой ажилладаг, хамгаалах байртай байгууллагуудын утасны дугаар, хаягийг хэлж өгөх; хэрүүл, маргааны талаар тодорхой баримт бүрдүүлэх, авсан арга хэмжээг тэмдэглэх, тэмдэглэл нь шүүхэд хүчирхийлэл удаан үргэлжилж буйг нотлох баримт болж болохыг ойлгуулах; нийгмийн ажилтанд хэлж хохирогчийг боломжит нийгмийн халамж, үйлчилгээнд хамруулах, хөршийн хяналтад оруулах зэрэг).

НЭД Сэтгэл санааны дэмжлэг нь хохирогч хүчирхийлэлтэй харьцаанаас салах шийдвэрийг гаргах, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг олж авах, дээшлүүлэхэд чиглэгдсэн өөртөө туслах, дэмжлэг үзүүлэх байгууллага, мэргэжилтэнд хамрагдах боломжийг санал болгох эсвэл хохирогчийг сургалтад хамруулах зэрэгт чиглэгдэнэ.

Хуулийн туслалцаа нь эдгээрээс дутахааргүй чухал бөгөөд төрийн бус байгууллагууд, өмгөөлөгчдийн холбоо болон түүнтэй адил хуулийн зөвлөгөө өгөх газарт холбон зуучилна. Эдгээр нь хүүхэд ба тэдний асран хамгаалал, өмчийн харилцаа ба гэр бүл салалт зэрэг гол асуудлуудыг хуулийн дагуу шийдвэрлэхэд тусална.

Дээрх бүгдийг судлан авч үзээд болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагч, ажилтнуудын дунд явуулсан судалгаагаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд дараах хүндрэл бэрхшээл учирч байна гэж үзлээ. Үүнд:

- Нийгмийн дийлэнх олонх нь, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, хүчирхийлэл үйлдэгч аль аль нь "цээрлүүлэх", "гэр бүл салах"-аас илүүтэйгээр хүчирхийлэлтэй харилцаагаа зогсоох, "эрүүл" гэр бүлийг бий болгох, засаж авахыг хүсэж байна. Гэтэл хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, хуулийн, сэтгэл зүйчийн зөвлөх үйлчилгээ хангалтгүй (тэр дундаа хөдөөгийн суманд байхгүй) байна.

- Эмнэлэгт түшиглэсэн "Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх төв"-дээсээ²⁹ нийслэлд Гэмтэл согогийн эмнэлгийн дэргэдэх нь л байнгын үйлчилгээ үзүүлдэг, гэхдээ хохирогч нарын байрлах хугацааны хоолны зардлыг эмнэлгийн хоолны зардлаас "даалгадаг", бусад нарийн шинжилгээ хийлгүүлэх боломж байдаггүй, эмнэлгийн анхан шатны туслалцаанаас нэг их хэтрэхгүй байна. Шүүх эмнэлгийн дэргэдэх мөн төвийн нэг өрөөг тус эмнэлгийн нэг эмч ажлынхаа хажуугаар давхар хариуцдаг, 24 цагийн үйлчилгээ үзүүлдэггүй, хоноглуулан байрлуулдаггүйгээс хохирогч нар нэг их очоод байдаггүй, зүгээр л дамжин өнгөрөх, хэсэг тайвшраад л гарах байдалтайгаар ажилладаг аж.

- Сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хувьд бараг байхгүйтэй адил, ганц нэг мэргэжлийн эмч, гэр бүл судлаач нар зөвлөгөө өгдөг ганц нэг төрийн бус байгууллага (ХЭҮТ, Хөөрхөн зүрхнүүдийн аян. Ужин төв³⁰ зэрэг)-хан завсар зайгаараа зөвлөгөө өгөх байдалтай, мэргэшсэн байгууллага, төв алга байна. Хамтарсан багийн хамт олон энэ төрлийн үйл ажиллагаа явуулах ёстой ч намын хурал, бусад ажил гээд багийнхаа хурлыг ч тогтмол хийдэггүй нь олон болсон.

²⁹ Нэг цэгийн үйлчилгээний төвүүд нь сэтгэл зүй, эрүүл мэнд, хамгаалах шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

³⁰ Хөөрхөн зүрхнүүд аян, Ужин төв хоёр байгууллаг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд туслалцаа үзүүлэх чиглэлийг барьж ажилладаг.

- Сум, багийн түвшинд энэ асуудлыг хариуцсан албан тушаалтан нь тэр бүр зохих туслалцааг цаг алдалгүй үзүүлж (хэрхэх ёстой, хаана хэнд хандах хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлоод арга замыг нь заах) чадахгүй байна, энэ нь ажлын ачаалал, ур чадвар (Ж: нь гэр бул салахаас айж байна гэвэл шийдвэрлэхгүйгээр орхичихдог, сэтгэцийн эмгэгийг илрүүлж чаддаггүйгээс цаг алддаг г.м.), нэгж тухайлсан байгууллага байхгүй, иргэдийн эрх зүйн ухамсар, хууль таниулах ажил дутмаг зэрэг олон шалтгаантай байна. Зан үйлийг засах сургалт, хүчирхийллийн дараах хяналт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Дээрх мэдээллийг дүгнэв гэр бул нь нийгмийг бүрдүүлэгч анхдагч үндсэн нэгж болохын хувьд нийгмийн хөгжлийн өөрчлөлтийг дагаж хувьсан өөрчлөгдөж байдаг. Тиймээс дэлхий нийтэд “гэр бул нь нийгэм, төрөөр хамгаалууах эрхтэй хэмээн үзэх нь эцсийн бүлэгтээ нийгмийн тогтворт байдлыг хангах зорилгод чиглэж буй бөгөөд төрийн бодлогын хамгийн чухал асуудлын тэргүүнд зүй ёсоор тооцогддог. Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн суурь нэгж болох гэр бүлийн дотоод уур амьсгалыг өөрчилж, сөрөг байдлыг үүсгэснээр гэр бүлийн дотоод асуудал бус нийгэм бүхэлдээ тогтворгүйтэх эрсдэлийг дагуулах, шэр бүлийн гишүүдийн эрхийг ноцтой зөрчихөд хүргэж болох гэмт хэрэг юм. Гэр бүлийн хүчирхийлэл хэзээ ч санамсаргүй үйлдэгдэхгүй. Биеэ барьж чадаагүй, хяналтаа алдсанаас шалтгаалж үйлдэгддэггүй. Эрх мэдэл, хяналтандаа хохирогчийг оруулах зорилго, сэдэл бүхий шууд, санаатай үйлдэл байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэр бүлийн гишүүд зан үйлд нөлөөлөх сургалтад өргөн хамруулж, хүчирхийлэгчийг албадан сургадаг сургалтаас илүү ач холбогдолтой” болохыг онцолсон. Тиймээс эхнэр, нөхөр, хүүхэд зэрэг гэр бүлийн бүх гишүүний нас, сэтгэхүйн онцлогт тохирсон сэтгэл зүйн болон зан төлөвийн сургалт, нөлөөллийн ажил зайлшгүй шаардлагатай байна.

Нөгөө талаас бид нийгэм, хамт олноороо хүчирхийллийн энэ үйлдлийг буруутгахгүй, харин ч өөхшүүлэн дуугүй байсаар байдаг. "Эр эмийн хооронд илжиг бүү жороол" гэдэг үгээр өөрийгөө тайвшруулж хэн нэгэн хүн хүчирхийлэлд өртөж байхад чимээгүй бүү суу гэдгийг энэхүү нийтлэлээрээ дамжуулж уншигчиддаа хэлэхийг хүсч байна. Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг бол хулгай, дээрэм, бүлэглэн нэг нэгнийгээ зодох, танхайрах зэрэг хэргүүдээс тэс өөр. Хамгийн нуугдмал бөгөөд хамгийн хүнд, эмзэг гэмт хэрэг. Учир нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг учраас гэр бүл салах, хүүхэд өнчрөх, насан туршдаа сэтгэлийн шархтай үлдэх, хэн нэгэндээ өс санах зэрэг хэзээ ч эдгэшгүй өвчинтэй болох үр дагаварт хүргэж болзошгүй байдаг. Иймд бид бие биенээ хайрлаж, хүндэтгэж, хамгаалж, санаа тавин сүүдэр тусаагүй гэр бул байхын төлөө хамтдаа зүтгээ хэмээн уриалж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгааны үр дүнд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр манай улсад олон ажил, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг хэдий ч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил төдийлөн буурахгүй байгаа нь арга барилаа өөрчлөх шаардлага байгааг харуулж байна. Хэдийгээр өндөр хөгжилтэй улсын хэрэгжүүлдэг арга хэмжээг нийгэмд нэвтрүүлж байгаа ч энэ өөрийн улсын онцлог, хууль тогтоомжид нийцэхгүй, хөрсөн дээрээ бууж чадахгүй байгаагын илрэг нь гэмт хэргийн гаралтын тоо харуулж байна. Иймд бид гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл, нөлөөлж буй сөрөг хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэхээр олон улсад авч хэрэгжүүлж байгаа тодорхой үр дүнд хүрсэн зарим туршлагыг нэвтрүүлэх замаар гаралтыг бууруулах боломж байна.

Мөн энэ чиглэлээр гадаадын зарим улсад хэрэгжүүлдэг аппликейшн, вэбсайт зэрэг технологи ашиглан алслагдсан орон нутагт, нуугдмал гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх сүлжээг бий болгох тогтоох, Алба хаагчдад зориулсан хохирогчид аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх (хүчирхийлэл үйлдэгчид хязгаарлалт хохирогчийг гэртээ байх эрхийг хангах, хүчирхийлэл үйлдэгчээс санхүүгийн хувьд их хамааралтай байдгийг харгалзан санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг шүүхийн захирамж гаргуулах, онцлог байдалд нь тохирсон холбон зуучлах, эрүүл мэндийн, нийгмийн халамжийн, хууль эрх зүйн зэрэг зохих туслалцааг үзүүлэх) сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзүүлэх тоглолт хэлбэрээр зохион байгуулах, түүгээр сургалтын кино, гарын авлага бүтээн дэлгэрүүлж олонд сурталчлан таниулах үйл ажиллагааг явуулах нь олон улсын

авч хэрэгжүүлдэг чухал арга хэмжээ юм байна. Монгол улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн, энэ талаар үйл ажиллагаа явуулах үндэсний тогтолцоо бий болсон, үйл ажиллагаа нь эрчимжиж байгаа хэдий ч гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, хохирогчийг цаг алдалгүй хамгаалах, хүчирхийлэлтэй гэр бүлийн харилцааг эрүүлжүүлэх, иргэдэд өөрийн болон бусдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг зөрчихөөс хамгаалах мэдлэг, ур чадвар олгох, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд хуулиар хүлээсэн чиг үүрэг бүхий байгууллагууд, иргэд, олон нийтийн туслалцаа дэмжлэгт тулгуурласан нягт хамтын ажиллагаа илүүтэй хэрэгжүүлэх хэрэгтэй гэдгийг олон улсуудын туршлагаас дүгнэж байна.

Хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг нээн илрүүлэх, танин мэдэх, улмаар түүнтэй үр дүнтэйгээр тэмцэх арга барилыг эрэлхийлж олон улсын туршлагаас суралцан, манай улсын хохирогчийг хамгаалалтын асуудал, эрх зүйн зохицуулалт, тэмцэх гарга барил, танин мэдүүлэх сургалт хүмүүнлэгийн ажлын алдаа оноог харан дүгнэж цаашдаа хэрхэн засан залруулах талаар санал зөвлөмжийг боловсруулав.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын аюулгүй байдлыг хангах, зөвлөгөө өгч сэтгэл санаагаар нь дэмжих, тусгаарах байр түүний орчин нөхцөлийг ая тухтай, таатай байдал бүрдүүлэхэд анхаарч хөгжингүй орны туршлагаас судлан тохиромжтой хувилбарыг хэрэгжүүлэх;
2. Эмэгтэйчүүдийг хүчирхийлсэн этгээдэд ял шийтгэл оногдуулах явцад эрүүгийн хууль тогтоомжийг ялгаварлан гадуурхалгүй хэрэглэх боломжийг ханган, төрийн албан хаагчдыг чадваржуулах чиглэлээр гадаадын улстай хамтран ажиллаж, туршлага солилцох ;
3. Хүчирхийлэл дахин гаргахгүй байлгах, гэр бүлийн бүх гишүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт танин мэдэхүйн эерэг хандлагыг бий болох чиглэлд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын сайн дурын байгууллагуудтай хамтарч үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй явуулах;
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гадаадын улс орнуудад олон хэлбэр, төрлийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байнаа үүнээс манай улсад хэрэгжүүлж болох арга нь: ОХУ-ын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй гэж үздэг 10 аргын нэг “Засгийн газрын дэмжлэгийг сайн авах”. Энэ арга нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, төлбөргүй утасны үйлчилгээ зэрэг нь хохирогчдод тусалж, аз жаргалтай, аюулгүй амьдрахад нь туслах зорилготой явагддаг юм. Энэ арга манай улсын хувь хэрэгжүүлэх шаардлагтай бөгөөд энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаггүй, нийгэмд мөнгө шаардахгүй хэрнээ хамгийн их дутагдаж буй зүйл нь бие биендээ сэтгэлийн дэм өгөх, урам зориг өгөх, халуун дулаан үг хэлэх юм.
5. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн зүгээс “Гэр бүлийн хүчирхийллийн цаад учир, холбогдлыг орхигдуулж зөвхөн эрчүүдэд бурууг өгөх хандлага их байдаг. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн гэр бүлийн гишүүд зан үйлд нөлөөлөх сургалтад хамтдаа хамрагддаг байх нь зүйтэй юм.
6. АНУ-д иргэдэд хууль зүйн туслалцаа туслалцаа үзүүлэх /өмгөөлөл/, хуулийн боловсрол олгох ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх хуулийн сургуулийн оюутнуудыг татан оролцуулах ажлыг өрнүүлдэг энэ аргыг манай улсад хэрэгжүүлэх нь тохиромжтой, хэрэгцээ шаардлага. Мөн хүчирхийлэгчид хяналт тавих, хохирогчийг хамгаалах үүрэг бүхий шүүхийн шийдвэрээр томилогддог нэмэлт ажилтан-хянагч байцаагчийг ШШГБ-д ажиллуулдаг туршлагыг судлан хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын хууль тогтоомж :

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Гэр бүлийн тухай хууль
3. Тэрч хохирогчийг хамгаалах тухай хууль

4. Нийгмийн халамжийн тухай хууль
5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тууний удирдлагын тухай хууль
7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
8. Зөрчлийн тухай хууль
9. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Олон улсын гэрээ, конвенци

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
2. Хүүхдийн эрхийн тухай Конвенци. 1989.
3. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай Конвенц. НҮБ.ЕА.

1993

Ном сурах бичиг, гарын авлага

1. Гэр бүлийн хүчирхийлэл. УБ. 2020.
2. Ц.Алтанцэцэг. Гэр бүлийн хүчирхийллийн эрх зүйн гарын авлага. УБ.2017
3. "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги" гарын авлага. УБ. 2005
4. Ч.Боловсон. "Гэр бүлийн эрх зүй" гарын авлага.
5. Н.Дугармаа , Монгол улсын гэр бүлийн эрх зүй. 2007.
6. Хохирогчийг хамгаалах цогц тогтолцоо ба дундын зохицуулалт . Мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага. УБ. 2019.
7. Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: Нотлох баримтын тойм. УБ. 2017.
8. Б.Минжуурдорж. Даяаршиж буй дэлхий: Харьцуулсан эрх зүй судлал. УБ. 2010

ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТ НОТОЛБОЛ ЗОХИХ БАЙДАЛ,
МӨРДӨН ШАЛГАХ АРГА ЗҮЙ
CONDITIONS PROVING CRIME OF THEFT, INVESTIGATION METHOD

П. Эрдэнэбаатар

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Erdenebaatar.P

Senior teacher, Police Lieutenant
Colonel of Department Criminal
Procedure Law, Police school of
of Internal Affairs

Товч утга: Хулгайлах гэмт хэрэг нотолбол зохих байдал, мөрдөн шалгах арга зүй, тулгамдсан асуудлууд, хууль эрх зүй хийгээд бодит байдлын хүрээнд шийдэхүйц нөхцөл боломжийг тодорхойлох талаар авч үзсэн болно.

Short meaning: The conditions for proving the crime of theft, investigation methods, problems, and the determination of the conditions to be solved within the framework of law and reality are considered.


Түлхүүр үг: Хувийн өмч, өмчлөх эрх, нууцаар, хууль бус, нотолбол зохих байдал

Key word: Personal property, ownership, secretly, illegal, conditions prove

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж заасан нь хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндэс юм.


Бусдын өмчлөх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулж, Эрүүгийн хуулийн хамгаалалтад авсан бөгөөд хэн нэгэн этгээд бусдын өмчлөлийн эд зүйлийг хулгайлах замаар өөрийн эзэмшилд авсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Монгол Улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн сүүлийн 5 жилийн судалгаанаас үзвэл, хулгайлах гэмт хэрэг тэргүүлж, дангаараа 37.2 хувийг эзэлж байна. Нийт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 53 хувь нь Улаанбаатар хотод, 47 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдэж, хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа шунахайн сэдэлттэй нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.

График № 1 Хулгайн гэмт хэргийн сүүлийн 5 жилийн судалгаа³¹.



³¹ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2018, 2019, 2020, 2021 оны гэмт хэргийн тоон мэдээлэл.

График №2 Хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ.



Хулгайлах гэмт хэрэг нь бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгийг гэмт этгээд ил буюу далд аргаар авч өөрийн эзэмшилд шилжүүлэн авахыг хэлэх бөгөөд гэмт этгээд авсан зүйлээ дураараа эзэмших буюу захиран зарцуулах боломж бүрдсэн үеэс төгсгөл болно. Энэ гэмт хэргийн онцлог нь:


- Хулгайлах гэмт хэргийг шунахай зорилгоор /хөдөлмөр бага зарцуулан эдийн засгийн сонирхлоо гүйцэлдүүлэх, амар хялбар амьдрах, гэсэн эрмэлзлээр/ үйлдэгдэг.
- Нууцаар, эзэмшигч буюу хөндлөнгийн хэн нэгэнд мэдэгдэхгүйгээр, өөрийн болгож байгаа гэмт үйлдэл.
- Энэ төрлийн гэмт хэрэг нь бусад ямар нэгэн хүч хэрэглэгддэггүйгээрээ бусад гэмт хэсгээс ялгаатай байна.

Хулгайлах гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан авч үзэхэд³². Хүн ам төвлөрсөн, нягтаршил ихтэй газар илүүтэй үйлдэгддэг. Хулгайлах төрлийн гомдол, мэдээллийн 56.7 хувийг нийслэл хот эзэлдэг.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн дийлэнх нь эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогын эх үүсвэргүй байдагтай холбоотой учирсан хохирлын 93.9 хувь нь нөхөн төлөгддөггүй.

3. Бүртгэгдэх үедээ сэжигтэн, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй байна.

График №3 Үйлдэгдсэн гэмт хэргийн цаг, гараг



Хулгайлах гэмт хэрэг нь хөгжлийн явцад нийгмийн эрэлт хэрэгцээ, тухайн улс үндэсний онцлог, нийгэм, эдийн засгийн хөгжил, зэргээр нөхцөлдөж объектив хүчин зүйлс буюу хадлагын зүйл үйлдлийн арга нь өөрчлөгдөн хувьсаж байна. Гэвч энэ гэмт хэргийн субъектив хүчин зүйл нь аль ч цаг үед өөрчлөгдөөгүй агуулгын хувьд хэвээр байна.

Хулгайлах гэмт хэргийг объектоор нь:

- Түүх, соёлын үнэт зүйлсийн хулгай;
- Мэдээллийн хулгай;
- Дэд бүтцийн хулгай;
- Мал хулгайлах;
- Орон байрны хулгай;

³² Д. Нямбат. Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл 2019 №1 (67) 17 Хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын үр нөлөөнд “татгалзуулах онол” (deterrence theory) -ын үүднээс хийсэн дүн шинжилгээ

- Тээврийн хэрэгслийн хулгай;
- Халаасны хулгай гэж төрөлжүүлэн ангилж болно.

Хулгайлах гэмт хэргийн дээрх төрлүүд нь үйлдлийн арга, халдлагын зүйл, гэмт хэрэгтэн бие хүний профайлаараа ялгаатай учир мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүйн хувьд өвөрмөц, онцлогтой. Тухайлбал,

- Гэмт хэрэг үйлдэгч этгээд хулгай хийх газраа сонгон авсан байдал, орон байранд нэвтрэн орсон арга, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг, хулгайлсан зүйлийн хэмжээ, ул мөрөө балласан байдал зэргийг тодорхойлох нь гэмт хэрэг үйлдэхдээ хэрхэн мэргэшсэнийг тодорхойлж өгнө.

- Гэмт хэрэг үйлдэгч этгээд хулгай хийх объектыг урьдчилан судалсан эсэх, байр саван дахь эд зүйлийг эмх замбараагүй болгосон байдал, эвдсэн, үнэт зүйлсийг олж аваагүй, гартаа аль тааралдсаныг авсан эсэх, зэрэг нь туршлагатай буюу урьдчилан судлаагүй байдлыг илтгэдэг.

- Мэргэжсэн хулгайн гэмт хэрэг үйлдэгч этгээд нь үнэлгээ өндөртэй эрэлт ихтэй, зүйлийг хулгайлдаг бол тохиолдлын шинжтэй хулгайч нь гарт тааралдсан, анхаарал татах зүйлсийг авдаг онцлогтой байж болно.

- Хулгайлах гэмт хэргийг ихэнх тохиолдолд бүлэглэн үйлддэг бол овор бага, амьжиргааны шинжтэй хулгайг ганцаараа үйлдэх тохиолдлууд олон байна. Зарим тохиолдолд хулгайн гэмт хэргийг ганцаараа үйлдэгч нь бусдыг хэрэгсэл болгон ашигладаг, олон удаагийн үйлдэлтэй, урьд нь тухайн төрлийн гэмт хэргийг үйлдэж байсан, урьд нь ял шийтгэл эдэлж байсан туршлагатай гэмт этгээдүүд байна.

- Бүлэглэн хулгайн гэмт хэрэг үйлдэгч нь өөрийн үйлдлийг хөнгөвчлөх, түргэтгэх, саадыг арилгах зорилгоор халдлагын объектоо урьдчилан судлах, бусадтай үгсэн тохирч үүргээ хуваарилах тээврийн хэрэгсэл, уналгаар хангахаар урьдчилан бэлтгэсэн байдаг.

Мөрдөн шалгах ажиллагааны практикт хулгайн гэмт хэргийг нотлох ажиллагаанд криминалистикийн тоо бүртгэлийг ашиглах, мэдүүлгээр нотлох баримтыг голлон хэрэглэж байгаа нь хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд нотлоход хангалтгүй байна.

Хулгайлах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-ийн 16.2 дугаар зүйлд заасан нотолбол зохих байдлыг зөв тогтоох шаардлагатай. Тухайлбал,

1.Гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж/ үйлдсэн болон эрүүгийн хуульд заасан бусад байдал; гэдэгт хулгайн гэмт хэрэгт гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн тухайлбал, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, газар, хугацаа, арга зэргийг нотлох ажиллагааны тусламжтайгаар тогтооно. Ингэхийн тулд юуны өмнө тухайн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэл нь үйлдэгдсэн эсэхийг тодруулах шаардлагатай. Эдгээрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд нотолсон байхыг шаардана.

2.Гэмт хэргийг хэн үйлдсэн гэдэгт хулгайлах гэмт хэрэгт тухайн гэмт хэргийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтооход чиглэгдэнэ.

3.Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр гэдэгт хулгайлах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүх хуралдааны явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь уг хэрэгт гэм буруутай эсэх, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн зорилго, хэлбэр гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын асуудлыг нотлон тогтооно. Хулгайлах гэмт хэргийг үйлдсэн зорилго, сэдэлтийг тогтоох, түүнчлэн эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн ЭХХШТХ, Эрүүгийн хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ.

4.Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдалд Эрүүгийн хуулийн 5.5, 5.6 дугаар зүйлүүдэд заасан заалтуудыг нотлох баримтын үндсэн дээр тогтооно.

5.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ гэдэгт хулгайлах гэмт хэрэгт эд хөрөнгийн хэмжээг нарийвчлан тогтоох нь хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах болон цаашид уг гэмт хэргийг зүйлчлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Хулгайлах гэмт хэрэгт дараах дараах хохирлын хэмжээг тогтооно. Үүнд:

1. Их хэмжээний хохирол
2. Үлэмж хэмжээний хохирол
3. Бага хэмжээний хохирол

Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл гэдэгт хулгайлах гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, нотолбол зохих байдлуудаас гадна завсрын шинжтэй зарим нөхцөл байдлуудыг нотолж тогтоосны үндсэн дээр нотолбол зохих үндсэн нөхцөл байдлуудыг тогтооход ач холбогдолтой. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн эсэхийг тогтоох шаардлагатай байдаг.

Мөрдөн шалгах ажиллагааны практикт “нотолбол зохих байдал”-д ялангуяа гэмт хэргийг хэн үйлдсэнийг шалгаж тогтоохгүй байдал гарч болох юм. Мөрдөн шалгах ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн төрсөн он, сар өдөр, төрсөн газар, регистрийн дугаар, хэн болохыг батлах иргэний баримт бичиг, байнга оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн засаг захиргаа, хэсгийн байцаагч, тухайн хаягт оршин суудаг эсэх, түүний хувийн байдлыг нарийн шалгаж тогтоохгүйгээр хэлсэн үгэнд нь итгэж бичсэнээр уг гэмт хэргийг хэн үйлдсэнийг буюу сэжигтэн, яллагдагчийн хэн болохыг тогтоох үүргээ биелүүлээгүйгээс өөр нэрээр шалгагдах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах боломж олгож, гэмт этгээд ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх, эрэн сурвалжлах ажилд хүндрэл учрах үр дагаврууд бий болдгийг анхааран хэрэгтэй.

ЭХХШТХ-ийн зорилтыг хангах үүднээс хулгайлах гэмт хэрэгт мөрдөн шалгах хойшлуулшгүй дараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ³³. Үүнд:

1. Үзлэг хийх;
2. Шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
3. Хохирогч, гэрчээс мэдүүлэг авах;
4. Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;
5. Эд хөрөнгийг битүүмжлэх;
6. Шинжээч томилох;

Эдгээр мөрдөн шалгах ажиллагааг хийж хэрэгжүүлснээр хулгайлах гэмт хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалган тогтооход ач холбогдолтой.

Хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд дараах ажиллагааг дэс дараалалтайгаар авч хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа хэвшил болгох шаардлагатай. Тухайлбал,

1. Удирдлага зохион байгуулалтаар яаралтай хангах;
2. Шуурхай, бүрэн илрүүлэх байх зарчмыг баримтлах;
3. Эрэн сурвалжлах ажлыг идэвхтэй, тасралтгүй явуулах;
4. Тодорхой төрлийн сангуудыг ашиглах;
5. Бусад тоо бүртгэлийн системийг ашиглахын зэрэгцээ, ул мөр, эд мөрийн баримтыг устаж үгүй болохоос өмнө цаг алдалгүй илрүүлж, цуглуулж, бэхжүүлэн авах шаардлагатай байдаг.

Олон үйлдэлтэй хулгай гэмт хэргийг нотлох ажиллагаа

Хулгайлах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч нь тохиолдлын байдлаар анх удаагаа гэмт хэрэг үйлдсэн этгээд бус гол төлөв бүлэглэн, удаа дараагийн үйлдлээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн байдаг. Хулгайлах гэмт хэргийг мөрдөн шалгахдаа дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Тухайлбал,

- Сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэгт хөтлөгдөхгүй, гэмт хэргийн үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан багаж зэвсэг, хань харилцаа гэх мэт байдлуудыг тогтоон бусад гэмт хэрэгтэй холбон мөрдөн шалгах ажиллагаа явуулах;

- Алдагдсан эд зүйлс, эд мөрийн баримтыг олж тогтоох;

- Гэмт хэрэг хамтран үйлдсэн этгээдүүдийг бүрэн дүүрэн илрүүлэх, ял завшуулахгүй байх;

³³ ЭХХШТХ-ийн 30.7 дугаар зүйл

- Хулгайлах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа хэргийн газрын үзлэг хийхээс эхэлдэг онцлогтой.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа мөрдөгчийн зүгээс таньж олуулах ажиллагааг хийж гэрч, хохирогч, сэжигтнийг таньж олуулж болохоос гадна, сэжигтнээр хохирогчийг таньж олуулж болдог.

Үзлэгээр сэжигтний хулгайлан авсан эд зүйлийг орон байрнаас нь эсхүл барьцаалан эзэлдүүлэх газар, бусад газарт хадгалуулсан зүйлийг хураан авч, сэжигтний ойр дотнын хүмүүсээр сэжигтнийг мөн эсэхийг, хохирогчоор өөрийнх нь эд зүйл мөн эсэхийг тогтоохоор танин олуулах ажиллагааг хийнэ. Хулгайлах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахдаа дараах тактикийн аргуудыг ашиглахыг санал болгож байна.

1. Санаагүй, бодоогүй зүйлийг гэнэт асуух. Урьдах мэдүүлэгтэй огт холбоогүй зүйлийг асуух, эсхүл сэжигтэн, яллагдагч нарын өөрийн нь мэдээгүй нотлох баримтыг гарган асуулт тавина. Яллагдагчаас хариулт бэлтгэж амжаагүй байхад нь санаанд нь ороогүй, санамсаргүй асуулт бэлтгэн тавих нь сандралд оруулах хэргээ хүлээхэд нэмэр болно.

2. Дэс дараатай ахиулан лавшруулж асуух. Урьдах мэдүүлгийг аажим аажмаар холбон асуух, бүрэн нотолгоо гаргахаас өөр аргагүй боллоо гэсэн ойлголт, бодлыг яллагдагчид тулган бий болгох, түрүүчийн арга барилын эсрэг талын арга юм.

3. Түгшүүр төрөхөөр хурц асуух. Яллагдагчийн оюун ухааныг ядартал нь олон асуулт тавилгүй, цөөн удаа бага хугацаанд бодит нотолгоонуудыг нэг зэрэг гарган асуух, Энэ арга нь хэрэгтэй хэрэггүй эсэн бусын яриа хариултаар үймүүлэх, самууруулах бололцоогүй болгоно. Хэргийн гол зүйлийг нэг зүйлд хандуулан бодуулж, улмаар яриа чөлөөтэй боловч хариулт нь түргэн, худал юм зохиох бодох зай, цаг олгохгүй байдаг онцлогтойг анхаарах шаардлага тулгарна. Харин олон цагийн турш асууж мэдүүлэг авах нь ашиг бага, сэжигтэн, яллагдагчийг ядраан залхааж хариулт бүрхэгдэх сөрөг тал гарна.

4. Сэтгэл зоригийн нь түгшүүр, эмзэглэлийг асуух. Мэдүүлэг өгөхөөс татгалзаагүй боловч, ярилцах боломжгүй болдог явдал цөөнгүй тохиолдоно. Мэдүүлэг авах байдал эвгүй хачин байсан, илүү юм хэлчих вий гэж эмзэглэсэн айх, хэт ядрах, олон асуултад дарагдах зэргээс шалтгаалан яллагдагч сэтгэл зоригоо хуримтлуулан барьсан тохиолдолд мэдүүлэг авах хэрэггүй гэж зөвлөмөөр байна. Гэхдээ энэ аргын эерэг тал нь сэтгэл зүйн хямрал, хөвчрөлийг³⁴ арилгах хангалттай мэдүүлэг авах бололцоо нээн өгч болох юм. Яллагдагчийн сэтгэл санаа, төрх, бодол төлөвлөгөөг байнга хянаж байх хэрэгтэйг мартаж бодохгүй.

Хэрвээ түгшүүртэй, эмзэглэсэн байдалд автагдахад мэдүүлэг авах хугацааг хойшлуулан, тухайн хүний хувийн байдал, яаж амьдардаг, юу сонирхдог, ажил хөдөлмөрт нь юу саад болж байгаа зэрэг жирийн байдлаар ярилцан санал бодлоо солилцож болно. Ингэж найрсаг яриа өрнүүлснээр яллагдагч хүнд байдал, түгшүүр болгоомжлолоос гарч, сэтгэл сэтгэл нь тайвшран, сэтгэл санааны ойр дотно холбоо тогтоох нь их байдаг. Ийнхүү чин сэтгэлийн яриа хийе гэж боддог хүн олон байдгийг үргэлж анхаарч бай. Энэхүү илэн далангүй ярианаас тэмдэглэн бичиж авах юмыг заавал тэр хүний нүдний өмнө бичиж тэмдэглэх нь хэрэггүй. Зарим хүн тийм хатуу тэмдэглэлээс сэжиглэн эмзэглэж ярих юмаа товчилдог гэм бийг санах нь зүйтэй.

5. Зөв, сайн талыг нь ашиглаж асуух. Яллагдагчийн сайн талыг олж мэдсэний үндсэн дээр түүний үнэнч шударга, шулуун цайлган, зоригтой зан сэтгэлийг нь түшиглэх нь зүйтэй юм. Түүний өнгөрсөн гавьяа зүтгэл, албан тушаал, гэр орны байдлыг ашиглан мэдүүлэг авч болно.

6. Сэтгэл санаанд нь байгаа сул талыг нь ашиглаж асуух. Аймхай хулчгар, хурдан дүрсхийн уурладаг, хурдан бухимддаг хүмүүс сэтгэл зүйд тохирох асуултыг хурцаар тавьж асууж болдог.

7. Үлгэр,³⁵ домог буюу худал ярихыг нь сонсож асуух. Яллагдагч худалж ярьж “хувийн үлгэр домог” зохиож байгааг нь мэдэж байвч түүнийг нь тэсвэрлэн сонсох явдал байдаг. Энэ тохиолдолд надад итгэж байна, анхааралтай сонсож байна гэж улам сүрхий ярих өөрийгөө буруугүй

³⁴ С. Жанцан Хууль зүйн сэтгэл судлал Уб., 2005, 323 дахь тал

³⁵ Ж. Хурцгэрэл Криминалистик II. Уб., 2002, 306 дахь тал

мэтээр нотолгоо баталгаа гаргахыг оролдоно. Энэ үлгэр, домог яриаг хэлүүлэх нь анхаарлыг юунд хандуулж байна, юуг яаж нууж байна, юунд итгүүлэх гэж оролдож байна, юуг нь хөндийрүүлэх, холдуулах санаатай байна гэдгийг мэдэхэд тус болдог. Ер нь худал мэдүүлэг ямагт үнэнийг тойрч эргэдэг билээ. Үүнийг нь ажиглан бодит үнэнд ойр, хол хэсгийн нь илрүүлэх нь чухал. Мэдүүлэг өгч байгаа этгээд нь үнэнийг өөртөө, дотроо бодож байж, үнэн зөвийг санаж байж худал хэлдэг гэж үздэг.

8.Худал мэдүүлэг өгүүлэхгүй асуух. Зарим үед худал мэдүүлэгт итгэж байна гэсэн ойлголт, бодлыг мэдүүлэг өгөгчид төрүүлэхгүй, харин үнэмшихгүй эргэлзэж байна гэдгийг мэдэгдэх нь зүйтэй байдаг. Энэ нь мэдүүлэг өгөгчид үр ашиг өгөхгүй, үнэнээ л ярьж гэсэн ойлголт бодлыг авахад тусална.

9.Шуурхай, эрчимтэй асуух. Мөрдөлтийн санаачилгыг гартаа авч, идэвхтэй шуурхай байр эзлэн элдэв хариулт, цохилт бэлтгэх зай завсар, өрсөлдөгч талд олголгүй сэргийлж, бодол, санаанаас түрүүлэн явах хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд асуултыг түргэн хурдан тавьснаас мэдүүлэг өгч байгаа этгээд худал мэдүүлэх, мөрдөлтийн эсрэг хариултыг тухтай бодож чадахгүй, тархи, оюундаа нэгэнт үлдэж хоцорсон ул мөрийн талаар үнэн зүйлийг хэлэхэд хүрдэг байна.

10.Аажим асуух. Яллагдагч хурдан түргэн цувруулан тавьсан асуултуудаас өөртөө аль осолтой эвгүй асуултыг нь орхин алгасаж, хариултыг сайн олигтой хариулахгүй, гол чухал асуудлаас зайлсхийн хөндийрүүлэхийг оролдоно. Иймээс удаан асууж мэдүүлэг авах нь мөрдөлтийг үндэс суурьтай, бодолтой нарийн явуулахад тус болно.

11.Яриандаа халсныг нь ашиглан хэлүүлэх. Зарим хүн мэдүүлэг өгөхдөө өөр бусад юм ярьж байгаад тэр эрчиндээ хүчээр хэлэхгүй гэсэн юмаа хэлчихдэг явдал бий. Нэг төрлийн яриаг нөгөө ярианд ургуулан орлуулж, жинхэнэ чухал сэдвийг хэлүүлэх юм. Аль чухал үндсэн асуудлыг хөндөн яриулахыг хичээх, бас тэгж хэлүүлэх цаг үе, тохироог яриан дундаа зөв олох нь чухал.

12. Хариулт бодуулахгүй асуух. Яллагдагч, эрх бүхий албан тушаалтны асуусан асуултуудыг сайтар тогтоон авч түүний аль нь чухал болох, аль нь үндсэн биш асуулт вэ? Гэдгийг мэдэж авах гэж хичээдэг онцлогтой. Иймээс өөртөө ашиг тус болох аль нэг зүйлд анхаарал, хариултаа чиглүүлнэ. Энэ үед мэдүүлэг өгөгч этгээдийн анхаарлыг зориуд гол бус зүйл руу чиглүүлж, асуулт, хариултынхаа аль чухал хэсгээс хөндийрүүлэхийг хичээх хэрэгтэй юм. Энэ үед яллагдагч болгоомжлон сэргийлэх, эмзэглэн хаширлахаа больж мөрдөн хэрэгтэй мэдээлэл баримтыг өгөхөд хүрнэ.

13.Мэдүүлгийг давтан³⁶ явуулж асуух. Мэдүүлгийг давтан авах нь ашигтай болон хор уршигтай гэдгийг сайн санаж байх ёстой юм. Дахин мэдүүлэг авахын хооронд мэдүүлэг өгөгч нь худал мэдүүлэг өгөх бэлтгэл сургууль хийдэг гэсэн үзэл байдаг. Түрүүчийн тавьсан асуултыг дахин мэдүүлэг авах тавих хэрэгтэй, ингэж мэдүүлэг авахад яллагдагч мэдүүлгийнхээ зарим нарийн эгзэгтэй хэсгийг мартсан байдаг.

Ингэж дахин мэдүүлэг авах нь:

а/ Эхний үеийн мэдүүлгээс гажсан зөрүүтэй зүйл юу байгааг олж мэддэг;

б/ Худал мэдүүлэг өгч байгааг нотлох баримт сэлт гаргаж авах зорилготой;

Давтан мэдүүлэг авах нь мэдүүлгийн зөрөөг илрүүлэх, худал хэлэх тутам гарч ирдэг зөрөө ялгааг мэдэхэд тусалдаг гэж үздэг.

14. Хүлээлгэн байж хэлүүлэх. Хэдэн удаагийн мөрдөн байцаалт хоорондоо завсарлага зай байх, сэжигтэн, яллагдагчийн сэтгэл санаанд хувирал өөрчлөлт гардаг. Үнэнийг мэдүүлэх санаа сэдэл ч төрж, уулзах ярилцах хүсэл төрдөг. Энэ тохиолдолд мэдүүлэг авахыг яарахгүй, хойшлуулах, өөрийгөө илчлэн баримт, нотолгоо бий болгохоос өмнө түр хүлээлгэх нь зүйтэй байдаг. Ингэж азнаж мэдүүлэг авах нь эхний худал мэдүүлгийн үүрэг холбогдлыг үгүй болгож байгаа хэрэг юм.

15.Эрх бүхийн албан тушаалтан бүгдийг мэдэж байна гэсэн ойлголт төрүүлэн асуух. Яллагдагчийг хуурч мэхлэхгүйгээр ийм бодлыг төрүүлэх хэрэгтэй. Үүнд:

а/ Бие, үйл хөдлөлөө зөв байлгах

³⁶ Ж. Хурцгэрэл Криминалистик II. Уб., 2002. 307 дахь тал

б/ Мэдэгдээгүй гэж бодсон үнэн зөв баримт, нотолгоог түүнд гарган хэлж өгөх, намтар түүх, хэрэг явдлаас зарим нарийн хэсгийг сануулах замар хандах нь зүйтэй. Мэдсэнээ ингэж цухуйлгах нь бүх болсон асуудлыг сайн мэдэж байна гэсэн ойлголтыг бий болгож цаашид худал мэдүүлэг өгөхөөс урьдчилан сэргийлнэ.

16. Энэ нь дутуу байна гэсэн ойлголтыг өгөөд яриулах. Нотлох баримт хангалтгүй энэ хэсэг л дутуу байна, тэр зүйл нь тодорхой бус байна эдгээрийг гүйцээх юм бол бидэнд маргах хэлэлцэх зүйл байхгүй болно гэдгийг итгүүлж ойлгуулах нь чухал байдаг.

17. Халз маргаанд дуудан ярилцаж ялах. Яллагдагчтай утга агуулгаараа зөв, дэс дараалалтай яриа өрнүүлэх ашигтай байдаг. Ялангуяа оюун сэтгэхүйн хөгжлөөр сайн хүмүүстэй харьцахад аятайхан боломжтой байдаг. Ингэж тэр хүмүүсийг халз маргаанд дуудан оруулж болно. Эхлээд ялын шийтгэлийн талаар аль хүчтэй маргааныг үүсгэх, сэжигтэн, яллагдагч маргах дуртай болно. Нотлох баримт, хүчтэй асуултыг тавьж, тайлбарлахыг шаардаж асуух мөрдлөгийн асуух утга, дэс дарааг эвдэх оролдлого биелэхгүй болсныг ойлгуулах хэрэгтэй. Энэ яриандаа хэрэг ач холбогдол бүхий мэдээллийг олж авах ёстой.

18. Хамтарч ярилцан хэрэг илрүүлэх. Харилцан ярилцах явцад, яллагдагчийн мэдүүлгийн бүтэц, утгыг сайн анхааран харж, түүний үндсэн дээр хэрэгт ач холбогдол бүхий мэдээллийг олж авна.

Дээрх дурдсан 18 зүйлийн аргыг эмхэтгэн цэгцэлж ангилж авч үзвэл:

1.7,11,12,13 дугаарт дурдсан арга яллагдагчаас мэдээ, баримт сэлт олж авах, хувийн байдлын тогтоох, хэргийн бодит үнэнийг тогтоож мэдэхэд чиглэгдсэн байна.

2. 4, 18 дугаарт дурдсан арга яллагдагчтай холбоо тогтооход чиглэгдсэн өөр сэдвээр ярилцах, асуулт мэдүүлгийнхээ байдлыг урьдчилан харж, мэдэх асуултаа зөв эхлэх дуусгахтай холбоотой юм.

3. 1, 3, 4, 9, 10, 14 дүгээрт дурдсан арга яллагдагчийн сэтгэл зүйд нөлөөлөх, ямар нэгэн шинэ байдал, өөрчлөлт үүсгэх, ярилцахад чиглэсэн байна.

4.5, 6 дугаарт дурдсан арга бие хүний хувийн чанарт ганцаарчлан хандаж нөлөөлсөн арга барил байна.

5. 2, 8, 12, 15, 16, 17 дугаар дурдсан арга яллагдагчид хэргийн талаар тодорхой бодол төсөөлөл, ойлголт төрүүлэн улмаар нотлох баримтыг гаргуулахад чиглэгдсэн байна. Харин 13 дугаарт дурдсан арга мэдүүлгийг давтан явуулж асуух арга нь яллагдагчийн мэдүүлгийн үнэн худлыг тодорхойлон илрүүлэхэд нэмэлт туслалцаа үзүүлэх арга байна.

Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн сэжигтнийг баривчилж биед нь үзлэг хийж хулгайд алдагдсан эд зүйл, үйлдлээ хөнгөвчлөхөд ашигласан багаж, зэвсэг байгаа эсэхэд анхаарч шалгах, үүнээс үндэслэн сэжигтэй зүйл илрүүлээгүй тохиолдолд түний орон байр, эд зүйлээ нуусан байж болох газруудад нэгжлэгийг явуулна.

Нэгжлэгийг цаг алдалгүй гэнэт явуулснаар хэрэгт хамаарал бүхий эд мөрийн баримтыг илрүүлж, цуглуулах, бэхжүүлэхэд ач холбогдолтой байдаг. Нэгжлэгээр нуусан сэжигттэй эд зүйл илэрвэл хураан авч уг эд зүйлийг гэрч, хохирогчоор таньж олуулан ажиллагааг явуулна.

Удаа дараа гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн бол хамгийн бага хохиролтой хэргээ хүлээж хурдан шийдвэрлүүлэх сонирхолтой байдаг, зарим тохиолдолд хэрэг үйлдээгүй гэж мэдүүлэх, харин урьд өмнө хулгайлах гэмт хэрэгт шийтгэгдсэн ялангуяа шийдвэр гүйцэтгэх газраас шалгагдахаар ирсэн яллагдагч өөрсдийн үйлдсэн ганц хоёр үйлдлийг яриад бусдаас сонссон хэргүүдийг өрөө үйлдсэн гэж мэдүүлэн мөрдөн шалгах ажиллагааг төөрөгдүүлэхээр оролддогийг анхаарах хэрэгтэй байдаг.

Ашигласан материал:

1. С. Амартүвшин. Хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах болон энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зарим асуудал. Уб., 2021
2. Д.Лхагварачаа, П.Эрдэнэбаатар, А. Дэлгэрбаяр нарын Эрүүгийн процессын эрх зүйн ерөнхий, тусгай анги сурах бичиг Уб., 2021Ж. Хурцгэрэл Криминалистик II. Уб., 2002.
3. С. Жанцан Хууль зүйн сэтгэл судлал Уб., 2005
4. Д.Нямбат. Гэмт явдалтай тэмцэх асуудал онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл 2019 №1 (67) 17 Хулгайлах гэмт хэрэгт оногдуулах ялын үр нөлөөнд “татгалзуулах онол” (deterrence theory) -ын үүднээс хийсэн дүн шинжилгээ -ын
5. Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2018, 2019, 2020, 2021 оны гэмт хэргийн тоон мэдээлэл.

--o0o--

**МОНГОЛ УЛСАД МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ,
ШҮҮХИЙН ПРАКТИК АНХААРАХ АСУУДАЛ**
LEGAL REGULATION OF MONEY LAUNDERING CRIME IN MONGOLIA,
ISSUES OF FOCUS ON JUDICIAL PRACTICE

Н.Бадраа
ДХИС- ийн Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗТ- ийн ахлах багш, доктор,
цагдаагийн дэд хурандаа

Хураангуй: Энэхүү өгүүлэлд мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, шүүхийн практик хэрэгжилт, цаашид анхаарах асуудлын талаар авч үзсэн болно.

Abstract: This article discusses the current state of legal regulation of money laundering, practical implementation of the court, and issues to be considered in the future.

Түлхүүр үг: Мөнгө угаах, шүүх эрх мэдэл, тулгамдаж буй асуудал

Keywords: Money Laundering, Judiciary, Challenges

Эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний язгуур ашиг сонирхол бөгөөд Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна³⁷ Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар Үндсэн хуульд тусгаж баталгаажуулсан билээ.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Монгол Улсын эрүүгийн хууль
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам зэрэг байна.

Монгол Улс 2003 оны 12 дугаар сарын 13-нд "Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц"-д нэгдэн орж 2004 онд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг тодорхойлдог "Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх түр хороо"-ны салбар байгууллага болох Ази Номхон далайн бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх байгууллага /APG/-д элсэн орсноор мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартуудыг мөрдөн ажиллах үүрэг хүлээж, улмаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, ийм төрлийн хэрэгт ял шийтгэл оногдуулах холбогдох үндэсний хууль тогтоомж, эрх зүйн актуудыг дээр дурдсан Олон улсын гэрээ, Конвенц, стандартуудад нийцүүлэх ажил үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 07 дугаар сарын 08-ны өдөр "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийг баталж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үндэс суурь тавигдсан ба Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

³⁷ Монгол улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл №1 -УБ.,1992.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

үндэсний хөтөлбөр"³⁸, 2017 оны 327 дугаар тогтоолоор "Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г тус тус батлан мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.

2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай" хуулийг шинэчлэн найруулж баталсан ба уг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.1 дэх заалтад мөнгө угаах гэдгийг "Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийг эрхийг нуун далдалсан"-ыг, "терроризмыг санхүүжүүлэх гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг ойлгоно"³⁹ гэж тус тус хуульчилжээ.

2006 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн албыг Монгол банкны дэргэд үйл ажиллагаа явуулах болсон.

Энэхүү алба нь мөнгө угаах гэмт хэрэг, түүнд холбогдох гэмт хэрэг, зөрчил болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мэдээлэл, 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр, тооцооны гүйлгээний тухай мэдээллийг хүлээн авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүн шинжилгээний Үр дунд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэсэн гүйлгээ, гүйлгээний оролдлогын талаарх мэдээллийг эрх бүхий хууль сахиулах байгууллагад шилжүүлэх чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага юм.

Санхүүгийн мэдээллийн албанд гүйлгээний талаарх мэдээллийг зохих этгээдүүдээс өгөх, түүнд хяналт тавьж, сэжигтэй гүйлгээг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх зэрэг процессын ажиллагааг зохицуулсан байна. Сэжигтэй гүйлгээ хийх замаар гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах, халхавчлах нь хамгийн түгээмэл арга юм. Сэжигтэй гүйлгээ гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналт механизм бүрдээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж байгаа гүйлгээг хэлдэг.

Судлаачид мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэрийг терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул энэ хоёр (мөнгө угаах, терроризмыг бизнес эрхлэгч зэрэг хүмүүс бус жижиг хэмжээний хулгайн эд зүйлийг худалдаж авдаг, худалдан авсан эд зүйлийн үнийн зөрүүгээс өчүүхэн ашиг олж амьдралаа залгуулдаг жирийн иргэн байгаа явдалд анхаарч дээрхи үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт бус тусад нь ялгаа заагтай хуульчлах зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

FATF-аас зохион байгуулалтай, олон шатлалтай гэмт хэргүүдийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцож илрүүлэх, нэг үйлдэлтэй ахуйн хүрээний гэмт хэргүүдийг ялгах талаар зөвлөдөг. Иймд Монгол улсын Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн анхдагч гэмт хэргийг зохион байгуулалттай эдийн засгийн гэмт хэрэг байхаар хуульчилж, жижиг төрлийн гэмт хэрэг үйлдэх замаар олсон орлого, эд хөрөнгийг худалдаж авсан тохиолдолд өмчийн эсрэг гэмт хэрэг байхаар гэмт хэргийн шинжийг зааглах нь мөнгө угаах гэмт хэрэгт зохион байгуулалттай гэмт хэргүүдийг хамтатган шийдвэрлэх, ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэргүүдээс ялгах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Ингээд Анхан шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

³⁸ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр // <https://legalinfo.mn/mn/detail/9242>

³⁹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2013. №24

Мөнгө угаах гэмт хэрэг улсын хэмжээнд 2017-2021 оны байдлаар анхан шатны шүүхүүд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18 дугаар бүлгийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэрэгт нийт 208 хүнд холбогдох 153 хэргийг хянан шийдвэрлэсэн байна⁴⁰.

№	Он	Шийдвэрлэсэн хэрэг	Мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон хүн	хорих	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Ялаас чөлөөлсөн	Хорихоос өөр төрлийн ялаар шийтгэсэн	цагаатгасан	Хэргийг Хэрэгсэхгүй болгосон
11	2017	3	5	3					2
2	2018	25	31	14	14			1	2
3	2019	37	49	17	25	1		1	5
4	2020	53	68	16	45			1	6
5	2021	35	55	9	23	1	10	1	11
Нийт		153	208	59	107	2	10	4	26

Шүүхээр шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийн өсөлт,бууралтыг графикаар харуулбал:



Шүүхээр хянан шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэрэг нь сүүлийн 5 жилд тогтмол өссөн үзүүлэлттэй буюу 2018 онд 22 хэргээр буюу 8.3 дахин, 2019 онд 12 хэргээр буюу 48.0 хувиар, 2020 онд 16 хэргээр буюу 30.2 хувиар өссөн бол 2021 онд 30 хэргээр буюу 56.6 хувиар буурсан байна. Шүүхээр шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийг Улсын хэмжээнд шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэрэгтэй харьцуулан авч үзлээ.

№	Он	Нийт хянан шийдвэрлэсэн		Мөнгө угаах			
		Хэрэг	Хүн	Хэрэг		Хүн	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1.	2017	8839	9019	3	0.03	5	0.05
2.	2018	12551	14925	25	0.2	31	0.2
3.	2019	13427	15366	37	0.3	49	0.3
4.	2020	13465	15953	53	0.4	68	0.4
5.	2021	12068	14484	35	0.3	55	0.4
Нийт		60350	69747	141	0.2	208	0.3

⁴⁰ Э.Ганцэцэг мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн статистик мэдээлэл.Шүүх эрх мэдэл сэтгүүл. УБ.,2022.№5.104-107 дахь тал

Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр 2017-2021 оны байдлаар хянан шийдвэрлэсэн нийт 60.350 хэргийн 0.3 хувийг мөнгө угаах гэмт хэрэг эзэлж байна.

Анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийг анхдагч гэмт хэргээр нь ангилан үзлээ.

№	Анхдагч гэмт хэргийн төрөл	2017он		2018он		2019он		2020он		2021он	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	Хувь	тоо	Хувь
1.	Хулгайлах болон мал хулгайлах	2	66.7	20	80.0	23	62.2	34	64.2	21	60.0
2.	Залилах	1	33.3	-	-	3	8.1	2	3.8	4	11.4
3.	Дээрэмдэх	-	-	3	12.0	7	18.9	4	7.5	5	14.3
4.	Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	-	-	-	-	-	-	2	3.8	2	5.7
5.	Хахууль	-	-	-	-	-	-	1	1.9	-	-
6.	Үндэслэлгүй хөрөнгөжих	-	-	-	-	-	-	1	1.9	-	-
7.	Хөрөнгө завших	-	-	1	4.0	-	-	3	5.7	-	-
8.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-	-	-	2	3.7	-	-
9.	Мөнгө угаах дангаараа	-	-	-	-	-	-	2	3.7	-	-
10.	Бусад	-	-	1	4.0	4	10.8	2	3.7	3	8.6
Нийт		3	100%	25	100%	37	100%	53	100%	35	100%

Жич: Бусад хэрэгт 2018 онд алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл хөрөнгө, алдуул мал завших-1, 2019 онд хүнийг санаатай алах-1, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах-2, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл хөрөнгө, алдуул мал завших-1, 2020 онд алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл хөрөнгө, алдуул мал завших-2, 2021 онд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох-1, хууль бусаар мод бэлтгэх-1, цэргийн албаны эсрэг-1 хэрэг тус тус багтсан байна.

Давж заалдах шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээр 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн нийт 60.350 хэргийн 18.7 хувь буюу 11.230 хэргийг давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн байна.

№	Он	Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг	Давж заалдах Шатны шүүх		Мөнгөн угаах	
			хэрэг	хувь	хэрэг	Хувь
1	2017	8839	1971	22.3	-	-
2	2018	12551	2166	17.3	5	0.2
3	2019	13427	2286	17.0	15	0.7
4	2020	13465	2702	20.1	24	0.9
5	2021	12068	2105	17.4	15	0.7
Нийт		60350	11230	18.7	59	0.5

Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 11.230 хэргийн 0.5 хувь буюу 58 хэргийг мөнгө угаах гэмт хэрэг эзэлж байна.

№	Он	Анхан шатны шүүх \мөнгө угаах\		Давж заалдах шатны шүүх \мөнгө угаах\			
		Хэрэг	Хүн	Хэрэг	Хувь	Хүн	Хувь
1	2017	3	5	-	-	-	-
2	2018	25	31	5	20.0	7	22.6
3	2019	37	49	15	44.1	21	42.9
4	2020	53	68	24	45.3	37	54.4
5	2021	35	55	15	42.8	48	87.3
Нийт		153	208	59	41.8	113	54.3

2017-2021 онд мөнгө угаах гэмт хэргээр давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн нийт хэргийн 41.8 хувь буюу 59 хэргийг хянан шийдвэрлэжээ. Мөн мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон нийт 208 хүний 54.3 хувь буюу 113 хүнд холбогдох хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг нарийвчлан авч үзвэл:

№	Шийдвэрлэсэн байдал	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт
1	Тогтоол, магадлал хэвээр	-	1	5	4	4	14
2	Тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан	-	3	4	12	9	28
3	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон	-	1	6	8	2	17
Нийт		-	5	15	24	15	59

Давж заалдах шатны шүүх тус онуудад мөнгө угаах гэмт хэргээр нийт 59 хэрэг хянан шийдвэрлэснээс анхан шатны шүүхийн шийдвэрийн 47.5 хувь буюу 28 хэрэгт еерчлөлт, 28.8 хувь буюу 17 хэргийг хүчингүй, 23.7 хувь буюу 14 хэргийг хэвээр болгож шийдвэрлэсэн байна⁴¹.

Шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг дүгнэвэл давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан тохиолдол олон байгаа нь ажиглагдаж байна.

Хяналтын шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байдал

Анхан шатны шүүхээр 2017-2021 онд хянан шийдвэрлэсэн нийт 60.350 хэргийн 4.3 хувь буюу 2.593 хэргийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн бол давж заалдах шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн хэргийн 23.1 хувийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэсэн байна.

№	Он	Давж заалдах шатны шүүх	Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэрэг		Мөнгө угаах	
			Хэрэг	Хувь	Хэрэг	Хувь
1	2017	1971	342	17.3	-	-
2	2018	2166	570	26.3	1	0.2
3	2019	2286	674	29.5	4	0.6
4	2020	2702	685	25.3	9	1.3
5	2021	2105	322	15.3	7	2.2
Нийт		11230	2593	23.1	21	0.8

Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 2593 хэргийн 08 хувь буюу 21 хэргийг мөнгө угаах гэмт хэрэг эзэлж байна.

Хяналтын шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг нарийвчлан авч үзвэл:

⁴¹ 2022 онд боловсруулсан Мөнгө угаах гэмт хэргийн аюул заналын эрсдэлийн үнэлгээний тайлангаас хэсэгчилэн авав.

№	Шийдвэрлэсэн байдал	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	Нийт
1	Тогтоол, магадлал хэвээр	-	-	2	4	2	8
2	Тогтоол, магадлалд өөрчлөлт оруулсан	-	-	1	5	3	9
3	Тогтоол, магадлалыг хүчингүй болгосон	-	1	1	-	2	4
Нийт		-	1	4	9	7	21

Хяналтын шатны шүүх тус онуудад мөнгө угаах гэмт хэргээр нийт 21 хэрэг хянан шийдвэрлэснээс давж заалдах шүүхийн шийдвэрийн 42.8 хувь буюу 9 хэрэгт өөрчлөлт, 38.1 хувь буюу 8 хэргийг хэвээр, 19.0 хувь буюу 4 хэргийг хүчингүй болгож тус тус хянан шийдвэрлэжээ.

Дүгнэлт. Мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг дүгнэвэл хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нь их бөгөөд шүүхийн шийдвэр тогтворгүй байгаа нь анзаарагдаж байна.

Судалгаанаас үзэхэд мөнгө угаах гэмт хэргийн анхдагч гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлгийн хулгайлах, дээрэмдэх, мал хулгайлах гэмт хэрэг дийлэнх хувийг эзэлж байна. Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зарим анхдагч гэмт хэргээс хөөн хэлэлцэх хугацаа бага байхаар хуульчилсан нь мөнгө угаах гэмт хэргээр ял оногдуулах боломжгүй болсон хэд хэдэн тохиолдол байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хулгайлах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байхад мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 1 жил байгааг өөрчлөх шаардлагатай байна.

Мөнгө угаах гэмт хэргээр ял шийтгүүлсэн байдлыг авч үзэхэд дийлэнх хувьд хорих ялыг тэнссэн эсхүл давж заалдах журмаар хэлэлцэхдээ хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг тэнсэх зэргээр шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн хор аюулын хувьд бага гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг угаасан үйлдэлд ихэвчлэн хорих ялыг тэнсэж шийдвэрлэсэн байдаг.

Анхан болон давж заалдах шатны шүүх мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлээр зөрдөггүй боловч анхдагч гэмт хэрэг буюу хулгайлах, дээрэмдэх, залилах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхдээ хэрэгт цугласан нотлох баримт, үйл баримтыг дүгнэхдээ няцааж буй үндэслэлээ хууль зүйн үүднээс тайлбарлаж хэргийг шийдвэрлээгүй, тухайн шатны шүүхэд, эсхүл прокурорт буцаасан байх бөгөөд мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн эсэх гэм бурууг хяналтын шатны шүүхээр хэлэлцээгүй байна. Өөрөөр хэлбэл, анхдагч гэмт хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байхад мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэх боломжгүй юм.

Давж заалдах болон хяналтын шатны шийдвэрээс үзэхэд хэргийн оролцогчид анхдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхэд маргаж байхад мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байх тул тухайн шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах эсхүл өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамтран оролцсон эсэхийг тогтоолгохоор прокурорт буцааж шийдвэрлэсэн нь практикаас харагдаж байна.

Санал.

1. Монгол Улсын хэмжээнд хууль хэрэгжүүлэгчдийн дунд мөнгө угаах гэмт хэргийн талаарх зөрүүтэй ойлголт байдаг нь шүүхийн шийдвэрт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байж болзошгүй байх тул сургалтыг үр дүнтэй зохион байгуулах

2. Ахуйн шинжтэй гэмт хэргүүд тухайлбал хулгайлах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж авсан эзэмшсэн, ашигласан үйлдлийг мөнгө угаах гэмт хэргээр зүйлчлэн шүүхээр шийдвэрлэсэн буруу жишгийг өөрчлөх

3. Мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой олон улсын гэрээ хэлэлцээр, Фатф-ын зөвлөмжүүдийг өөрийн орны онцлогт нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх

Ашигласан эх сурвалжууд

1

1. Авлигын болон мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт. Гарын авлага.
2. Бат-Эрдэнэ Б. Криминалистик. Лекцүүд 1. Уб., 2003
3. Х.Буянтогтох, Б.Батжаргал Мөнгө санхүүгийн үндэс. Гарын авлага. Уб., 2010
4. Э.Ганцэцэг Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн статистик мэдээлэл. Шүүх эрх мэдэл сэтгүүл. Уб., 2022 №5 104-107 дах тал
5. Д.Дашмаа, Б.Батжаргал. Эдийн засгийн гэмт хэрэг II. Гарын авлага.. Уб., 2018
6. Г.Батзаяа “Мөнгө угаалт” Улаанбаатар 2009 он 11 дэх тал
7. Использование результатов ОРД в уголовном процессе Монголии /нэг сэдэвт бүтээл/ 2010. С. 127
8. Мөнгө угаах гэмт хэргийн аюул заналын эрсдэлийн үнэлгээний тайлан 2022 он
9. Монгол Улсын Мөнгө угаах гэмт хэргийн аюул заналын эрсдэлийн үнэлгээний тайлан. 2021.

ТООН УЛ МӨР ИЛРҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХЭД АНХААРАХ
ЗАРИМ НЭГ АСУУДАЛ
FOCUS ON DIGITAL FOOTPRINT DETECTION AND
ENHANCEMENT SOME PROBLEMS

Б.Ганболд

Дотоод Хэргийн Их Сургуулийн Цагдаагийн
сургуулийн Гүйцэтгэх ажлын тэнхимийн багш,
цагдаагийн ахмад

Ganbold.B

lecturer of the Department of Criminal
intelligence at the Police School of the University
of Internal Affairs, police captain

Хураангуй: Гэмт хэрэг үйлдэгдсэн газар компьютер байгаа тохиолдолд яах ёстой вэ? Ихэнх тохиолдолд мөрдөгчид шууд компьютерыг унтрааж хураан авдаг. Тухайн эд мөрийн баримтаар хураан авсан компьютерыг тоон ул мөр илрүүлэх шинжээч шалгах бөгөөд тухайн мөрдөгчид хамааралгүй болдог. Шинжээчид унтраалттай ирсэн компьютер дээрээс тоон ул мөр илрүүлэхийн тулд компьютерын хатуу дискэн дээр ажиллахаас өөр арга үлддэггүй. Харамсалтай нь зарим нэг гэмт хэргийн ул мөр асаалттай байсан компьютер дээрээс дахиж сэргээх боломжгүйгээр устдаг. Эдгээр ул мөр нь компьютерын Шуурхай Санах Ой буюу /RAM/-д хадгалагдаж байдаг юм⁴².

Abstract: What to do if a computer is found at a crime scene? In most cases, detectives immediately turn off the computer and seize it. Computers seized through physical evidence will be examined by a digital forensics expert and become irrelevant to the detective. Analysts have no choice but to work on the computer's hard drive to find digital evidence on computers that arrive turned off. Unfortunately, traces of some crimes are irretrievably erased from a computer that was turned on. These traces are stored in the computer's RAM.

Түлхүүр үгс: Шуурхай санах ой, дижитал төхөөрөмж, тоон ул мөр.

Keywords: Random Access Memory, digital device, digital evidence

Оршил: Өнөө цагт хүн бүр компьютер, гар утас, таблет зэрэг олон төрлийн дижитал төхөөрөмж ашигладаг болсон. Дижитал төхөөрөмжүүд нь бидний амьдралд эерэг олон зүйлсийг бий болгодог ч мөн тэдгээрийг гэмт хэрэг үйлдэхэд ашиглах нь илбэг болсон.

Аливаа цахим төхөөрөмжийг ашиглан гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тохиолдолд тухайн төхөөрөмж дээрх өгөгдөл нь түүний гэм буруугийн тоон нотлох баримт болох боломжтой. Иймд илтгэл бичихдээ “Шуурхай санах ойноос нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх” сэдвийг сонгон өөрийн туршлагад суурилан олон улсад ашиглагддаг тоон ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, шинжлэн магадалдаг программ хангамжуудыг ашиглав. Илтгэл бичихдээ доорх асуултуудад хариулав. Үүнд:

Шуурхай санах ойн /RAM/ зураглалыг /RAM capture/ хийгээгүйгээс мөрдөгч нь гэмт этгээдийн нийгмийн сүлжээгээр хамгийн сүүлд илгээсэн захидал, шифрлэж хадгалсан мэдээллийг тайлах нууц үг зэрэг үнэ цэнтэй нотлох баримтууд дахин хэзээ ч сэргээх боломжгүйгээр алдаж байдаг. Хэрвээ гэмт этгээд нь интернэт хөтөч дээрх өөрийгөө нууцлах боломжийг олгодог “incognito” горимыг ашиглаагүй л бол интернэт хандалтуудын мэдээлэл, имэйл хаяг, фэйсбүүк хаягийн нууц үг гэх мэт бусад олон өгөгдөл мэдээллийг сэргээх боломжгүй болох юм.

⁴² rca: ram capture and analysis training lesson.

Эдгээр болон бусад олон тоон нотлох баримтыг хадгалж үлдэхийн тулд Шуурхай Санах Ой /RAM/-ны зураглалыг /RAM capture/ хийж бэхжүүлж авах шаардлагатай.

Цахим ул мөр бэхжүүлэх, Шуурхай Санах Ойн /RAM/ зураглалыг /RAM capture/ хийх хэрэгслүүд

Компьютерын Шуурхай Санах Ойн /RAM/ дотроос мөрдөгч олон зүйлсийг олох боломжтой. Жишээлбэл, TrueCrypt, BitLocker, PGP Disk криптоконтейнүүдийн агуулгыг шууд шифрлэх болон тайлж болох түлхүүрүүд гэх мэт. Гэхдээ шифрлэж нууцалсан файлуудын нууц үгийг эвдэх зориулалт бүхий PassWare, ElcomSoft зэрэг программ хангамжууд байдаг боловч нууц үгийн чанараас хамаарч хэдэн арван жил хүлээх шаардлага гарах эрсдэлтэй.

Шуурхай санах ой (RAM) нь нийгмийн сүлжээгээр дамжуулан хүлээн авсан, илгээсэн хамгийн сүүлийн үеийн мессеж, мөн форум дээр үлдээсэн сэтгэгдэл, илгээсэн зурвас, мөн цахим тоглоомд суулгасан чат ашиглан илгээсэн зурвасууд гэх мэт мэдээллийг агуулж байдаг. Мөн гэмт этгээдийн хамгийн сүүлд татаж авсан файлуудын талаарх мэдээлэл, зочилсон вэбсайт, зураг зэрэг мэдээллүүд компьютерын шуурхай санах ойд хадгалагдсан байдаг.

Вэб хөтөч дээр нууцлал хамгаалалтын горимыг идэвхжүүлсэн, кэш болон вэб хуудсанд зочилсон түүхийг идэвхгүй болгосон байсан ч тухайн мэдээллүүдийг харах боломжтой байдаг. Хэрэв компьютер вирусээр халдварлагдсан эсвэл троян төрлийн хортой код ажиллаж байгаа бол шуурхай санах ойн /RAM/ зураглалыг /RAM capture/ авч шалгаж үзэхэд дээрх мэдээллүүд нь тодорхой харагдаж байдаг.

Гэмт хэргийн нотлох баримт цуглуулах, гэмт хэрэг илрүүлэхэд тоон нотлох баримтыг шинжлэн судлахад Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийх нь зайлшгүй шаардлагатай юм.

Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийхэд тухайн компьютерын Шуурхай Санах Ойн хэмжээнээс хамаарч 3-10 минут орчим хугацаа шаардагдах юм. Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг энгийн зөөврийн мэдээлэл тээгч /USB Flash, HDD/ зэрэгт тусгай программ хангамжийн тусламжтайгаар хуулах боломжтой.

Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал хийхэд BelkaSoft Ram Capturer, Magnet Ram Capturer эсвэл FTK imager зэрэг үнэгүй программ хангамжуудыг ашиглаж болно⁴³.

Тоон ул мөр бэхжүүлэх дараах дараах программ хангамжийг ашиглаж болно. Үүнд:

Windows үйлдлийн системд:

- FTK Imager
- RAM Capturer (Belkasoft)
- Magnet's RAM Capture
- Cedarpelta (BriMor Labs)

Mac үйлдлийн системд:


- Cedarpelta (BriMor Labs)

Linux үйлдлийн системд:

- Cedarpelta (BriMor Labs)
- LiME


Зураг №1. FTK Imager жишээ харуулав

⁴³ CISSP Study Guide (Second Edition), 20




Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийж гүйцэтгэхдээ зарим зүйлсийг анхаарах хэрэгтэй. Ашиглаж буй программ хангамж нь энгийн хэрэглэгчийн эрхээр ажиллаж байгаа тохиолдолд компьютер гацах, бэхжүүлж авах гэж буй мэдээллээ бүрмөсөн устгах зэрэг эрсдэлтэй байдаг. Иймд заавал тухай компьютерын админ эрхээр орж шуурхай санах ойн зураглалыг хийж байх хэрэгтэй.

Зураг №2. RAM Capturer (Belkasoft) программ жишээ харуулав



Зарим нэг онлайн төлбөртэй тоглоомын программ, хортой код нь Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийлгэхгүй байх хамгаалалтын тохиргоотой байдаг. Зарим тоон ул мөр шинжилгээний программ хангамж хөгжүүлэгч компаниудаас дээрх хамгаалалттай тохиолдолд ч мэдээллийг амжилттай гаргаж авах боломжтой программ хангамжийг хөгжүүлсээр байна. Үүний нэг нь BelkaSoft Ram Capturer программ юм. Тус программ нь 32 бит болон 64 бит-ийн үйлдлийн системүүдэд зориулсан хувилбартай.


Зураг №3. Magnet RAM Capture программ жишээ харуулав



Хэрэв компьютер нууц үгээр түгжээтэй тохиолдолд яах вэ?

Үйлдлийн системд нэвтрээд орчихсон, эсвэл мөрдөгч нь тухайн компьютерийн нууц үгийг мэддэг тохиолдолд Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийх нь илүү хялбар юм. Гэвч компьютерийн үйлдлийн системийн нэвтрэх нууц үгийг мэдэхгүй, тухайн компьютер нууц үгээр түгжээтэй тохиолдолд ихэнх орчин үеийн компьютерт байдаг FireWire, i-Link буюу IEEE 1394 портын тусламжтай Шуурхай Санах Ойн /RAM/ зураглал /RAM capture/-ыг хийх боломжтой юм. FireWire стандарт нь DMA /Direct Memory Access/ сувгаар дамжуулан компьютерийн RAM руу шууд нэвтрэх боломжийг олгодог. Гэхдээ гэмт этгээдийн компьютер дээр FireWire порт байхгүй бол яах вэ? Энэ тохиолдолд тоон ул мөрийн шинжээч өөрийн PC Card адаптерийг ашиглаж болно. Хэрэв та нэлээд нийтлэг загвар сонговол систем нь зохих драйверуудыг автоматаар ачаална. Харамсалтай нь зөвхөн PCMCIA, CardBus эсвэл ExpressCard интерфэйстэй адаптер нь тохиромжтой, учир нь зөвхөн эдгээр интерфэйс нь компьютерын санах ойд шууд нэвтрэх боломжийг олгодог.

Хэрэв дээрх аргуудыг хэрэгжүүлэх боломжгүй бол мөрдөгч **Hiren's BootCD бэлдэж ашиглах боломжтой**: Hiren's Boot программ нь компьютерын USB диск дээр ажилладаг жижиг үйлдлийн систем бөгөөд компьютерын үйлдлийн системийн эвдрэл, вирусийн халдвар авсан, хатуу диск хуваах, нууц үг сэргээх, өгөгдөл сэргээх зэрэг үйлдлийг хийх боломжтой үнэ төлбөргүй программ юм. Hiren's Boot USB диск ашиглан хэргийн газар дээрх компьютерын нууц үгийг тайлах, эсвэл компьютерын үйлдлийн системийг ажиллуулахгүйгээр Hiren's Boot USB диск дээр байрлах бие даасан үйлдлийн системийг ажиллуулж компьютерт үзлэг хийх боломжтой.



www.hirensbootcd.org хаягаар орж дээрх программ хангамжийн зааврын дагуу татаж үнэ

төлбөргүй хэрэглэх боломжтой.

Анхаар: Хэрэв та "USB төхөөрөмжийг форматлах" сонголтыг сонговол таны USB флаш диск дээрх бүх өгөгдөл болон хуваалтууд устах болно. Доорх алхмуудыг хийхээсээ өмнө USB флаш диск дээрх файлуудыг нөөцлөхөө бүү мартаарай.

Дүгнэлт: Хэргийн газар байгаа компьютерын шуурхай санах ойн мэдээллийг гаргаж авах нь гэмт хэргийн талаар үнэ цэнэтэй нотлох баримтыг олох ач тустай юм. Компьютерын шуурхай санах ой дотор байгаа өгөгдлийг бэхжүүлж авснаар мөрдөгч санах ойд бүрэн дүн шинжилгээ хийж, гэмт этгээдийн хайлтын түүх, сүүлд бичсэн чат, нууц үгээр хамгаалагдсан өгөгдөлд хандах зэрэг бусад боломжийг олгодог.

Ашигласан материал:

www.hirensbootcd.org

The Cloud Security Ecosystem, 2015

CISSP Study Guide (Second Edition), 2012

RCA: RAM CAPTURE AND ANALYSIS training lesson.

www.belkasoft.com/get

www.sectecho.com

--o0o--

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ, ТҮҮНД ҮНЭЛГЭЭ ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЖИЛГЭЭ

CRIME PREVENTION, ANALYSIS OF LEGAL REGULATIONS RELATED TO EVALUATION

Б.Хулан

Дотоод хэргийн их сургуулийн
ЭЗНУС-ийн Хувийн эрх зүйн
тэнхимийн багш, доктор,
цагдаагийн ахлах дэслэгч

Д.Булган

Дотоод хэргийн их сургуулийн
УА-ын ЦУСПБ-ийн
дэд профессор, доктор (Ph.D),
цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиас 2022 оныг дуустал хугацаанд батлагдсан, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 830 шахам хуулийг түүвэрлэн үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай холбоотой 20 шахам хууль, түүнээс хуульд үнэлгээ хийхтэй холбоотой зүйл, заалтууд байна. Үүнээс бид Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиудад дүн шинжилгээ хийж үзлээ.

Abstract: From the 1992 Constitution of Mongolia until the end of 2022, a sample of almost 830 laws that are currently in force, there are almost 20 laws related to crime prevention, as well as articles and provisions related to the evaluation of laws. From this, we have analyzed the Law on Prevention of Crime and Misdemeanors, the Law on Combating Domestic Violence, and the Laws on Development Policy, Planning, and its Management.

Түлхүүр үг: гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх ажил, үнэлгээ, эрх зүйн зохицуулалт.

Key words: crime, preventive work, evaluation, legal regulation.

Удиртгал. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой олон хууль тогтоомж байгаа бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан..

Монгол Улсын Үндсэн хууль нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол эрх зүйн үндэслэл бүхий зохицуулалт бөгөөд түүнд үндэслэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль баталсан. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль нь эрх зүйн олон салбарын хэм хэмжээг нэгэн зэрэг агуулсан байдаг тул түүний чухам аль хэсэг зүйл, заалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн эх сурвалж вэ? гэдгийг тэдгээрийг нэг бүрчлэн судалсны үндсэн дээр тодорхойлдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хариуцна”⁴⁴, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д Засгийн газар нь “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ”⁴⁵ хэмээн заасан. Энэ дагуу төр, засгийн зүгээс гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлэн, хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор

⁴⁴ Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992 он. №1.

⁴⁵ Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992 он. №1. 38.2.7.

баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”⁴⁶-ийн 4.4.7-д “эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэсэн зорилт тавьсан бөгөөд УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”⁴⁷ -ийн 149-д заасны дагуу Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж УИХ-аас 2019 онд баталсан⁴⁸.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын ангилал, зохион байгуулалтын бүтцийг шинэчилж практикт бий болгоход чиглэсэн хууль тогтоомжуудыг баталсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 2019 оны хуулийг 1997 оны хуультай харьцуулан үзье.

Хүснэгт 1. Хуулийн харьцуулалт

№	2019 оны Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	1997 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
1	1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино.	1.1. Энэ хуулийн зорилт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, үндсэн чиглэл, төрөл, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2	3.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн.	3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн.
3	5.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах зарчмыг баримтална: 5.1.1.хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх; 5.1.2.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил цогц, тогтвортой, уялдаа холбоотой байх; 5.1.3.төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлэхгүй байх; 5.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн	4 дүгээр зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим 4.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана.

⁴⁶ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2020 он. Улсын Их Хурлын тогтоол №24.

⁴⁷ Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл. 2017 он. Улсын Их Хурлын тогтоол №11.

⁴⁸ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, //Төрийн мэдээлэл. 2019 он. №42.

	ололт, амжилт, шинэ мэдлэгт үндэслэсэн байх; 5.1.5. зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх; 5.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх;	
5	3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна.	5.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлнэ: 5.1.1. гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох; 5.1.2. гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх; 5.1.3. давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох; 5.1.4. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах; 5.1.5. гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах.
6	6.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дараах үндсэн чиглэлээр зохион байгуулж, хэрэгжүүлнэ: 6.1.1. ерөнхий; 6.1.2. тусгай; 6.1.3. нэг бүрчилсэн; 6.1.4. соён гэгээрүүлэх; 6.1.5. гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх.	6.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дор дурдсан төрөлтэй байна: 6.1.1. ерөнхий арга хэмжээ; 6.1.2. тусгай арга хэмжээ; 6.1.3. нэг бүрчилсэн арга хэмжээ.

Хуулийн харьцуулалтаас дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зөвхөн гэмт хэрэг бус зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, тогтолцооны талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байсныг тухайлан зохицуулжээ.

2. 2019 оны хуульд “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зорилго”-ыг шинээр тусгаж өгсөн нь урьдчилан сэргийлэх ажлын ач холбогдол, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тодорхойлжээ.

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчимд нэлээд шинэлэг зарчмуудыг тусгасан нь харагдана. Тухайлбал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зардал, үр өгөөжийн хувьд үндэслэлтэй байх талаар тусгасан нь үнэлгээ хийх үндэслэлийг тусгажээ.

4. 1997 оны хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлд гэмт хэргийн талаарх мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох талаар тусгасан бол 2019 оны хуулиар үр дүнг үнэлэх замаар урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахаар тусгажээ. Үр дүнг үнэлэх ажил нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ, дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох, сайжруулах үндэс болох юм.

5. Урьдчилан сэргийлэх ажлын “чиглэл”, “төрөл”-ийг харьцуулан авч үзэхэд “соён гэгээрүүлэх”, “гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх” талаар нэмж тусгажээ.

6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 2019 оны хуульд нэг бүрчлэн тусгажээ. 1997 оны хуулиар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн гурван чиглэлийг тодорхойлсон боловч тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуульд ямар нэгэн зохицуулалт тусгаагүй бөгөөд тэдгээр арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар батлахаар заасан байв.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль⁴⁹-д үнэлгээ хийхтэй холбоотой нэлээд зохицуулалтууд тусгасан. Үүнд:

- 3.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бодлого боловсруулах, төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх замаар зохион байгуулна.

- 15.1.8.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;

- 18.2.7.зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа арга хэмжээний үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх;

- 17.1.7.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тогтолцооны үр дүнтэй байдлыг хангах, төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

- 19.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг улсын хэмжээнд болон Салбар болон Дэд зөвлөл, төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллагын түвшинд гурван жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хийнэ.

- 20.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна.

- 22.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллага гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын судалгааг хоёр жил тутам гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааг гурван жил тутам улсын хэмжээнд, эсхүл тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд, эсхүл тодорхой гэмт хэрэг, зөрчлийн төрлөөр олон нийтийн дунд зохион байгуулна.

- 22.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 22.1-д заасан судалгааны үр дүнг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөх үндэслэл болгоно.

- 25.1.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журмыг батлах.

Үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалтыг түүвэрлэн авч үзвэл үр дүнг үнэлэх, үр нөлөөг үнэлэх талаар тусгасан байх бөгөөд системтэй үнэлгээ хийх зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, тогтмол үр дүнг үнэлэх эсхүл 3 жил тутамд үнэлэх, урьдчилсан, явцын, зардал үр ашгийн, үр нөлөөний үнэлгээг огт тусгаагүй байна. Тиймээс хуульд нийцүүлэн журамд энэ талаар тодорхой тусгаж өгөх нь зүйтэй юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль⁵⁰-ийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино. Энэ хуульд дараах үйлдлийг гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр гэж үзжээ. Үүнд:

- бие махбодын хүчирхийлэл;
- сэтгэл санааны хүчирхийлэл;
- эдийн засгийн хүчирхийлэл;
- бэлгийн хүчирхийлэл.

⁴⁹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, //Төрийн мэдээлэл. 2019 он. №42.

⁵⁰ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №5.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоонд Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Прокурорын байгууллага, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүх шатны Засаг дарга, Хамтарсан баг, Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллагуудыг хамааруулж, бүрэн эрх, үүргүүдийг нэг бүрчлэн хуульд заасан байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалт байгаа эсэхийг түүвэрлэн дараах хүснэгтээр авч үзье.

Хүснэгт 2. Үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалт байгаа эсэх

Хуулийн заалт	Урьдчилан сэргийлэх үнэлгээ эсэх
6.6.Энэ зүйлд заасан гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд харгалзан үзнэ.	Үгүй
25.4.1.хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, хуульд заасан журмын дагуу аюулын зэргийн үнэлгээ хийж, түүнийг үндэслэн хохирогчийг нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садан, ойр дотнын хүний түр хамгаалалтад өгөх;	Үгүй
31 дүгээр зүйл. Аюулын зэргийн үнэлгээ 31.1.Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлээ хийнэ.	Үгүй
32.1.Нийгмийн ажилтан дараах байдлыг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ: 32.1.1.гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй байдлыг; 32.1.2.хохирогчид учирсан, эсхүл учирч болзошгүй сөрөг үр дагаврыг; 32.1.3.хохирогчид үзүүлэх үйлчилгээг.	Үгүй

Хүснэгтээс харахад тус хуульд нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд үнэлгээ хийснээр хамгаалалтад авах, үйлчилгээ үзүүлэхээр заасан. Харин урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулаагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль⁵¹-ийн 10 дугаар зүйлийн 10.1-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг дараах дарааллын дагуу боловсруулна. Үүнд:

-Улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг тодорхойлсон нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;

-Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тогтоосон асуудлыг шийдвэрлэх хөгжлийн загвар, төсөөлөл, үр нөлөө, гарах үр дүн, нөөцийн судалгаа, санхүүгийн хэмжээ, эх үүсвэрийн тооцоолол хийж, бодлогын хувилбарыг боловсруулах;

-Бодлогын хувилбаруудад хүний хөгжлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн урьдчилсан үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн урьдчилсан тооцоо хийх;

-Бодлогын хувилбарыг урьдчилсан үнэлгээ, тооцоонд үндэслэн, хуульд заасан зарчмыг баримтлан сонгох;

-Бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг эрэмбэ дараалал, үе шатаар тооцож тодорхойлох;

-Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинд үндэслэн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох.

⁵¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2020 он. №21.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 зүйлд заасан зохицуулалт нь хөтөлбөр боловсруулахаас өмнө хийгдэх урьдчилсан үнэлгээний байх бөгөөд явцын үнэлгээ хийхтэй холбоотой дараах зохицуулалтуудыг тусгажээ. Үүнд:

- 12.2.Улсын Их Хурал хэрэгжилтийн явцын үнэлгээнд үндэслэн Засгийн газарт Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэл өгч болно.

- 19.1.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын дүгнэлт, зөвлөмжөөр түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон байх г.м.

Үр дүнг үнэлэх нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбоотой зарим зохицуулалтыг түүвэрлэн авч үзье. Үүнд:

Хуулийн 21.2.-т “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино” гэж заасан бөгөөд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үүнд:

1. мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
2. зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
3. биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
4. гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
5. төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;
6. биелэлтийн түвшнийг үнэлэх;
7. бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.

Хуулийн эдгээр заалтаас харахад хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахдаа үнэлгээний төрөл болох урьдчилсан үнэлгээ, явцын үнэлгээ, зардал үр ашгийн үнэлгээ, нөлөөллийн үнэлгээг хийхээр тусгасан нь шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулагдах гол зохицуулалт юм.

Хүснэгт 3. Хуулийн харьцуулалт

Харьцуулалт	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль (2015)	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)
Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.	1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино.
Үнэлгээний тодорхойлолт	Байхгүй	4.1.24."бодлогын уялдааны үнэлгээ" 4.1.26."нөхцөл байдлын дүн шинжилгээ" 4.1.27."нөлөөллийн урьдчилсан үнэлгээ"
Урьдчилсан үнэлгээ		4.1.19."бодлогын хувилбар" гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын хоёроос дээш сонголтыг; 10.1.3.бодлогын хувилбаруудад хүний хөгжлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн урьдчилсан үнэлгээ

		болон байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн урьдчилсан тооцоо хийх;
Явцын буюу хэрэгжилтийн үнэлгээ	7.5.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. 9.4.Төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	9.2.5.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, түүнчлэн холбогдох судалгаа, шинжилгээ, явцын болон эцсийн үнэлгээг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх;
Нөлөөллийн, үр дүнг үнэлэх үнэлгээ		4.1.19."бодлогын хувилбар" гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын хоёроос дээш сонголтыг; 4.1.27."нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг.

Хүснэгтээс харахад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль”-ийг өмнөх хуультай харьцуулан судлахад урьдчилсан болон нөлөөллийн үнэлгээ хийхтэй холбоотой зохицуулалтууд шинээр нэмэгдсэн байна.

Дүгнэлт. Цаашид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хуульд үнэлгээ хийх, түүний агуулга, шалгуур үзүүлэлтийн талаар боловсронгуй болгох шаардлагатай.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 2019 онд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг шинэчлэн баталсан нь өмнөх хуулиас улам боловсронгуй болсон гэж дүгнэх үндэслэлтэй байна. Учир нь гэмт хэргээс бус зөрчлөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг давхар зохицуулсан. Мөн урьдчилан сэргийлэх ажлын ач холбогдол, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тодорхойлоход чиглэсэн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг тусгасан бөгөөд цаашид боловсронгуй болгох, сайжруулах үндэс болох юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ хийхтэй холбоотой нэлээд хэдэн зохицуулалтуудыг тусгасан байна. Тухайлбал, үр дүнг үнэлэх, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэх, тогтолцооны үр дүнтэй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр төлөвлөгөө нь ... төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна, үр дүнг үнэлэх журам батална, үр нөлөөг тогтмол судлах, үнэлэх ... г.м олон зохицуулалт тусгасан.

Гэсэн хэдий ч онолд тулгуурлан системтэйгээр үнэлгээ хийж, түүнийг сайжруулахтай холбоотой зохицуулалт байхгүй байна. Хэрэв үнэлгээний онол дээр тулгуурласан бол урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг тогтмол үнэлэх, урьдчилсан, явцын болон хэрэгжилтийн, үр нөлөөний, зардал үр ашгийн үнэлгээг хийхтэй холбоотой зохицуулалтыг тусгах юм. Тиймээс хууль болон журамд энэ талаар тусгаж өгөх шаардлагатай юм.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам” нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан чухал

журам болсон хэдий ч цаашид сайжруулах, зарим нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Тухайлбал, үр дүнг үнэлэх ажлыг тайлан мэдээ гаргах журмаар зохицуулах зохимжгүй байна. Мөн урьдчилан сэргийлэх ажлын үнэлэх үзүүлэлтийг бодитой, ойлгомжтой болгох, үнэлгээг хэзээ, ямар үнэлгээ хийж болгох талаар бүрэн дүүрэн тусгах нь зүйтэй юм.

Эх сурвалжийн жагсаалт

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992 он. №1.
2. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992 он. №1. 38.2.7.
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, //Төрийн мэдээлэл. 2019 он. №42.
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №5.

Хоёр. УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2020 он. №21.
2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2020 он. Улсын Их Хурлын тогтоол №24.
3. Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл. 2017 он. Улсын Их Хурлын тогтоол №11.

--oOo--

**ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ОНЦЛОГ
VICTIM PROTECTION ACTIVITIES LEGAL
REGULATION FEATURE**

Д.Бямбахүү

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, цагдаагийн дэд хурандаа

Byambakhuu.D

Senior teacher of police Law department,
Police school of University of Internal Affairs,
Police major

Товч агуулга: Хүний эрх зүйн байдал нь нийгмийн бүтэц, ардчиллын түвшин хууль ёсны байдалтай нягт холбоотой улс төр, хууль цаазын хамгийн чухал ухагдахууны нэг мөн. Нийгэм дэх бие хүний байдал нь хүнээс нийгмийн орчинтой харилцах олон янзын холбоог зохицуулж байгаа хууль зүйн хэм хэмжээгээр хэрхэн тодорхойлсон, бие хүний эрх зүйн байдал нь нийгэм дэх хүний эрх, эрх чөлөө, үүрэг ба хариуцлагыг хууль зүйн талаас нь товч авч үзсэн.

Summary: Human legal status is one of the most important political and legal concepts closely related to social structure and the level of democracy. How the status of a person in society is defined by the legal norms that regulate the various relations between a person and the social environment, and the legal status of a person is briefly considered from the legal point of view, the rights, freedoms, duties and responsibilities of a person in society.

Түлхүүр үгс: Хохирогч, нийгэм, эрх зүй, хамгаалалт, харилцаа, хууль

Key words: Victim, society, legal, protection, relationship, law

Үндсэн хэсэг. Монголчуудын дунд уламжлал болон хэллэгдэж ирсэн “Адгийн зарга арав хоног” гэсэн үг нь олон нийтийн сэтгэлгээнд буруу ойлголт төрүүлж байгаа ч хэрэг шийдэхдээ үеийн үед хохирогчид түвэг чирэгдэл учруулсаар байна.

Хүний эрх зүйн байдал нь нийгмийн бүтэц, ардчиллын түвшин хууль ёсны байдалтай нягт холбоотой улс төр, хууль цаазын хамгийн чухал ухагдахууны нэг мөн⁵². Нийгэм дэх бие хүний байдал нь хүнээс нийгмийн орчинтой харилцах олон янзын холбоог зохицуулж байгаа хууль зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдох учраас эрх зүй гэж нэрлэгдсэн. Бие хүний эрх зүйн байдал нь нийгэм дэх хүний эрх, эрх чөлөө, үүрэг ба хариуцлагыг хууль зүйн хувьд бэхжүүлэх, өөрөөр хэлбэл эрх зүйн субьектын хувьд хүний эзэмшиж байгаа эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг эрх зүйн шинжлэх ухаанд нийтлэг, тусгай ба нэг бүрчилсэн гэж төрөлжүүлэн авч үзнэ.

Эрх зүйн ерөнхий байдал нь үндсэн хуулиар тодорхойлогдох бөгөөд бүх хүмүүст нийтлэг, нэгдмэл байна. Эрх зүйн тусгай байдал нь өөрт ногдсон тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа тодорхой хэсэг хүмүүсийн байдал мөн.

Харин эрх зүйн хувийн байдал нь зөвхөн хувь хүнд хамаарч байгаа эрх, үүргийн /иргэний харьяалал, гэр бүлийн байдал, нас хүйс гэх зэрэг/ нийлбэрийг тусгаж байгаа байдал юм. Мөн эрх зүйн субьектээр нь бие хүний эрх зүйн байдал ба хуулийн этгээдийн эрх зүйн байдал, эрүүгийн эрх зүйн гэх зэргээр ангилж болно. Эрх зүйн байдлын бүтцэд иргэний харьяалал, иргэний эрх, эрх чөлөө ба хууль зүйн үүрэг, хууль зүйн хариуцлага, эрх зүйн нийтлэг чадвар, хууль ёсны ашиг сонирхол зэрэг багтдаг.

Хохирогч ялтны хууль ёсны ашиг сонирхол нь хууль зүйн эрх, үүрэгт шууд хуульчлагдаж, бэхжигдээгүй учир эрх зүйн байдлын бие даасан бүрдэл хэсэг биш гэж үзэх хандлага байдаг. Хууль

⁵² Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи, Уб., 2005., х.320

ёсны ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн хууль цаазны зөвшөөрлийн нэг төрөл учраас хууль тогтоомжоор хамгаалагдаж, хангагдаж байдаг⁵³. Гэвч эрүүгийн процессын шинэчлэлтийн үр дүнд сэжигтэн, яллагдагчид олгогдсон эрхийн нийлбэр нь хүний эрхийг хангах салбар дахь дэлхийн стандартад ихээхэн ойртож очсон боловч, гэмт хэргийн хохирогчийн хувьд зарим нэгэн зүйлд анхаарал хандуулах хэрэгтэйг тэмдэглэх нь зүйтэй.

Гэмт хэргийн хохирогч шүүн таслах ажиллагаанд голлох байр суурь эзэлдэг учраас байцаан шийтгэх ажиллагааны төгсгөлийн үе шатанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Ийм учраас эрүүгийн байцаан шийтгэх онолд эрүүгийн процесс нь эсрэг тэсрэг хоёр ашиг сонирхлын сөргөлдөөнийг эрүүгийн тодорхой хэргийг хянан шийдвэрлэх замаар шийдвэрлэх явдал гэж тооцогдоно. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь гэмт халдлагын улмаас эрүүгийн материаллаг хуулиар хамгаалагдсан харилцаа, эрх ашиг зөрчигдсөнөөс уламжлан үүсдэг, тодорхой дэс журмын дагуу явагдах өвөрмөц төрлийн харилцаа гэж ойлгож болно.

Тиймээс төрийн ба олон нийтийн байгууллагууд нь дараах үйл ажиллагааг явуулж байна.

- Гэмт хэргийн хохирогчийн эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн байдлыг өргөжүүлэх.
- Хохирогчоос эрхээ “мэдэх эрх”-ийг нь ойлгуулах, хэрэгжүүлэх.
- Хохирогчтой холбоотой үйл ажиллагаанд хуулийн байгууллагуудын ажилтнуудын тавих хяналтыг чангатгах.
- Гэмт явдлын улмаас хохирлын нөхөн төлбөр авах хохирогч талын боломжийг улам өргөжүүлэх.
- Хохирогчийн аюулгүй байдал ба нууцлалыг хангах.
- Гэмт хэргийн хохирогчид туслах үндсэн үүрэг бүхий төрийн бус буюу төртэй хамтран үйл ажиллагаа явуулдаг тусгай байгууллагыг бий болгосон.

Хэдийгээр янз бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч тэр тусмаа хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч ялтны эрхийг зохих ёсоор хангах тухай асуудал бүрэн хэрэгжиж чадаагүй одоогийн авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь гэмт хэргийн хохирогчийг эрүүгийн порцесст хоёрдугаарт тавигдаж байсан дүр төрхөө өөрчлөх цаг нь болжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн агуулгаар авч үзэхэд хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч бүр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч болохгүй, энэ нь нуугдмал гэмт хэргийн хохирогч болон гэмт хэргийн хохирогч нас барсан тохиолдолд илүү тод илэрхийлэгддэг. Түүнээс гадна хохирогч нь зөвхөн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээдийн гаргасан тусгай шийдвэрийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн оролцогч-хохирогчийн эрх зүйн байдлыг олж авна.

Ийм учраас хорих ангид хохирогчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохиролыг нөхөн төлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах зэрэг байцаан шийтгэх ажиллагааны эрхийг гэмт хэрэгт хохирсон этгээд, түүний төлөөлөгчид эдлэхээр тодорхой заасан.

Харин төр хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө үндсэн хуулиар хүлээсэн байдаг.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166 дугаар зүйлд эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэлийг зааж өгсөн. Үүнд: Гэмт хэрэг гарсан талаар иргэн гомдол гаргасан буюу мэдээлсэн, гэмт хэрэг гарсан талаар аж ахуй нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн зэрэг нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болно. Гэмт хэргийн улмаас хохирол учирсан этгээд нь гэмт хэрэг гарсан талаар гомдол гаргах буюу мэдээлэл гаргасныг “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор” заавал хүлээн авах үүргийг хуулиар тогтоож өгсөн. Хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч гэмт хэрэг гарсан тухай мэдээлэх үүрэг хүлээхгүй, харин

⁵³ Нямсүрэн, Ч. Эрх зүй, төрийн ерөнхий онол, УБ., 2004., х.156

гомдол гаргах эрхтэй тийм учраас гомдол гаргах нь гэмт хэргийн улмаас хохирол шууд буюу шууд бус, мөн дам учирсан этгээдүүдээс гаргах эрхтэй юм. Гомдол гаргах эрхийг гэмт хэргийн улмаас хохирол шууд учирсан этгээд өөрөө, мөн шууд бус хохирсон түүний хууль ёсны төлөөлөгч, үр хүүхэд, гэр бүлийн гишүүд, мөн дам хохирсон төрөл садангийн хүн, мөн хохирлын хэр хэмжээ, багтаамжаас хамаарч хохирогчтой ажил хэргийн холбогдолтой байсан түнш, хамтран ажиллагч хэн ч гаргах боломж нээлттэй байдаг. Гэхдээ дам хохирсон этгээд нь субъектив эрхээ эдлээгүйн төлөө эрүүгийн хуульд заасан “гэмт хэргийг үл мэдээлэх” гэмт хэргийн субъект болж эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой.

Харин мэдээлэл өгөх нь хууль зүйн үүрэг мөн. Эрх зүйн харилцаанд оролцогчдоос хууль зүйн үүргээ биелүүлэх нь бусдын эрх, эрх ашгийг хангах, хамгаалах нэг баталгаа болно. Эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд, иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эл хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан гаргах учраас энэ нэхэмжлэл нь эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болохгүй. Харин хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч нь үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцна.

Эрүүгийн хэрэг үүсгэх өөр үндэслэл болох гэмт хэрэг үйлдсэн хэмээн өөрийгөө илчилж ирсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг өөрсдөө шууд илрүүлсэн, гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугмаар авагдаж, баримтжуулагдсан мэдээ баримтад үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэх нь хохирсон этгээдийг хохирогчоор тогтооход мэдээжийн саад болохгүй.

Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 42 дугаар зүйлд “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ” гэж хохирогчийн тухай тодорхойлдог. Харин гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх үндэслэл нь хохирогчийн хүсэлт, эсхүл өмгөөлөгч, мөрдөгч, порокурор, шүүгчийн бичгээр гаргасан санал, шийдвэр байна.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэгт “Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх”-ээр заасан түүнчлэн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан. Авилгын эсрэг конвенци, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон бусад олон улсын гэрээ, конвенцид “Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан, бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна⁵⁴ ” гэж үүрэг хүлээжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 40/34 дугаар тогтоолоор, 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргасан нь олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “Гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдол гэрчийг хамгаалах”-ыг⁵⁵ улсуудад уриалсан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлан гаргасан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд Монгол Улсын Засгийн газрын “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулж, хэрэгжүүлэх тухай зааснаар Монгол Улсын

⁵⁴ Хүний эрх ба Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл, Шүүх эрх мэдэл дэхь хүний эрх, УБ., 1998., х.85

⁵⁵ Хүний эрх ба Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл, Шүүх эрх мэдэл дэхь хүний эрх, УБ., 1998., х.125

Засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоолоор “Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр” нь гэрч, хохирогч нэг бүрт хуулиар олгогдсон эрхээ эдэлж, мэдээлэл авах, аюулгүй байдлаа хангуулах, хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, учирсан хохирлоо арилгуулах, нийгмийн халамж, туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн зохицуулалт бий болсон. Хөтөлбөрт зорилго, хэрэгжүүлэх зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохион байгуулалт, хугацаа, санхүүжилт болон хөтөлбөрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг тусгажээ. Хөтөлбөрийг 2016-1024 он хүртэл гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр болсон юм⁵⁶.

Хохирогч нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд бөгөөд судалгаанаас үзэхэд тэдний аюулгүй байдал хамгаалалтгүй байна. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох оролдлого хийх, амиа хорлох зэрэг үйлдэл гарч буйг судлаачид тэмдэглэсэн байна⁵⁷.

Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй этгээдүүд гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, бааз суурь байхгүй гэсэн шалтгаанаар гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг хийдэггүй байсан нь судалгаагаар тогтоогдсон. Харин амь нас, эрүүл мэндэд нь заналхийлэл тулгарсан хүүхэд, эмэгтэйчүүдийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг Хүйсийн тэгш эрхийн төв гэсэн төрийн бус байгууллагууд хамгаалах зарим арга хэмжээ авч хэрэгжүүлд⁵⁸. Бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтын бий болгож, үүний үр дүнд хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байдаг.

Дээрх хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн 2013 оны 07 сарын 05-ний өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдан, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна. Хууль зүйн салбарт эрүүгийн хариуцлагын тогтолцооны шинэтгэл хийгдэж байгаатай холбогдуулан хууль тогтоомжийн төдийгүй дэд бүтцийн бодлогыг салбарын яамнаас шинээр тодорхойлж Эрүүгийн хууль тогтоомж гэсэн ойлголт нь өргөн болж материаллаг болон процессын хуулиудыг бүхэлд нь хамарч, хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх, оролцогчдын аюулгүй байдлыг хангасан, шудрага ёсыг тогтооход чиглэж байна.

Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуульд: Гүйцэтгэх байгууллага нь:

9 дүгээр зүйлийн 9.1.3 Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад далд аргаар үйлдэгдсэн, эсхүл тодорхой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдал болон шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох.

9.1.4.шүүхийн шийдвэр биелүүлэх газрын гүйцэтгэх алба хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.1.6-д заасан байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх /Энэ заалтад 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/-ээр тус тус заасан байна.

⁵⁶ <http://www.zasag.mn/>

⁵⁷ Хохирогчийн эрхийн судалгааны төв UNDP судалгааны тайлан, Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, УБ., 2010.

⁵⁸ Хохирогчийн эрхийн судалгааны төв UNDP судалгааны тайлан, Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, УБ., 2010.

Эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хамаарах дээрх хууль тогтоомж батлагдан гарснаар, хохирогчийг хамгаалах үр ашигтай, уян хатан бүтэц бий болгох үндэс тавигдаж, энэ хүрээнд дараах эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлсон. Үүнд:

1. *Цагдаагийн мөрдөх албанд хамаарах гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо*: Түгээмэл гарч байгаа, цагдаагийн байгууллагаас бүртгэн шалгадаг 24 мянга гаруй хэргийн дийлэнх хувийг иргэдийн бие махбодийн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хэргүүд эзэлдэг. Иймээс хорих ангийн хэмжээнд түгээмэл төрлийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, хууль сахиулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн хууль бус нөлөөнөөс хамгаалах арга хэмжээг тусгасан.

2. *Мөрдөх албанд хамаарах хохирогчийг хамгаалах тогтолцоо*: Авлига, албан тушаал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогчийг олон улсын болон дотоодын түвшинд хамтран ажиллах, хамгаалах, туслалцаа үзүүлэх шинэ хэлбэрийг тогтоож, төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх.

3. *Шүүхийн шатанд хохирогчийг хамгаалах тогтолцоо*: Шүүхийн шатанд хохирогчийг хамгаалах, тусгаарлах байранд байлгах, эрэн сурвалжлах, шүүх хуралдааны явцад аюулгүй байдлын хангах гэсэн гурван хэсгээс гадна энэ хуулийн хэрэгжүүлэх зөвлөмж, аргачилсан заавар боловсруулагдана гэж хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс төлөвлөж, хэрэгжүүлж байна.

Хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны төрөл нь хувийн хамгаалалт, орон байрны хамгаалалт, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олох, холбоо харилцааны болон дохиоллын системийн хэрэгслэлүүдийг олох, утасны дугаар болон авто машины дугаарын өөрчлөх тодорхой хугацаанд аюулгүй газар байлгах, оршин суугаа газрыг өөрчлөн нүүлгэх, баримт бичгийг өөрчлөх гадна төрхийг өөрчлөх гэх мэт олон төрөлтэй. Уг хамгаалах аргын төрлийг Гэрч, хохирогчийг хамгаалах хуулинд тусгахдаа олон улсын нийтлэг жишгийг харгалзан Монгол Улсад хэрэгжүүлж чадахуйц аргыг сонгохыг эрхэмлэнэ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар, мөрдөн шалгах ажиллагаанд, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээнүүдийг хэрэглэх шийдвэрийг прокурор гаргаж, “Хохирогчийг биечилсэн хамгаалалтанд авах тухай”, “Хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах тухай”, “Хохирогчийн хувийн нууцыг задруулахыг түр хугацаагаар хориглох тухай”, “Хүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулах тухай”, “Гэрч, хохирогчийг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах тухай”, “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах тухай”, “Сэжигтэн, яллагдагчын тодорхой үйлдлийг хязгаарлах тухай” тогтоолыг тус тус үйлдэж, тогтоолын хэрэгжилтийг хангаж, нууцлалыг хамгаалахыг Цагдаагийн алба, мөрдөн байцаах байгууллагад даалгаж, хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээ санаатайгаар удаа дараа зөрчвөлуг арга хэмжээг цуцлах тухай тогтоолд дурьдаж хохирогчид танилцуулдаг.

Хохирогчийн эрх зүйн хамгаалалтын ойлголт, практикт: Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өөрийн болон төлөөлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж оролцдог нэг үндсэн оролцогч нь хохирогч байдаг. Хохирогч хамгаалалтад байх эрх Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтаар “иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй”⁵⁹ хэмээн баталгаажсан.

Хорих байгууллагад хохирогчийн эрхийг баталгаажуулах арга механизм төлөвшөөгүй, уг эрхийг хангах эдийн засгийн баталгаа суурь боломжууд хангалтгүйн улмаас хохирогч хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нь элбэг байна. Хохирогчийн нотлох эрх (мөрдөн байцаалтанд оролцох), зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд туслах шинжтэй үүрэг болсон нь хохирогч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн үндсэн агуулгыг зөрчихөд хүргэж байна.

⁵⁹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл. УБ., 1992., №01.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь: Гэмт хэргийг нотлох үүрэг хүлээдэг тул хохирогчийн эрхийг хангах нь тэдэнд хоёрдогч ажиллагаа болдог байна. Энэ нь хохирогчийн эрхийн хамгаалал хуульд сул байгаагийн илрэл бөгөөд үүний улмаас хохирогчийг олон дахин явуулах, хүлээлгэх, залхаах, хүнд суртал гаргах, хохирогчийг хэргээ өөрөө нотлохыг шаардах зэрэг ноцтой бэрхшээл, дутагдал гарсаар байна.

Иймээс хохирогчийн гомдол, хүсэлтэнд ач холбогдол өгч түргэн шуурхай шийдвэрлэх, түүний бие эрхтэн, сэтгэл санаа, эд хөрөнгөнд учирсан хор хохирлыг арилгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, улмаар хохирогчид сэтгэл зүйн болон хууль зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авах шаардлага амьдралаас урган гарч байна. Юуны өмнө гэмт хэргийн хохирогчийн үндсэн эрхийг зөв тогтоон түүний хүрээнд гарч буй алдаа дутагдлыг арилгах арга замаар тодорхойлох учиртай.

Өнөөгийн байдлаар Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлж Цагдаагийн Ерөнхий газрын гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс байгуулагдсан. Тус хэлтэс нь аюулгүй байдлын хамгаалалтын тасаг, эрүүгийн цагдаагийн тасаг гэсэн бүтэц нэгжтэй 30 хүний орон тоотойгоор ажиллаж байна.⁶⁰ Тус алба нь өдөр тутмын ажилдаа дараах хууль, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд:

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
4. Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр /засгийн газрын 2015 оны 346 дугаар тогтоол/
5. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний журмууд /ХЗС-ын 2014 оны а/110,111,112,113,114,204, Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 356/182 дугаар тушаал /
6. Аюулгүй байдлын арга хэмжээний маягт /ХЗС-ын 2015 оны А/88/
7. “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам” /Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 дугаар тушаал/
8. “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам” /УЕП, ХЗДХС-ын хамтарсан 2017 оны А/22, А/31/
9. “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам” /ХЗДХС-ын 2017 оны А/37/
10. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “гэрч хохирогчийг хамгаалах” журам / код511/ журам.

Шүүхээс шийдвэр оноохдоо хохирогчид сүүлд нь ямар дарамттай учрахыг тооцоолдоггүй гэх шүүмжлэл байсаар байна. Хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах амиа хорлох оролдлого хийх, бүр амиа хорлох ч үйлдэлд хүргэж буйг судлаачид тэмдэглэсэн байна.

Хууль бус явдлынх нь талаар гэрчийн мэдүүлэг дээр тулгуурлан нийтэлсэн сэтгүүлч сүүлд гэрч мэдүүлгээсээ буцсанаас болж буруудан гэмт хэрэгтэн болж байсан жишээ ч бий. “Чи охинтой хүн шүү” гэж хуулиар хамгаалагдсан шүүгчийг дарамталж чадаж байгаа хүмүүс, ямар ч хамгаалалтгүй хохирогчийг яаж ч дарамталж, хэрхэн худалдаж авч байгаа бол гэдгийг төсөөлөхөд ч бэрх. Аархсан, мөнгө, эрх мэдэлдээ эрдсэн “том ах” гэж өөрсдийгөө бодогч нар хэзээд байсаар л байна, мөн мөнгөний төлөө хэн нэгний хүслээр хөдлөх залуус байсаар л байгаа нь нийгэмд тулгамдсан асуудал болоод байна.

Түүнчлэн биечилсэн хамгаалалтын журам, тусгай тасгийн ажиллах журам, гэрч, хохирогчтой харилцах журам, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах журмыг боловсруулах үйл ажиллагааг Цагдаагийн алба Хууль Зүйн Яамны болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулах шатандаа явж байна.

⁶⁰ Цагдаагийн ерөнхий газрын, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн жилийн эцсийн тайлан, УБ., 2016.

Сэжигтэн, яллагдагч, ялтны зүгээс хамт хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд халдах, тэднийг дарамтлах зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсээр байна. Түүнчлэн эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор, сэтгэл зүйн онцлог, бусад шалтгааны улмаас амиа хорлох, бие эрхтэндээ гэмтэл учруулах зэрэг ноцтой үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд тэдний болон хохирогч болсон этгээдийн аюулгүй байдлыг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хорих ял эдэлж буй хүмүүс нь сэтгэл зүйн хувьд тогтворгүй байдалд байдгийн хувьд Нийгэм-Эдийн засгийн амьдралын аливаа өөрчлөлт, хөдөлгөөнийг маш эмзэг, сөргөөр хүлээж авдаг нь судалгааны ажиглалтаас харагдаж байна. Түүнээс гадна нийгмийн амьдралын баталгаагүй, тогтворгүй байдал нь ялтны хувьд гэр бүлийнхний амьдралын хүндрэл, үр хүүхдийн ирээдүйн баталгаатай байдалд ч эргэлзээтэй, үл итгэх байдал бий болгодог.⁶¹

Тахарын алба 2014 онд 33 гэрч, хохирогчийг хамгаалан ажилласны дотор шүүгч гурав, хохирогч 19, хамаарал бүхий этгээд 11 багтжээ. Шүүж буй хэргийнхээ төлөө заналхийлэлд өртсөн тул гурван шүүгчийг хамгаалалтад авчээ. Үүнээс гадна гэрч, хохирогчийн өрөөг камераар 24 цагаар хянадаг тул айх аюулгүй гэдэг нь харагдаж байлаа. Хэрвээ өөрөө зөвшөөрсөн тохиолдолд гэртээ камер суулгах боломжтой юм. Хамгийн гол эрүүгийн хэрэг үүсгэсэн гэмт хэргийг тохиолдлуудад энэхүү арга хэмжээ авах боломжтой. 2015 онд хамгаалалтад авахуулах тухай иргэдийн өргөдөл –22, өмгөөлөгчийн хүсэлт –2, Шүүгчийн захирамж –2, Шүүгчийг хамгаалалтад авахуулах тухай албан бичиг –3, Цагдаагийн газраас хохирогчийг хамгаалалтад авахуулах тухай албан бичиг –4, Төв аймгийн Цагдаагийн газраас гэрчийг хамгаалалтад авахуулах тухай албан бичиг –1, төрийн бус байгууллагын хүсэлт –2 нийт 36 албан бичиг, өргөдөл хүсэлт хүлээн авч нөхцөл байдлыг судлан эрсдэлийн түвшинг тогтоож, урьдчилан сануулах хамгаалалтын арга хэмжээ –11, биечилсэн хамгаалалтын арга хэмжээ –3, аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээ –2, тусгай техник хэрэгслээр хангах арга хэмжээ –1-ийг тус тус хэрэгжүүлэн шүүгч –1, хохирогч –13, гэрч –5, хохирогчийг хамаарал бүхий этгээд 19 нийт 38 иргэний аюулгүй байдлыг ханган ажилласан.

Мөн 2014 оны 12 дугаар сарын 27-ны өдөр өргөдөл гаргасан иргэн Т-гийн өргөдлийн дагуу насанд хүрээгүй 3 гэрчийг сэтгэл зүйн хамгаалалтад авч, 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн иргэн Т-ийн өргөдлийн дагуу холбогдох арга хэмжээ авч Монголын хуульчдын холбоонд албан бичиг хүргүүлэн үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж хууль зүйн туслалцааг тус тус үзүүлсэн⁶².

Шүүхийн хэмжээнд 2014 онд нийт 1488 эрүүгийн хэрэг шийдвэрлэснээс 407 буюу 3.6 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлжээ. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь хүүхэд, эмэгтэйчүүд их байдаг, сүүлийн үед гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид ихээр хандаж байгаа. Хамгийн гол нь иргэд хохирогчийг хамгаалах талаар мэдээлэл муу байгаа. Хохирогчдын хувьд аюултай нөхцөл байдалд байгаа ч аль болох ажил төрөл, сургууль, хичээлдээ явахыг илүүд үздэг. Ажлынхан, ангийн хүүхдүүд маань хүчирхийлэлд өртдөг гэдгийг яагаад мэдэх ёстой юм гэдэг үүднээс ханддаг учраас хүсэлтийг нь зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрдэг” гэдгийг онцолсон юм. Хамгийн чухал асуудал гэвэл хохирогчид өндөр түвшинд хамгаалуулахыг шаардах болжээ.

Гэмт хэргийн хохирогчийн үндсэн эрхийг дараахь байдлаар ангилж болохоор байна.

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад оролцох (нотлох) эрх
2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх (шаардах эрх)
3. Эрх зүйн үйлчилгээ (хамгаалалт) авах эрх

Гэмт хэргийн хохирогчийн хамгийн чухал бөгөөд үндсэн эрх нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрх юм. Энэ эрхийн хүрээнд хохирогч нь юуны өмнө прокурорт хандаж гэмт хэрэг үйлдсэн буюу үйлдсэн байж болох этгээдийг олж тогтоох улмаар сэжигтэн, яллагдагчид ял оногдуулах асуудлаар санал гаргах зэргээр хамтран ажиллах боломжоор хангах хэрэгтэй байна. Мөн тухайн хэргийн эрх зүйн байдлын талаар хохирогчид мэдээлэх явдалд туйлын ажил хэрэгч хандах шаардлагатай. Өөрөөр хэлбэл сэжигтэн, яллагдагчид Эрүүгийн хуулийн ямар зүйлд заасан гэмт

⁶¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл, Илтгэл, УБ., 2015., №01. х.25

⁶² Тахарын ерөнхий газар, Гэрч, хохирогчийг хамгаалах газрын тайлан, УБ., 2015.

хэрэгт холбогдуулан шалгаж байгаа болон хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх ямар нөхцөл боломж байгаа эсэх, хэргийн хугацаа сунгах болсон талаар хохирогчид зөв ойлголт өгч эрх зүйн дэмжлэг үзүүлэх учиртай. Тухайн хэргийн эрх зүйн байдлыг хохирогчид ингэж зөв ойлгуулаагүйгээс хохирогч бухимдах, шалгаж буй мөрдөн байцаагчийг болон хяналт тавьж буй прокурорыг хардах, ялих шалихгүй үндэслэлээр хүсэлт, гомдол гаргаж мөрдөн байцаах ажиллагаанд бэрхшээл учруулах хандлага ажиглагдаж байна.

Сэжигтэн, яллагдагчийг батлан даалтанд гаргах, хэргийн хугацаа сунгах болсон шалтгаан, хэргийн зарим үйлдлийг болон хэргийг хэрэгсэхгүй болгох, зүйлчлэлийг өөрчлөх, хохирлын хэмжээ өөрчлөгдөх, үнэлгээ хийлгэх журам, үнийн эцсийн дүн түүнийг нөхөн төлүүлэх арга замын талаар хохирогчид байнга мэдээлж байх хэрэгтэй. Ингэх нь хохирогчийн зүгээс тааламжгүй байдал үүсгэхгүй байх бөгөөд хэргийг шуурхай үнэн зөв шалгахад ач холбогдолтой.

Прокурор нь хохирогчтой хамтран ажилласнаар түүний итгэл үнэмшлийг үнэлэх боломж прокурорт бий болно. Ялангуяа хэргийг яагаад хэрэгсэхгүй болгож байгааг хохирогчид маш сайн ойлгуулах шаардлагатай бөгөөд энэ нь прокурорын хувьд уг хэргийг шүүхэд шилжүүлэхэд хүргэж болохуйц итгэл үнэмшил бүхий нотлох баримтыг хохирогчоос шинээр олж авч болохыг анхаарах хэрэгтэй.

Зарим тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах онцгой шаардлагатай байдаг. Тухайлбал хүчин, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон насанд хүрээгүй хохирогчийн хэргийг туйлын шуурхай мөрдөх ёстой. Учир нь ийм төрлийн хохирогч нар хэргийг удаашруулснаас сэтгэлийн хямралд удаан хугацаанд байх, итгэл алдрах, холбогдогчийн зүгээс түүнд янз бүрээр нөлөөлж “найрах” ажиллагаа явуулахаас прокурор урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байх хэрэгтэй юм. Жишээ нь: Э гэгч иргэний холбогдсон Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-д заасан гэмт хэргийн хохирогч Д-г найз нөхөд, /хорих ангид хамт ял эдэлж байсан гал хам/, хууль ёсны өмгөөлөгчөөр нь дамжуулан олон удаа ятгаж байж анхны мэдүүлгээс нь буцаалган худал мэдүүлэг өгүүлэн улмаар уг хохирогч өөрөө гэмт хэрэгтэн болж сэтгэл санааны давхар хохирол амсаж байгаа эмгэнэлтэй баримт байна. Энэ нь хохирогчийн хамгааллын асуудлаар бидэнд практик тогтоогүй, анхаарал сул хандуулдагаас болж байгаа ноцтой зөрчил юм. Хохирогч нар нөлөөнд өртөж байгаа тохиолдол ганц энэ ч биш олон хэлбэрээр голдуу далд байдлаар явагдаж байна.

Аливаа шүүх хуралдаанд оролцож байгаа хохирогчид эсрэг талын сэжигтэн этгээд, тэдний гэр бүлийнхэн, өмгөөлөгчтэй нүүр тулахаас аргагүй болдог. Өөрөөр хэлбэл яллагдагчийн талынхан ямар ч байдлаар хохирогчид нөлөөлж дарамт үзүүлэх боломжтой. Ийм нөхцөлд шүүх хуралд гол нотолгоо, эх сурвалж болж буй хохирогч айдас түгшүүрт автах, дарамтанд орох явдал их байдаг. Цаашилбал хохирогч айдастай амьдрахгүйн тулд худал мэдүүлэг өгөх, мэдүүлгээсээ буцах, хохирогч ял сонссон этгээдийн ар гэрийнхний дарамт шахалтад амьдардаг гажуудал манай тогтолцоонд бат бөх оршсоор ирсэн. Үүнийг халах эхлэл нь гэрч, хохирогчдод зориулсан тусгай өрөө юм. Жишээ нь: Хүчингийн хэргийн хохирогчид ихэвчлэн бага насны хүүхэд байдаг бол гэмт этгээд нь түүний гэр бүлийн хүрээний эсвэл хөршийн таньж мэддэг хүн байх нь элбэг. Хүний эрхийн үүднээсээ ч ийм хүмүүсийг нэг танхимд оруулж, шүүх хуралдааныг явуулах нь учир дутагдалтай.

Хохирогчийг хамгаалах газарт байгуулагдсан тусгай өрөө нь хохирогч шүүх хуралдааны өмнө сэтгэл зүйн зөвлөгөө тусалцаа авах, шүүх хуралдааны танхимд орохгүйгээр тусгайлан байрлуулсан дэлгэцээр мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлсэн. Тус өрөөнд шүүх хуралд оролцох дэлгэц, хохирогчийн нүүр царайны төрхийг өөрчлөх хэрэгсэл зэргийг байрлуулж, тав тухтай орчин бүрдүүлсэн байна. Ингэснээр хамгаалалтын гадна байсан хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах чухал алхам хийгдсэн. Ийм жишиг өрөөг бусад шүүхүүдэд байгуулснаар хохирогчдод аливаа хэргийг үнэн зөвөөр шийднэ гэсэн итгэл үнэмшил төрж, хэргийг хуулийн хүрээнд шударга шийдүүлэхэд чухал нөлөө үзүүлж эхэлсэн.

Тодорхой үйлдлийг хязгаарлах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хэрэгтэй технологийн дэвшлийг нэвтрүүлэхээр судалгааны ажлаа эхлүүлсэн байна. Ялангуяа насанд хүрээгүй хохирогч, хүчингийн гэмт хэргийн хохирогч, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчийн хувьд шүүх хуралдаанд оролцохдоо гэмт этгээдтэй дахин нүүр тулна гэдэг нь сэтгэл санааны

очирдолд оруулж, айдаст автуулдаг. Айж, сандарсандаа мэдүүлгээ үнэн зөв өгч чадахгүй байх тохиолдол ч гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс хохирогчийг төр хамгаалалтад авдаг.

Гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх шалгах, нотлох гэм бурууд тохирсон ял шийтгэл оногдуулах, нийгмээс тусгаарлан хорих, ял эдлүүлэх асуудал нь нэг талаас шүүх болон хууль сахиулах салбарын үйл ажиллагаа, нөгөө талаас иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг болдог байна.

Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/112 тушаалаар “Мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”, 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/113 тушаалаар “Тусгай техник хэрэгслийн жагсаалт хэрэгслээр хангах, хэрэглэх журам”, 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/114 тушаалаар “Аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ууд батлагдсан.

“Тусгай хамгаалах байр” гэдэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд нөлөөлж болох этгээдүүдийн зүгээс тодорхой цаг хугацаанд шууд тусгаарласан, эсхүл эрж хайж олох боломжгүй, тухайн цаг үеийн шаардлага, аюулгүй байдлын бодит нөхцөл байдалд нийцсэн эрсдэлийн түвшин өндөртэй хохирогчийн аюулгүй байдлыг бүрэн хангахаар ажиллаж буй эрх бүхий байгууллагын тусгай хамгаалалтад байх байрыг хэлдэг.

Гэрч хохирогчийг хамгаалах жишиг өрөөг 2014 оны 10 дугаар сарын 7-ны өдөр одоогийн Баянзүрх дүүргийн анхан шатны шүүх дээр байгуулсан. Шүүх хуралдаанд хохирогчийг цахимаар оролцуулах төхөөрөмж бүхий хамгаалах өрөөнд ороход зөөлөн буйдан, сандал тавьж, хананд нь уран зураг өлгөжээ. Энэхүү өрөөнөөс тав тухтай байдал илт мэдрэгдэж байсан.

Хохирогч нарт гэртээ байгаа мэт амар, тайван орчинг бүрдүүлэх гэж ийнхүү тохижуулсан байна. Энэхүү өрөөнд мэргэжлийн баг ажиллаж хохирогчийг хамгаалах бөгөөд шүүгдэгчтэй нүүр тулахгүйгээр мэргэжлийн сэтгэл зүйч, хуульчийн зөвлөгөөн дор шүүх хуралд цахимаар холбогдож, мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлжээ. Тус өрөөнөөс нийслэл дэх шүүхүүд болон орон нутаг дахь аль ч шүүхтэй цахим хэлбэрээр шууд холбогдож, мэдүүлэг өгөх боломжтой бөгөөд хохирогчийн аюулгүй байдлыг бүрэн хангах бүхий л нөхцөлийг бүрдүүлсэн байна. Наад зах нь шаардлага гарвал хохирогчийн зүсийг хувиргах гоо сайхны хэрэгсэл, хиймэл сахал, үс хүртэл ашиглаж байлаа.

Тусгай техник хэрэгсэл: Тусгай техник хэрэгсэлд дохиолол хамгаалалтын, галын аюулын, дүрсний хяналтын, байршил тогтоогч, хаалганы цахим болон хурууны хээ мэдрэгч цоож зэргийг хэрэглэхээр журамд тусгасан. Хамгаалах хэрэгсэлд хутга, сумнаас хамгаалах хантаазыг хэрэглэхээр заасан байгаа. Одоогийн байдлаар бид биечилсэн хамгаалалтанд байгаа хүмүүстээ дохиолол хамгааллын хэрэгсэл ашиглан шуурхай дуудлагаар хүрч ажиллаж байна. Бусад хамгаалах техник хэрэгслэлээр хангах бэлтгэл ажлаа эхлүүлээд байна. Мөн "Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, хэрэглэх журам"-д гэрч хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний үед нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангахдаа гэрээ байгуулан тэдгээрийг хэрхэн ашиглах талаар заавал зөвлөгөө өгөх, ямар хугацаанд хэрэглэх, хэрэглэх хугацааг хэн тогтоох, мөн тусгай техник хэрэгслийн жагсаалтыг уг журмаар баталсан.

Хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад хэрэглэгдэх камер, машины хар хайрцаг, GPS, Гар бууны сум, хутганаас хамгаалах хантааз зэрэг тусгай хэрэгслийг худалдан авах ажил зохион байгуулагдсан. Үүний үр дүнд гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.15-д заасан тодорхой үйлдлийг хязгаарлах техникийн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Техникийн хяналтын төвийг байгуулан 2015 оны 05 сарын 27-ны өдрөөс ашиглалтад оруулаа. Тус техникийн хяналтын төвийг ашиглалтад оруулснаар байршил тогтоогч /GPS/, автомашины болон суурин хяналтын камераар хяналт тавьж гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах, 24 цагийн турш хяналтад авах, нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх, хуульд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж байна.

Насанд хүрсэн хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын

зөвшөөрснөөр аюулгүй газар түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Цагдаагийн харуул хамгаалалт бүхий газар, зэвсэгт хүчний анги нэгтэл, нутгийн захиргааны байгууллагатай хамтран байгуулах байранд түр байрлуулахыг зааж өгсөн нь нэлээд ач холбогдол бүхий заалт юм.

Хууль зүйн сайдаас аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2015 онд байгуулсан үр дүнгийн гэрээнд “Гэрч, хохирогчийг хамгаалах байрны асуудлыг шийдвэрлэх” талаар тусгагдсан. Хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй хохирогчийг түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт түр байрлуулна. Мөн хохирогчийг аюулгүй газарт байрлуулахдаа эрсдэлийн ямар түвшинд байгааг тогтоон хамгаалалтын арга хэмжээ авах ба хамгаалалтанд байх хугацаанд сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцааг мэргэжлийн баг үзүүлнэ. “Хохирогчдод эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”-д хамгаалуулагчид эрүүл мэндийн туслалцаа үйлчилгээг бүх шатны эрүүл мэндийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран үзүүлэхээр тусгагдсан бөгөөд хэрэв хамгаалуулагч эмнэлэгт хэвтэж, эмчлүүлж эмнэлгийн тусламж авах бол түүний аюулгүй байдлыг хамгаалалтад авсан байгууллага хариуцахаар заасан.

“Хамгаалах байр” гэдэг нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах үүднээс тодорхой цаг хугацаанд тусгаарласан, эсхүл эрж хайж олох боломжгүй, эрсдэлийн түвшин дунд эсвэл багаар тодорхойлогдсон хохирогчийг байрлуулах эрх бүхий байгууллагын болон төрийн бус байгууллагын харьяалалд байгаа байрыг ойлгоно. Хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулахдаа эрсдэлийн түвшинг харгалзан үзнэ. Тусгай хамгаалах байрыг Цагдаагийн алба, Авилгалтай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Мөрдөх алба байгуулан ажиллана.

Аюулгүй байдлын хамгаалалтыг цуцлах үндэслэл:

1. Хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчийн бичгээр гаргасан хүсэлтээр аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг цуцалж болно.

2. Хамгаалалтын арга хэмжээ авах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан, эсхүл түүний дээд шатны албан тушаалтны шийдвэрээр гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нөхцөл байдал арилсан тохиолдолд цуцална. Мөн хамгаалуулагч нь аюулгүй байдлын хамгаалалтын шаардлага, арга хэмжээг санаатайгаар удаа дараа зөрчсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтны санаачлагаар цуцална.

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогч нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх шийдвэрийн талаар гомдлоо 14 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана. Шүүх гомдлыг ажлын таван өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

Хохирогчид зөвхөн гэмт этгээдээс гадна цагдаагийн ажилтан, тэр дундаа эрүүгийн төлөөлөгч, өмгөөлөгч, сэжигтэн, яллагдагч түүнтэй холбоотой этгээдүүд нөлөөлдөг байна. Түүнчлэн хохирогч айдаснаас болж хувийн сэдэлтээр худал мэдүүлэг өгөх тохиолдол гардаг тул хохирогчид дараахь зорилгоор нөлөөлж, халдаж байсан.

- Сэжигтэн яллагдагч нь хэргийн зүйлчлэлийг өөрчлүүлэх, хэргийг өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг удаашруулах, саатуулах, хэргийг хэрэгсэхгүй болгуулах, үйлдсэн хэргээ бусдад тохих, эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх зорилгоор нөлөөлдөг.
- Цагдаагийн ажилтан буюу эрүүгийн төлөөлөгч нар нь гэмт хэрэг илрүүлэх үүргээ биелүүлэх зорилгоор нөлөөлдөг, халддаг.
- Өмгөөлөгч нарын хувьд үйлчлүүлэгчийнхээ эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх зорилгоор тус тус хохирогчид нөлөөлж халддаг нь судалгаагаар тогтоогдсон байна.

Ийм учраас хохирогчийн эрхэд сүрдүүлэх, дарамтлах, мөнгө өгөх, өгөхөөр амлах, хуурч мэхлэх, гуйх, ятгах, өрөвдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь заналхийлэх, эд хөрөнгөд нь халдах зэрэг хэлбэрүүдээр нөлөөлдөг ба эдгээр субъект тус бүрийн онцлогт тохирсон хамгаалалтын арга механизмыг бүрдүүлэх ёстой юм.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох хохирогчийн эрхийн хүрээнд анхаарах нэг асуудал бол нөгөө талтай эвлэрэх шалтгаан боломжийн талаар түүнд заавал мэдэгдэж зөвшилцөх

явдал юм. Үүнийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорууд орхигдуулж болохгүй. Энэ нь мэдээж хүнд биш гэмт хэрэг дээр яригдана.

Хохирогч нь өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй байдаг. Хэрэв хохирогч нь хэлгүй, дүлий, хараагүй зэрэг хөгжлийн бэрхшээлтэй буюу сэтгэцийн өвчтэй, насанд хүрээгүй, монгол хэл мэддэггүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь тухайн хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүргийг хүлээнэ. Насанд хүрээгүй хохирогчийг байцаахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлан өгч харин мэдүүлэг өгөхөөс татгалзах юм уу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахыг хориглоно.

Насанд хүрээгүй хохирогчийг нэг удаа байцаахдаа 2 цаг, өдөрт 4 цагаас хэтрүүлж болохгүй ба 2 цагаас илүү байцаах бол заавал завсарлана. Насанд хүрээгүй хохирогчийг байцаахдаа түүний эцэг, эх, хууль ёсны төлөөлөгч, эсвэл төрөл, садангийн хүн, түүнчлэн сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч энэ тухай тэмдэглэлд тусгана. Байцаалт дуусмагц мэдүүлэг зөв бичигдсэнийг баталж байцаалтад байсан хүнээр гарын үсэг зуруулна. Хүүхдийг байцаахдаа түүний эцэг, эх, төрөл, садангийн хүн, багш зэрэг хүмүүсийн аль нэгийг байлцуулна.

Сэжигтэн ямар хэрэгт сэжиглэгдэж байгааг тодорхойлох яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байгааг тодорхойлж хуулийн зүйл хэсгийг заана. 2 сар, хүндэвтэр, хүнд онц хүнд хэргийн яллагдагчийг цаашид хорих зайлшгүй шаардлагатай бол шүүх хугацааг сунгаж болно. Гэвч нийт хорих хугацаа 24 сараас хэтэрч болохгүй. 1 сар, цаашид Цагдан хорих хугацаа 14 хүртэл хоног, насанд хүрээгүй бол шаардлагатай бол хорьж мөрдөх нийт хугацаа 18 сараас хэтэрч болохгүй.

Сэжигтэн, яллагдагч нар нь өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Өөрийгөө өмгөөлөх гэдэг нь өөрийн нэрийн өмнөөс гомдол, хүсэлт гаргах, мөрдөн байцаалтын болон шүүх ажиллагаанд биечлэн оролцох, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрт учирсан хохирлоо гаргуулан авах хэлбэрээр хэрэгжиж байдаг онцлогтой.

1. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд шөнийн цагаар явуулахгүй байна.
2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахдаа гэмт хэргийн ул мөрийг илрүүлэх, түүнийг буулган авах, бэхжүүлэхдээ шинжлэх ухааны үндэслэл бүхий арга, техник хэрэгслэлийг ашиглана.
3. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулахдаа хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон бусад хууль бус арга хэрэгсэл хэрэглэх, түүнчлэн оролцогчдын эрүүл мэнд, амь насанд аюултай байдал бий болгохыг хориглоно.
4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг гагцхүү прокурорын зөвшөөрснөөр, түүний бололцоотой гэж үзсэн хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно.

Хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ: Улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгө, хандивлагч орон болон олон улсын байгууллагын тусламж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тусламж, бусад эх үүсвэрээс тус тус санхүүждэг байна.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: Үүнд: Ялгаварлан гадуурхахгүй байх, олон нийтийн оролцоонд тулгуурлах, хүртээмжтэй, хүрэлцээтэй байх, нууцлалыг хангах, оновчтой зохион байгуулалт, хөгжлийн шинэ хандлагыг нэвтрүүлэх.

Манай орны хувьд гэрч, хохирогчид туслалцаа үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд, нийгмийн бүлгүүдийн үүрэг, оролцоо тодорхой бус байгаа бөгөөд гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл систем үгүйлэгдэж байна. Мөн түүнчлэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг олон нийтэд сурталчлахаас гадна шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, цагдаагийн алба, төрийн захиргааны байгууллага

болон холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах зайлшгүй шаардлагатай байна.

Хүний эрхийн асуудал нь улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбартай шууд холбоотой учир Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил, хууль, хяналтын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажилласнаар гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх чиглэлээр тодорхой үр дүнд хүрэх юм.

Хохирогчийг хамгаалах тухай хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, шаардлагатай хууль тогтоомж, дүрэм, журам батлагдаж, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон улсын байгууллагын оролцоо нэмэгдэж, ажлын уялдаа сайжирна. Хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэхийн ач холбогдлын талаарх иргэд, олон нийтийн мэдлэг, ойлголт сайжирч, иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж хохирогчийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, чадавхи сайжирна. Хохирогчийг хамгаалах түр болон тусгай байрууд байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрч, хохирогчийг мэргэжлийн сургалт, нийгмийн үйлчилгээнд хамруулах тогтолцоо бүрднэ.

Хохирогч нь: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах эрхтэй байдаг. Давж заалдах шатан дахь хохирогчийн эрх, анхан шатны шүүхийн шийдвэр хохирогчийн эрх ашгийг хамгаалж чадаагүй бол хохирогч тухайн шүүхийн тогтоолыг гардаж авсан буюу танилцсанаас хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдлоо шүүхэд гаргах эрхтэй байдаг⁶³. Хэрэв давж заалдах гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол түүний шалтгаан, нотолгоог зааж хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтийг тогтоол гаргасан шүүхэд гаргаж болдог.

Хохирогчийн үүрэг: Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн дуудсанаар ирэх, өөрт илэрхий болсон хэргийн талаарх баримт сэлтийг задруулахгүй байх, хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх.

Татгалзан гаргах эрх нь: Тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгчийг оролцуулахгүй байх, тэдний чин шударга нь эргэлзээтэй байх үед хүсэлт гаргах хэлбэрээр хэрэгжинэ. Гэхдээ хуульд заасан дараахь үндэслэлийн аль нэг илэрсэн үед татгалзан гаргах хүсэлтээ гаргах ёстой.

Татгалзан гаргах үндэслэл: Нэгдүгээрт гэр бүлийн гишүүн байх, Хоёрдугаарт төрөл садангийн холбоотой байх, Гуравдугаарт шууд буюу шууд бусаар хувийн сонирхолтой байх зэрэг юм. Дээрх татгалзах хүсэлтийг хуульд зааснаар яллагдагч, сэжигтэн, өмгөөлөгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нар гаргах эрхтэй.

Хохирогч нь өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй байдаг. Хэрэв хохирогч нь хэлгүй, дүлий, хараагүй зэрэг хөгжлийн бэрхшээлтэй буюу сэтгэцийн өвчтэй, насанд хүрээгүй, монгол хэл мэддэггүй бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь тухайн хохирогчийг өмгөөлүүлэх бололцоогоор заавал хангах үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

Өмгөөлөгч сонгоход Монголын Өмгөөлөгчдийн Холбоо болон аймаг, нийслэлийн өмгөөллийн зөвлөлөөс гаргаж буй лавлах мэдээлэл, жагсаалтыг ашиглах нь зүйтэй. Өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах гэдэг нь тухайн сэжигтний эрх ашгийг хамгаалсан үр нөлөө бүхий заалт юм. Хохирогч өмгөөлөгчөө өөрөө сонгодог, хохирогчийн зөвшөөрснөөр буюу хүссэнээр түүний хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгчийг сонгон авч болно. Нэг этгээд хэд хэдэн өмгөөлөгчтэй байж болно. Хэрэв тэд өмгөөлөгчөө сонгон аваагүй бол хүсэлтээр нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд харин өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэрийг зааж тулгаж болохгүй.

⁶³ Бат-Эрдэнэ, Б. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги, УБ., 2005., х.35

Сонгосон өмгөөлөгч уг хэрэгт оролцох боломжгүй болсон, түүнчлэн өмгөөлөгчөөсөө татгалзсан бол өөр өмгөөлөгч сонгон авна.

Өмгөөлөгч нь дараахь хууль зүйн туслалцаа үзүүлнэ: Үйлчлүүлэгчийн тавьсан эрх зүйн асуудлаар амаар болон бичгээр зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийн холбогдох заалтаар лавлагаа гаргаж өгөх, өргөдөл, гомдол, гэрээ, хэлцэл зэрэг эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож, бичиж өгөх, иргэний хэрэг, захиргааны зөрчлийн хэргийг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэхэд үйлчлүүлэгчээ төлөөлөн оролцох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа болон эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд үйлчлүүлэгчийн өмгөөлөгчөөр оролцох, иргэд байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх, олон улсын шүүхийн байгууллага, бусад байгууллагад үйлчлүүлэгчийн сонирхлыг төлөөлөх.

Өмгөөлөгч нь өмгөөллийн үүрэг гүйцэтгэж байхдаа олж мэдсэн үйлчлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх, үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг ямар нэгэн үйлдэл хийхгүй байх үүргийг хуулиар хүлээдэг. Төлбөрийн чадваргүй хүн өмгөөлөгчөөс туслалцаа авах иргэний төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлохдоо Үндэсний статистикийн газраас гаргасан хүн амын амьжиргааны доод түвшинг үндсэн шалгуур болгоно. Өөрийгөө болон гэр бүлээ тэжээх сарын орлого нь хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээнд хүрэхгүйн улмаас байнгын хязгаарлагдмал хэрэглээтэй амьдардаг иргэнийг төлбөрийн чадваргүй өмгөөлүүлэгч гэж тооцдог.

Төлбөрийн чадваргүй иргэнийг хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээ эдлэхэд нь тусалж, Шүүхийн тухай хууль болон Өмгөөллийн тухай хуульд төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгайлсан заалт орсон байдаг. Хуульд зааснаар энэхүү санхүүжүүлтийг Монголын Өмгөөлөгчдийн холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина. Одоогийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 69 дүгээр тушаалаар баталсан “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан гаргах журам”-ыг мөрдөж байна.

Өмгөөлүүлэгч өөрөө төлбөрийн чадваргүй боловч түүний төрөл садан болон бусад байгууллага, иргэн өмгөөлүүлэгчид тусалж, өмгөөллийн хөлсийг төлсөн бол уг зардлыг төсвөөс давхардуулан олгохгүй байхаар журамд заажээ. Төлбөрийн чадваргүй иргэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө авах боломж бий.

Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг болон ёсчлон биелүүлэх үндсэн үүргийг тодорхойлсон ба “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” хэмээн заасан байдаг. Гэтэл зарим хүн нийгэмд биеэ зөв авч явж, хуулийг сахин биелүүлээгүйгээс гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл хүлээдэг. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж нь хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгө, төр, нийгмийн эрх ашигт хор аюул учруулж буйгаар илэрхийлэгдэнэ.

Хорих ялын зорилгыг хангах чухал хэрэгслийг үндэсний хууль тогтоомж, хууль зүйн практикт хорих ял эдлүүлэх дэглэм, нөхцөл болон хорих ял эдлүүлэх нэг үндэслэл болсон хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, төрөл, ялтан бие хүний хувийн онцлогтой холбон тодорхойлсноор хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хорих анги дотроо зохион байгуулдаг.

Гэмт хэрэг үйлдэгдсэн этгээд, гэмт хэргийн хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр тэдэнд нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний улмаас хохирогч сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох, хорих ангиас оргох, оргохыг завдах оролдлого хийх, эсвэл аль болох хурдан дэглэм дээшлэх зэрэг зохисгүй үйлдэл удаа дараа гарсаар байна. Энэ нь Хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нь нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, тэдэнд төрөөс нийгмийн халамж, туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалахад эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практик зайлшгүй хэрэгтэй болсоныг өнөөгийн нийгэм, Хохирогчийг хамгаалах тухай хууль, Хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын эрх зүйн үндсийг тодорхой болгох шаардлагатай болсныг харуулж байна.

Санал

1. Одоогийн дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, эрх зүйн акт, хорих ангийн дотоод журамд нэмэлт өөрчлөлтийг оруулах, тэр тусмаа хохирогчийг хамгаалах тухай хууль, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хорих анги, цагдан хорих байранд бүрэн хангуулах, Олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өөрчлөх замаар эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээлгэж, хохирлоо төлүүлэх эрх зүйн зохицуулалтийг бий болгох.

2. Хорих ял эдлүүлэх байгууллагын төрлийг нэг талаас гэм буруутай этгээдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, түүний нийгмийн аюул занал, нөгөө талаас хувь хүний шинж байдал, онцлог, засрал хүмүүжил нийгэмшилтэй уялдуулан нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх.

3. Хорих байгууллага нь хохирогч ялтныг тусгаарлан өөр хоорондоо харилцахгүй байх нөхцлөөр хорих ялыг нь эдлүүлэх зохицуулалт, хамгаалах байр, байгууламжийг бий болгох, энэ ажиллагаанд тавих прокурорын хяналтыг сайжруулах.

4. Хохирогчийг хамгаалах түр болон тусгай байрууд байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрч, хохирогчийг мэргэжлийн сургалт, нийгмийн үйлчилгээнд хамруулах тогтолцоо бий болгох. Хохирогчийн онцлогоос шалтгаалан хууль зүйн, сэтгэл зүй, эрүүл мэндийн туслалцааны цогц үйлчилгээ үзүүлдэг олон улсын жишиг загварыг нэвтрүүлэх асуудлыг судлаж практикт нэвтрүүлэх гэх мэт.

Ашигласан материал

Монгол Улсын хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль
3. Гүйцэтгэх ажлын тухай хууль
4. Эрүүгийн хууль

Ном сурах бичиг, гарын авлага

5. Нямсүрэн, Ч. Гэмт хэргийн виктимологи, УБ., 2005
6. Нямсүрэн, Ч. Эрх зүй, төрийн ерөнхий онол, УБ., 2004
7. Бат-Эрдэнэ, Б. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн ерөнхий анги, УБ., 2005

Сэтгүүл, эмхтгэл:

8. Хүний эрх ба Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхэтгэл, Шүүх эрх мэдэл дэхь хүний эрх, УБ., 1998
9. Төрийн мэдээлэл. УБ. 1992., №01
10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал. УБ., 2015., №01

Цахим эх сурвалж:

11. <http://www.zasag.mn/>

Судалгааны тайлан, мэдээ

12. Хохирогчийн эрхийн судалгааны төв UNDP судалгааны тайлан, Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний тогтолцоог бий болгох асуудал, УБ., 2010
13. Цагдаагийн ерөнхий газрын, Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн жилийн эцсийн тайлан, УБ., 2016.
14. Тахарын ерөнхий газар, Гэрч, хохирогчийг хамгаалах газрын тайлан, УБ., 2015

МОНГОЛ УЛСЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ЭРҮҮГИЙН ХУУЛИУДЫН
УЯЛДАА ХОЛБООНЫ УЛАМЖЛАЛ
VIOLATION LAW AND CRIMINAL LAWS OF MONGOLIA
THE TRADITION OF THE UNION

Б.Наргулан

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, цагдаагийн дэд хурандаа

Nargulan.B

Senior teacher of police Law department,
Police school of University of Internal Affairs,
Police major

Хураангуй: Гэмт хэргийн үндсэн шалтгааны нэг болох нийгмийн дэг журмыг хангах, захиргааны зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар хууль тогтоогчид анхаарал хандуулж байгаа ч тухайн салбарын эрдэмтэн, судлаачдын онолын үндэслэлтэй санал, дүгнэлтийг бүрэн тусгаж чадахгүй байгаагаас нэгэнт батлагдсан хууль тогтоосон хугацаанд хэрэгжихгүй хойшлогдож, дахин шинэчилсэн найруулга хийх шаардлага тулгарч байгаа нь алдаа дутагдалтайг харуулж байна. Иймд гэмт хэрэг, зөрчил хоорондоо хэрхэн харилцан уялдсан байдлыг судлах судалгааны ажлын хүрээнд гэмт хэрэг болон зөрчлийн уялдаа холбоог тодорхойлж цаашид боловсронгуй болгох талаар та бүхэнтэй өөрийн санал бодлыг хуваалцах талаар авч үзлээ.

Abstract: Legislators are paying attention to improving the legal regulations for maintaining social order and combating administrative violations, which is one of the main causes of crime. The need for re-editing shows that there are flaws. Therefore, as part of the research work to study how crimes and violations are interconnected, I have decided to share my opinion with you on how to further refine the relationship between crimes and violations.

Түлхүүр үгс: Зөрчлийн хууль, Эрүүгийн хууль, түүхэн уламжлал, уялдаа холбоо, төрөлжсөн хууль

Key words: Conflict law, Criminal law, historical tradition, coherence, specialized law

Үндсэн хэсэг: инэчлэн батлагдсан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхлээгүй боловч эрдэмтэн, багш, судлаачдын дунд маргаантай ойлголт багагүй байгаа тул уялдаа холбоог боловсронгуй болгох шаардлагыг бий болгож энэхүү судалгааны ажлын үндэслэлийг тодорхойлж байна.

Хүн төрөлхтний өмнө байнга тулгамдаж байдаг асуудлуудын нэг бол яах аргагүй гэмт явдал бөгөөд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх нь төрийн дотоод чиг үүрэг болдог. Төр нь эрүүгийн бодлогыг тодорхойлж хуульчлан баталгаажуулснаар хэрэгжих нөхцөл нь бүрдэнэ.

Эрүүгийн бодлого гэдэг нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох, оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, эсхүл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үр өгөөжтэй арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм⁶⁴.

⁶⁴С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2002.24дэх тал

Эрүүгийн бодлого нь иргэн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулдаг нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдалтай хийх тэмцэл, нийгмийн дэг журмыг сахиулах үйл ажиллагааны үндсэн чиглэл, арга замыг тодорхойлдог.

Эрүүгийн болон Захиргааны эрх зүй, Криминологийн шинжлэх ухаанууд нь гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, хандлага, шалтгаан нөхцөл зэргийг судлах замаар төрөөс гэмт хэрэгтэй хийх тэмцлийн бодлогыг хэрэгжүүлэх өөрөөр хэлбэл Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулиудын үйлчлэх үр нөлөөг дээшлүүлэх арга замыг судлан шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын практик ажиллагааг боловсронгуй болгох талаарх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Нийгмийн хөгжлийн шаардлагаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал нь тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц бөгөөд энэ асуудал нь зөвхөн хууль тогтоомжийг шинээр батлах, тэдгээрт зохих нэмэлт өөрчлөлт оруулах төдий асуудал биш нэгэнт батлагдсан хуулийг амьдралд хэрэгжүүлэх, хуулиудын хоорондын уялдаа холбоог хангах явдал чухал юм.

Монгол Улсын Эрүүгийн болон Захиргааны эрх зүйн уялдаа холбооны тухай асуудлыг Эрүүгийн эрх зүйн болон Захиргааны эрх зүйн чиглэлээр гарсан сурах бичгүүдэд тодорхой хэмжээнд авч үзсэн⁶⁵байх боловч Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн уялдаа холбооны уламжлалыг судалсан нь үгүй байна.

Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж нь 1926 оны Шүүх цаазын бичгээс эхтэй хөгжлийн адармаатай түүхэн замналыг туулж иржээ. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн өмнө 1926, 1929, 1936, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хуулиуд үйлчилж байснаас үзэхэд энэ хууль нь 8 дахь нь бөгөөд ардчилсан төрийн эрүүгийн бодлогын илэрхийлэл юм.

Түүнчлэн Монгол Улсад 1993 он буюу Захиргааны хариуцлагын тухай хууль батлагдах хүртэл захиргааны янз бүрийнхүчин чадал бүхий олон төрлийн хууль тогтоомж, эрх зүйн актаар захиргааны хариуцлага хүлээлгэж байв. Тэдгээрийгхууль, БНМАУ-ын АИХ-ийн тэргүүлэгчдийн зарлиг, СНЗ-ийн тогтоол, Ороннутгийн АДХ-ийн заавал биелүүлэхшийдвэр⁶⁶ээрэг эрх зүйн актаар зохицуулж иржээ.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр захиргааны албадлагын арга хэмжээ,түүний дотор шийтгэлийн төрөл хэмжээг нарийвчлан тогтоож захиргаанызөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах болсон юм⁶⁷.

д/д	Эрүүгийн хуулиудын батлагдсан огноо	Захиргааны хариуцлагын тухай хуулиуд, батлагдсан огноо
1	Шүүх цаазын бичиг 1926.11.11	- БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн зарлиг. - СНЗ-ийн тогтоол. - Орон нутгийн АДХ-ын заавал биелүүлэх шийдвэр
2	Шүүх цаазын бичиг 1929.09.23	
3	Шүүх цаазын бичиг 1934.05.24	
4	Эрүүгийн хууль 1942.01.17	
5	Эрүүгийн хууль 1961.01.31	
6	Эрүүгийн хууль 1986.12.05	
7	Эрүүгийн хууль 2002.01.03	Захиргааны хариуцлагын тухай хууль 1992.11.27
8	Эрүүгийн хууль 2015.12.03	Зөрчлийн тухай хууль 2015.12.04

⁶⁵Г.Совд. БНМАУ-ын ЭЭЗүйн курс.Ерөнхий анги. УБ., 1973. 15-16 дахь тал, С.Нарангэрэл. Монгол Улсын ЭЭЗ.Ерөнхий анги. УБ., 1999. 8-9 дэх тал, С.Жанцан. Монгол Улсын ЭЭЗүй Ерөнхий анги. УБ., 2002. 11 дэх тал

⁶⁶Ж.Долгорсүрэн. Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль тогтоомжийн өнөөгийн байдал, чиг хандлагын тухай. Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ., 2010. №1. 5 дахь тал

⁶⁷Ж.Долгорсүрэн. Захиргааны хариуцлага. УБ., 1998. 14 дэх тал

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 7 бүлэг 40 зүйлтэйгээр, тусгай ангийг 24 бүлэг 187 зүйлтэйгээр батлан гаргаж хэрэгжүүлсэн энэ түүхэн цаг мөчөөс эхлэн Монгол Улсын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр зохицуулах болсон нь түүхэн ач холбогдолтой үйл явдал юм

Профессор Г.Совд "Манай анхны Эрүүгийн хуульд Зөвлөлтийн эрүүгийн хуульд тусгагдсан хувьсгалт эрүүгийн хуулийн ардач, намч зарчим, эрүүгийн бодлогын хамгийн шударга журмыг үлгэр дууриал болгон тусгахын зэрэгцээгээр өөрийн орны хууль цаазын үндэсний уламжлал, ардын зан заншил, ардчилсан хувьсгалт төр, нийгмийн хөгжлийн өвөрмөц онцлогуудыг тусгаж чадсан юм"⁶⁸ гэж анхны нэгдсэн Эрүүгийн хуулийн ач холбогдлыг өндөр үнэлсэн нь үндэслэлтэй юм.

1926 оны Шүүх цаазын бичгийн 17 дугаар бүлгийн /Ард олны хэв суртлыг зөрчих нь/122 дугаар зүйлд "Аливаа хүн дүрсгүйтэн авирлаж, ард олны хэв суртлыг үл хүндэтгэн дагагсдыг 1 жил хүртэл гяндан хорих буюу 600 төгрөг хүртэл торгоно", 130 дугаар зүйлд "Аливаа хүн архи ууж хэтэрхий согтууран олны хуран цугларсан газруудаар явбаас 14 хоног гяндан хорих буюу 25 төгрөг хүртэл торгоно" гэж тус тус заасан нь гудамж талбай, олон нийтийн газар биеэ зүй бус авч явах, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг зөрсөн, мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан хүнд захиргааны хариуцлага оногдуулах эхлэлийг тавьж өгсөн гэж үзэхээр байна.

Шүүх цаазын бичгийн тайлбарт "Аливаа цааз хууль дор заасан эл явдлыг гэмт хэрэг дор тооцвоос зохино" гэмт хэргийн тодорхойлолтыг анх удаа өгсөн байдаг боловч гэмт хэргийн тухай ямар ч хуульд зааж болохоор агуулгатай байгаа нь учир дутагдалтай байжээ.

"Аливаа гэмт явдлыг үйлдэхдээ зориуд санаагүй эндэгдэн ташаарсан буюу, эцэстээ гэм гарахыг үл мэдсэн ба мэдсээр боловч зогсоохыг завдаж чадсангүй учир илэрвэл санаатайгаар үйлдсэн ёсоор яллаж үл болно" гэж хор уршгийг гэм буруугүйгээр эсхүл ташаарч учруулсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр заасан нь дэвшилттэй юм. Мөн түүнчлэн 21-р зүйлд "Аливаа хүн оногдсон албан тушаалыг болон харьяалах эрх баригчдын өгсөн тушаалыг хуулийн дагуу ёсоор гүйцэтгэж гэм учруулсан"⁶⁹, 22-р зүйлд "мөн түүнчлэн өөрийн буюу бусдын амь ба биеийг бусад эрх чөлөөг хамгаалахын тулд үйлдсэн хэрэг нь /аргагүй хамгаалат/ хэр хэмжээнээс хэтрээгүй бол тус тус ял хэлэлцэхгүй гэж нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудыг анх удаа хуульчилсан байна.

Монгол орныг капиталист бус замаар хөгжүүлэх талаар МАХН-ын V, VI их хурлуудаас дэвшүүлсэн зорилтыг шийдвэрлэх, улс оронд бий болсон дотоод гадаад хурцадмал байдлыг намжаах чухал нөхцөл болох хувьсгалт хууль ёсыг улам бэхжүүлэх, аливаа дайсагнасан үйл ажиллагааны эсрэг үр дүнтэй тэмцэл явуулах зорилгоор хууль цааз, тэр тусмаа эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгож, түүнд тухайн үед дэвшигдэн гарч ирсэн нийгэм, улс төр, эдийн засгийн шаардлагыг аль болох бүрэн тусгах шаардлага зүй ёсоор тулгарсан учир 1929 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Засгийн газрын 30 дугаар хурал, Улсын XIV бага хурал, Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулж батлан мөрдөж эхэлсэн.

1929 оны шүүх цаазын бичиг нь бүтэц агуулгын хувьд өмнөх хуулиас ялгагдах үндсэн өөрчлөлтгүй боловч гэмт хэрэг, ялын тухай асуудлын онолын үндэслэлийг улам боловсронгуй болгох, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлүүдийг бүрэн тусгах замаар нийгэм, иргэдийн эрх ашгийг эрүүгийн хуулийн хамгаалалтад авах зорилтыг хангасан гэж үзэж болохоор байна. Энэ үүднээс 1929 оны хууль нь хэд хэдэн зарчмын шинжтэй өөрчлөлт шинэчлэлийг агуулж байжээ. Тухайлбал "Энэхүү цааз бичиг дор заасан аливаа явдлыг гэмт хэрэг дор тооцвоос зохимой" гэж гэмт хэргийг зөвхөн эрүүгийн хуульд заасан байх хууль цаазын чухал шинжийг тодотгож өгсөн. Мөн хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан хүмүүс, хөхүүл хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйд цаазаар авах ял хэрэглэж болохгүй, гэмт хэрэг үйлдсэн 14 хүртэлх насны /өмнөх хуульд 10 хүртэлх гэж байв/

⁶⁸Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс(ерөнхий анги). УБ., 1973. 57 дахь тал

⁶⁹Тушаал, захирамж биелүүлж, бусад хохирол учруулахыг 2002 оны Эрүүгийн хуульд үйл явдлыннийгмийн хор аюулыг үгүйсгэх бие даасан нөхцөл байдал болгон заав.

багачуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй зарчмын шинжтэй энэрэнгүй агуулгатай өөрчлөлт оруулжээ.

Цэргийн гэмт хэргийг 228-253-р зүйлүүдэд заагаад цэргийн газарт ажиллаж буй энгийн хүмүүс субъект байхаар хуульчлав⁷⁰.

Монголын ардын армийн байлдааны хүчин чадал, цэргийн сахилгыг бэхжүүлэх, байлдааны бэлэн байдлыг хангах бодит шаардлагатай уялдан Ардын засгийн газраас 1930 оны 10 дугаар сарын 22-нд 1929 оны шүүх цаазын бичигт "Цэргийн гэмт хэргийн тухай" 31-р бүлгийг нэмсэн. Мөн 1934 оны 03 дугаар сарын 02-ны Ардын сайд нарын зөвлөлийн 4 дүгээр хурлаар 30-р бүлгийг "Төр шашныг тусгаарласан тухай хууль дүрэм" гэж өөрчлөн найруулж баталжээ. Энэ өөрчлөлтөөр тус улсын аливаа сургуульд шашны ном заах, шашны явдалд албадан бадарлах, татвар хураах, шинээр дуган сүм барих, 18 хүрээгүй хүмүүсийг лам болгох, улсын ба олон нийтийн зэрэг албан ба үйлдвэрийн газруудад шашны ёслол явуулахаар лам нарыг хурал ном үйлдүүлэх явдлыг гэмт хэрэг гэж үзэж ял шийтгүүлэхээр нэмэлт оруулсан байна.

Уг шүүх цаазын бичгийг өөрчлөх болсон шалгааны тухайд "Элдэв гэмт хэргүүдийг бүлэг бүрийн зохих зүйлүүдэд хутгалдуулан бичсэн, хувьсгалд тэрсэлсэн гэмт хэргүүдийг хэдэн бүлэг болгон бичсэнээс гадна аж ахуйн ба албан тушаалын ялангуяа хурыцлын гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан зэрэг дутагдлууд гарсан учир 1934 онд шинэчлэн зохиож өөрчлөн найруулсан байна⁷¹. Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 1934 оны 05 дугаар сарын 04-нд Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөн сарын 24-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас 6 бүлэг 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр нь 1934 оны 8-р сарын 24-нд Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөн оны 10-р сарын 8-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас тус тус батлан гаргажээ.

1934 оны Шүүх цаазын бичигт анх удаа түүний зорилтыг "Шүүх цаазын бичиг зарласан нь Ардын хувьсгалт засаг ба улс хийгээд тогтоосон хэм хэмжээнд харшлах олон нийтийн дор аюул бүхий хэргүүдээс хамгаалах зорилготой бөгөөд тийнхүү хамгаалахдаа уул үйлдсэн хүмүүст энэ шүүх цааз бичигт заасан ёсоор шийтгэх ялуудыг хэрэглэмой" гэж өмнөх хуульд байгаагүй зорилтыг тодорхойлжээ. Энэ нь тэр үеийн эрүүгийн улс төрийн бодлогын гол чиглэл юм. Хоёрдугаар бүлэгт, Шүүх цаазын бичгийг журамлах явуулах хэмжээ хязгаарыг /нутаг, дэвсгэр хамаарах этгээд/ хуульчилсан. Тухайлбал, энэ хуулийн хэм хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн дотоод, гадаадын бүх хүмүүст болон бүх хязгаар нутагт үйлчилнэ. Тус улсын засгийн газраас өөр улстай гэрээ ёсоор халдаж болохгүй эрхтэй хүмүүст үл хамаарна гэж заасан. Хуулийг буцаан хэрэглэх үндэслэл, журмыг тодорхой болгосон байна.

Шүүх цаазын бичгийн ерөнхий үүсэл хэмээх 3-р бүлгийн 4-р зүйлд "Эдүгээ оршин буй төрийн байгууллагын үндсийг тэрсэлсэн буюу ардын хувсгалт засгаас тогтоосон эрх зүйн хэмжээг зөрчин үйлдсэн буюу эс үйлдсэнээр олон нийтэд аюултай явдал үүссэнийг гэмт хэрэг гэнэ" гэж тодорхойлсон байна. Энд анх удаа гэмт хэрэг боловч үнэхээр ялимгүй гэм хор үл болох аваас гэмт хэрэгт тооцохгүй гэж заав. Ял шийтгэх явдал нь хүний бие махбодийг зовоох ба хүн хэмээх нэр алдрыг доромжлох зорилго байж болохгүй гэж энэрэнгүй ёсны илрэл хуульчлагдсан нь тэр үедээ туйлын дэвшилттэй заалт байв. Мөн анх удаа гэм буруугийн хэлбэр, шалгууруудыг заасан эрүүгийн хууль хэрэглэхэд ач холбогдолтой болсон юм. Архи ууж согтуурсан байдалд гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй гэж заасан. Шүүх цаазын бичигт ял хөөн хэлэлцэж болохгүй үндэслэл, гэмт хэрэгт хамтран оролцогсдын тухай, субъектын насны хязгаар /16 нас/, санаатай гэмт хэргийн үе шат зэрэг асуудлуудын эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгосон юм.

Шүүх цаазын бичгийн 10-р зүйлд уг хуулийн тусгай ангид шууд заагаагүй үйлдэлдтөсөөтэй зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заалт хуульчлагдан хэрэгжих болсон нь хууль ёсны зарчим алдагдахад хүргэсэн энэ хуулийн учир дутагдалтай тал юм.

⁷⁰Б.Баярсайхан. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн товчоон. УБ., 1911-2008. 87 дахь тал

⁷¹Монголын эрт, эдүүгээгийн хууль цаазын түүхэн сэдэв дэвтэр. УБ., 1936. 129 дэх тал

Хорих ялын хугацааны доод хязгаар 1929 оны хуульд нэг өдрөөс эхэлж байсан бол нэг сар болгосон. Шүүхийн цаазны бичгийн 5-р бүлэгт ял оногдуулах журмыг заагаад удирдлага болгох зарчмуудыг шинээр тогтоож ял оногдуулахдаа гэмт хэргийн хор аюул, субъектын хувийн зангаар, ял хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөлбайдлуудыг харгалзах, насанд хүрээгүй болон өтөл насны хүмүүст оногдуулах ялыг хөнгөвчлөх, хуульд заасан хэмжээнээс доогуур ял оногдуулах ба өөр төрлийн хөнгөн ял оногдуулах, шүүхээс оногдуулсан хорих ба албадан ажил хийлгэх ялыг гүйцэтгэхийг түдгэлзүүлэх, тэнсэх, хорих ялын хугацаа дуусахаас өмнө суллан тавьж тэнсэх, ял шийтгэлгүйд тооцох үндэслэл, журмыг шинээр хуульчилсан нь бүх талаар дэвшилттэй, эрүүгийн эрх зүйн онолыг хөгжүүлэхэд ач холбогдолтой болсон юм.

Сайд нарын зөвлөлийн 1936 оны 12-р сарын 4-ний 45-р тогтоол, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн мөн сарын 11-ний 57-р тогтоолоор шүүх цаазын бичгийн 6-р бүлгийн 128-р зүйлд нэмэлт оруулан, жирэмсэн эмэгтэйчүүдийн хүүхдийг санаатайгаар устгагчид, авагчид, авхуулагчид болон төрүүлсэн хүүхдээ хаяж орхигчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр болов. Сайд нарын зөвлөлийн 1937 оны 3-р сарын 19-ний 9-р хурал, Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн мөн оны 4-р сарын 9-ний өдрийн 16-р хурлаар энэ хуулийн 60-р зүйлд тээврийн жолооч нараас дүрэм заавар зөрчиж, тээж нэвтрүүлэх зүйлүүдийг гэмтээсэн буюу хүний биеийг дайруулах, гэмтээх явдал гаргасан бол таван жил хүртэл хорих, мөн явдлуудыг үйлдэхдээ онц их хохирол сүйтгэл учруулсан ба хүний амь бусниулсан бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих буюу хүндрүүлэх шалтгаантай бол буудан алах ял оногдуулахаар зааж байв.

Сайд нарын зөвлөлийн 1939 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Феодалыц үлдэгдэл ба ялангуяа үндэс угсааны өшөө хонзон хадгалах явдалтай тэмцэх арга хэмжээний тухай" тогтоолын заалтыг биелүүлэх үүднээс 1934 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангид нэмэлт, өөрчлөлт оруулснаас олон эхнэр авах, эхнэр авахаар эцэг эх болон төрөл садан, бусад этгээдэд бэлэг хүргэх, авах, эмэгтэйчүүдийг гэрлүүлэхээр албадан хавчих, хүслийн эсрэг гэрлүүлэх, дээр дурдсан зорилгоор эмэгтэйчүүдийг хулгайлах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцжээ⁷².

МАХН-ын XV их хурлаас баталсан намын программ-д "1940 он хүрэхэд БНМАУ-ын ардын хувьсгалын анхны шат үндсэндээ төгсөж, ардчилсан хувьсгалаас социалист хувьсгалд аажмаар дэвшин орох үе эхэллээ"⁷³ гэж дүгнэсэн байдаг. 1940 онд БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөн зохиож, түүнтэй уялдуулан 1942 оны 01-р сарын 17-нд Улсын XXV Бага Хурлаас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг 6 бүлэг, 54 зүйл, тусгай ангийг 10 бүлэг 165 зүйлтэйгээр батлан гаргажээ. Энэхуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг, сонирхлыг хамгаалалтад авсан бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулбал тогтолцоо, бүтцийн хувьд илүү боловсронгуй болжээ.

Эрүүгийн хуулиар ард иргэдийн эрх чөлөө, ялангуяа хувийн өмчийн эрхийг хамгаалах болсон нь бүх талаар дэвшилттэй байжээ. Эрүүгийн хуулийн 2-р бүлэгт манай улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдсэн гадаадын харьяат хүмүүс энэхүү хуулиар шийтгэгдэх болсон. Тус хуулийн 13-р зүйлийн тайлбарт хувьсгалын эсэргүү гэмт хэрэгт хөөн хэлэлцэх явдал хамаарахгүй гэж заасан. Энэ бүлгийн 15-р зүйлд "Энэхүү эрүүгийн хуульд шууд үл заагдсан ямар нэгэн гэмт хэрэг гарвал мөнхүү хуулийн тусгай ангийн зүйлүүдээс тэрхүү үйлдсэн гэмт хэргийн төрөл ба зүйлд хамгийн төсөөтэйг баримтлан зохих ялын хэмжээг тогтоовол зохино" хэмээн урьд хуулинд байсан төсөөтэй хэрэглэх явдлыг хуульчилсан нь дутагдалтай юм. Гэмт хэрэг санаатай үйлдэх үе шатны болон гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрүүдийг улам боловсронгуй байдлаар хуульчилсан. Цэргийн албан хаагчаас эх орноосоо урвах явдалд бэлтгэж байгааг мэдсээр байж засгийн байгууллагад үл мэдээлсэн, тусалсан гэр бүлийн насанд хүрсэн хүмүүст ял оногдуулахаар болсон нь оновчтой бус заалт юм.

1942 оны Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлгийн /Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бусад гэмт хэргүүд/ 97 дугаар зүйлд "Олны хэв суртлыг илт үл хүндэтгэн зүй бусаар авирлаж танхай балмад явдлыг үйлдэхэд онц дүрсгүйгээр догшин авирлаж зүй бус маяг гаргах буюу уул явдлыг

⁷²Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971. 52-56 дахь тал

⁷³МАХН-ын программ. УБ., 1966. 11 дэх тал

дахин үйлдсэн, эсвэл нийтийн журмыг сахиж байгаа байгууллагуудаас сануулсаар атал уул явдлаа эрс зогсоогоогүй буюу уул үйлдсэн явдлыг онц жигшүүртэй муухайгаар үйлдсэн байвал таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэвэл зохино" гэж зааснаас хойш 17 жилийн дараа буюу 1959 онд "Олон нийтийн хэв ёсыг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх тухай"⁷⁴ АИХТ-ийн 127 дугаар зарлигийн 1-р зүйлд "Олон нийтийн хэв ёс, тайван байдал, тогтоогдсон журмыг гажуудуулж ноцтой бус жижиг зөрчил гаргасан 16-аас дээш насны хүмүүст уул зөрчлийн үйлдлийнх нь байдлаар буруушааж сануулах, олон нийтийн өмнө донгодох, 200 төгрөг хүртэл торгох, 5-аас 30 хоног хүртэл албадан хөдөлмөр хийлгэх арга хэмжээг захиргааны журмаар авч байх ..." гэж заасан нь үйлдийн шинжээр нь гэмт хэргээс ялгасан байна.

Дээрх зарлигийг биелүүлэх тухай зааврын 1-р зүйлд "Олон нийтийн хэв ёс, тайван байдал, тогтоогдсон журмыг гажуудуулах, засаг захиргааны байгууллагаас энэ талаар гаргасан заавал биелүүлэх шийдвэрийг үл биелүүлэх зэрэг хэлбэрээр албан, үйлдвэр, олон нийт, үйлчилгээний газрууд болон гудамж талбай, нийтийн байр зэрэг олны цугларсан газруудад боловсон бус зохисгүй байдал гаргаж, хүмүүсийнтайвнаар хөдөлмөрлөх, амрах, сурах, үзвэрийн газарт явж зорчих зэрэгт саад учруулсан элдэв хэлбэрээр танхайрах, нийтийн тайван байдлыг алдагдуулах зэрэг социалист зан суртахуунд харштай жижиг зөрчил гаргагчид энэ зарлигт хамаарна" хэмээн нийгмийн дэг журмыг тогтоож өгсөн боловч "элдэв хэлбэрээр танхайрах" гэсэн нь гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэлтэй, хуулийг төсөөтэй хэрэглэх үндэслэлтэй байсан гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1960.10.20-ны өдрийн 198 дугаар "Ууж согтуурах явдалтай тэмцэх тухай"⁷⁵ зарлигаар согтууруулах ундаа хэрэглэх, худалдахыг хориглосон газруудыг зааж өгсөн байна. Үүнд:

- Улсын олон нийт, албан үйлдвэрийн ажлын газар, нийтийн орон сууц, цэргийн байр, гуанз, хүйтэн хоолны газар, халуун ус, эмнэлэг, амралт, сувиллын газар, театр, кино, клуб, улаанбулан, соёлын ордон зэрэг олон нийт, соёл гэгээрлийн газар архи дарс худалдах ба уухыг,

- Дэлгүүр мухлаг, гудамж талбай, цэцэрлэг, зах зээлийн газар архи дарс уухыг,

- 18 насанд хүрээгүй буюу согтуу хүнд архи дарс, пиво худалдахыг,

- Хүнсний комбинатын сүү тосны завод, сангийн аж ахуй, хөдөө аж ахуй нэгдлүүдэд шимийн архи үйлдвэрлэхийг зогсоож, мөн шимийн архи худалдахыг,

- Ууж согтууран хэвийн бус байдлаар яваа хүнийг урлаг үзвэр, олон нийтийн үйлчилгээний газар оруулахыг тус тус хориглон зааж, зөрчсөн гэм буруутай этгээдэд 25-аас 100 төгрөг хүртэл торгох шийтгэл ногдуулахаар заасан байна. Мөн ууж согтууран хэвийн бус байдлаар гудамж талбай, зах зээл, нийтийн үйлчилгээний авто тээвэр, галт тэрэг, албан үйлдвэр, олон нийтийн газраар яваа хүнийг эрүүлжүүлэх байранд 24 цагаас хэтрүүлэхгүй байлгаж, энэ тухай уг этгээдийн харьяалагдах байгууллагад нь мэдэгдэх, ууж согтууран олон нийтийн хэв журам зөрчсөн гэр бүлийнхээ хүмүүст хэрцгий зан авир гаргаж, түгшүүр төрүүлсэн этгээдийг олон нийтийн шүүхэд шилжүүлэх буюу 25-200 төгрөгөөр торгох, архины өвчтэй хүнийг эмчийн актын үндсэн дээр эдгэртэл нь шүүхийн магадлагаагаар нийтийн журмаар буюу тусгай байранд байлган эмчлэх, эмчлүүлэхээс зайлсхийгсдэг 200-аас 500 төгрөгөөр торгохоор заасан нь согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн хүнтэй хийх тэмцлийг эрчимжүүлж, түүнийг засан хүмүүжүүлэх талаар авах арга хэмжээг тогтоож өгсөн байна.

1960 оны Үндсэн хуулийн дагуу хууль тогтоомжийг шинэчлэн өөрчлөх үйл явцын дагуу 1961 оны 01 дүгээр сарын 31-нд баталсан Эрүүгийн хууль нь ямар нэг хэмжээгээр хууль ёс, ардчилал, шударга ёсны зарчим дээр суурилсан хүний эрхийг бүрэн хасах, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх тухай урьд хуулийн үзэл баримтлалууд хасагдсан боловч тэр үеийн нийгэм, эдийн засгийн байгууламжийн гол агуулга болох захиргаадалт дэглэм, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, нэг намын тунхаглалын шинжтэй үзэл сурталыг хэрэгжүүлэх гол үндэс болсон. Тус хуульд ууж

⁷⁴БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. УБ., 1959. №3. 9 дэх тал

⁷⁵БНМАУ-ын хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл. УБ., 1961. №4.

согтуурснаас бусдын амь бие, эрүүл мэндэд, хүнд хор хүргэсэн, бусдыг гүтгэсэн хэрэгт ял шийтгэл оногдуулахдаа хүндрүүлж үзэх шалтгаан болгон заасан.

1961 Эрүүгийн хуулинд заагаагүй зарим үйлдэл, эс үйлдэлд БНМАУ-ын АИХТ-ийн зарлигаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хор аюулаар бага, давтагдан үйлдэгдэх шинжтэй зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэхээр зааж байжээ. Тухайлбал: "Ойн ба хээрийн түймэр тавигчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай"⁷⁶ АИХ-ийн төлөөлөгчдийн зарлигийн 1-р зүйлд сэрэмж болгоомжгүйгээс гал түймэр алдсаны улмаас ой мод, бэлчээр, улс, хоршоолол, иргэдийн хөрөнгө үлэмж хэмжээгээр сүйрсэн буюу хүний эрүүл мэнд, амь биед хор аюул учирсан бол ял оногдуулж байсан байна.

Эрүүгийн хуулийн 123-р зүйлийн а)-д "Ой модыг хууль бусаар огтолсон, устгасан буюу гэмтээнээс болж учирсан хохирол нь хэрэв захиргааны арга хэмжээнээс хэтэрсэн байвал 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу таван зуун төгрөг хүртэл торгоно"⁷⁷ гэж учирсан хохирлоос нь хамаарч ялган зүйлчилдэг байсан байна. Харин 1957 онд "БНМАУ-ын ойг арчлан хамгаалж хөгжүүлэх ба ашиглах журмын тухай"⁷⁸ АИХТЗ-ийн 4-р бүлгийн /Ойн хуулийг зөрчих явдалд оногдох хариуцлагын тухай/ 33-р зүйлд ойгоос зөвшөөрөлгүйгээр мод огтолбол хүлээлгэх захиргааны шийтгэлийг зааж өгсөн байжээ.

Танхайрах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 169 дүгээр⁷⁹ зүйлийн 169.а-д "Олон нийтийг илтэд хүндэтгэн үзэхгүй, нийтийн хэв ёс, хамтын аж байдлын социалист хэв журмыг санаатайгаар зөрчсөн бол 1 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 500 хүртэл төгрөгөөр торгоно", б-д "Энэ гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн буюу засгийн төлөөлөгч, нийтийн хэв журам сахиулж байгаа хүнийг эсэргүүцсэн, эсхүл онц жигшүүртэй дүрсгүйтэж догшин авирласан буюу танхайрсан хэрэгт шийтгэгдсэн этгээдээс үйлдсэн бол уг нутгаас зайлуулах буюу зайлуулахгүйгээр 4 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ" гэж заасан бол АИХ-ийн тэргүүлэгчдийн 1961 оны "Олон нийтийн хэв журам эвдэж танхайрагчдад хариуцлага хүлээлгэж байх тухай"⁸⁰ зарлигт "... ард иргэдийн амгалан тайван байдал, тогтоогдсон хэв журмыг ямар нэг хэлбэрээр эвдэн танхайрсан, арван зургаагаас дээш насны хүмүүсийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлах буюу 25-аас 200 төгрөг хүртэл торгож байсугай" гэж үйлдлийн хор аюулаар нь ялган заасан байна. Мөн АИХТ-ийн 1974 оны "Танхайрагчдад, нийгмийн хэв журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай"⁸¹ зарлигийн I бүлэгт захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэлийг;

- Олон нийтийн газар хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөөн хоргоох, айлган сүрдүүлэх, цээртэй үгээр хараах, үйлчилгээний газрын журмыг гажуудуулах, дарааллын журам зөрчих, байр орон сууцанд бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, барилга байгууламж, гудамж талбай, зүлэг модыг гэмтээх, бохирдуулах зэргээр нийтийн хэв журмыг санаатайгаар зөрчиж, жижгээр танхайрсан этгээдийг 10-30 хоног хүртэл баривчлах буюу 300 төгрөг хүртэл торгоно,

- Энэ зүйлд заасан зөрчлийг 16 хүртэл насны хүүхэд үйлдвэл тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагчдад олон олон нийтийн арга хэмжээ авахуулах буюу 300 төгрөг хүртэл торгоно гээд II бүлэгт Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлийг өөрчилөн найруулж 169.а)-д "Олон нийтийг илтэд хүндэтгэн үзэхгүй, нийгмийн хэв журам, хамтын аж байдлын социалист хэв журмыг санаатайгаар зөрчсөн эсхүл нийгмийн хэв журам зөрчсөн хэрэгт захиргааны арга хэмжээ авагдсан этгээд 1 жилийн дотор дахин тийм хэрэг гаргасан байвал ...", б)-д "Энэ зүйлийн а-д заасан гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэсэн буюу онц жигшүүртэй догшин авирласан, эсхүл нийгмийн хэв журам сахиулах үүргээ гүйцэтгэж байгаа хүмүүс буюу танхайрсан үйлдлийг таслан зогсоох гэсэн иргэдийг эсэргүүцсэн, түүнчлэн танхайрсан хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн бол ..", в)-д "Энэ зүйлийн а, б-д заасан гэмт хэрэг үйлдэхдээ галт зэвсэг, хутга, мэс, түүнчлэн хүний бие махбодид гэмтэл

⁷⁶ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010. №5 боть. 221 дэх тал

⁷⁷ Мөн тэнд. 195 дахь тал

⁷⁸ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010. №4 боть. 542 дахь тал

⁷⁹ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010. №5 боть. 200 дахь тал

⁸⁰ Мөн тэнд. 227 дахь тал

⁸¹ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010. №6 боть. 202-203 дахь тал

учруулахаар тусгайлан бэлтгэсэн зүйлийг хэрэглэсэн буюу хэрэглэхээр завдсан, танхайрсан хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, эсхүл насанд хүрээгүй хүмүүсийг уруу татаж танхайрсан хэрэгт оруулсан бол ..." Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

АИХТ-ийн 1965 оны "Хутга, мэс, бусад зүйлийг зэвсгийн чанартайгаар биедээ авч явахыг хориглох тухай"⁸² зарлигт "... хутга, мэс, бусад зүйлийг хотын дотор зэвсгийн чанартайгаар биедээ авч явсан хүмүүсийг 25-200 төгрөг хүртэл торгож байх" талаар заасан байна.

Мөн АИХТ-ийн 1967 оны "Ууж согтууран автомашин, өрөө явагч бусад машин, механизм жолоодогчдод хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай"⁸³ зарлигийн 1-р зүйлд "согтууруулах ундааны зүйл уусан үедээ автомашин, мотоцикл буюу цахилгаан тээврийн болон өөрөө явагч бусад машин, механизм жолоодож явсан жолоочийн техник жолоодох эрхийг бсараас 1 жил хүртэл хасах", 2-р зүйлд "... урьд эрхээ хасагдаж байсан буюу эсхүл согтууруулах ундааны зүйл уусан үедээ хүн тээвэрлэсэн жолоочийн техник жолоодох эрхийг 1-ээс 2 жил хүртэл хугацаагаар хасах", 3-р зүйлд "... 2 удаа захиргааны журмаар эрхээ хасагдаж байсан буюу мөн дээрх шалтгаанаар осол аюул гаргаж ял шийтгэгдсэн жолооч нарт дахин техник жолоодох эрх олгохыг хориглох" гэж заасан ба согтууруулах ундааны зүйл уусан үедээ автомашин жолоодож бусдын бие махбодид гэмтэл учруулсан буюу эд материалын үлэмж хэмжээний хохирол учруулсан жолоочид Эрүүгийн хуулийн 174-р зүйлийн 174.в, 174.г-д зааснаар хүндрүүлж ял оногдуулдаг байжээ.

АИХТ-ийн 1974 оны "Согтууруулах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай"⁸⁴ зарлигт өмнө энэ талаар журамласан /хамт хүчин төгөлдөр үйлчилнэ/ зарлигаас ялгагдах онцлог зүйлийг авч үзье.

- Эрүүлжүүлсэн зардалд 25 төгрөг гаргуулж авах,

- Согтууран хэвийн бус байдал гарган яваа хүнийг олон нийтийн үйлчилгээний газар оруулсан буюу үйлчилсэн, согтууруулах ундаагаар шахаж бусдыг согтоосон этгээдийг 100 төгрөг хүртэл торгох,

- Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл уулгасан этгээдийг Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал 25-100 төгрөг хүртэл торгох гэж заан Эрүүгийн хуулийн 171¹-р зүйлийг нэмж насанд хүрээгүй хүнийг уруу татан удаа дараа согтууруулах ундааны зүйл уулгасан этгээдэд Эрүүгийн хариуцлага оногдуулахаар зааж байжээ.

АИХТ-ийн 1975 оны "Улс, олон нийтийн хөрөнгийг бага хэмжээгээр ашиглан шамшигдуулагчдад захиргааны арга хэмжээ авч байх тухай"⁸⁵ зарлигт "Улс, олон нийтийн хөрөнгийг хулгайлах, залилан мэхлэх, ажлын байдлаа далимдуулах зэргээр ялимгүй 30 төгрөг хүртэл хэмжээгээр ашиглан шамшигдуулсан этгээдээр уг зүйлийн үнийг зөрчилд ирүүлснээс хойш 7 хоногийн дотор 2 буюу 3 нугалан төлүүлж, ажиллаж байгаа газарт нь захиргааны журмаар 2 сар хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэж, цалингийн 10-15 хувийг суутган улсын орлого болгох буюу 100-300 төгрөгөөр торгох"-оор харин 30 төгрөгнөөс дээш хэмжээгээр ашиглан шамшигдуулсан этгээдийг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлд зааснаар ял оногдуулдаг байжээ.

АИХТ-ийн 1975 оны "Дамын худалдаа хийгчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай"⁸⁶ зарлигт захиргааны хариуцлага хүлээлгэх талаар:

- Дамын худалдаа анх удаа бага хэмжээгээр хийсэн этгээдийг захиргааны журмаар 3-20 хоног хүртэл хугацаагаар баривчлах буюу 100-800 төгрөг хүртэл торгож, дамлан худалдаж байгаа зүйлийг хураана,

- Хувийн болон бусад сонирхлын үүднээс буюу нүүр тал харж өргөн хэрэгцээний барааг тогтоосон журам зөрчин худалдсан худалдааны байгууллагын ажилтанд БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлд заасан хариуцлага /удаа дараа буюу их хэмжээтэй худалдсанаар ялгагдана/ хүлээлгэхээргүй байвал түүнийг 100-700 төгрөг хүртэл торгох,

⁸²Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010.№5 боть. 429 дэх тал

⁸³Мөн тэнд. 470-471 дэх тал

⁸⁴Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010 .№6 боть. 205-206 дахь тал

⁸⁵Мөн тэнд. 261 дэх тал

⁸⁶Мөн тэнд. 261-262 дахь тал

- Зах зээл, гудамж, талбай, дэлгүүр худалдаа болон бусад олон нийтийн газар эд бараа солихыг хориглож, энэ журмыг зөрчвөл 50-300 төгрөг хүртэл торгож, сольж байгаа зүйлийг хураана хэмээн зааж, харин дамын худалдааг ашиг хонжоо олох зорилгоор байнга буюу их хэмжээтэй хийвэл Эрүүгийн хуулийн 128 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахаар заасан байна.

Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд "Мөрийтэй тоглоомоор тоглосон буюу мөрийтэй тоглоомыг тусгайлан бэлтгэлгүйгээр өөрийн мэдлийн орон байрандаа тоглуулсан бол 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 1 мянган төгрөг хүртэл торгож хонжворын бүх зүйл ба тоглоомын бүх хэрэгслийг хураана" гэж заасан ба АИХТ-ийн 1977 оны "Мөрийтэй тоглогчдод хүлээлгэх захиргааны арга хэмжээг чангатгах тухай"⁸⁷ зарлигт "Мөрийтэй тоглосон буюу тусгайлан бэлтгэлгүйгээр орон байрандаа тоглуулсан 16-гаас дээш насны этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал 200-500 хүртэл төгрөгөөр торгох"-оор заасан нь хэм хэмжээний хувьд давхардсан төсөөтэй хэрэглэх нөхцөл бүрдсэн байжээ.

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1986 оны 12-р сарын 5-ны өдрийн 217 зарлигаар шинэчлэн найруулж, 5 бүлэг 59 зүйлтэй, тусгай анги 13 бүлэг 301 зүйлтэйгээр батлаад 1987 оны 7-р сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн юм.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь бүтэц, хэлбэрийн хувьд өмнөх хуулиас харьцангуй сайжирсан хууль боловч социалист өмчийн харьцааг хамгаалан дэмжих, төлөвлөгөөт эдийн засаг, захиран тушаах дэглэмийн тогтвортой байдлыг энэ хуулийн албадлагаар баталгаажуулахад чиглэгдсэн заалтууд хуульд хадгалагдаж үлдсэн. АИХТ-ийн 1987 оны "Дамын худалдаа хийсэн этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлагыг хүчтэй болгох тухай"⁸⁸ зарлигт "Ашиг хонжоо олох зорилгоор эд зүйлийг бага хэмжээтэй дамлан худалдсан, согтууруулах ундааны зүйлийг ашиг хонжоо олох зорилгоор худалдан авч дамлан худалдаалсан этгээдэд ..." захиргааны арга хэмжээ оногдуулахаар заасан бол Эрүүгийн хуулийн 169 дүгээр зүйлд "Ашиг хонжоо олгох зорилгоор бараа, бусад эд зүйлийг бага бус хэмжээтэй худалдан авч дамлан худалдаалсан бол ..." гэж худалдаалж байгаа барааны хэмжээгээр ялгагдахаар зааж өгсөн байна.

АИХ-ын тэргүүлэгчдийн 1987 оны "Эд хөрөнгийг багавтар хэмжээтэй ашиглан шамшигдуулсан этгээдэд хүлээлгэх захиргааны хариуцлагыг хүчтэй болгох тухай"⁸⁹ зарлигийн 1-р зүйлд "Улс, хоршоолол, олон нийтийн хөрөнгийг анх удаа хулгайлах, завших, үрэгдүүлэх, албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглах, залилан мэхлэх замаар багавтар хэмжээтэй /200 хүртэл төгрөгийн/ ашиглан шамшигдуулсан этгээдийг 100-500 төгрөгөөр торгох буюу 3 сараас 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэн, цалингийн 10-20 хувийг суутган улсын орлогод оруулж, ашиглан шамшигдуулсан эд хөрөнгийн жижиглэн худалдаалах үнийг 2 нугалан төлүүлэх", 2-р зүйлд "Иргэдийн 200 хүртэл төгрөгийн үнэтэй амины эд хөрөнгийг хулгайлсан этгээдийг 100-400 төгрөгөөр торгох буюу 3 сараас 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэн, цалингийн 10-20 хувийг суутган улсын орлогод оруулж, хулгайлсан эд хөрөнгийг эзэнд нь буцааж өгөх" гэж заасан ба 200 төгрөгнөөс дээш буюу зөрчлийг нэг жилийн дотор давтан буюу удаа дараа, бүлэглэн үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 131 /Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах/, 153-р /иргэдийн амины эд хөрөнгийг хулгайлах/ зүйлээр ялган зүйлчлэхээр заажээ.

Ардчилсан Үндсэн хууль /1992/ нь Монголын ард түмний амьдралд түүхэн эргэлт хийж, Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн бусад хуулиудыг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай уялдуулан Эрүүгийн хуульд 1994-2001 онуудад байнга нэмэлт өөрчлөлт орж байсан. Ингэж Эрүүгийн хуульд бараг жил тутам шахуу элдэв өөрчлөлт оруулж Эрүүгийн шинэ хуулийг 2002 оны 01-р сарын 03-ны өдөр ерөнхий ангийг 4 хэсэг 13-р бүлэг, 78 зүйлтэйгээр, тусгай ангийг 7 хэсэг 16 бүлэг, 225 зүйлтэйгээр баталжээ. Доктор, профессор Д.Зүмбэрэлхам Эрүүгийн хуульд хийгдсэн шинэчлэлийг тусгайлан судлаад;

⁸⁷Мөн тэнд. 299 дэх тал

⁸⁸Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. УБ., 2010 №7 боть. 140 дэх тал

⁸⁹Мөн тэнд. 141 дэх тал

а/ Өмнөх хуульд агуулга давхцуулсан хэм хэмжээнүүдийг нэгтгэн найруулж, цомхотгосон агуулга, зорилгын хувьд тусдаа байх, ёстой хэм хэмжээг бие даасан зүйлүүд болгон задалсан.

б/ Цаг үеийн шалгарлаар гэмт хэргийн шинж чанараа алдсан үйлдэл, эс үйлдэхүйг хуулиас хассан, гэмт хэргийн шинжтэй болсон үйлдэл, эс үйлдлийг нэмсэн гэж нэмэлт өөрчлөлтүүдийг ангилан авч үзсэн төдийгүй тусгай ангид 131 хэрэгт оногдуулах дээд хэмжээг, 13 хэргийн доод хэмжээг хуучин хуульд байснаас багасгасан ба 53 хэрэгт хорих ялыг хорихоос өөр төрлийн ял болгож хөнгөрүүлсэн нь уг хуулийг боловсруулж батлахдаа уян хатан бодлого баримталсны илрэл юм⁹⁰ гэж оновчтой бодитой дүгнэлт хийжээ.

1992 онд батлагдан хүчин төгөлдөр болсон "Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль" нь өнөөдөр захиргааны зөрчил, түүнтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа ганц хууль бөгөөд энэхүү хуульд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 20 гаран удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд зарчмын шинжтэй шинэчлэлт хийгдээгүй байсан юм.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан зөрчлүүдээс үзэхэд Эрүүгийн хуультай шууд давхардсан 9 зүйл, зөрчилдөж байгаа 10 зүйл, давхардаж байгаа боловч хор уршиг шаардсанаараа ялгаатай 7 зүйл, хэсгийн (Хүснэгт 1-ээс үзнэ үү) хувьд гэмт хэргийн нийгэмд аюултай шинжийг тодорхойлдог гол нөхцөл нь хор уршиг юм байна гэсэн ойлголтыг төрүүлж байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулинд эрүүгийн хэрэгтэй ижил төрлийн харилцааг хамгаалсан хэм хэмжээ Захиргааны хариуцлагын тухай хуульд байгаа нь хуулийн байгууллагын ажилтнуудын дунд хардлага бий болгох, хэргийг өөрт ашигтай байдлаар шийдэх, улмаар эрүүгийн хариуцлагаас зайлсхийж, ял завших боломжийг олгож байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 240 дүгээр зүйл, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийг нэрлэж болно. Эрүүгийн хуулийн 240 дүгээр зүйлийн 240.1-д "... Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад байх эрхийн баримт бичиггүй буюу хүчингүй баримт бичгээр оршин суусан, бүртгүүлэх, хаягийн бүртгэл хийлгэх, шилжин суурьших, оршин суух газраа сонгох талаар тогтоосон журам зөрчсөн, эсхүл оршин суух, тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх журам зөрчсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ ..." гэж заасан бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28 дугаар зүйлд "... 1. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух эрхийн бичиггүй эсхүл хүчингүй болгосон баримт бичиг ашиглаж буюу зохих зөвшөөрөлгүй оршин суусан бол 100000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна. 2. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 100000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна. 3. Гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрээр зорчих, түүнчлэн шилжин суурьших болон бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 100000-200000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна ..." гэж зааснаас үзэхэд гэмт хэрэг захиргааны зөрчлийн ялгаа үндсэндээ алдагдсан байна. Ийм жишээ Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуульд 10-аад бий.

Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжид "... хэрэв эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ..." хэмээн тодорхой захиргааны зөрчлийг заасан боловч Эрүүгийн хуульд уг үйлдлийг гэмт хэрэгт тооцоогүй байх эсвэл хүчингүй болгосон, гэмт хэрэгт тооцохгүй болсон тохиолдол цөөнгүй байна⁹¹. Жишээ нь: Дархлаажуулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд Дархлаажуулалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, эрх бүхий улсын байцаагч захиргааны шийтгэл ногдуулна гээд захиргааны зөрчил болох үйлдлүүдийг заасан боловч ийм төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуульд огт хуульчлаагүй байна.

⁹⁰Д.Зүмбэрэлхам. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчлэлийн үзэл баримтлал- "Legus"сэтгүүл. УБ., 2003. №4.50 дахь тал

⁹¹Г.Гантөмөр. Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн уялдаа холбооны зарим асуудал. Монголын төр эрх зүйн сэтгүүл. УБ.,2005.№1. 19 дэх тал

Өөрөөр хэлбэл "... эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол ..." гэсэн нэр томъёо нь хууль тогтоомжид захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоохдоо хэрэглэдэг жижүүрийн үг болсон байна.

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий сүбъект Захиргааны хариуцлагын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар 10 төрлийн этгээд /төрийн байгууллагын албан тушаалтан, албан хаагч/ байдаг ба тэдгээрийн мэргэжил, эрх зүйн мэдлэг, боловсрол харилцан адилгүй байдгаас тэр бүр гэмт хэрэг, захиргааны зөрчлийн бүрэлдэхүүнийг хооронд нь ялган зааглаж зөв зүйлчилж чадахгүй байх, хууль тогтоомжийг буруу хэрэглэх зэргээр алдаа дутагдал гаргаж байгаагийн зэрэгцээ тэдний хууль хэрэглэх үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг алдагдуулахад хүргэж байна. Өнөөдрийн байдлаар нийт 240 гаран хууль тогтоомжид захиргааны зөрчил тусгагдсан бөгөөд 60 гаран эрх бүхий сүбъект захиргааны шийтгэл оногдуулж байна⁹².

Захиргааны хариуцлага тогтоосон хэм хэмжээг төрөлжүүлэн Захиргааны хариуцлагын тухай төрөлжсөн нэг хуульд хуульчлах саналыг эрүүгийн болон захиргааны эрх зүйн эрдэмтэн судлаачид нилээн эртнээс дэвшүүлж ирсний үр дүн нь 2015 онд батлагдсан Зөрчлийн тухай хууль юм. Амьдралд хэрэгжиж эхлээгүй ч шинэчлэн найруулсан Эрүүгийн болон Зөрчлийн хуулиудын уялдаа холбоог судлан дээрх байдлаар давхардсан, зөрчилдсөн хэм хэмжээ байгаа эсэхийг судалж өөрийн дүгнэлт, саналыг боловсруулахыг гол зорилгоо болгосон юм.

Дүгнэлт

1. Монгол Улсад 1993 оныг хүртэл буюу төрөлжүүлж нэгтгэсэн хууль байгаагүй, Захиргааны хариуцлагын тухай хууль батлагдах хүртэл дүрсгүйтэн авирлаж ард олны хэв суртлыг үл хүндэтгэн дагагсад, архи ууж хэтэрхий согтууран, олны хуран цугларсан газруудаар явах, жижиг хэмжээгээр бусдын эд хөрөнгийг завших зөрчилд захиргааны янз бүрийнхүчин чадал бүхий олон төрлийн дүрэм, зарлиг, эрх зүйн актаар захиргааны шийтгэл хүлээлгэж, ууж согтуурах, ард олны хэв суртлыг зөрчих зөрчилтэй эрчимтэй тэмцэж байсан байна. 1993 онд батлагдсан Захиргааны хариуцлагын тухай хууль нь бүрэн төгс төрөлжүүлж нэгтгэсэн хууль биш байсан юм. Энэ нь түгээмэл үйлдэгдэг зөрчлүүдийг хуульчилснаас бусад зөрчлүүдийг салбарын органик хуульд өнөөг хүртэл хуульчилж ирснээр батлагдаж байна.

2. Эрүүгийн хуулинд заагаагүй зарим үйлдэл, эс үйлдэлд БНМАУ-ын АИХТ-ийн зарлигаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хор аюулаар бага, давтагдан үйлдэгдэх шинжтэй зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэхээр зааж байжээ. Тухайлбал: "Ойн ба хээрийн түймэр тавигчдад эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай" АИХ-ийн төлөөлөгчдийн зарлигийн 1-рзүйлд сэрэмж болгоомжгүйгээс гал түймэр алдсаны улмаас ой мод, бэлчээр, улс, хоршоолол, иргэдийн хөрөнгө үлэмж хэмжээгээр сүйрсэн буюу хүний эрүүл мэнд, амь биед хор аюул учирсан бол ял оногдуулж байсан байна.

3. 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хууль нь хамгийн анхны томоохон кодификаци буюу төрөлжүүлэн нэгтгэсэн хууль гэж үзэх бүрэн үндэстэй. Өөрөөр хэлбэл нийгмийн бүх салбарын хүрээнд үйлдэгддэг захиргааны зөрчлүүдийг нэг дор нэгтгэж ангилсаны хууль хэрэглээний болон эрдэм шинэжилгээ, судалгааны ач холбогдолтой гэж үзэж байна.

4. Шинэчлэн найруулсан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбооныасудал дээрх хуулиудын хүрээнд эрдэмтэн, судлаачдын хүссэн хэмжээнд хүрч хуульчлагдаагүй, уялдаа холбоо хангагдаагүй байна. Тухайлбал, нэр томъёоны хувьд тодорхойгүй, практикт уг хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл үүсгэх боломжтой, утга найруулгын алдаатай, зарим гэмт хэргийн шинжийг зөрчлийн шинжээс нарийн ялгаж хуульчлаагүй, оногдуулах санкцын хувьд ялгаагүй заалтууд байна гэж судлаачийн хувьд үзлээ.

Санал

1. Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбоог хангах, түүнийг практикт зөв хэрэглэх, дадал, хандлага төлөвшүүлэхийн тулд их, дээд сургуулийн хуулийн ангийн сургалтын хөтөлбөрт "Зөрчлийн эрх зүй" гэдэг хичээлийг оруулах. Энэ хичээлийг зарим их, дээд сургууль /Отгонтэнгэр/ сургалтын хөтөлбөртөө тусган ороод эхэлчихсэн байна.

⁹²Г.Оюунболд. Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа. Гэмт явдалтай тэмцэх сэтгүүл. УБ., 2007. №3(21). 28 дахь тал

2. Эрүүгийн гэмт хэрэг, эрүүгийн зөрчил, цагдаагийн зөрчил буюу захиргааны жижиг зөрчил гэсэн нэр томъёог гадаад орны харьцуулсан эрүүгийн эрх зүйгээр орчуулж гаргасан ном, бүтээлийн хэмжээнд судлахаар нарийн ялгаа нь гарахгүй байгаа тул тухайн оронд нь очиж хууль тогтоомжинд нь болон практик хэрэглээнд нь судлах шаардалагтай байна.

3. Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулиудын уялдаа холбооны асуудлыг судласан ганц, хоёр хүний илтгэл, өгүүллээс өөр бүтээл байхгүй бөгөөд цаашид үргэлжлүүлэн судлан ном бүтээл гаргах, Эрүүгийн эрх зүйн судлагдахууны нэг чиглэл болгон шинжлэх ухааны эргэлтэнд оруулж, онолын хүрээнд гүнзгийрүүлэн судлах.

4. Шинэ Эрүүгийн хууль тогтоомжид жижгээр танхайрсан, бага хэмжээгээр бусдын эд зүйлийг хулгайлсан /халаасны хулгай/, ашиглан шамшигдуулсан, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг түгээмэл үйлдэгддэг зөрчлийг давтан үйлдвэл гэмт хэрэгт тооцох.

5. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тодорхой гэмт хэргийн шинжийг зөрчлийн шинжээс бараг ялгаагүй, хоёрдмол утгатай, найруулгын алдаатай хуульчилсан хэд хэдэн заалт байгаа тул доорх байдлаар өөрчлөлт оруулах саналтай байна.

Ашигласан материал

Монгол Улсын хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн хууль
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
4. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага

5. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2002.
6. Г.Совд. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс. Ерөнхий анги. УБ., 1973
7. С.Нарангэрэл. Монгол Улсын ЭЭЗ. Ерөнхий анги. УБ., 1999
8. Б.Баярсайхан. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн товчоон. УБ., 2008
9. Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971

Сонин сэтгүүл

10. Монголын төр эрх зүй сэтгүүл. УБ., 2010. №1
11. Legus. сэтгүүл. УБ., 2003. №4
12. Монголын төр эрх зүйн сэтгүүл. УБ., 2005. №1
13. Гэмт явдалтай тэмцэх сэтгүүл. УБ., 2007. №3

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО,
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ
POLICE OFFICER TRAINING SYSTEM,
PROBLEMS OF LEGAL REGULATION

Энхсайханы Дашгаадан

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний
нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан-багш,
хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн ахмад

Dashgaadan EnKhsaikhan

United Research Institute of the University of Internal Affairs
Researcher-teacher of the Institute of Crime and Police Studies,
doctor of law (Ph.D), police captain

Хураангуй. Орчин үеийн нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлага, шинж чанар шинэчлэгдэн өөрчлөгдөх үйл явцын үр дүнд хүн бүрийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн чанартай, хүртээмжтэй, боловсрол эзэмших эрхийг хангах асуудал дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлуудын нэг болсон. Эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, хуульт ёсыг мөрдүүлэх, нийгэмд дэг журам тогтоох, иргэдийн аюулгүй байдлыг хангахад голлох үүрэгтэй цагдаагийн алба хаагчийн боловсролын асуудлыг хууль зүй, цагдаа судлал, боловсрол судлалын талаас уялдуулан авч үзэх зайлшгүй шаардлагатай юм.

Энэхүү өгүүлэлээр цагдаагийн алба хаагчийн сургалтад практикийн болон академик салбар дахь үйл ажиллагааны цогц байдал хангагдахгүй байгаа бөгөөд үзэл баримтлал, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай гэсэн дүгнэлт, саналыг дэвшүүлэхээр зорилоо.

Түлхүүр үгс: Цагдаагийн алба хаагч, сургалт, тогтолцоо, эрх зүйн зохицуулалт

Нэг. Цагдаагийн алба хаагчийн сургалтын талаарх үзэл баримтлал, эрх зүйн зохицуулалт

Цагдаагийн алба хаагчийн сургалт, тогтолцоо, уламжлал

Цагдаагийн байгууллагын нийгэмд оршин байдаг зорилго, үүргийн талаар авч үзэхийн тулд хууль дээдлэх ёсыг авч үзэх хэрэгтэй болж байна⁹³. Өөрөөр хэлбэл, төрийг төлөөлөх, хуулийг дээдлэх ёсны үүднээс нийгмийн хэм хэмжээг сахиулах, шаардах, албадах хөшүүрэг нь цагдаагийн байгууллага юм. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг тайлбарлахад криминологийн, тэр дундаа нийгмийн хяналтын онолууд хувь нэмрээ оруулсан бөгөөд хүн өөрийгөө болон бусад системээр тухайн хүнийг хяналтад байлгаснаар гэмт явдлаас урьдчилан сэргийлэх боломжтой гэж үздэг онцлогтой.

Харин цагдаагийн буюу хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага нь нийгмийн хөгжлийн явцад хэрэгцээ, шаардлагаар үүссэн гэлтэй. Хүн төрөлхтөн түүхэн хөгжлийнхөө явцад нарийн ээдрээтэй нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт явдлыг төрүүлдэг бөгөөд хор уршигт нь нэрвэгдэж, эргээд түүнтэй тэмцэж ирсэн түүхтэй⁹⁴. Үүнтэй холбоотойгоор гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай сургаал нь хүн төрөлхтний эрх зүйн сэтгэлгээний олон зуун жилийн үр дүнд бүхэл бүтэн цогц онол болон хөгжсөн юм⁹⁵.

Объектын гол шинж, зүй тогтлын талаар цогц төсөөлөл бий болгох шинжлэх ухааны танин мэдэхүйн дээд түвшнийг онол гэж үздэг. Доктор Ч.Нямсүрэн “танин мэдэхүйн талаасаа онол ба

⁹³ L.Green and other, Police innovation and police control., p.145.

⁹⁴ Батзориг, Б. Гэмт хэргийн бодит тоон үзүүлэлийг тогтооход нөлөөлж болох хүчин зүйлс, гэмт явдалтай тэмцэх асуудал. -УБ. 2002. 9 дэх тал.

⁹⁵ Гантөмөр, Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. -УБ., 2011. 6 дахь тал.

шинжлэх ухаан гэсэн ойлголтууд адил утгатай⁹⁶” гэж тэмдэглэжээ. Энэ утгаараа цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо нь онолгүй байх үндэсгүй бөгөөд түүний зүй тогтлыг зөвөөр илэрхийлсэн онолыг баримтлах нь судалгааны үр дүнд чухал ач холбогдолтой юм. Сургалтыг шинжлэх ухаанд дидактик хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь грек хэлний “didaktikos” буюу сургамжилж байгаа хүн гэсэн утгатай. Энэ үгийг анх шинжлэх ухааны хэрэглээнд оруулсан хүн бол Германы сурган хүмүүжүүлэгч В.Ратке (1571-1635) юм. Тэрээр дидактик бол сургах урлаг, практик чадвар гэж үзсэн⁹⁷.

Чехийн их сурган хүмүүжүүлэгч Ян Коменский 1627-1632 онд Didactica Magna нэрт алдарт бүтээлдээ сурган хүмүүжүүлэх ухааны эцэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн ба дидактикийг сургалт, хүмүүжлийн онол, арга зүйн түвшинд гүйцэд боловсруулсан гэж тооцогддог. Цагдаагийн алба хаагчийг бэлтгэн сургах, чадваржуулахад хэд хэдэн түвшний сургалт шаардлагатай тул дидактик, андрогоги, прагматик сургалт, шаталсан сургалт зэрэг олон төрлийн онол үйлчилдэг. Эдгээрийг онолын талаас нь нэгтгэхийн тулд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо гэх ойлголтыг нарийвчлан авч үзэх хэрэгтэй бөгөөд тогтолцоо нь тодорхой бүхэл чанар, нэгдлийг олж өөр хоорондоо холбоо, уялдаа харилцан шүтэлцээнд оршиж байдаг элементийн цогц юм.

Системийн онолын үүднээс авч үзвэл, цагдаагийн алба хаагчийг сургалтын тогтолцоо нь төрийн зорилт чиг үүргийн дагуу цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий сургалтын байгууллага, ажлын байран дээр нь сургах үйл ажиллагааг хамарсан хоорондоо харилцан үйлчлэл, “орц”-“явц”-“үр дүн”-“эргэх холбоо”-нд оршдог элементүүдийн олонлог бөгөөд насан туршийн боловсролын хэв шинжтэй буюу бэлтгэх-хөгжүүлэх, бэлтгэх-хөгжүүлэх гэсэн зарчмыг баримталбал зохино.

Манай орны хувьд цагдааг бэлтгэж ирсэн сургалт дотоодыг хамгаалах газрын “Төв сургууль” анх 1934 онд байгуулагдсан ба түүхэн үйл явцын хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллага, хилийн цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, онцгой байдал, шүүхийн шинжилгээний үндэсний төв зэрэг төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын бэлтгэж ирсэн байна. 1934-1965 онд Дотоодыг хамгаалах газрын төв сургуулиас Дотоод явдлын яамны хязгаар ба Дотоодын цэргийн нэгдсэн сургууль, 1965-1982 онд Цэргийн ерөнхий дээд сургуулийн дэргэд цагдан сэргийлэх байгууллагад хуульч мэргэжилтэн бэлтгэж байгаад НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль байгуулан улмаар хилийн цэрэг, цагдан сэргийлэх, засан хүмүүжүүлэх байгууллагад ажиллах цэргийн ба хуулийн дунд мэргэжлийн хуульч, 1982-2000 онд НАХЯ-ны Цэргийн дээд сургуулиас Цагдаагийн дээд сургууль болж, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, гал түймэртэй тэмцэх байгууллагын дээд боловсролтой боловсон хүчин, 2012 онд Дотоод хэргийн их сургууль болж, аюулгүй байдал, хууль зүй дотоод хэргийн салбарын тусгай алба хаагчдыг бэлтгэдэг их сургууль болон өргөжсөн төдийгүй цагдаагийн сургууль нь бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж, өөрсдийн сургалтын үйл ажиллагааг тодорхойлж, ахлагч болон ахисан шатны сургалтын хөтөлбөрүүдийг ялгаж тус тусын сургуульд хэрэгжүүлж байгаа нь онцлогтой болжээ⁹⁸.

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа эрх зүйн актууд нь цагдаагийн алба хаагчийн сургалт, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна.

Үүнээс үзвэл, цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх талаар алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн эх сурвалж, баримт бичиг,

⁹⁶ Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. -Уб., 2017. 6 дахь тал.

⁹⁷ Ичинхорлоо, Ш. Сургалтын онол, арга зүй. -Уб., 2018. 4 дэх тал.

⁹⁸ Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хураангуй. -Уб., 2019. 11 дэх тал

хууль, тогтоомжууд хангалттай мэт байгаа боловч нэгдсэн тогтолцоог бүрдүүлээгүй, сургалтууд нь зөвхөн тухайн нэг үе шатны боловсролыг олгоход чиглэж байгаа нь хоорондын уялдаа, залгамж холбоог хангахгүй байх гол нөхцөл болжээ. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-д зааснаар мэргэжлийн анхан, дунд, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтоох эрхийг боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд олгосон бөгөөд үүнийг үндэслэн мэргэжлийн чиглэл, индексийг баталсан нь практикт хэрэгждэг. Гэвч НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын гаргасан зөвлөмжид суурилан цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн индексийг аюулгүй байдал ангилалд авч үзсэн нь учир дутагдалтай бөгөөд манай орны цагдаагийн байгууллагын хувьд хууль сахиулах, хэрэгжүүлэх чиглэлээр голлох үүргийг гүйцэтгэж, аливаа гэмт хэрэг, зөрчлийн бодит байдлыг тогтоох чиглэлээр ажилладаг нь эрх зүйч мэргэжилтэн байх гол шалгуурыг илэрхийлж байгаа юм.

Орчин үеийн хөгжлийн чиг хандлага нийгэм, эдийн засаг, техник технологийн хөгжил, хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шаардлага, шинж чанарын шинэчлэгдэн өөрчлөгдөх үйл явцын үр дүнд хүн бүрийг “зөөлөн ур чадвар”-тай байх, тэднийг насан туршдаа суралцах үйл явцад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна. Дэлхий нийт дээрх хэрэгцээ, шаардлагыг харгалзан хууль зүйн болон бодлогын орчноо тасралтгүй сайжруулж, боловсронгуй болгосоор байна. Тухайлбал НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2030 он хүртэлх хөгжлийн бодлогыг тодорхойлсон “Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг батлан хэрэгжүүлж байна.⁹⁹ Цагдаагийн алба хаагч, сонсогч, суралцагчдын төлөөллийн судалгааны үр дүнд сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтад мэргэжлийн индексийн зөрүү, ажлын байранд сул орон тоо их учир их хэмжээний чанаргүй алба хаагчдыг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, сонгон шалгаруулалт сул, сургалтын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул, сургалтуудын уялдаа холбоо сул, ажлын ачааллаас шалтгаалж суралцах, хөгжих боломж тааруу зэрэг үр дүн гарсан.

Цагдаагийн төв байгууллагаас жил бүр цагдаагийн байгууллагын алба хаагчдыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлдэг хэдий ч хэрэгжүүлж буй сургалтын үйл ажиллагаа тогтворгүй, сэдэв, ангилал, хүрэх үр дүн тодорхойгүй байгаа нь жил бүрийн тайлан, мэдээнээс ажиглагдаж байв. Үүнээс үзвэл, эрх зүйн зохицуулалтын хувьд цагдаагийн алба хаагчийг бэлтгэж байгаа сургалтын үйл ажиллагаа, практикт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө ялгаатай, үйл ажиллагаа явуулах чадамж, туршлага эрс ялгаатай байна. Мөн сургалтын үйл ажиллагаанд аль аль байгууллагын төлөөлөл оролцож, хөтөлбөр, төлөвлөгөөг баталж байх зохицуулалттай ч хэрэгждэггүй байна.

Хоёр. Цагдаагийн алба, алба хаагчийн сургалтын үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ

Цагдаагийн алба хаагчийн сургалтад тулгамдаж буй асуудал

Дотоод хэргийн их сургуулийн 2021-2025 оны Хөгжлийн стратегийн хөтөлбөрийн “Нийгмийн болон захиалагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцсэн үүрэг гүйцэтгэх бүрэн чадамжтай эх оронч, бүтээлч, ёс зүйтэй мэргэжилтэн, судлаачийг бэлтгэнэ. Хүний эрх, шударга ёс, хуулийг дээдлэх хандлагыг суралцагч бүрд төлөвшүүлж, хууль сахиулах салбарын дэвшилд бодитой хувь нэмэр оруулах бүтээлч сэтгэлгээтэй, мэргэжлийн өндөр ёс зүй, чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ” гэсэн зорилтод тусгагдсан үндсэн агуулгыг дэмжин хэрэгжүүлэхийг зорьсон болно.

Энэхүү өгүүллээр сургалтын үйл ажиллагаанд нөлөөлөх хувьсагчийн талаар илүү дэлгэрүүлэн судлах, дараа дараагийн судлаачдын судалгааны ажлын суурь судалгаа болгох, сургалт хэрхэн хэрэгжиж байгааг хянан судалсан. Судалгаанд Цагдаагийн сургуулийн нийт 205 сонсогч, Ахлагчийн сургуулийн 86 сонсогч, 3240 цагдаагийн алба хаагч оролцсоноос алба хаагчдын хувьд нас, хүйс, ажилласан жил, албан тушаал, цол, зэрэглэл, сонсогч суралцагчдын курс, дамжааны ангилал зэргээс үзвэл оролцоог тэгш хангасан тул үр дүн тэнцвэртэй бодитой гарсан болохыг илтгэнэ.

⁹⁹ Боловсролын эрх зүйн харьцуулсан шинжилгээ ба үр дүн. 2020 он

Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоог загварчлах, тус тусын буюу өөр хоорондоо захиалга өгөх төдий байдлаар харилцаж буй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан урт болон богино хугацааны сургалтуудын эрэмбэ, дараалал, ажлын байранд нь шаардагдах сургалтуудыг журамлан зохион байгуулах үндсэн загваруудыг бий болгох шаардлагатай. Түүний дараа тухайн үйл ажиллагаанд тохирсон хууль, эрх зүйн орчинд нэмэлт, өөрчлөлт хийх нь зүйтэй талаар санал дэвшүүлэв.

Цагдаагийн алба хаагчид, сонсогч, суралцагчдаас авсан судалгааны үр дүнд цагдаагийн алба хаагчийн сургалтад тулгамдаж буй асуудлуудыг дараах байдлаар жагсаалт болгон гаргаж байна. Үүнд:

- Онол, үзэл баримтлалын хувьд холимог шинжтэй бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын хэв шинж тогтоогүй;
- Ажлын байрны тодорхойлолт, бэлтгэж буй мэргэжлийн индекс зөрүүтэй;
- Ажлын байранд сул орон тоо их гардаг нь чанаргүй бөгөөд их хэмжээгээр алба хаагчдыг бэлтгэх шалтгааныг үүсгэж байна;
- Тогтвор суурьшилтай ажиллуулах үйл ажиллагаа хангалтгүй;
- Гадаадад төгссөн, мэргэжил дээшлүүлсэн алба хаагчид ажлын байрандаа тогтвортой ажиллахгүй байна;
- Сонгон шалгаруулалтын чанар алдагдсан;
- Бүх түвшинд шинээр томилогдоход дасан зохицох сургалт зайлшгүй шаардагдаж байна;
- Сургалтын үе шаттай хөгжих тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай;
- Алба хаагчийг бэлтгэх болон ажлын байрны давтан, мэргэшүүлэх сургалтын уялдаа алдагдсан;
- Сургалттай холбоотой эрх зүйн зохицуулалтуудын хэрэгжилт хангагддаггүй;
- Ажлын ачааллаас шалтгаалж, суралцах, хөгжих боломж тааруу зэрэг асуудлууд тулгамдаж байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэхжүүлэх, чадварлаг алба хаагчдыг бэлтгэх, албаны болон давтан мэргэшүүлэх сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, үр дүнгийн дагуу урамшуулах, дэвшүүлэх зохицуулалтыг нэвтрүүлэх нь дан ганц алба хаагчид бус цагдаагийн байгууллагын хөгжилд үнэтэй хувь нэмэр болно гэж дүгнэж байна.

Цагдаагийн алба хаагч, сонсогч, суралцагчдын төлөөллөөс авсан судалгааны үр дүнд сургалтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтад мэргэжлийн индексийн зөрүү, ажлын байранд сул орон тоо их учир их хэмжээний чанаргүй алба хаагчдыг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, сонгон шалгаруулалт сул, сургалтын эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт сул, сургалтуудын уялдаа холбоо сул, ажлын ачааллаас шалтгаалж суралцах, хөгжих боломж муу байдаг нь өнөөгийн тулгамдаж буй гол асуудлууд болж байна.

Гадаадын зарим орны цагдаагийн алба хаагчийн сургалт, онцлог

Цагдаагийн байгууллагын алба хаагчид бие биедээ харилцан туршлага солилцох, шинээр ажилд орж буй залуу хүний нөөцөд дадлага, туршлагатай алба хаагч өөрийн туршлагыг хуваалцах нь практикт өндөр ач холбогдолтой.

Аль ч улс орны цагдаагийн алба хаагчийн сургалтын асуудал тухайн нийгмийн хэрэгцээ, шаардлагын дагуу бий болж, нийгмийн хөгжлийн шат шатны онцлогтой уялдан улам сайжирч хөгжин ирээдүй рүү чиглэсэн үзэл баримтлал, стратеги төлөвлөлтийг өөр өөрийн түүх, соёлын хүрээнд боловсруулж ирсэн нь дээрх туршлагуудаас харагдана.

Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог зарим улс тусгайлан хуульчилсан бол ихэнх улс орнууд тусгайлан хуульчлаагүй бөгөөд цагдаагийн байгууллагын эсвэл цагдаагийн албаны тухай хуулиар голчлон эрх зүйн орчныг хангаж иржээ. Манай улсын хувьд Цагдаагийн албаны тухай хуульд ерөнхий байдлаар адилтган авч үзжээ.

Дэлхийн аль ч улс оронд нийгмийн нөхцөл байдлаас үүдэлтэй цагдаагийн алба хаагчийн сурган бэлтгэх шаардлага үүссэн төдийгүй бүх улсад цагдаагийн анхан шатны сургалтыг академик

болон прагматик хэлбэрээр зохион байгуулж байна. Харин шууд цагдаагийн алба хаагчаар томилох, дадлагажигчаар тодорхой хугацаанд ажиллуулах эсэх нь тухайн улс орны зохицуулалтаас шалтгаалж байгаа ба анхан шатны сургалтаас эхлээд үе шаттай хөгжих боломжийг бүрдүүлж байдаг нийтлэг чиг хандлагатай байна. Англосаксоны эрх зүйн бүлийн орнуудад цагдаагийн алба хаагчийг анхан шатны түвшинд түлхүү бэлтгэхэд анхаарч, практикт сургах, дадлагажуулахад голчлон ач холбогдол өгдөг бөгөөд сургалтын эрх зүйн зохицуулалт, хууль, журам, нэгдсэн акт байхгүй. Харин Ром-Германы эрх зүйн бүлийн орнуудад бакалавр, магистр, докторын түвшинд сургах тогтолцоог түлхүү нэвтрүүлсэн төдийгүй дийлэнх оронд цагдаагийн алба хаагчийн сургалтын талаар хууль, дүрэм, журам батлагдсан байна.

Цагдаагийн алба хаагчийн анхан шатны сургалтаас ахисан түвшний сургалт хүртэл бүх зохион байгуулалт нэг удирдлагатай, нэг зохион байгуулалттай, шударга, ил тод байдлаар зохион байгуулагддаг нь цагдаагийн байгууллагын хөгжил, хүний нөөцийн чадамж нэмэгдэх гол гарц болно гэж үзлээ.

Дүгнэлт

Орчин үеийн цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэдэг мэргэжлийн бүтэц, зохион байгуулалттай байх, орон тооны мэргэшсэн алба хаагчидтай байх, албаны дүрэмт хувцас, тусгай хэрэгсэлтэй байх, үйл ажиллагааг нь зохицуулсан эрх зүйн акттай байх зэрэг хэд хэдэн шинжийг бүрдүүлсэн байдаг ба алба хаагчдын мэргэшил, боловсрох, тэднийг сургах, бэлтгэх, хөгжүүлэх асуудал нь хууль сахиулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнгийн үндэс болдог нь эрдэмтэн судлаачдын үзэл баримтлалд харьцуулсан үр дүнгээр илэрч байна.

Бид судалгааны ажлын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж, цагдаагийн алба хаагчийн сургалтын үйл ажиллагааны үзэл баримтлал, түүхэн баримт бичиг, хэрэгжилтийн өнөөгийн байдал, тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, практик хэрэглээний нөхцөл байдлыг судалж үзсэнээр дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Сургалт нь танин мэдэх, аль нэг чадварыг эзэмших үйл явц бөгөөд цагдаагийн алба хаагчийг бэлтгэн сургах, чадваржуулахад олон төрлийн онолоор илэрдэг боловч цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо нь тодорхой бүхэл чанар, нэгдлийг олж өөр хоорондоо холбоо, уялдаа харилцан шүтэлцээнд оршиж байдаг элементийн цогц бөгөөд харилцан үйлчлэлд оршдог элементүүдийн олонлог бөгөөд насан туршийн боловсролын хэв шинжтэй.

2. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3-д заасны дагуу мэргэжлийн анхан, дунд, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтоох эрхийг боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд олгосон бөгөөд үүнийг үндэслэн мэргэжлийн чиглэл, индексийг баталсан нь практикт хэрэгжиж байна. Мэргэжлийн чиглэлийг тогтоох бүрэн эрх боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд байгаа боловч ЮНЕСКО-ийн гаргасан зөвлөмжид суурилан цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн индексийг аюулгүй байдал ангилалд авч үзэх нь учир дутагдалтай байна.

3. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирал дангаар болон хамтарсан байдлаар батлан хэрэгжүүлж байгаа эрх зүйн актууд нь цагдаагийн алба хаагчийн сургалт, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна.

4. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх талаар алба хаагчийн сургалтын тогтолцоо, уялдаа холбоо, залгамж чанарыг зохицуулсан эрх зүйн эх сурвалж, баримт бичиг, хууль, тогтоомжууд хангалттай бий боловч нэгдмэл тогтолцоог бүрдүүлээгүй бөгөөд сургалтууд нь зөвхөн тухайн нэг үе шатны боловсролыг олгоход чиглэж байгаа нь хоорондын уялдааг хангахгүй байх гол нөхцөл болж байна.

5. Бид цагдаагийн алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын байгууллага, цагдаагийн төв байгууллага сургалтыг ямар эрэмбэ дараалал бүхий тогтолцоотой хэрэгжүүлэх талаар авч үзэхийг чухалчилсан бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо нь хэд хэдэн тодорхой үе шаттай, байгууллагуудын хамтарсан буюу эрэмбэ, дараалал бүхий зохион байгуулалттай байх шаардлагатай.

6. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, үйл ажиллагааг зохицуулсан Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны ойлголтыг бусад нөхцөл байдлаас ялгах, практикт зөв хэрэглэх шаардлага тулгарч байна.

Санал

Судалгааны үр дүн, түүний эцэст хийсэн дүгнэлтэд түшиглэн цаашид цагдаагийн алба хаагчийн сургалтын онолын үндсийг тодорхой болгох, үзэл баримтлалыг бий болгон хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, харилцан уялдааг хангах үүднээс тодорхой саналыг дараах чиглэлээр боловсрууллаа.

Нэг. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, ойлголтыг хөгжүүлэх чиглэлээр:

-Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоог системийн онолын үүднээс хэд хэдэн дэд тогтолцоонуудаас бүрдэх бүхэллэг шинжтэй гэж үзэн үзэл баримтлалыг хөгжүүлэх; Үүнд:

- **“Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо”** гэж цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, сургах, хөгжүүлэх өөр хоорондоо холбоотой, уялдаа, харилцан хамааралтай, эрэмбэ, дараалал бүхий сургалтын дэд тогтолцоо буюу элементийн цогц гэсэн тодорхойлолт;

Хоёр. Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар:

- Цагдаагийн алба хаагчийг бэлтгэх, давтан бэлтгэх сургалтын тогтолцоог загварчлах, тус тусын буюу өөр хоорондоо захиалга төдий өгөх байдлаар харилцаж буй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг сургалтын үйл ажиллагаанд хамтрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллагуудын хамтын ажиллагаанд суурилан урт болон богино хугацааны сургалтуудын эрэмбэ, дараалал, ажлын байранд нь шаардагдах сургалтуудыг журамлан зохион байгуулах;

- Цагдаагийн төв байгууллагын сургалт хариуцсан нэгж буюу институтийн орон тоо, албан тушаалыг шинээр байгуулж, сургалтуудын үр дүнг үнэлэх, эргэх холбоог хангах, үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй явуулах нөхцөлийг хангах;

- Цагдаагийн албаны бэлтгэл, давтан, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, сэдвүүдийг хөгжүүлэх, тогтмол болон үе шаттай хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг ангилан зохион байгуулж, алба хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийж хэвших;

Гурав. Цагдаагийн алба хаагчийн сургалтыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар:

- Цагдаагийн алба хаагчдын гүйцэтгэж буй үүрэг, хууль хэрэгжүүлэх, ашиглах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд шаардагдах суурь мэргэжлийг “эрх зүйч” байхаар зохицуулж, мэргэжлийн индексийг шинэчлэн батлах;

- Цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны загварыг шинээр боловсруулсан тогтолцоо нь “Мэргэжил олгох сургалт”, “Албаны бэлтгэл сургалт”, “Давтан, мэргэшүүлэх сургалт”, “Боловсролын зэрэг дээшлүүлэх сургалт” гэсэн хоорондоо харилцаа хамаарал бүхий дэд тогтолцооноос бүрдсэн тогтолцоотой байх нь оновчтой бөгөөд тус бүрийн дэд тогтолцоо, элементийн бүрдлийг харгалзан эрх зүйн зохицуулалтыг хангах;

- Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй албаны сургалтын төрлүүдийг түвшин, хугацаа, зохион байгуулалтын талаар шинэчлэх шаардлагатай бөгөөд ангилал тус бүрд бүрдлийг ханган, цахим сан үүсгэж, алба хаагчдыг хамрагдах боломжийг бүрдүүлэх зэргийг журмаар зохицуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

- Цагдаагийн алба хаагчийн сургалтыг зохицуулсан холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай бөгөөд цагдаагийн алба хаагчийн сургалтын тогтолцооны ойлголтыг практикт

зөв хэрэглэх нь хууль сахиулагчдын онолын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургалтын тогтолцоог эргэлтэд оруулан хэрэгжилтийг хангах зэрэг болно.

Ашигласан материалын жагсаалт

1. Батзориг, Б. Гэмт хэргийн бодит тоон үзүүлэлийг тогтооход нөлөөлж болох хүчин зүйлс, гэмт явдалтай тэмцэх асуудал. -Уб. 2002
 2. Гантөмөр, Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. -Уб., 2011
 3. Ичинхорлоо, Ш. Сургалтын онол, арга зүй. -Уб., 2018
 4. Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. -Уб., 2017
 5. Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хураангуй. -Уб., 2019
- Гадаад эх сурвалж:
6. A.Hüseyin, B.Fatih, Y.Mehmet. “Türk Polis Eğitiminde Durum Eğitimi Modelinin Uygulanması, Polis Eğitiminde Modern Uygulamalar” , 2012, Ankara.
 7. Başar, H. Sınıf Yönetimi. Ankara: Milli Eğitim Bakanlığı Yayınları No., 2009
 8. M.Knowles. A Theory of Adult Learning: Androgogy, The Adult Learner: A Neglected Species, 4th Ed., Houston: Gulf Publishing Company, 1990
 9. E.Lindeman. “Насанд хүрэгчдийн боловсролын утга учир”, 2001 он
 10. Allard, Frank Dennis. Police probationer training : policy and practice an historical review. 1997. University of Hull
 11. Hills, Andrew. A case study to investigate the application of programme evaluation theory to the Metropolitan Police Diversity Training Programme. 2005. University of Hull.

--oOo--

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТАД
ТАНХИМЫН БОЛОН ЗАЙН СУРГАЛТЫГ АШИГЛАХ ӨНЦЛОГ ШИНЖ
FEATURES OF USING CLASSROOM AND DISTANCE LEARNING IN TRAINING
HUMAN RESOURCES OF POLICE ORGANIZATION**

Т.Туяа

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

T. Tuuya

Senior lecturer of Police School,
University of Internal Affairs,
police lieutenant colonel

Хураангуй. Мэдээллийн эрин зуунд суралцаж буй сонсогч, суралцагчдад мэдээллийн технологи, түүний өргөн хэрэглээний тусламжтайгаар сургалтын үйл ажиллагааг орчин үеийн техник технологийн дэвшилд суурилсан зайн болон танхимын хосолмол хэлбэрийг нэвтрүүлэх нь ач холбогдолтой. Энэхүү асуудлаар олон улсад сургалтын ач холбогдолын талаар хийгдсэн судалгаа, туршлагыг үр дүнгээс харахад сургалтын энэхүү хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэхэд сонсогч, суралцагчдын суралцах арга барил хандлага, мэдээллийн технологийг ашиглах чадвар, онлайн сургалтаар мэдлэг эзэмших боломж нэн чухал хүчин зүйлс юм. Иймд дээрх хүчин зүйлсийн одоогийн байдалд хийгдсэн судалгаа, дүн шинжилгээг харьцуулан үзэхэд хосолмол сургалтыг хэрэгжүүлснээр суралцагчдын сургалт, судалгааны ажлын дүн шижилгээ, үнэлгээ ахисан үзүүлэлттэй байна.

Abstract. For cadets and students learning in the era of information technology, with the help of modern information technology, it is more beneficial and meaningful to organize any training in a combined form of teaching classroom and distance education based on technological innovations. According to the results of international research and experience on the importance of training in this matter, the learning methods and attitudes of cadets and students, the ability to use information technology, and the opportunity to acquire knowledge through online training are significant factors in the efficient implementation of this type of training. Therefore, comparing the research and analysis of the above factors, the analysis and evaluation of students' training and research work have improved by implementing combined and interactive training.

Түлхүүр үг: Мэдээллийн технологи, технологийн дэвшлийн хурд, онлайн сургалт, зайн сургалт, танхимын сургалтын арга, хэлбэр

Keywords: Information technology, speed of technological development, online learning, distance learning, classroom learning methods, and forms.

Үндсэн хэсэг. XX зууны дунд үед уламжлалт сургалт буюу нүүр нүүрээ харсан танхимын сургалт зонхилж байсан бол орчин үед зайн сургалт, онлайн сургалт, хосолсон сургалт илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна. Мэдээллийн технологийн асар хурдацтай хөгжил нь сургалтын арга хэлбэр, заах арга зүй шинэчилэхэд хамгийн гол түлхэц болсон гэж үздэг. Сургалтын арга зүйн мэдээлэлжсэн эрин зуунд суралцах улам амар хялбар болж байгаа гэдэгтэй та санал нийлэх бизээ. Мэдээлэл харилцааны технологи, зайн сургалт, интернэт болон вэбэд суурилсан сургалт, онлайн сургалт гэх мэт.

Зайн сургалт гэдэг нь нэг үгээр хэлбэл мэдээллийн технологид суурилсан сургалт юм. Зайн сургалтын материалыг боловсруулах нь танхимын сургалтын материал боловсруулахаас үнэтэй, цаг хугацаа, хүн хүч, хөдөлмөр их шаарддаг. Харин боловсруулж, бэлтгэсний дараа зайн сургалтыг явуулах нь танхимын сургалтыг явуулахаас олон талаараа давуу талуудтай байдаг.

Сургалтанд мэдээллийн технологи тэр дундаа мультимедиа технологийг ашиглах нь хийсвэр ухагдахуунууд болон төсөөлж, харахад төвөгтэй зүйлсийг бодит юм шиг харагдуулан хичээлийг ойлгомжтой, илүү сонирхолтой болгоод зогсохгүй онолын хэсгийг заах хугацааг багасгаж суралцагчдын дадлага хийх цагийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл, онлайн сургалт гэдэг нь интернэт ба сургалтын нийлбэр цогц ойлголтыг хэлдэг.

Онлайн сургалтыг боловсруулдаг түгээмэл аргын нэг бол ADDIE буюу үндсэн таван алхамт үйл ажиллагаа юм.

- Analysis (Судалгаа, шинжилгээ) – Энэ үе шатанд тухайн сургалтыг хүргэхэд заах арга зүйн ямар хүндрэл байгааг илрүүлдэг ба, сургалтын зорилго, зорилтуудаас гадна суралцагчийн одоогийн мэдлэг, ур чадварын түвшинг тодорхойлдог.
- Design (Дизайн, шийдэл) – Энэ үе шат нь сургалтын зорилтыг хэрхэн хангах, үнэлгээний ямар хэрэгсэл сонгох, дасгал ажил, агуулга, мэргэжлийн багшийн дүн шинжилгээ, хичээлийн төлөвлөлт болон тохирох медиа бүрэлдэхүүнийг сонгох зэрэг асуудлууд багтана.
- Development (Боловсруулалт) – Боловсруулалт, хөгжүүлэлтийн шатанд Заах, арга зүйч болон Медиа боловсруулагч нар дизайны түвшинд тодорхойлсон тойм зураглалын дагуу шаардлагатай медиа бүрэлдэхүүнүүдийг боловсруулж, нэгтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Мөн ерөнхий зураглал (Storyboard)-ыг Заах арга зүйч, тухайн сэдвийн багшийн гарган өгсөн агуулгын дагуу бэлтгэх ба хамтран график дүрслэлийн дизайныг хийдэг. Бэлэн болсон ерөнхий зураглал болон мэргэжлийн багшийн өгсөн материалыг ашиглан цахим объект боловсруулах ажлыг мультимедиа мэргэжилтнүүд/програмистууд хийдэг.
- Implementation (Хэрэгжүүлэлт, туршилт) – Энэ шатанд бэлэн болсон цахим объектыг СУС-д байршуулж туршдаг. Мөн энэ талаар багш нар болон суралцагчдад сургалт явуулна. Багш нарт явуулах сургалт нь хичээлийн хөтөлбөр, сургалтын үр дүн, сургалтын арга зүй болон шалгалтын үе шат зэргийг агуулдаг.
- Evaluation (Үнэлгээ) – Форматив болон суматив гэсэн үндсэн хоёр төрлийн үнэлгээ хийнэ. Форматив буюу явцын үнэлгээ нь дээр дурдсан үе шат бүрт хийгддэг бол суматив үнэлгээний зорилго нь боловсруулсан бүтээгдэхүүндээ хэрэглэгчдийн санал бодлыг авахад оршдог.

Энэхүү сургалтын боловсруулалт нь багийн ажил бөгөөд, хийх ажлын цар хүрээ, багийн гишүүдийн ур чадвар, туршлага, тухайн ажлыг гүйцэтгэх хугацаа, техникийн хүчин чадал зэргээс хамааран багийн бүрэлдэхүүнийг шийдэгддэг.

Манай улсад өнөөгийн байдлаар бүх түвшний сургалтыг онлайн хэлбэрээр явуулахад сонсогч, суралцагчдын хэрэгцээ, сонирхол, дэлхийн даяаршилт, техник технологийн өргөн хэрэглээ зэрэг олон хүчин зүйлсийн улмаас зайн сургалтын хэлбэрийн хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Энэ нь онлайн болон танхимын сургалтыг хослуулсан сурган хүмүүжүүлэх шинэ арга ухаан хэмээн тооцогдож байгаа бөгөөд боломжит олон аргыг хооронд нь агуулгаар нь холбох, суралцагч төдийгүй багш хоорондын харилцааг дэмжих боломжтой сургалтын хэлбэр юм.

Сүүлийн үед боловсрол судлаачдын нэлээд анхаарлын төвд байгаа сэдэв бол идэвхтэй буюу суралцагч төвтэй сургалтын арга технологи юм. Уламжлалт буюу танхимын сургалтын явцад хичээлийг төлөвлөх, лекц унших, тайлбарлах, зохион байгуулах, шалгах, үнэлэх зэргээр бүхий л үйл ажиллагааг багш удирддаг учир хичээлийн үеэр оюутнууд сонсох, тэмдэглэл хөтлөх, асуултад хариулах, шалгуулах, дүгнүүлэх зэргээр идэвхгүй үйлдлүүдийг голлон гүйцэтгэдэг. Харин цахим буюу зайн сургалтын явцад суралцагч нэмэлт мэдээллийн эрэл хайгуул хийх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сурах үйл явцаа өөрөө бие даан төлөвлөх, өөрийн үнэлгээ хийх, эргэлзээтэй асуудлыг эрэл хийх, асуулт бэлтгэх, багшаас зөвхөн чиглэл авах замаар хичээлд оролцдог. (Salcedo, 2010)¹⁰⁰

¹⁰⁰ Salcedo, C. S. (2010). Comparative analysis of learning outcomes in face-to-face foreign language classes vs. language lab and online. J. Coll. Teach. Learn., 7, 43–54.

Танхим болон зайн сургалтын хэлбэрийг харьцуулсан судалгаанд танхимын сургалт ихэвчлэн багш төвтэй учир суралцагчаас суралцахуйн идэвхгүй үйлийг шаарддаг харин зайн сургалт нь суралцахуйн идэвхтэй үйлд суралцагчийг чиглүүдэг гэж үзэх хандлага ажиглагддаг. Тиймээс танхим болон зайн сургалтын давуу талуудыг хослуулан боловсруулсан сургалтын холимог-blended, хосолмол-hybrid, тонгоруу-flipped гэсэн хэлбэрүүд боловсролын системд хөгжиж үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд цөөнгүй байна.

Хосолсон сургалтын загвар нь уламжлалт заах арга зүйн нэг хэлбэр болох амьд, нүүр тулсан харилцааг хөнгөвчлөх зорилгоор медиа технологитой хослуулдаг ба эдгээр хослолууд нь хосолмол сургалтыг нэвтрүүлэхэд ихээхэн давуу тал олгодог ч нэгтгэх явцад сул тал, бэрхшээлүүд гарч ирдэг. Тиймээс олон улсын эрдэмтэн судлаачид судалгааны бүтээлээрээ энэхүү хосолмол сургалтын давуу талуудыг нээлттэй хуваалцахын зэрэгцээ уг сургалтын онцлогоос шалтгаалан тулгардаг сул талуудыг авч үзсэн байдаг. Тухайлбал, Midwestern их сургуулийн инженерийн коллежийн тэнхимийн багш нар энэхүү сургалтыг явуулахдаа дараах гурван саад бэрхшээлтэй тулгарсан байна (Ilg, 2015). Үүнд: 1) цаг хугацаа их шаардагддаг, 2) багш, оюутны харилцаа хөндийрдөг, 3) техникийн асуудал.¹⁰¹ Үүнийг тайлбарлавал, сургалтын агуулга бэлтгэн, хөгжүүлэхэд жил гаруй хугацаа зарцуулсан нь эхний бэрхшээл байв.

Мөн түүнчлэн сэдвийн агууллагаас хамааран лабораторид д явуулах нарийн төвөгтэй дасгал ажлыг боловсруулах нь цаг хугацаа илүү шаардсан ажил байв. Сонирхолтой, бодит дасгалуудыг бий болгох нь зөвхөн сурах бичгээс жишээ авахаас огт өөр зүйл байсан тул багш, ажилчдаас багагүй хүчин чармайлт шаардсаныг онцолсон байдаг. Хоёрдахь бэрхшээл нь оюутнуудтай холбоо тогтоохгүй байх явдал байв.

Энэ нь сургалтын уян хатан байдлын нөгөө тал гэж үзэж болох юм. Оюутнуудад хэт их ачаалал үүсгэхгүйн тулд онлайн дасгал даалгаварт зарцуулах цаг хугацаанаас хамаарч оюутнуудтай харилцах цагийг бууруулсан нь эмх цэгц, зохион байгуулалттай сургалтын арга барилыг илүүд үздэг зарим оюутнуудад энэ нь сул тал байж болох талтай. Мөн гурав дахь бэрхшээл нь, шинэ сургалтын дизайн, онлайн агуулгыг хөгжүүлэх, видео лекц засах, асуулт хариултын тест хийх зэрэг сургалтын бэлтгэл ажилд техник технологийн өндөр мэдлэгтэй баг хамт олон шаардлагатай болж байсан гэжээ.

Сургалтын технологи нь юуны өмнө үйл ажиллагааны болон бүтэц тогтолцооны онол, оношлон танихад үндэслэн цаашид хөгжих учиртай. Иймээс өрнө, дорнын гүн ухаан, боловсрол судлал, сэтгэл судлал, хүн судлал, залуур зүйн ухаантай нягт уялдаатайгаар сургалт-үйлдвэрлэл-шинжлэх ухааны хоршлыг бүх түвшинд хангахуйц сургалтын технологи боловсруулахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэх ёстой гэж үзсэн болно.

- Сургалтыг эрчимжүүлэн экстенсив хэлбэрээс интенсив хэлбэрт шилжих оновчтой болгох тодорхой үр дүнд хүрэх технологи боловсруулалт хийснээр сургалтын явцад цаг хожих, хүний хүчин зүйлийн ашиглалт сайжирна.
- Бие хүний төрөлх шинж, онцлогт тохируулан аль талыг хүчтэй хөгжүүлэн, цаашид энэ талд нь түшиглэн сургалтыг зохион байгуулах технологи шинэчлэл хийвэл сургалтын агуулга, бүтэц түүний зохион байгуулалтын хэлбэрт зарчмын өөрчлөлт орох юм.
- Сургалтын агуулга, түүнийг хэрэгжүүлэх хэрэглэгдэхүүн, бичиг баримт багш суралцагчийн аль алинд нь зориулан бэлтгэж, уян хатан бүтэцтэй сургалтын технологи боловсруулснаар суралцагсдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, өнөөгийн багш төвтэй сургалтын технологийг өөрчилж чадна.
- Багш сурган хүмүүжүүлэгчид өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлэх, боловсронгуй болгохоос өөр замгүй тийм эрчимтэй, оновчтой, чөлөөтэй сургалтын хувилбар, технологид шилжвэл багш нарын мэдлэг, боловсрол технологи, ур чадварыг нэмэгдүүлэхэд хүчтэй хөшүүрэг болно.

¹⁰¹ Ilgu, A. K. (2015). Faculty Perspectives on Benefits and Challenges of Hybrid Learning. 122nd American Society for Engineering Education Annual Conference and Exposition 2015: Making Value for Society. Seattle, Washington, USA.: American Society for Engineering Education (ASEE).

Суралцахуйн тогтолцоог оновчтой сонгох, үр дүнг тооцох, үнэлэх, танин мэдэхүйн үндсэн зүй тогтол, үе шатанд зохицуулагдснаар энэхүү хосолмол сургалтын технологийг ахисан түвшний сургалтад ашиглах давуу талтай. Тухайлбал: ахисан түвшний сургалтын технологийн явц нь олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд судалгааны ажил хийхэд шаардагдах материал, өгөгдлийг судлаачдад хамгийн бага хугацаанд хүссэн гадаад хэл дээр, эх сурвалж тодорхой дамжуулалт нь технологийн дэвшил юм.

Онлайн сургалт гэдэг нь компьютерийн сүлжээний төрлүүдийг ашиглан орон зай, цаг хугацаанаас үл хамааран, өөрийн сурах үйл явцаа зохион байгуулах, суралцагдчын суралцах чадварыг хөгжүүлэх, суралцах сонирхолыг идэвхижүүлсэн хэлбэр мөн. Боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрэгжүүлэх явцад сургалтыг танхим болон онлайн сургалтын технологийг оновчтой хэрэгжүүлснээр суралцагчаас судалгааны материал хайх, цуглуулах, түүний боловсруулалт нь судалгааны ажилд илүү үр өгөөжтэй байх давуу талууд бий.

Дүгнэлт

1. Олон улсын их дээд сургуулиуд дээр хийгдэж байгаа сургалт, судалгааны ажлуудын үр дүнгээс харахад орчин үеийн мэдээлэл, техник технологийн дэвшил төдийгүй нийгэм, эдийн засгийн байдал бүх шатны сургалтыг танхим болон зайн хосолсон хэлбэрт хурдацтай шилжих нөхцөл бүрдсэн байна.

2. Хосолсон сургалтын хэлбэрүүдийг хэрэгжүүлэхэд дидактик зарчмыг гүнзгийрүүлэн судлах, сургах зүйн талаас багшлах боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн дизайн болон хэрэглэгдэхүүнийг боловсруулах бэлтгэл ажил шаардлагатай.

3. Танхим болон зайн хосолсон сургалтыг нэвтрүүлэхэд онол, практикийн судалгааг олон талаас нь хийх, боловсролын суурь зарчимд түшиглэсэн туршилт сургалтууд хэрэгжүүлэх, судлагдахууны онцлогоос шалтгаалан сургалтын хэлбэрийг сонгох гэх зэргээр шинжлэх ухаанч байр суурьтай, зохион байгуулалттай үйл ажиллагаа шаардлагатай болох нь харагдаж байна.

4. Өнөөгийн байдлаар сургалтын технологийг хэт өргөн хүрээтэй авч үзэж, бүхнийг технологи гэж тайлбарлан явцуу хүрээгээр үгүйсгэх, туйлшрах хандлагууд байгаа нь дидактикийн онолын хөгжил, сургалтын технологийн шинэчлэлд сөрөг нөлөөтэй гэдгийг бид анхаарах явдал. Боловсролын технологийг боловсронгуй болгох, шинэчлэх явцад өөрчлөгдөх зарим хандлага, чиглэлийг баримтлах нь чухал хэмээн дүгнэж байна.

Ашигласан материал

1. Боловсролын тухай хууль. УБ., 2016 он
2. Лувсандорж Ц., Цахим сургалтын гарын авлага. УБ. 2013 он
3. Ичинхорлоо Ш., Сургалтын онол, хэрэглээ УБ. 2013 он
4. Ilgu, A. K. (2015). Faculty Perspectives on Benefits and Challenges of Hybrid Learning. 122nd American Society for Engineering Education Annual Conference and Exposition 2015: Making Value for Society. Seattle, Washington, USA.: American Society for Engineering Education (ASEE)
5. Salcedo, C. S. (2010). Comparative analysis of learning outcomes in face-to-face foreign language classes vs. language lab and online. J. Coll. Teach. Learn., 7

--o0o--

СУРГАЛТЫН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛД БАГШИЙН ҮҮРЭГ

ROLE OF THE TEACHER IN THE DEVELOPMENT OF LEARNING TECHNOLOGY

Д.Нямдорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн хошууч

D. Nyamdorj

Teacher of police Law department, Police school
of University of Internal Affairs, Police major

Хураангуй. Энэхүү өгүүлэлд сургалтын технологийн тухай ойлголт, онолын үндэс, сургалтын технологийг боловсруулах үе шат болон багшийн сургалтын ажлыг үнэлэх, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны зарим үр дүнгийн талаар товч авч үзсэн болно.

Abstract.. In this article, the concept of learning technology, its theoretical basis, the stages of developing learning technology, and some of the results of the study of student satisfaction and evaluation of teacher's teaching work are briefly discussed.

Түлхүүр үг. Сургалтын технологи, онол, сургалт, боловсруулах үе шат, сургалтын ажил

Key word. Teaching technology, theory, training, development stage, training work

Оршил хэсэг. Боловсролын тогтолцооны үндсэн үйлдвэрлэл болон сургалтын технологи нь улам боловсронгуй болж байдаг хөгжлийн зүй тогтолтой билээ. Анги, танхимын хэлбэрээр явуулах сургалт нь боловсрол эзэмшүүлэх илүү үр дүнтэй арга сургалтын технологийг тасралтгүй хөгжүүлэхэд багшийн үүрэг чухал болсон өнөө үед сургалтын технологийг урсгалаараа өөрчлөгдөж байдаг үзэгдэл хэмээн үзэж болмооргүй байна. Сургалтын технологийн асуудлаар Монголын эрдэмтэд, судлаачид онол практикийн талаас нь цөөнгүй судалгааг хийсэн байдаг. Технологи судлалын асуудлыг янз бүрийн түвшинд авч үзсэн байхын зэрэгцээ салбар ухаан тус бүрийг тус тусад нь байгаагаас үзвэл технологийн тухай нэгдсэн ойлголтод өнөө хүртэл хүрээгүй байгааг илтгэн харуулж байна.

Сургалтын технологийг улам боловсронгуй болгож ирсэн хэдий ч соёлын шинэ үнэлэмж, үнэт зүйлсийг цоо шинээр хүлээн авахын хэрээр сургалтын технологи нийгмийн хөгжлийн явцаас урган гарсаар байна. Тэгвэл манай орны хувьд сургалтын технологийн шинэчлэл хийх ямар, ямар хэрэгцээ шаардлага байгааг авч үзэхийн өмнө уг үзэгдлийн мөн чанарыг ойлгох нь нэн чухал юм.

Сургалтын онолын үндэс. Өнөө үед сургалтын технологийг урсгалаараа өөрчлөгдөж байдаг үзэгдэл хэмээн үзэхээргүй байна. Сургалтын технологи хэмээн нэр томъёог 1960-аад оноос сургалтад техник хэрэгсэл, программчилсан сургалтыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор ярьж бичих болсон. Боловсролын хөгжлийн түүхэнд нэр томъёог 1960-аад он хүртэл хэрэглэж байгаагүй ч түүнийг боловсруулах асуудал хүнийг сурган хүмүүжүүлэх үйл явцтай хамт хөгжиж ирсэн хэмээн үзэж болно.¹⁰²

Оросын /ЗХУ хуучнаар/ сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменскийн анги, хичээлийн систем бий болсноор улам гүнзгийрэн хөгжиж ирсэн байна. Эрдэмтэн Д.Ванчинсүрэн “Хүний боловсрол, хүмүүжил, төлөвшлийн горимын тухай ойлголт өөрөөр хэлбэл хүнээр хийх ухаан буюу хүний гарыг ганзаганд, хөлийг дөрөөнд хүргэх нийгмийн тогтолцоо” хэмээн үзжээ. Мөн түүнчлэн сургалтын технологи гэдэг нь нэг цагийн дотор гүйцэтгэх багш, шавийн үйл ажиллагааны мөрдөх горимыг тодорхойлсон ухагдахуун хэмээн байна. Энэ асуудлаар судлаач Г.Эрдэнэ-Очир “Сургалтын технологи гэдэг нь сургууль боловсролын байгууллагын өмнө тавьсан зорилго түүнийг

¹⁰² Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. 1992. №1.

хэрэгжүүлэхэд баримталдаг зүй тогтол, зарчим, зохион байгуулах хэлбэр, аргын түгээмэл дэс дараа, зохистой хувилбар” хэмээн тайлбарласан нь бий.

Хөгжингүй орнуудад хэрэглэж байгаа нээлттэй сургууль, цахим сургууль, зайны сургалт, программчилсан сургалт зэрэг хэлбэрүүд бүгд л технологийг төлөөлөх илэрхийлэл юм. Оросын эрдэмтэн Н.Ф.Талызина “Технологи бол нэг талаас ур чадварын шинжлэх ухаан, нөгөө талаас бүтээгдэхүүнийг янз бүрийн аргаар боловсруулах дамжлага юм. Мөн удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулсан үйлийг гүйцэтгэх хамгийн оновчтой эрэмбэ, дэс дараа, түүний хувилбар” гэж үзэж байхад, Европын сургалтын онолчид, “Сургалтанд дэвшигдсэн зорилт түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зүй тогтол, зарчим зохион байгуулах хэлбэр” гэсэн байхад, АНУ-ын эрдэмтэн Б.Блум “Сургалтын материалыг эзэмшихэд зарцуулсан хугацаа” хэмээн тодорхойлсон байна.

Гэтэл Японы эрдэмтэн Т.Сакамото “Сургалтыг системчлэх явдал” хэмээн өөр өөр өнцгөөс тайлбарласан байдаг. Сургалтын технологийн шинэчлэлийн семинарт зориулсан баримт бичигт “Сургалтын технологи гэдэг нь бие хүний буюу суралцагсдын мэдлэг, дадлага, хандлагын өөрчлөлтийг буюу чанарын хувиргалтын үйл явцыг зохион байгуулах соёл буюу ур ухаан, арга зам” хэмээн тодорхойлжээ. Хичээлийн технологи гэдэг нь суралцахуйн түгээмэл үйлийн дэс дараа, оновчтой хувилбар гэж тодорхойлсон байна.¹⁰³

Монгол Улсын зөвлөх, Монгол Улсын гавъяат багш, судлаач Н.Лхагва, “Сургалтын технологи гэдэг нь боловсролын байгууллагын “орцыг”, “гарц” болгон хувиргадаг сургалтын үйл явц юм. Монгол хүүхдийн төрөлх эрх, язгуур эрх ашгийг дээдлэх, Монгол хүүхдийн төрөлхийн гарваль шинж, давтагдашгүй онцлогт нийцсэн сургалтыг зохион байгуулах шинэ хандлагыг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн ялгавартай байдлыг хүлээн зөвшөөрөх, ялгавартай байдлаар явж болдог хэрэглээнд тулгуурласан сургалтын шинэ хандлага, сургалтын шинэ хэлбэр, арга технологи, сургуулийн шинэ хэв шинж бий болгох явдал” хэмээн үзсэн байна.

Нийгмийн өөрчлөн байгуулалт, боловсролын шинэ эрхэм зорилго боловсрол судлалын үндсэн ухагдахууны агуулгын өөрчлөлт, боловсролын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шинэ зарчим, шинэ стратеги буюу ур ухаан, арга зам зэрэг олон хүчин зүйлийн улмаас технологийн шинэчлэл хийх үндэслэл гарч ирдэг.

Сургалтын технологийг боловсруулахад дараах үндсэн зарчмыг баримталсан болно.

- Хүүхдийн төрөлх эрх, язгуур эрх ашигт нийцсэн байх зарчим:
- Сургалтын технологийг сонгож авахдаа уян хатан, олон хувилбартай байх чиглэлийг барина гэсэн үг юм.
- Эрчимтэй байх зарчим:
- Сургалтын үйл явц нь зорилтыг илүү хурдан шийдвэрлэхийг шаардана. Энэ зарчим нь хамгийн бага цаг, хугацаа зарцуулж илүү үр дүнд хүрэхэд оршино.
- Үйл ажиллагаанд тулгуурлах зарчим:
- Онол практикийн нэгдлийг хангах амьдрал үйл ажиллагаанаас салангид - мэдлэг байж болохгүй.¹⁰⁴

Учир нь амьдрал, хөдөлмөрт бэлтгэхийн тулд боловсролыг зохион байгуулдаг тул үйл ажиллагаанд тулгуурлах зарчим гэдэг нь сургалтын ямар ч хувилбарын технологи боловсруулах явцад онол, практикийн нэгдлийг хангаж, бодит үйл ажиллагаа, хөдөлмөрийнхөө үйл явцад тасралтгүй оролцох нөхцлийг хангах ёстой гэсэн үг юм. Өнөөгийн байдлаар сургалтын технологийг хэт өргөн хүрээтэй авч үзэж, бүхнийг технологи гэж тайлбарлах, аль эсвэл алхам тутамдаа даган давтах хэв загвар мэтээр үзэж явцуу хүрээгээр үгүйсгэх, зөвхөн монгол технологи хэмээн туйлшрах хандлагууд байгаа нь дидактикийн онолын хөгжил, сургалтын технологийн шинэчлэлд сөрөг нөлөөтэй гэдгийг бид юуны өмнө анхаарах хэрэгтэй. Цаашид боловсролын технологийг боловсронгуй болгох, шинэчлэх явцад дараах зарим хандлага, чиглэлийг баримтлах нь чухал байна.

¹⁰³ Наранчимэг, Н. Боловсролын шинэчлэл хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. Багш сонин. Уб.1999.

¹⁰⁴ Пүрэвдорж, Ч. (1999). Боловсролын шинэчлэл, хөгжлийн онол арга зүйн асуудал. Улаанбаатар

Нэг. Сургалтын технологийг дидактикийн онолын нэгэн судлагдахуун гэж үзсэнээр тухайн ухагдахууныг хэт өргөсгөхгүй байх боломжтой болохын зэрэгцээгээр түүний судлагдахууныг тодотгох боломжтой болно. Дидактик буюу сургах зүй нь сургалтын бүхий л үйл явцын түгээмэл зүй тогтол, зарчим, ерөнхий шаардлага, дүрэм, хэлбэр, арга барилыг судалдаг учраас сургалтын технологийг сургалтын тодорхой зорилго, үр дүнгийн хоорондох үйл явц, түүний оновчтой хувилбарыг судлах чиглэлээр хөгжүүлэх хэрэгтэй гэж үзэж болно.

Хоёр. Сургалтын технологи нь юуны өмнө үйл ажиллагааны болон бүтэц тогтолцооны онол, оношлон таних, авах гээхийн ухаанд үндэслэн цаашид хөгжих учиртай. Иймээс өрнө, дорнын гүн ухаан, боловсрол судлал, сэтгэл судлал, хүн судлал, залуур зүйн ухаантай нягт уялдаатайгаар сургалт-үйлдвэрлэл-шинжлэх ухааны хоршлыг бүх түвшинд хангахуйц сургалтын технологи боловсруулахын тулд дараах зорилтуудыг шийдвэрлэх ёстой гэж үзсэн болно.¹⁰⁵

- Сургалтыг эрчимжүүлэн экстенсив хэлбэрээс интенсив хэлбэрт шилжих оновчтой болгох тодорхой үр дүнд хүрэх технологи боловсруулалт хийснээр сургалтын явцад цаг хожих, хүний хүчин зүйлийн ашиглалт сайжирна.

- Бие хүнийг сургалтын тулгуур болгон хүн төвтэй сургалтыг хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт бэлтгэх, үндэсний онцлогт тохирсон технологи боловсруулснаар өнөөгийн сургалтад ноёрхсон субъект, объектын харилцааг субъект, субъектын харилцаа болгож сая чадах юм.

- Бие хүний төрөлх шинж, онцлогт тохируулан аль талыг хүчтэй хөгжүүлэн, цаашид энэ талд нь түшиглэн сургалтыг зохион байгуулах технологи шинэчлэл хийвэл сургалтын агуулга, бүтэц түүний зохион байгуулалтын хэлбэрт зарчмын өөрчлөлт орох юм.

- Сургалтын агуулга, түүнийг хэрэгжүүлэх хэрэглэгдэхүүн, бичиг баримт багш суралцагчийн аль алинд нь зориулан бэлтгэж, уян хатан бүтэцтэй сургалтын технологи боловсруулснаар суралцагсдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, өнөөгийн багш төвтэй сургалтын технологийг өөрчилж чадна.

- Аль болох бага наснаас нь ирээдүйн амьдрал, мэргэжилд нь бэлтгэх чиглэлээр ерөнхий боловсролын агуулгыг өөрчлөн тогтоож, хэрэгжүүлэх технологи хэрэглэж эхлэвэл ерөнхий ба мэргэжлийн боловсролын залгамж холбоо сайжирч мэргэжилтний чадамж дээшлэх юм.

- Багш сурган хүмүүжүүлэгчид өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлэх, боловсронгуй болгохоос өөр замгүй тийм эрчимтэй, оновчтой, чөлөөтэй сургалтын хувилбар, технологид шилжвэл багш нарын мэдлэг, боловсрол технологи, ур чадварыг нэмэгдүүлэхэд хүчтэй хөшүүрэг болно. Суралцахуйн тогтолцоог оновчтой сонгох, үр дүнг нь хэрхэн яаж тооцох, үнэлэх хүртэлх бүх шатыг танин мэдэхүйн үндсэн зүй тогтол, үе шатанд зохицуулан, тухайн нөхцөлд тохирсон хувилбараар сонгох хэрэгтэй болно. Энэ хувилбарын эрэл бол бидний ярьж буй технологийн эрэл юм. Сургалтын технологийг ямар ч түвшинд тодорхойлж болох талтай. Тухайлбал: Сургалтыг танин мэдэхүйн нэг хэлбэр буюу үйл явц, үр дүн гэхчлэн үйл ажиллагааны үе шат гэж үзэхээс технологи боловсруулалт янз бүр байж болно.

Багш, сурган хүмүүжүүлэгчдийн олон үеийн турш боловсруулсан арга технологи хязгааргүй олон хувилбартай, дахин давтагдашгүй байсны учир ч бас энд бий. Өнөөдөр аль ч шатны сургалтын байгууллагад хэрэглэж байгаа сургалтын технологи нь танин мэдэх, мэдлэг эзэмших, тодорхой үе шатыг үндэс болгосон нэгэн нийтлэг технологи ажээ. Энэ нь олон үеийн турш нэг л загвараар хэрэглэгдсээр сонгомол шинжтэй болсон хэдий ч өөртөө олон сул талтайг бид ярьсаар л байгаа. Юуны өмнө суралцахуйн үйл ажиллагааг хүнлэг, хүмүүнлэг уян хатан харилцаа болгоход уламжлалт технологийн нийтлэг бүтэц саад тотгор болсоор байгааг тэмдэглэх хэрэгтэй юм.

Технологийн хувьсгал хийхгүйгээр нийгмийн үйлдвэрлэл хөгжихүйн нэг адил сургалтад технологийн хувьсгал хийхгүйгээр бид үндэсний соёлын болон оюуны санг арвижуулж чадахгүйд хүрч улмаар хойч үе маань сэтгэхүй, оюуны хоосролд хүрч болзошгүй юм. Сургалтын технологи шинэчлэх зарим эрэлт хайлт Сургалтын технологийн хувилбарыг боловсруулахад тулгуур болохуйц зарим дүгнэлтүүдтэй энд танилцъя.

¹⁰⁵ Авдай, Ч., Энхтуяа, Д. (2000). Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй. Улаанбаатар

Сургалтын технологийг боловсруулахын тулд дараах үе шаттайгаар сургалтын ажлыг зохион байгуулах нь илүү оновчтой болно гэж үзсэн болно.¹⁰⁶ Үүнд:

- Сургалтын үе шат бүхэнд сургалтын агуулгыг тодорхойлно. Үүний тулд сургалтын зорилго, чиглэлийг оношлох, анги бүхэнд судлах, судлагдахууны нэгдэл, залгамж холбоо, шинжлэх ухааны үүднээс тодорхойлсон судлагдахуунуудын агуулга орох юм. Энэ үр дүн нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн оновчтой бүтэц, хувилбаруудаас шууд хамаарна.

- Суралцагсдын ачаалал зэргийг шалгах, сургалтыг зохион байгуулахад шаардагдах сургалтын хугацаа, суралцагчийн мэдлэг эзэмших хурдыг тодорхойлох. Үүний үр дүн нь хэт ачааллын коэффициент болон сургалтын хугацааг бодитой тогтоох юм.

- Сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах хэлбэрүүдээс ганцаарчилсан, хэсэгчилсэн, анги нийтийг сонгож авах, энэ шатны үр дүн нь сонгон авсан зохион байгуулалтын хэлбэр ба түүнд шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүнүүдээр сурах бичиг, сургалтын техник хэрэгслүүд материал зэрэг нь/ тодорхойлогдоно.

- Сургалтын явцад эзэмшүүлэх мэдлэгийг бататгах дасгалуудын систем ба хичээлээр эзэмшүүлэх мэдлэгийг үнэлэх өгөгдсөн үзүүлэлтүүдийн чанараар тодорхойлогдоно.

- Суралцагсдын мэдлэг, дадлага эзэмшилтийн чанарт шалгалт хийх хяналтын материалуудыг боловсруулах. Үр дүнг нь тестийн сан, мэдлэг эзэмшилтийн шалгуур үзүүлэлтүүд болон суралцагчдын бүтээлч сэтгэхүйн түвшин ямар байгаагаар тодорхойлогдоно.

- Суралцагсдад мэдлэг эзэмшүүлэх, хөгжүүлэх зорилгыг оновчтой шийдвэрлэх, хичээлийн бүтэц, агуулгыг тодорхойлох, бие даасан ажлыг төлөвлөх. Үр дүн нь суралцагчдын бие даах ажлын арга зүй болон хичээлийн агуулгыг тогтоосон сэдэвчилсэн төлөвлөгөөгөөр тодорхойлогдоно.

- Сургалт практикт төгс хэрэгжсэн эсэхийг шалгаж төслийг засварлах, энд мэдлэг эзэмшилтийн коэффициент ямар байгаагаар үр дүн нь хэмжигдэнэ. Сургалтын технологийг сонгон авах, боловсронгуй болгох явцад дээрх үе шатуудыг байнга анхааран үзэж, судалгаа хийхийн хамтаар боловсруулсан технологи оношлох, засварлах арга замыг боловсруулах нь бидний тулгамдсан зорилтуудын нэг юм.¹⁰⁷

Мөн багш гэдэг хүн өөрийн суралцагчдад өгөх мэдлэг, мэдээллийг хүргэх, зохион байгуулахад сурган хүмүүжүүлэх ухааны мэдлэгээс гадна сэтгэл зүйн шинжлэх ухааны талаарх ойлголт мэдлэгийг сургалтад хэрхэн уялдуулах шаардлагатай вэ? захиран тушаах, сургалтад удирдагчийн байр суурьнаас хандах бус суралцагчийн танин мэдэх процесст оролцогч, чиглүүлэгч, зөвлөгчийн байр суурьнаас оролцох, тэдний бүтээлч үйл ажиллагааг хөхүүлэн дэмжигч оролцогч болсоныг сургалтад нэвтрүүлэх шаардлагатай болохыг дүгнэн ойлгосон болно гэжээ¹⁰⁸

Багшийн сургалтын ажлыг үнэлэх, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааны зарим үр дүн: Цагдаагийн сургуулийн 2 дугаар дамжааны 5 ангийн 120 орчим сонсогч нартай хийсэн уулзалт ярилцлагаар:

Сургуулийн орчинд цаг үеэ дагасан социал орчинд ажиллах интернэт холболт байхгүй, мөн албан ёсны эх сурвалж нь тодорхой, үнэ төлбөргүй нэвтрэн орох цахим сургалтын материал, гарын авлага, ном зохиол хомс зэргээс үүдэлтэй мэдлэгийг цуглуулах ажилд хүндрэлтэй байдаг.

Мөн уламжлалт номын сангаас ном зохиолын хайлт хийх, хэрэгцээт мэдлэгийг шуурхай шууд авахаар заасан ном, сурах бичиг болон хуудас дараалал зэрэг нь ойлгомжгүй байдгаас цаг хугацаа алдах, өөр зүйлийг унших зэрэг нь хүндрэлтэй байгаа.

Багшийн мэдлэг, заах ур чадвараас хамаарч суралцагч нар сонирхолгүй болох, хичээлээ ойлгохгүй байх хүндрэл гардаг. Харин багш суралцагч хамтарч суралцсанаар мэдлэг авах, суралцах үйл ажиллагаа сонирхолтой үр дүнтэй болдог талаар өөрсдийн санал, бодлоо илэрхийлж байлаа. Сонсогч нартай хийсэн яриалагын үр дүнг бататгах, цаашид авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхойлохоор Цагдаагийн сургуулийн 1,2 дугаар дамжааны 51 суралцагчдаас багшийн сургалтын ажлыг үнэлэх, суралцагчийн сэтгэл хамнажийг тогтоох зорилгоор дараах судалгааг авлаа.

¹⁰⁶ Жадамба,Б., Чимэдлхам, Ц. Судалгааны арга зүй. Уб. 2002


¹⁰⁷ Ванчинсүрэн, Д. Хичээлийн технологи. Уб.1993

¹⁰⁸ Уянга.Х, Ангийн ажил /ДХИС багшийн эрхий сургалт/ 2022

Судалгаанд оролцсон 51 оролцогчийн 23% нь “1 жил”, 64.7% нь “2 жил”, 11.8% нь “4 ба түүнээс дээш жил” суралцаж байгаа сонсогч, суралцагчид байна.

Таны суралцсан жил


51 хариулт



Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинг авч үзвэл 68.6% нь “бүрэн дунд”, 29.4% нь “бакалавр”, 2% нь “тусгай дунд” боловсролтой сонсогч, суралцагчид байна.

Таны боловсролын түвшин


51 хариулт



Судалгаанд оролцогчдоос “Сургалтын технологийн талаар сонсож байсан уу” гэсэн асуултад хэрхэн хариулт өгсөнийг графикт оруулан авч үзвэл:


Та сургалтын технологийн талаар сонсож байсан уу

51 хариулт



таны сурах үйл явц нь багшийн заах ур чадвараас хамаардаг уу?

51 хариулт



Түүнчлэн судалгаанд оролцогчдоос “Таны сурах үйл явц нь багшийн заах ур чадвараас хамаардаг уу” гэсэн асуултад 47.1% нь “тийм”, 43.1% нь “заримдаа аль алинаас нь”, 9.8% нь “үгүй, суралцагчаас хамаардаг” гэсэн хариултыг өгсөн байна.

Та ямар орчин нөхцөлд өөрийгөө сайн сурах боломжтой гэж үздэг вэ?


51 хариулт



Сурах орчны талаар судалгаанд оролцогчдын 64.7% нь “тав тухтай, дулаахананги танхимд суралцах”, 19.6% нь “тав тухтай, сэрүүн танхимд”, 11.8% нь “анги танхим нь ямар байхнь сонин биш” хэмээн хариултыг өгсөн байна.


Сургалтын тоног төхөөрөмж, лабораторын хүрэлцээг үнэлнэ үү?

51 хариулт




Судалгаан оролцогчид багшийн заах арга зүйд үнэлгээ өгөх талаар асуухад 52% нь “сайн”, 38% нь “дунд зэрэг”, 10% нь “хангалтгүй, муу” гэсэн хариултыг өгсөн байна.

Та нийт их сургуулийн багш нарын заах арга зүйд үнэлгээ өгнө үү?
50 хариулт



Судалгаанд оролцогчид суралцах, сурах арга зүйн үнэлгээний талаар асуухад 14.3% нь “суралцагч нараас шалтгаалан хичээлээ сурахгүй байна”, 22.4% нь “суралцагчид хангалттай сурч байгаа”, 36.7% нь “тухайн багшийн ур чадвараас хамаарч харилцан адилгүй суралцаж байна”, 20.4% нь “бусад” гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.

суралцах, сурах арга зүйг үнэлнэ үү?
49 хариулт



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал бол хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг мэтээр харах тохиолдол байна. Гэтэл манай нийгмийн ирээдүйн асуудал бол чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд оршдог бөгөөд энэ нь багшийн хөгжлөөс, түүний мэдлэг заах арга зүйтэй шууд холбоотой.

Өөрөөр хэлбэл ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал нь багшийн мэргэжлийн ур чадвартай шууд хамааралтай гэдгийг багшлах эрхийн төлөө суралцаж буй миний хувьд хамгийн гүнээр ойлгож авсан судлагдахуун юм.

Эрдэм мэдлэг, оюуны зарцуулалт, мэдээллийн багтаамж ихтэй салбарыг түлхүү хөгжүүлэх замаар дэлхийн улс орнууд нийгмийн дэвшилд хүрсээр байна. Ийм салбаруудын наг нь боловсрол бөгөөд улс орны эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийн олон асуудлуудыг цаг тухайд нь оновчтой зөв шийдвэрлэх үндсэн нөхцөл нь боловсролын сургалтын үйл ажиллагаа, түүний дэвшилтэт технологи юм.

Дүгнэлт. Аливаа сургалтын зорилго, зорилт нь гагцхүү сургалтын технологиор дамжиж хэрэгжих боломжтой. Сургалтын технологи нь түүний зорилго, агуулга, арга зүй, зохион байгуулалт, суралцахуйн үйл явц, үр дүнгийн үнэлгээ зэргийг хамарсан өргөн ойлголт юм байна.

Сургалтын технологийг хэрэгжүүлэгч нь зөвхөн багш байх учир түүний хөгжил нь багшийн чанар, санаачилгаас нөхцөлдсөн хязгааргүй олон хувилбар бүхий өвөрмөц бүтээл, байнгын хөгжилд орших динамик процесс болно.

Сургалтын технологи нь шилдэг сайн хөтөлбөр, сургалтын орчныг амьдруулж, суралцагчийн бүтээлч, идэвхтэй үйл ажиллагааг нөхцөлдүүлэгч хүчин зүйл бөгөөд, түүнээс сургалтын эцсийн үр дүн шалтгаалж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын үндсэн хууль
2. Наранчимэг, Н. Монгол Улсын Их Хурал. УБ. 1999
3. Наранчимэг, Н. Боловсролын шинэчлэл хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. УБ. 1999
4. Пүрэвдорж, Ч.Боловсролын шинэчлэл сургалтын технологийн удирдлага. УБ. 1999.
5. Авдай, Ч., Энхтуяа, Д. Боловсролын шинэчлэл, хөгжлийн онол арга зүйн асуудал. УБ. 2000
6. Жадамба,Б., Чимэдлхам, Ц. Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй. УБ.2002
7. Ванчинсүрэн, Д. Судалгааны арга зүй. УБ. 1993
8. Лувсандорж, Ц. Хичээлийн технологи. УБ. 2011
9. Наранчимэг, Э. Орчлонгийн амьтан олон боловч. Багш сонин. УБ. 2015

--o0o--

**МОНГОЛ УЛСЫН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР БА
ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ
MONGOLIA DRIVER'S LICENSE ASSESSMENT MODEL AND
BUILDING LEGAL CAPACITY**

Н.Пүрэвдорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Замын цагдаагийн тэнхимийн багш,
цагдаагийн хошууч

Purevdorj.N

Teacher of the Traffic Police
Department of the Police School
of the University of Internal Affairs,
police major

Хураангуй: Манай улсын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн загварыг шинээр 5 удаа, доторх агуулга мэдээллийг өөрчилж 3 удаа батлуулсан бөгөөд хамгийн сүүлд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 2011 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хэрэглэгдэх болсон 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгын дагуу эзэмшигчийн гэрийн хаяг, үнэмлэхийн суурь өнгө ягаан байвал зохино гэснийг орхигдуулсан, 14 буюу тусгай тэмдэглэлд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээллийг агуулах хэсгийг огт ашигладаггүй. /харааны шил зүүдэг эсэх, тулгуур эрхтний болон сонсголын бэрхшээлтэй эсэх, автомат болон механик тээврийн хэрэгсэл жолоодох эсэх г.м/

Мөн Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгад орсон тээврийн хэрэгслийн дэд ангилал А1 буюу моторын багтаамж 125 см³-ээс ихгүй эсвэл цахилгаан хөдөлгүүрийн багтаамж 11 кВт-аас ихгүй чадалтай мотоцикл буюу хөнгөн мотоцикл гэсэн заалтыг, В1 буюу моторт гурван дугуйт буюу дөрвөн дугуйт квадрицикл гэсэн дэд ангиллуудыг оруулаагүй үлдээсэн.

Abstract: The driver's license model of our country has been approved 5 times, the contents have been changed 3 times, and the latest one was approved by order No. A/48 dated April 1, 2019 of the Minister of Justice and Internal Affairs.

According to the revised version of Article 41 and Annex 6 of the Vienna Convention on Road Traffic, which came into force on March 29, 2011, it was omitted that the background color of the owner's home address and identity card should be pink, 14 or special note with traffic safety. The section containing other related information is not used at all. /whether to wear glasses, whether to have a disability or hearing impairment, whether to drive an automatic or mechanical vehicle, etc./

Also, the provisions of sub-category A1 of vehicles included in the revision of Article 41 and Annex 6 of the Vienna Convention on Road Traffic, i.e. motorcycles or light motorcycles with engine capacity not exceeding 125 cm³ or electric motor capacity not exceeding 11 kW, B1 or omitted subclasses motor tricycles or quadricycles.

Түлхүүр үг: тээврийн хэрэгсэл, жолоодох эрхийн үнэмлэх, авто сургууль,

Keywords: vehicle, driver license, driver school,

Оршил хэсэг. Манай улсын анхны авто тээврийн байгууллага болох “Монгол Транс” нэртэй байх үед 1931 оноос эхлэн жолооч нарыг мэргэжлийн түвшинд бэлтгэн тухай үеийн Цагдан сэргийлэх байгууллагаас улсын комисс шалган 1934 оноос эхлэн Монгол Улсын жолоодох эрхийг үнэмлэхийг анх 1934 оноос эхлэн олгож эхэлсэн түүхтэй.¹⁰⁹

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн шийдвэрээр 1938 оноос эхлэн Яам, Тусгай газар, Үйлдвэр аж ахуйн газруудад курс дугуйланг байгуулах болсон бөгөөд дагалдан сургах замаар жолооч, засварчин бэлтгэж эхэлсэн. Цэргийн яам Монгол тээх нэвтрүүлэх газартай хамтран 1939 оноос эхлэн уурын тэрэг /автомашин/-ний жолооч бэлтгэх түргэвчилсэн курс явуулж эхэлсэн байна.¹¹⁰

1934-1940 оны үед Улсын цагдан сэргийлэх байгууллагад тусгайлсан чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэжлийн албад, аймаг, хотод цагдан сэргийлэх анги бий болж үйл ажиллагаа нь өргөжсөн бөгөөд үүний дотор 1936 онд Уурын машин тэрэгний хэргийг байцаах хэлтсийн байгуулсан нь өнөөгийн Тээврийн цагдаагийн албаны үүсэл юм. Мөн ондоо Улсын цагдан сэргийлэх газрын Уурын тэрэгний хэлтсийн дүрэм, Улсын мэргэжлийн комиссын дүрмийг шинэчлэн баталж, жолооч нарт үнэмлэх олгох, шалгах, хөдөлгөөний биелэлтэд тавих хяналтыг улам нарийсгаж дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан байна.

Улсын мэргэжлийн комиссын дүрмийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан 1936 оны 1 дүгээр сард дарга, гишүүн, нарийн бичгийн дарга тус бүр нэг хүний бүрэлдэхүүнтэйгээр шалгалтын комиссыг байгуулан тухайн үеийн нөхцөлөөс шалтгаалан мөн оны 10 дугаар сард 2 гишүүн нэмэгдэн 5 орон тооны ажилтантай болгож өргөжүүлж Уурын машин тэрэгний хэргийг байцаах хэлтэст харьяалуулсан байна.

Анхны жолоодох эрхийг үнэмлэхийг олгож эхэлснээс хойш 1936-1940 оны хооронд 353 жолооч, 1946 онд 460 орчим хүнийг дагалдан жолоочоор бэлтгэн гаргаж мэргэжлийн үнэмлэх олгосон бөгөөд тухай үеийн анхны жолооны үнэмлэх нь одоогийн А4 хэмжээтэй цаасан дээр монгол бичгээр овог, нэр, төрсөн огноо болон “БНМАУ-ын Уурын тэрэгний сургууль. Хувь нийлүүлсэн тээх, нэвтрүүлэх Монгол транс” гэж бичсэн байжээ.¹¹¹

Цаг үеэ дагаад жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагаа эрчимжиж улс орны хөгжилд суудлын, ачааны, зорчигч тээврийн, тусгай зориулалтын автомашинууд явж эхлэхдээ зэрэгцэн “зэрэг, ангилал, чадвар”-ын асуудал сөхөгдөн Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч I, II, III зэрэг тогтоож эхэлсэн. Гуравдугаар зэргийн үнэмлэх хүрэн хавтастай, хоёрдугаар зэргийнх цэнхэр, нэгдүгээрх нь улаан үнэмлэх олгодог байжээ.

Жолооч зэргээ ахиулахын тулд тухайн бааз байгууллагадаа таваас дээш жил сайн ажилласан, унаа тэргээ сайн арчилдаг болон бусад нэмэлт шаардлагуудыг тавьдаг байсан.

1970-аад оноос эхлэн жолоочийн сургуульд 8 дугаар ангиас дээш боловсролтой хүнийг элсүүлдэг журам тогтсон байна. Мөн 1974 оноос улсын хэмжээний бүх жолоочийг шалгах, аттестатчилах ажлыг зохион байгуулж I зэрэг нь улаан, II зэрэг нь ногоон, III дугаар зэрэг нь хөх байсныг өөрчилж, анхны ангилал бүхий 3 нугалдаг үнэмлэхийг бий болгосон байна.¹¹²

Мэргэжлийн комисс нь жолооч нарын сахилга хариуцлага, тэдэнд авах арга хэмжээний асуудалд биечлэн оролцдог байсан бөгөөд арга хэмжээ авагдаж буй жолоочийг байгууллагын төлөөлөгчийн хамтаар хэлтсийн хурлаар оруулж асуудлыг шийдэн үнэмлэхийн 3 дахь нүүрэнд авагдсан арга хэмжээ /эрх хасах, сануулах/-г тодорхой бичиж тэмдэглэдэг болсон нь тухай арга хэмжээ авагдсан этгээдэд ихийг ойлгуулдаг байжээ.

Жолоодох эрхийн үнэмлэхийн загварыг 1991 оноос В, С, Д, Е ангилал бүхий үнэмлэх талоныг улсын хэмжээнд сольж олгож эхэлсэн бөгөөд 1997-2008 оны хооронд дэлхийн бусад улсын жолоодох эрхийн үнэмлэхийн загвар хэлбэрт ойртуулах зорилгоор пластик сорон туузтай картыг ашиглан шар үнэмлэх олгож байсан. Тэгвэл өнөөдөр ашиглагдаж буй жолооны үнэмлэх нь 2008

¹⁰⁹ Замын цагдаагийн газар, “Замын цагдаагийн албаны түүхэн товчоо”, УБ 2006, 10 дахь тал

¹¹⁰ Замын цагдаагийн газар, “Замын цагдаагийн албаны түүхэн товчоо”, УБ 2006, 11 дэх тал

¹¹¹ Замын цагдаагийн газар, “Замын цагдаагийн албаны түүхэн товчоо”, УБ 2006, 14 дэх тал

¹¹² Д.Дүгэрээ, “300 гаруй мянган хүний жолооны үнэмлэх миний гарын үсэгтэй”, <https://gogo.mn/r/52411?i=>

оноос эхлэн олон улсын СР 80 /85мм X 54мм/ стандартыг хангасан дотор талдаа чип агуулсан саарал өнгийн дэвсгэртэй жолооны үнэмлэхийг хэвлэн олгож байна.

Үндсэн хэсэг: Цагдаагийн байгууллага нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 10 дугаар зүйлийн 10.1.3-т “...жолоочийн бүртгэл, мэдээллийн санд жолоодох эрхийн үнэмлэх дээрх мэдээллийн бүртгэл, мэдээллийг цагдаагийн байгууллага хариуцан хөтөлнө.” гэж заасны дагуу улсын хэмжээнд жолоодох эрхийн үнэмлэхтэй холбоотой асуудлыг хариуцан бие даан хэрэгжүүлж жолооны үнэмлэх олгох ажлыг зохион байгуулж байна.¹¹³

Цагдаагийн байгууллагын жолоочийн бүртгэл, мэдээллийн сан нь 1997 оноос хойш шинэ загварын шар пластик үнэмлэх солихтой холбогдуулан цахим хэлбэрт шилжсэн бөгөөд 2022 оны байдлаар 1,469,707 иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхтэй гэсэн бүртгэлтэй томоохон мэдээллийн санг үүсгээд байна.¹¹⁴ /График 1/



График 1. Монгол Улсад бүртгэлтэй жолоочийн тоон өсөлт сүүлийн 10 жилээр.

Монгол улсад 2018-2022 онд тээврийн хэрэгсэл жолоодох эрх шинээр авсан иргэдийн тоон үзүүлэлтээс харахад сүүлийн 5 жилд дунджаар 53,4 мянган жолооч шинээр бэлтгэгдэн тээврийн хэрэгсэл жолоодох эрх авч байгаа бөгөөд өнгөрсөн 2022 онд 62,865 иргэн шинээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авсан байна.¹¹⁵ /График 2




График 2. Шинээр жолоодох эрх авсан иргэдийн тоон үзүүлэлт сүүлийн 5 жилээр.

Монгол Улсын жолоодох эрхийн санд бүртгэлтэй 1,469,707 иргэнийг нас, хүйсийн байдлаар нь авч үзэхэд 18-23 насны 100,204 буюу 6.8 хувь, 24-29 насны 215,019 буюу 14.6 хувь, 282,607 буюу 19.2 хувь, 299,185 буюу 20.4 хувь, 572,692 буюу 39.0 хувийг тус тус эзэлж байгаа бол 926,201 буюу 63.1 хувийг эрэгтэй, 543,506 буюу 36.9 хувийг эмэгтэй жолооч нар тус тус эзэлж байна.¹¹⁶


¹¹³ Улсын Их Хурал, “Төрийн мэдээллийн эмхэтгэл”, УБ 2015, 1515 дахь тал

¹¹⁴ Ц.Эрдэнэчимэг, Г.Хулангоо, Б.Базаррагчаа, Д.Уянга, Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл, УБ 2022, 101 дэх тал

¹¹⁵ Ц.Эрдэнэчимэг, Г.Хулангоо, Б.Базаррагчаа, Д.Уянга, Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл, УБ 2022, 102 дахь тал

¹¹⁶ Ц.Эрдэнэчимэг, Г.Хулангоо, Б.Базаррагчаа, Д.Уянга, Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл, УБ 2022, 102 дахь тал

График 3. Жолоочийн насны байдлаар



Манай улсын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхийн загварыг шинээр 5 удаа, доторх агуулга мэдээллийг өөрчилж 3 удаа батлуулсан бөгөөд хамгийн сүүлд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Мөн манай улсын нэгдэн орсон "Замын хөдөлгөөний тухай" болон "Замын дохио, тэмдгийн тухай" Вений конвенцод хамгийн сүүлд орсон нэмэлт өөрчлөлтүүд нь 2006 оны 3-р сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд зарим нэмэлт өөрчлөлтөд "Замын хөдөлгөөний тухай" конвенцын 41-р зүйл (жолоочийн үнэмлэхтэй холбоотой)-ийг бүхэлд нь шинэчлэн найруулсан өөрчлөлт болон 6-р хавсралт (үндэсний жолоочийн үнэмлэхэд тавих шаардлага)-ын шинэчилсэн найруулга нь тус конвенцын 43-р зүйлд тусгагдсан шилжилтийн заалтын дагуу хүчин төгөлдөр болсноос хойш 5-н жилийн дараагаас буюу 2011 оны 3-р сарын 29-ний өдрөөс эхлэн гишүүн орнуудад хэрэглэгдэж эхэлсэн байдаг¹¹⁷. Гэтэл манай улсын хувьд 2015 онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан бөгөөд үүнтэй уялдуулан Замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэх шаардлага гарсан тул тухай үед жолооны үнэмлэхийн загварыг өөрчлөлтгүй түр үлдээсэн байдаг.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар шинэчлэн баталсан загвар нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн шинэчилсэн найруулга 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын 239 дугаар тогтоолоор батлагдсан төсөлд "Механикжсан тээврийн хэрэгслийн ангилал" нэртэй 6-н зүйл бүхий 2-р бүлэгт Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 2011 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хэрэглэгдэх болсон 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгын дагуу механикжсан тээврийн хэрэгслийн ангиллын тодорхойлолтыг шинэчлэн найруулж тээврийн хэрэгслийн "C1", "D1", "C1E", "D1E" дэд ангиллын тодорхойлолтыг нэмж, холбогдох заалтууд тусгагдсан.¹¹⁸ Мөн эцэг /эх/-ийн нэр, нэр, төрсөн огноо, төрсөн газар, регистр, олгосон огноо, хүчинтэй огноо, олгосон байгууллага, үнэмлэхийн дугаар, жолоочийн фото зураг, жолоочийн гарын үсэг, зөвшөөрөл олгосон ангилал, дэд ангилал, ангилал олгосон огноо, цусны бүлэг, нэмэлт мэдээлэл оруулахаар тусгаж өгснөөс гадна Монгол Улсын төрийн далбаа, MGL тэмдэглэл, франц, англи хэлээр жолооны үнэмлэх гэж бичиж өгсөн нь нэлээдгүй шинэчлэлийг хийж чадсан байна. /Зураг 1/

Зураг 1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/48 дугаар тушаалаар баталсан жолоочийн үнэмлэхийн загвар

А. Нүүрэн тал



Б. Ар тал



й өдрөөс
шигчийн
у тусгай

¹¹⁷ https://en.wikipedia.org/wiki/Vienna_Convention_on_Road_Traffic

¹¹⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14200>

тэмдэглэлд замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээллийг агуулах хэсгийг огт ашигладаггүй. /харааны шил зүүдэг эсэх, тулгуур эрхтний болон сонсголын бэрхшээлтэй эсэх, автомат болон механик тээврийн хэрэгсэл жолоодох эсэх г.м/

Мөн Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгад орсон тээврийн хэрэгслийн дэд ангилал А1 буюу моторын багтаамж 125 смЗ-ээс ихгүй эсвэл цахилгаан хөдөлгүүрийн багтаамж 11 кВт-аас ихгүй чадалтай мотоцикл буюу хөнгөн мотоцикл гэсэн заалтыг, В1 буюу моторт гурван дугуйт буюу дөрвөн дугуйт квадрицикл гэсэн дэд ангиллуудыг оруулаагүй үлдээсэн.¹¹⁹

Монгол Улсын 120 орчим мянган иргэд дэлхийн бусад улс оронд ажиллаж, амьдарч байгаа бөгөөд БНСУ-д 32,000, АНУ-д 25,000, БНХАУ-д 8,600, Европын холбооны улсуудад 42,000, Канад 5,300, ОХУ-д 4,900 гэх зэрэг бүртгэлтэй байна¹²⁰. Энэхүү тоонд албан ёсны зөвшөөрөлтэй болон хууль бусаар /хараар/ оршин сууж буй нийт иргэдийг багтаасан учраас нэг бүрчлэн нарийн тоо гарах боломжгүй байгааг Гадаад харилцааны яамнаас мэдэгдсэн байна.

Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын дүрэм, тэмдэглэлийг мөрдөн хэрэгжүүлэхээр нэгдсэн орсон 87 улс бүртгэлтэй байгаа бөгөөд манай улс 1997 онд уг конвенцод нэгдэн орсноор эдгээр орнуудаас олгосон жолоодох эрхийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Мөн энэ талаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-д “Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын гишүүн орноос олгогдсон бөгөөд уг конвенцод нийцсэн жолоодох эрхийн буюу олон улсын жолоодох эрхийн хүчин төгөлдөр үнэмлэхээр гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтэрснээс хойш нэг жилийн хугацаанд тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодож болно” гэж заасан байдаг.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар шинэчлэн баталсан загварыг Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгад орсонтой харьцуулж үзүүлээ. /Хүснэгт 1/

д/д	ХЗДХС-ийн 2019 оны А/48 дугаар тушаалаар баталсан загвар	ЗХ-ний тухай Вений конвенцын 41-р зүйл, 6-р хавсралтын мэдээлэл
1.	Тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэхийн мэдээлэл нь цахим байдлаар агуулагдах олон улсын ISO/IEC 7810 ID-1 (85.60 x 53.98 mm) стандарт, чанарын шаардлага хангасан смарт /чиптэй/ картаар хийгдэнэ.	Жолоодох эрхийн үнэмлэх нь хуванцар эсвэл цаасаар хийж болно. Хуванцар үнэмлэхийн хамгийн тохиромжтой хэлбэр нь 54x86 мм хэмжээтэй байна. Жолоодох эрхийн үнэмлэхийн өнгө нь ягаан өнгөтэй байна. 6, 7 дахь хэсэгт заасныг баримтлан бичилт хийх, хэвлэмэл болон зайг дотоодын хууль тогтоомжоор тогтооно
2.	Жолоочийн үнэмлэхийн дэвсгэр өнгө нь мөнгөлөг саарал бөгөөд төвөөс цацарсан хэлбэртэй усан хээтэй байна. Нүүрэн талын голд бадамлянхуа цэцгийн суурин дээр “Төрийн соёмбо”, ар талын голд Монгол Улсын газрын зураг, дотор нь “Монгол Улс, Mongolia” гэсэн бичвэр байна. Нүүрэн талын дээд, баруун талд, ар талын дээд талд “Жолоочийн үнэмлэх” гэж Монгол, Англи, Франц, Уйгаржин монгол бичгээр бичнэ.	Нүүрэн талд “Жолооны үнэмлэх” гэсэн гарчгийг дотоодын хэлээр байна, зөвшөөрөл олгосон улсын нэр, түүнчлэн зөвшөөрөл олгосон улсын ялгах (MGL) тэмдэг байна.
3.	1. гэр бүлийн нэр, 2. нэр, 3. төрсөн огноо, газар, 4.(a) олгосон огноо, 4.(b) хүчинтэй огноо, 4.(c) зөвшөөрөл олгосон байгууллагын нэр, тэмдэг,	1. овог 2. эзэмшигчийн нэр 3. төрсөн он сар өдөр, газар 4.a. олгосон огноо 4.b. хүчинтэй огноо 4.c. зөвшөөрөл олгосон байгууллагын нэр, тэмдэг 5. үнэмлэхийн дугаар

¹¹⁹ https://treaties.un.org/pages/ViewDetailsIII.aspx?src=TREATY&mtdsg_no=XI-B-19&chapter=11

¹²⁰ <https://montsame.mn/mn/read/300309>

	5. үнэмлэхийн дугаар, 6. эзэмшигчийн зураг, 7. эзэмшигчийн гарын үсэг, 9. тээврийн хэрэгслийн ангилал, 10. Ангилал ахиулсан огноо, 13. “Цусны бүлэг” гэж заасны дагуу мэдээллийг монгол, англи хэл дээр хэвлэсэн байна. 14. “Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээлэл” гэж заасны дагуу хэвлэсэн байна.	6. эзэмшигчийн зураг 7. эзэмшигчийн гарын үсэг <u>8. оршин суугаа газар</u> 9. тээврийн хэрэгслийн ангилал 10. ангилал олгосон огноо <u>11. ангиллын хүчинтэй огноо</u> <u>12. ангиллын нэмэлт мэдээлэл /тайлбар/</u> 13. оршин суугаа газраа өөрчилсөн тохиолдолд бүртгүүлэх мэдээлэл 14. Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой бусад мэдээлэл. /харааны, хөгжлийн бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй эсэх болон бусад нэмэлт мэдээлэл/
4.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар загварыг баталж сольж эхэлсэн.	Шинэ загвар нь 2011 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

Харьцуулалтад тусгагдсан өөрчлөлтийг Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхэд нэмэлт оруулж өөрчилснөөр Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын дүрэм, тэмдэглэлийг мөрдөн хэрэгжүүлэхээр нэгдсэн орсон 87 улсад манай улсын жолоодох эрхийн үнэмлэх эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болох бөгөөд тухайн улсад амьдарч, ажиллаж буй 47 орчим мянган хүн, мөн аялал жуулчлал, сургалтаар зорчиж буй болон зорчихоор төлөвлөгдсөн иргэдэд автомашин хөлслөн ажил, аяллаа зохицуулахад ихээхэн нэмэр, тус болно.

Дүгнэлт. Өнөөдрийн байдлаар Европын зарим орнууд болон Канад, Австар, ОХУ-д Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодоход тодорхой хугацаанд зөвшөөрч байгаа бөгөөд хэрэв ажиллах, амьдрах зорилгоор очсон тохиолдолд тухай улсын жолоодох эрхийн үнэмлэхээр сольж олгож байна.

Харин Вений конвенцын гишүүн орон боловч Монгол Улсын жолоодох эрхийн үнэмлэхэд шаардлагатай мэдээлэл оруулаагүйгээс болж давтан сургалтад хамрагдах, шалгалт өгөх зэрэг хүндрэлүүд гарч байгаа талаар иргэд өөрсдийн байр сууриа facebook хуудас, Twitter-ээр жиргэж бусдадаа мэдээлэл түгээдэг.

Гаднын улс орнуудын шалгалтын төв нь 100-150 долларын хураамжтайгаар¹²¹ шалгалтыг зохион байгуулдаг бөгөөд ийм хэмжээний төгрөгийг манай улсын иргэдээс гардаг гэж үзвэл 50 орчим мянган иргэнээс 7,5 сая доллар буюу 26 орчим тэрбум төгрөг гадагшаа урсаж байна.

Санал:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/48 дугаар тушаалаар шинэчлэн баталсан загварт нэмэлт өөрчлөлт оруулан Замын хөдөлгөөний тухай Вений конвенцын 41-р зүйл ба 6-р хавсралтын шинэчилсэн найруулгад орсон мэдээллийг багтаан өөрчлөх, жолоодох эрхийн үнэмлэхийн дэвсгэр өнгийг ягаан өнгөөр сольж өөрчлөх.

2. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 2 дугаар зүйлд дэд ангилал А1 буюу моторын багтаамж 125 см3-ээс ихгүй эсвэл цахилгаан хөдөлгүүрийн багтаамж 11 кВт-аас ихгүй чадалтай мотоцикл буюу хөнгөн мотоцикл гэсэн заалтыг, В1 буюу моторт гурван дугуйт буюу дөрвөн дугуйт квадрицикл гэсэн дэд ангиллуудыг нэмэлт оруулж өгөх.

Эдгээр өөрчлөлтүүдийг хийснээр жолоодох эрхийн үнэмлэхийг олноор нь солих шаардлагагүй бөгөөд үрэгдүүлсэн, хугацаа сунгасан, шинээр болон ангилал ахиулах, өөрийн хүсэлтээр солиулах тохиолдолд бүрд шинээр батлагдсан жолоодох эрхийн үнэмлэх олгосноор 3-5 жилийн дотор 60 орчим хувь нь солигдох боломжтой гэж үзэж байна.

¹²¹ <https://www.gov.uk/driving-test-cost>

Ашигласан материал

1. ЦЕГ, “Монгол Улсын Цагдаагийн түүхэн баримт бичгийн эмхэтгэл”, 2021 он, УБ хот;
2. ЗЦГ, “Замын цагдаагийн албаны түүхэн товчоо”, 2016 он, УБ хот
3. С.Энхтөр, Г.Ринчиндорж, “Түүх төрсөн он цагууд” дурсамж, дурдатгалын эмхэтгэл, 2011 он, УБ хот
4. Ц.Эрдэнэчимэг, Г.Хулангоо, Б.Базаррагчаа, Д.Уянга, “Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл”, 2022 он, УБ хот;
5. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны А/48 дугаар тушаал;

Цахим хуудас:

1. https://en.wikipedia.org/wiki/Vienna_Convention_on_Road_Traffic
2. https://treaties.un.org/pages/ViewDetailsIII.aspx?src=TREATY&mtdsg_no=XI-B-19&chapter=11
3. <https://www.gov.uk/driving-test-cost>
4. <https://montsame.mn/mn/read/300309>
5. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11224>
6. <https://mfa.gov.mn/>

--oOo--

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НАСЖИЛТ, ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

AGING OF VEHICLES AND THE PROBLEMS AFFECTING THEM

Э.Хандармаа

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан, цагдаагийн дэслэгч

E. Khandarmaa

Researcher of Institute of Criminology and Police Studies,
United Research Institute, University of the Internal Affairs,
Mongolia, police lieutenant

Хураангуй: Тээврийн хэрэгслийн гүйлт, насжилтаас үүдэн түүний эд ангиудад элэгдэл үүсч ялангуяа явах анги, жолооны механизм болон тормозны системийн аюулгүй байдал алдагдан зам тээврийн осол, гэмт хэргийн эрсдэл бий болсоор байгаа билээ. Монгол улсад 1990 онд гарсан нийгмийн харилцааны өөрчлөлтөөс өмнө тээврийн хэрэгслийн насжилт, гүйлтэд хяналт, хязгаарлалт хийж актлан улмаар устгалд оруулдаг байсан тогтолцоо нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд ихээхэн ач холбогдолтой байлаа. Үүнийг сэргээн хэрэгжүүлж гадаадын тэргүүн туршлагыг Монгол Улсад нутагшуулах эрх зүйн боломжит харилцааны талаар өгүүлнэ.

Abstract: Due to the age and mileage of the vehicle, wear and tear occurs in its parts, especially the safety of the chassis, steering mechanism and brake system, and the risk of traffic accidents and crimes continues to arise. Before the changes in social relations in Mongolia in 1990, the system of monitoring and limiting the age and mileage of vehicles and then destroying them was very important for road safety. It will be discussed about the possible legal relationship of localizing the best foreign experience in Mongolia by re-implementing it.

Түлхүүр үгс: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн элэгдэл, хорогдол, насжилт, тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношлогоо, төмрийн хаягдал.

Key words: road traffic safety, vehicle wear and tear, aging, vehicle technical inspection and diagnostics, scrap metal.

Орчлон хорвоо дээр элэгдэл, хорогдол явагддаггүй зүйл нэгээхэн ч байхгүй билээ. Эрдэмтэдийн судалгаа тооцооллоор бидний мэдэх хамгийн гөлгөр толины гадаргуу ч салхи, нарны гэрэлд тодорхой хэмжээнд элэгдэж байдаг байна.

Тээврийн хэрэгслүүд үйлдвэрээс гарч замын хөдөлгөөнд орох, эдэлгээнд орохдоо байнгын элэгдэлд орж байдаг. Тээврийн хэрэгслийн элэгдэлийг гүйлт, насжилтаас нь хамааруулан тооцох аргачлал байдаг. Гэхдээ гүйлт харилцан адилгүй байдаг, сервис үйлчилгээний өртөг, байгаль, экологид үзүүлэх хорвог чанарын үзүүлэлт зэргээс хамааруулан дэлхийн олон улс оронд насжилтаас хамааруулан тооцож актлан устгалд оруулдаг байна. Дэлхийд дунджаар нэг тээврийн хэрэгсэл, автомашиныг ашиглах хугацаа 15 жил байдаг байна. Энэхүү ашиглалтын хугацааг 3 хувааж үздэг. Үүнд:

1. Автомашины үйлдвэрийн баталгаат хугацаан дахь үе буюу 5 хүртэлх жилийн насжилт. Ийм насжилттай автомашин техникийн бүхий л стандартыг хангах бөгөөд утаан дахь хорт хий байх ёстой хэмжээ, нормоо барьдаг ба эвдрэл гэмтэл ч бага гардаг. Автомашин үйлдвэрлэгч орнууд өөрийн улсынхаа зам дээр зорчих тээврийн хэрэгслүүдээ 1-5 жилийн насжилттай автомашинаар бүрдүүлэх сонирхолтой байдаг нь ард иргэдээ хамгаалах бодлогын илрэл юм.

2. Автомашины хоёрдох мөчлөгийн үе буюу 6-10 жилийн насжилттай автомашинууд ихэвчлэн гүйлт нормоо дуусган, хэрэглээнээс гарч аюул эрсдэл дагуулах хэрэгслүүд болсон байдаг.

Энэ мөчлөгт үйлдвэрлэгчийн баталгаат хугацаа дууссан байх ба утаан дахь хорт хий заримдаа зохих хэмжээ, нормоо барихгүй байх төдийгүй эвдрэл гэмтэл гарах нь түгээмэл. Харин үйлдвэрлэгчтэй улс орон ийм автомашиныг 2 дагч зах зээлрүү экспортолох арга замыг хайж эхлэх ба үүнийгээ автомашины татвар, даатгалыг өндрөөр тогтоох зэргээр гүйцэтгэдэг.

3. Гурав дахь үе буюу арваас дээш жилийн насжилттай автомашинууд бөгөөд ойр ойрхон эвдэрч, хорт утааны хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ сэлбэг хэрэгсэл нь олдохоо больж эхэлнэ. Энэ үед улс ч гэлтгүй хэрэглэж буй эзэд нь ямар нэг аргаар салахыг хичээнэ. 2 талын ашиг сонирхол нэгдмэгц 10-с дээш жилийн насжилттай автомашиныг задлаж дахин боловсруулна эсвэл буурай орон руу маш хямдхан экспортолдог.

Автомашин үйлдвэрлэгч улсуудын дээрхи бодлогын дүнд шинэ автомашинууд тус улсдаа үлдэж эдийн засгийн зөв бөгөөд ашигтай эргэлтэд үлдэн харин 7-с дээш жилийн насжилттай хэт хөгшин автомашинууд буурай орнуудын автопаркийг бүрдүүлдэг. Агаарын бохирдол бий болгож байгаа эх үүсвэрүүдийн тодорхой хувийг тээврийн хэрэгсэл эзэлдэг.

Бидний хүсэл ба хэрэглээ

Монголчууд зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас буюу 1990 оноос эхлэн автомашины тухай ойлголт, хэрэгцээ нэмэгдэж өрх бүр автомашинтай болохыг хүсч байлаа. Гэвч хэрэгцээ сонирхол нь өндөр боловч төлбөрийн чадвар нь бага байсан тул төр засаг нь хуучин автомашин импортлохыг хориглоогүй юм. Эхэн үедээ 15-20 жилийн настай Герман тэрэг орж ирдэг байсан бол дараа нь Эксель, Соната, Марк-2 гээд хямд үнэтэй маш олон төрлийн марк, загварыг автомашинуудыг импорлон оруулж ирсээр 3 иргэн тутмын 1 нь ямар нэгэн авто тээврийн хэрэгсэлтэй болсон байна.

Тоёота Приус автомашинууд нь:

Эхний үе (1997-2003)

Хоёр дахь үе (2003-2009)

Гурав дахь үе (2010-2016)

Дөрөв дэх үе (2016 оноос өнөөг хүртэл) ¹²² гэсэн загваруудыг үйлдвэрлэн гаргасан байна. Японы үйлдвэрүүдээс гадна Ази, Европын олон оронд сайжран шинэчлэгдэн үйдвэрлэгдэж байна. Хайбрид хөдөлгүүр бүхий автомашинууд 2000 оны эхэн үеэс Монголын жолооч нарын хэрэглээ, эдийн засгийн хувьд ашигтай тээврийн хэрэгсэлд тооцогдож байна.

Хайбрид автомашинуудаас илүү эдийн засгийн үр өгөөжтэй нь цахилгаан автомашинууд гарч ирсэн. Гэхдээ сайн зүйлийн хажууд саар зүйл салахгүй орших нь диалогтик зүй тогтол юм. Цахилгаан болон хайбрид тээврийн хэрэгслүүдийн экологийн аюулгүй байдалд нөлөөлөх хорт чанар нь батарейны хэрэглээний дараах хаягдал байдлаараа ердийн дотоод шаталтат хөдөлгүүр бүхий автомашинуудаас дутахааргүй байгаа юм.

Өнөөдөр Монгол улс нь автомашины талаар ямар нэг нэгдсэн бодлогогүй явж байна гэхэд буруудахгүй. Төрийн бодлого байхгүй бол хөгжил, аюулгүй байдал нэг алхам урагшаа алхаад хоёр алхам хойшоо алхадаг бол өндөр хөгжилтэй оронд эсрэгээр байдаг байна. Тухайлбал: Хэт хуучин буюу 15-20 жилийн насжилттай автомашин импортын дийлэнхийг бүрдүүлж эхлэхэд онцгой татварт өөрчлөлт оруулж 10-с дээш жилийн насжилттайг нь өндөр татвар тогтоон хязгаарлах бодлого барьсан.

Газрын хөрсний болон агаарын бохирдлын эсрэг хийж буй тэмцэл, жижиг дунд бизнесийг дэмжих зорилтынхоо хүрээнд хайбрид/хийн хөдөлгүүрт болон ачааны автомашин, автобусыг насжилтаас үл хамааран онцгой албан татвараас чөлөөлөх шийдвэр гаргасан байдаг. Уг шийдвэрийн үр дүнд өрх бүр шатахуун бага зарцуулдаг орчин үеийн технологи бүхий супер автомашинтай болж, бизнесийн байгууллагуудад хуучин автомашинуудыг аж ахуйдаа ашиглах амжиргааны автомашин болгож эхэлсэн байдаг.

Гэвч энэ төрлийн автомашины импортынх нь 80% нь үйлдвэрлэгчийн баталгааны хугацаа дуусч, ашиглалтын шаардлага хангахаа больсон хэт өндөр насжилттай тул дөнгөж залуужиж эхэлсэн

¹²²https://mn.wikipedia.org/wiki/%D0%A2%D0%BE%D1%91%D0%BE%D1%82%D0%B0_%D0%9F%D1%80%D0%B8%D1%83%D1%81

манай улсын авто парк эргээд 90%-ийн хэт өндөр насжилттай автомашинаар дүүрлээ. Үүний хор хөнөөл нь мэдээжээр олон олон баримтаар нотлогддог.

Хэдхэн жилийн дотор авто замын ачаалал дээд цэгтээ тулан автомашин, иргэдийн зохистой харьцаа алдагдаж эхлэхийн зэрэгцээ газрын хөрсний болон агаарын бохирдол, авто замын осол гамшигийн хэмжээнд хүрэв. Түүнчлэн хүүхдүүдийн цуснаас хар тугалга илэрч байгаа талаар сошиал хэвлэл, мэдээлэлээр хангалтай үзүүлж байна.¹²³

Гэр хорооллын хүүхдүүдийн цуснаас хар тугалга их хэмжээгээр илэрчээ¹²⁴ гэх асуудал нь зөвхөн гэр хорооллын утаа биш автомашинаас гарах хорт хий болон батарей аккумуляторын хаягдалыг хаях устгах арга технологи хоцрогдож байгаагийн илрэл юм.

Тээврийн хэрэгсэл нь аль ч улсын амьдралд баттай байр суурь эзэлж хүний үйл ажиллагааны бүхий л салбарт их үүрэг гүйцэтгэж байна. 2021 оны 11 сарын байдлаар тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллээс харахад Монгол Улсад нийт 1201066 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 648527 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Нийт тээврийн хэрэгслийн 63.04 хувь буюу 710361 нь суудлын автомашин эзэлж байна. Ачааны автомашин 222642, автобус 29410, тусгай зориулалтын автомашин 16587, зүтгүүр 25315, механизм 14472, чиргүүл 50328, мотоцикл 49419 тус тус бүртгэгдсэн байна.

Автомашинжиж байгааг илтгэх үзүүлэлт бол хотын оршин суугчдын 1000 хүн амд ногдох бүх төрлийн тээврийн хэрэгслийн тоо юм. Хүн амд ногдох автомашины эзлэх түвшин ингэж өсөх нь аливаа улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боловч, зам тээврийн осол нэмэгдэн, түүнээс шалтгаалж нас барсан, гэмтсэн хүний тоо, эдийн хохирлын хэмжээ өсөх, хүрээлэн байгаа орчныг бохирдуулах, гудамж замд түгжрэл үүсэх зэрэг сөрөг үр дагаваруудыг зайлшгүй дагуулж байдаг.

Автомашинжилтын түвшингийн зүй тогтолоор 1000 хүнд ногдох автомашины тоо 30-аас дээш болоход гудамжны нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг хангах асуудалд бэрхшээл үүсэх, 130-аас дээш бол хотын автомашины тоонд хязгаар тавих, 200-250-д хүрвэл нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд давуу эрх өгч зөвхөн түүгээр үйлчлүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Дүгнэлт. Улаанбаатар хотын хэмжээнд 1000 хүнд 75 тээврийн хэрэгсэл ногдох үеэр мэргэжлийн хүмүүс гамшигийн хэмжээнд үнэлдэг. Улсын хэмжээнд бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн 65 хувь нь Улаанбаатар хотод 35 хувь нь орон нутагт харъяалалтай байна.

Зам тээврийн осол хэрэгт оролцсон сэргээн засах боломжгүй тээврийн хэрэгслүүдийг дахин засварлан замын хөдөлгөөнд оролцох нь улам их эрсдлийг дагуулж байгаа юм. Гадаадын ихэнх улс оронд тээврийн хэрэгслийн нийт эд ангийн зам тээврийн осол, гэмт хэрэг, гал түймэр, усанд живсэнээс 30%-иас дээш эвдрэл илэрсэн тохиолдолд устгалд оруулдаг байна.

Манай улсад сүүлийн жилүүдэд тээврийн хэрэгслийн насжилтанд өөрчлөлт орж шинэ тээврийн хэрэгсэл импортлох нь ихэсч байна. Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгслийн тоо ихсэхийн хэрээр нөгөө төлд нь гүйлт, насжилт дууссна тээврийн хэрэгслүүд зайлшгүй устгагдах ёстой бөгөөд энэ нь дэлхий нийтэд эрчимтэй хөгжиж байна.

Тэр дундаа тээврийн хэрэгслийн насжилт өндөрсөх тусам агаар, орчны бохирдолд сөргөөр нөлөөлж байгаа судалгаанаас харахад 10-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгслийн тоо сүүлийн 10 жилд хоёр дахин нэмэгджээ. Улсын хэмжээнд 2021 оны байдлаар Нийт автобусны 78%, Нийт ачааны автомашины 95% Нийт суудлын автомашины 87% нь 10-аас дээш жилийн насжилттай байна. Энэхүү тоон үзүүлэлтүүдээс харахад Монгол Улсад тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэхийн хэрээр устгах бодлого үгүйлэгдэж байна хэмээн дүгнэж байна.

Энэ нь Замын хөдөлгөөний аюулгүй байдалд бодитой аюул, занал хийлэлийг дагуулж байгаа бөгөөд төмрийн хог хягдал нь экологийн аюулт нөхцөлийн суурь болдог. Гадаадын орнуудад насжилт, гүйлт дууссан тээврийн хэрэгслүүдийг устгах, тэдгээрийг түүхий эдийн дахин

¹²³ <https://www.facebook.com/watch/?v=1836700403267344>

¹²⁴ <https://news.zindaa.mn/1y94>

боловсруулалтад ашиглах зэргийн эрх зүйн орчныг судлан нутагшуулан ашиглаж хэвшүүлэх нь цаг нь болжээ.

Монгол улс БНМАУ-ын социализмын материал техникийн баазыг барьж байгуулж байх үед буюу 1990 он хүртэл хуучин автомашинуудыг актлан устгадаг 5 газар улсын хэмжээнд байсан зэргийг эргэн судлах шаардлагатай байна.

Санал. Монгол Улсын хэмжээнд насжилт, гүйлтээр тээврийн хэрэгслүүдийг нь устгалд оруулах, улсын бүртгэлээс хасах, актлах чиглэлээр дараах ажлуудыг хийх талаар саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийг устгах болон төмрийн үйлдвэрт түүхий эд болгон ашиглах хууль, эрх зүйн орчныг бий болгох;
2. Зам тээврийн ослын дараах оношлогоо, үнэлгээгээр автомашины эд ангиудын 50%-иас дээш хувийн эвдрэл, гэмтэлтэй тохиолдолд сэргээн засах шаардлагагүй гэсэн дүгнэлт гарган бичиг баримтуудыг улсын бүртгэлээс төрийн албадлагаар хасч байх;
3. Гүйлт, насжилт хэтэрсэн тээврийн хэрэгслүүдийг устгах цэг, төвүүдийн үйл ажиллагааг төрөөс дэмжин зарим тохиолдолд ийм төрлийн бизнес, аж ахуйг санхүүжүүлж байх;
4. Хайбрид автомашины батареийг үйлдвэрүүд нь буцаан авдаг харилцааг Монгол улсад нэвртүүлэх;
5. Дугуйн хаягдалыг дахин боловсруулах зезин эдлэлийн үйлдвэр байгуулах орчны судалгаа хий;
6. Хар тугалгын дахин боловсруулалтад өндөр хяналт тогтоох;
7. Техникийн захууд дээр задлагдсан автомашины бичиг баримт зарагдан, эргэн ашиглагдаж байгаатай тэмцэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Ашигласан материал:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном-2018
2. Автомашины цахилгаан тоноглол Цэвэгжав. Ц, Далхжав Ш. 2017
3. А.Энхболд “Замын хөдөлгөөний аюулгүй байдал” 2006 он

--oOo--

**ХҮНИЙ ЭРХ: ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧНЫГ ТОДОРХОЙЛОХ
АМЬДРАХ ЭРХИЙН “ХҮЛЦЭХ ТҮВШИН”
HUMAN RIGHTS: DEFINING A HEALTHY AND SAFE ENVIRONMENT
"TOLERANCE LEVEL" OF THE RIGHT TO LIFE**

Х.Уянга

Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн дэслэгч, хууль зүйн магистр

UYANGA.KH

University of Internal Affairs School of Law and
Social Sciences Lecturer at the Department of Public Law,
Lieutenant of Police, Master of Laws

Хураангуй. Энэ өгүүлэлээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зарим саналыг дэвшүүлсэн болно.

Abstract. In this report, some suggestions on how to the implementation of the right to live in a healthy and safe environment, the problems, and the measures to be implemented in the future have been put forward.

Түлхүүр үг: Үндсэн хууль, хүний эрх, эрүүл аюулгүй орчин, орчны бохирдол, Үндсэн эрх

Key words: Constitution, Human Rights, Healthy and Safe Environment, Environmental Pollution, Government

Нэг. Оршил. Үндсэн хуулийн 16.2-т зааснаар Монгол улсын иргэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, бөгөөд иргэний энэхүү үндсэн эрх бодитой хангагдаж чадахгүй байгаад нийт иргэд шүүмжлэлтэй хандсаар байна.

Үндсэн хуулийн энэ эрхийг хангах зорилгоор Монгол Улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг улам бүр баталгаажуулах үүднээс олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд нэгдэн орох, түүнчлэн дотоодын эрх зүйн актуудад тухай бүр тусган баяжуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. Энэ хүрээнд Монгол Улс Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенц, Биологийн олон янз байдлын Конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь Конвенц гэх мэт 14 баримт бичигт нэгдэн орсон.

Үндсэн хуульд “Төр... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар¹²⁵ тогтоосон. Харин энэхүү үүргээ хэрхэн бодитоор хэрэгжүүлэх эрх зүйн шийдэл тодорхойгүй байна.

Хүний эрхийн конвенц, зохицуулалт заалтуудыг хэрэгжүүлэх асуудал дэлхийн улсуудын хувьд өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна. Монгол улсын хувьд “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг” бодитоор хамгаалах, хэрэгжүүлэх асуудал тунхаглалын шинжтэй оршсоор байна.

Дэлхийн нийтийн жишигт энэхүү эрхийг бодитоор хэрэгжүүлэх үндэслэл нь дараах хоёр төрлийн идэвхтэй үйлдлээр илэрдэг. Нэгт, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын идэвхтэй үйл ажиллагаа хоёрт, шүүх байгууллага энэхүү үндсэн эрхийн зөрчлийг харьяалан шийдвэрлэх эрх хэмжээ ба хүсэл зоригтой шууд холбогддог. Харин эрх бүхий албан тушаалтнууд түүнийг эдийн засгийн байдалтай шууд холбон идэвхгүй хүлээлтийн байдал үүсгэдэг. Энэ

¹²⁵ Монгол улсын үндсэн хууль, 19 зүйл 19.1, 1992он

тохиолдолд Монгол улсын шүүх байгууллагуудын идэвхтэй үйл ажиллагаа нь энэхүү хүний эрхийн заалтыг бодитойгоор хэрэгжүүлж, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллагад хууль ёсны шахалт үзүүлэх нь гол гарц юм.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдаж мөрдөгдсөнөөс хойш 25 жил өнгөрч байна. Харьцангуй урт хугацаанд Үндсэн хуулийн манлайд нь удиртгал болгож, Монголын ард түмний даяар олноороо зарлан тунхагласан эрхэм зорилгууд болон Монгол Улсын дэвшил хөгжлийн мөн чанар, шинж төрхийг бүрэлдүүлэн төлөвшүүлэх нийгэм-эдийн засгийн зорилтуудын хэрэгжилт нь бодит байдал дээр илт хангалтгүй байгаа нь олон зүйлээр илэрч байна. Эрхийн хэрэгжилтийг хангах үүднээс байгаль орчны стандартуудыг баталан мөрдүүлсэн.

Хүний эрх болон байгаль орчин хамгаалалт хоорондын хамаарлыг Үндсэн хуульдаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэнд тусгаж хүлээн зөвшөөрсөн. Агаарын бохирдол, ашигт малтмал зэрэг нарийвчилсан байгаль орчны талаар хуулиудыг батлан гаргасан. 2012 онд зүйл заалтуудыг нь сайжруулж, илүү уялдаа холбоотой, хооронд нь илүү нийцүүлэх зорилгоор байгаль орчны хууль тогтоомжуудаа дахин хянасан. Хэдийгээр зарим нэгэн дутагдал байсаар байгаа боловч гол асуудал нь стандартуудын чанарт бус тэдгээрийн хэрэгжилтэд байна.

Үндсэн хуульд ач холбогдол багатай өөрчлөлт оруулах талаар ярьдаг болохоос, хэрэгжилт хэр байгаа талаар төдийлөн авч хэлэлцдэггүй билээ. Төрийн албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаандаа холбогдох байгаль орчны стандартуудыг дагаж мөрдөж, хувийн хэвшлийн оролцогчид болон төрийн албан тушаалтнууд эдгээр стандартуудыг зөрчихөөс урьдчилан сэргийлж, мөрдөн шалгаж, хариуцлага хүлээлгэж, стандартыг дагаж мөрдөж байгаад хяналт шинжилгээ хийж, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үндсэн хэсэг. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн тухай ойлголт, хэрэгжилт:

Хүн амьд явах салшгүй эрхтэй. Мөн эрүүл мэндээ хамгуулуулах эрхтэй. Харин эдгээр эрхээ зүй ёсоор эдлэхийн тулд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах зэргээр байгаль, нийгмийн элдэв сөрөг нөлөөллөөс ангид байх ёстой юм. Амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах үндсэн баталгаа нь эрүүл, аюулгүй орчин бөгөөд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдах явдлаас төр иргэнээ хамгаалах үүрэг хүлээдэг.

Эрүүл, аюулгүй орчин гэж юу вэ? Энэ нь хүмүүс өдөр тутмын амьдралдаа амь бие, эрүүл мэндэд халтай орчны аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломж юм. Эрүүл орчин нь гол төлөв байгалийн тэнцэл, хүрээлэн буй орчны төлөв байдал дээр Үүнд: агаар, ус, газар болон үүнтэй холбоотой бусад өргөн хүрээний байгалийн болон хүний хүчин зүйлс багтдаг. Харин аюулгүй орчин нь илүү нийгэм-улс төрийн шинжтэй ойлголт юм. Нийгэм-улс төрийн шинжтэй хүчирхийллээс ангид байх, хүчирхийллийн үед төрийн онцгой бүрэн эрхийг хууль ёсны хүрээнд хэрэгжүүлэх, олон нийтийн хэв журмыг хангах, бие махбодын аюулгүй байдалд амьдрах зэргийг ойлгоно.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь хүмүүс ямар ч үед амь бие, эрүүл мэндэд халтай аливаа нөлөөлөлд өртөхгүй байх, түүнээс ангид байх боломжийг баталгаажуулсан хүний эрх юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүрээлэн буй орчны асуудлаарх чуулга уулзалтаар Стокгольмын тунхаглалыг 1972 оны 6 дугаар сард баталж, “Хүн бүр эрхэмсэг, сайн сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн дээд зэргийн орчинд эрх чөлөөтэй, эрх тэгш байх, амьдралын таатай нөхцөлөөр хангагдах үндсэн эрхтэй агаад одоо ба хойч үеийнхээ өмнө хүрээлэн буй орчноо хамгаалах, хөгжүүлэх журамт үүргийг хүлээнэ” хэмээн хүн төрөлхтөний оршихуйн үндсийг тодорхойлжээ.

Өнөөдрийн байдлаар 140 гаруй улс хүрээлэн буй орчныг хамгаалах талаар төрийн хүлээх үүрэг хариуцлагыг Үндсэн хуульдаа тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтад “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх”-ийг баталгаажуулсан.

Монгол Улсын хамгийн ноцтой байгаль орчны асуудал нь агаарын бохирдол. Улаанбаатар хотын хүрээлэн буй орчны агаарын нарийн ширхэгтэй тоосонцор (PM_{2.5}) дунджаар жилийн 70 µg/m³ байгаа нь Монгол Улсын агаарын чанарын стандарт (25µg/m³)-аас өндөр байгаа бөгөөд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тогтоосон хэмжээ (10 µg/m³)-ээс давсан байна.¹²⁶

Хүхрийн диоксид болон азотын оксид зэрэг бусад бохирдуулагч нь мөн дотоодын болон олон улсын стандартуудаас давсан түвшинд байна.¹²⁷ Энэхүү их хэмжээний агаарын бохирдол нь эрт нас баралтад хүргэдэг амьсгалын замын болон зүрх судасны өвчин үүсгэх аюултай тул хүний амьд явах, эрүүл байх эрхэд сөргөөр нөлөөлж байна. Улаанбаатар хот дахь гучаас дээш насны хүмүүсийн нас баралтын 10 хувь, нийт улс даяарх нас баралтын 4 хувь нь агаарын бохирдолтой холбоотой байх магадлалтай.¹²⁸

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 14 жилийн хугацаанд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нийт 2,632 буюу жилд дунджаар 188 бүртгэгджээ. Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн дэлгэрэнгүй судалгаа, Монгол Улсын шүүхийн цахим сан (www.shuukh.mn)-д тулгуурлан “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн талаар явуулсан судалгаа” зэргээс үзэхэд хууль бусаар буюу зохих зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнасан, ой мод бэлтгэсэн, ашигт малтмал олборлосон, химийн хорт бодис ашигласан, болгоомжгүй байдлаас гал алдсан, хээрийн түймэр тавьсан зэрэг үйлдлүүд зонхилж байна.¹²⁹ Тэр дундаа хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгт төрийн албан хаагч нар албан тушаалаа урвуулан ашиглах замаар холбогдож байна.

Улсын хэмжээнд байгаль орчныг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбогдох зөрчилд 260 акт тавьж, 82,681 заалт бүхий 10,517 шаардлага тавьсныг тухайн үеийн хууль тогтоомжид заасан байгаль орчныг хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн зүйлчлэлээр үүсгэн шалгасан 165 гэмт хэрэгтэй харьцуулж үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг ихээхэн нуугдмал түвшинд байна гэж дүгнэжээ.¹³⁰ Энэ нь байгаль орчныг хамгаалах, эрдэс баялгийг ашиглахтай холбоотой хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэгэн илрэл юм.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн зөрчил нь өөр хоорондоо уялдаа холбоотой олон хүчин зүйлээс үүдэн гарч буй тул зөвхөн хууль тогтоомжийг өөрчилж шинэчилснээр хүний эрхийн зөрчлийг арилгаж чадахгүй билээ.

Эрүүгийн хуульд заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль хамгаалах түүнийг зохистой ашиглах, элдэв халдлагаас хамгаалах зорилгоор төрөөс газар, түүний хөрс, газрын хэвлий түүний баялаг, ус ургамал, амьтан агаарт халдаж хор уршиг учруулдаг тул энэ төрлийн гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын хэмжээг бодитой, бүрэн тогтоох аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах хэрэгтэй байна.

Эрүүл, аюулгүй, эсвэл бохирдолгүй хэмээх ойлголтуудыг хэрхэн ойлгох вэ? Ялангуяа дээрх хийсвэрлэлийн хувьд эрүүл, аюулгүй, бохирдолгүй гэж юуг ойлгох вэ? “0” агаарын бохирдол, 100% эрүүл, аюулгүй байдал хэмээх агуулгаар энэхүү ойлголт нь тайлбарлагдах уу? Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх нь Хүн-Байгаль-Нийгмийн шүтэлцээнээс уламжилсан жам ёсны үндэс болохын хувьд “хүлцэх түвшин” хэмээх ойлголттой шууд холбогдоно.

Өөрөөр хэлбэл бохирдлын ямар түвшин, ямар боломжит нөхцөлийг эрүүл, аюулгүй гэж үзэх вэ гэдгийг хууль, хууль тогтоомжийн бусад актаар тогтоож, тохиолдол тус бүрд хянан шийдвэрлэснээр бодитоор хамгаалагдах юм. Тийм учраас энэхүү эрхийг хамгаалахад зөвхөн хуульч,

¹²⁶ ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм:- 2014 он УБ., Монгол Улс, 354 дэх тал. 2.5 микрометр буюу түүнээс бага диаметртай учраас нарийн тоосонцорууд уушгинд нэвтрэн орж, хүний эрүүл мэндэд богино болон урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэх боломжтой. ДЭМБ, хүрээлэн буй орчны агаарын бохирдол: Дэлхий нийтийн өвчлөлд өртөмтгий байдал болон хүндрэлийн үнэлгээ, 2016, 19 дэх тал.

¹²⁷ ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм: -2014, УБ., Монгол Улс, 190 дэх тал

¹²⁸ Дээрхтэй адил, 354 дэх тал.

¹²⁹ Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он, 249 дэх тал

¹³⁰ Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он, 248 дахь тал

хууль тогтоогчдийн шийдэл бус харин хими, физик, байгалийн ухааны эрдэмтдийн хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй болдог. Учир нь хүн гэдэг нийгмийн амьтан болохынхоо хувьд байгаль, хүрээлэн буй орчиндоо нөлөөлж, ихэнх тохиолдолд гол бохирдуулагч нь болдог ба “0” бохирдолгүй, эрүүл, аюулгүй орчин гэдэг нь өөрөө утопи шинжтэй юм.

“Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг” хамгаалах иргэдийн үндсэн эрхийг хамгаалах асуудал тухайн эрхийг хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулиар баталгаажуулахаас эхэлнэ. Үндсэн хуулиар тогтоосон эрхийг бодитой эдлүүлэх үндэслэл нь УИХ-аас хууль батлах, Засгийн газар батлагдсан хуулийг хэрэгжүүлснээр биеллээ олдог.

Харин эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн тухайд энэхүү эрх нь Үндсэн хуулийн тунхаглал хэвээр хадгалагдсаар байна. Үүний шалтгаан нь: Нэг бол Хууль тогтоох байгууллага шаардлагатай хуулийг батлахгүй байна эсвэл батлагдсан хуулийг Гүйцэтгэх эрхийн байгууллага хэрэгжүүлэхгүй байна. Хэрэв дээрх хоёр байгууллага Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ хангалттай түвшинд биелүүлэхгүй бол иргэнд ямар боломж байна вэ? Үндсэн эрхийн (эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрх) зөрчил, хөндөлтийг шүүх хянан шийдвэрлэх боломжтой болсноор хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагыг идэвхжүүлж болно. Харин ямар зөрчил!!

Procedure хэмээх ойлголтыг Монгол хэлнээ хөрвүүлэхдээ Журамлал, Процесс, Substantive гэх ойлголтыг Материаллаг эрх зүй гэж хөрвүүлсэн байдаг. Өгүүлэлийн турш яригдсан үндсэн эрхээс ялгагдахын тулд Материаллаг гэдэг орчуулгыг “Журамлалын¹³¹ болон Материаллаг¹³² эрх”: дэлгэрүүлэх.

“Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг” хамгаалах, тулгамдаж буй асуудлыг хөндөгдсөн тохиолдолд сэргээх асуудал нь журамлалын эрхийг хамгаалах, сэргээх харилцаатай шууд холбогдоно. Судлаачдын дунд энэхүү эрхийг хамгаалах, сэргээх асуудал нь утопи шинжтэй гэх шүүмжлэл байдаг ч өнөөдөр журамлалаар дамжуулан зохих төвшинд хамгаалж байна. Энэ эрхтэй холбоотой журамлалын үндсэн агуулга бол иргэд хүрээлэн буй орчинд нөлөөлж болох үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, түүнчлэн шийдвэр гаргах ажиллагаанд хяналт тавих, оролцох боломжоор хангагдах зэрэг юм.

Гэхдээ энэхүү журамлалын эрх нь “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг” хамгаалах шууд үндэслэл болохоосоо илүүтэйгээр иргэний оролцоо, хяналт төдийхөн байдаг нь иргэний үндсэн эрхийн шууд баталгаа болж чаддаггүй. Монгол улсын хувьд шүүх байгууллага “журамласан эрхийн” зөрчлийг хүлээн авч шийдвэрлэх замаар “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийг” бодитоор хамгаалах нөхцөл бүрэн байна. Энэ нь шүүхийн идэвхийг өдөөх (Judicial Activism), иргэний “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийн” мэдрэмжийг дээшлүүлэх үндсэн эхлэл мөн.

Дүгнэлт. Зарим судлаачдын зүгээс Үндсэн хуулийн байгаль орчны эрх буюу явцуу утгаар “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрхийн” заалтыг хэт тодорхой бус, хүний эрхийн бусад заалттай давхардсан, ардчилалтай харшилдсан, хэрэгжүүлэх боломжгүй, утга учиргүй шүүхдэлтийг нэмэгдүүлэх шинжтэй эсвэл төдийлөн үр дүнтэй бус гэх зэргээр шүүмжилдэг байна. Хэдийгээр эдгээр шүүмжлэл нь зарим талаараа үндэслэлтэй мэт боловч “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрх” нь хүний эрхийн бусад заалт бүрэн утгаараа хэрэгжих суурь нөхцөл нь болдог үндсэн эрх юм.

Иргэдийн зарим эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлаж болох ч хэзээд хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байхыг... хязгаарлаж болохгүйн адилаар “эрүүл, аюулгүй орчинд амьдрах ... эрх”-ийг дордуулж, хязгаарлаж болохгүй юм. Учир нь энэ эрхийн тайлбар нь зөвхөн орчны цэвэр, бохирдолгүй, эрүүл, аюулгүй байдалтай холбоотой бус хүний амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрхийн заалтаар мөн тайлбарлагдаж буйд оршино.

Олонх судалгаагаар “эрүүл аюулгүй орчинд амьдрах... эрх” зөрчигдөж тэдгээрийн хэрэгжилтүүд бодитой хэрэгжихгүй байна. Иймд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаандаа холбогдох байгаль орчны тухай хууль, эдгээр стандартуудыг дагаж

¹³¹ С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он, 442-р тал.

¹³² С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он, 514-р тал.

мөрдөх зөрчихөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх, хяналт шинжилгээ хийх замаар хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангах шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын дунд сургуулиудад эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх түүний агуулгын талаар олон нийтэд сурталчлах сургалт, дадлагын тогтолцоог бий болгох, хууль хэрэглэх хэрэглээг нэмэгдүүлэх, мөн агаарын бохирдлоос эрүүл мэндийн байдал хохирсон талаар Монгол улсын хэмжээнд судалгааг гаргах, мэргэжлийн салбарын сургалт болон сургалтын чанарыг сайжруулах сургалтын хөтөлбөр, материал бэлтгэх, сургалтын арга зүй, сургалтын орчин болон хүрэлцээ хангамжийг сайжруулах, бэлтгэсэн хүний нөөцийн ашиглалт, томилгоог сайжруулах зэрэг таатай нөхцөл байдлыг бий болгож, өгөх давуу талтай.

Ашигласан материал:

1. Монгол улсын үндсэн хууль, 1992 он
2. Монгол улсын Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль 1997 он.
3. Б.Чимэд, Үндсэн хуулийн мэдлэг, 2008 он
4. Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном – 2016, УБ., 2017 он
5. С.Нарангэрэл, Хууль зүйн Англи-Монгол эх толь, 2012 он
6. Монгол хэлний эх тайлбар толь
7. ЕЭЗК, Байгаль орчны үзүүлэлтийн тойм:- 2014 он УБ.,
8. Дэлхий нийтийн өвчлөлд өртөмтгий байдал болон хүндрэлийн үнэлгээ, 2016 он
9. Том Гинсбург, Шинэ ардчилсан тогтолцоон дахь Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ, 2003 он

--oOo--

**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНД СИСТЕМИЙН
БҮТЦИЙН АШИГЛАЛТ БА ХЯЗГААРЛАЛТ**
SYSTEMATIC REVIEW OF SECURITY RESULTS AND ITS
APPLICATION AND LIMITATIONS

ахмад Ш.Эвсанаа (МА)

Дотоод хэргийн хэргийн их сургуулийн

Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн

Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш

Хураангуй: Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа, мэдээлэл, мэдлэг, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээнд суурилах нь арга зүйн чухал ач холбогдолтой. Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, арга зүйд өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулгүй байдалд нөлөөлж буй аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ юм. Энэ нь аюулгүй байдалд заналхийлж буй аюулын хэлбэрийн агуулга, шинж чанар өөрчлөгдөж, өргөжих, шинэ чиглэл рүү шилжиж буй зэрэг үйл явцыг ойлгож мэдэхийн тулд аюулгүй байдалд заналхийлж буй хэлбэрүүдийг олж тогтоох явдал юм.

Abstract: Approach to security and actions to ensure it are based on knowledge, information, research, analysis, and evaluation are of great methodological importance. There have been major changes in security theory, concepts, and methodologies, and the primary activity of ensuring security is the study, analysis, and risk assessment of threat trends affecting security. It is the identification of security threats in order to understand the process of changes in the content and nature of threats to security, as they expand and move into new directions.

Түлхүүр үгс: Төр, аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, систем, системийн бүтэц, хүчний тэнцвэржилт, зөөлөн хоёр туйлт, хатуу хоёр туйлт.

Key words: State, security, national security, system, system structure, balance of power, soft bipolar, hard bipolar.

Оршил. Хувь хүн, үндэстэн, олон улсын аюулгүй байдал нь хүн төрөлхтний шийдвэрлэвэл зохих нэн чухал асуудлын гэдгийг үгүйсгэх аргагүй. Ялангуяа үндэсний аюулгүй байдал нэн чухал. Аюулгүй байдлын зохицолдоо тааруу бусад хоёр түвшинг, нөхцөл байдлыг тодорхойлоход төр зонхилох үүрэгтэй.

Түүхийн туршид төрийн оршин тогтнол, нэг нь нөгөөгийнхөө аюулгүй байдалд заналхийлсээр иржээ. Үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлж эхэлэхэд нөгөө нь эдийн засгийн эмх замбараагүй байдалд орж, дайнд бэлдэх болдог байна. Үндэсний аюулгүй байдлын асуудлын цар хүрээ, шинж чанар түүхэн цаг үеэс шалтгаалан асар их зөрчилдөөн, эсвэл намжмал байдал, өсөн нэмэгдэж буй хамтын ажиллагаагаар тодорхойлогдсоор иржээ. Иймэрхүү хэлбэлзэл байдаг ч, айдас түгшүүр оршсоор байна.¹³³

Аюулгүй байдлын дүн шинжилгээнд системийн бүтцийн ашиглалт, хязгаарлалтын талаар судлаачдын үзэл баримтлал, онолын сэтгэлгээгээр хэрхэн авч үзэж байсныг судлахыг зорилоо. Аюулгүй байдал нь зөвхөн үндэстний шинжтэй үзэл баримтлал биш юм. Түүнийг судалж, дүн шинжилгээ хийж, зөвлөмж болгосон ихэнх ном зохиолд хүчин чадал ба энх тайвны үзэл баримтлалд үндэслэдэг нь хэвээр байна.

Үндсэн хэсэг. Их гүрнүүдийн тухай мэтгэлцээн бол олон улсын аюулгүй байдлыг системийн бүтцийн үүднээс авч үзэхэд хэрэглэж болох хамгийн түгээмэл үр ашигтай хандлага байж болох юм. Энэ нь хэрэг дээрээ системийн дотор хүчин чадлын хуваарилалтыг “эсрэг тэсрэг

¹³³ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он, 5 дахь тал

түвшнээр” авч үзэн системийн тогтвортой байдал, дайн гарах магадлал, цар хүрээг тодорхойлох зорилготой юм.

Судлаач К.Уольцийн¹³⁴ тодорхойлолтоор хүчин чадлын хуваарилалт нь системийн бүтцийн өчүүхэн /анархи байдлын нарийн бүтэцтэй харьцуулахад/ түвшин юм.¹³⁵ Гэвч бүтцийн дүн шинжилгээг Уольцоос өөр хүн нэг их сонирхоогүй билээ. Үүний шалтгаан гэвэл эсрэг тэсрэг байдал өөрчлөгдлөө ч гүн дэх бүтцүүд хэвээрээ үлдэхээс гадна Дэлхийн хоёрдугаар дайны дараа дэлхий ертөнц олон туйлт системээс ихээхэн ховор тохиолдох хоёр туйлтай түүхэн хэв маяг руу эрчимтэй шилжсэн явдал юм.

АНУ энэхүү өөрчлөлтийн төвд орших болсноос хойш Америкийн эрдэмтэд энэ нөхцөл байдлыг судлах сонирхолтой болсон нь ойлгомжтой.

Юуны өмнө системийн бүтцийн олон хэв маягийг хөгжүүлэх хэрэгтэй байсан. Судлаач Мортон Каплан¹³⁶, хүчний тэнцвэржилт, зөөлөн хоёр туйлт, хатуу хоёр туйлт, хориг тавих нэгж, бүх нийтийн ба шатлан захирах гэсэн системийн зургаан хэв маягийг тодорхойлжээ. Хүчний тэнцвэржүүлэлтийн загвар Европын төрт ёсноос үүсэж, 1914 он хүртэл давамгайлж байсан бол зөөлөн, хатуу хоёр туйлт загвар хүйтэн дайны эхний ба сүүл үед ихээхэн тод илэрч байсан ба бусад нь одоогоор илрэлээ олоогүй, онолын хувьд байж болох загвар юм.

Улс төрч К.Ж.Холсти¹³⁷ жишээлбэл, шатлан захирах, тархмал бүлэг, туйлт загварууд гэж ангилж байгаа бол харин судлаач Р.Роузкранс давхраажилт, туйлт байдал, хүчин чадлын хуваарилалт, нэгэн төрөл байдал гэсэн дөрвөн үзүүлэлтээр илүү нарийвчилсан ангилал хийжээ¹³⁸. Эдгээр оролдлогод хүчний тэнцвэржилтэд системийн үйлчлэх дүрэм журмыг тодорхойлох гэх мэт сонирхолтой асуудлыг хөндөж, онолын маргаан өрнүүлэх ач холбогдолтой боловч бусад бүтэцтэй үед аюулгүй байдлын шаардлага ямар байх талаар тодорхой дүгнэлт хийж чадаагүй.

Дипломатч Холстийн үзэж байгаагаар түүний судалсан аль загвар бие даасан улс төрийн субъектийн аюулгүй байдлыг илүүтэй хангаж байна гэж хэлэх аргагүй ажээ. Өөр өөр загвар олон улсын харилцааны хэв маягт нөлөөлснөөр системийн гишүүдэд учирч болох аюулгүй байдлын шинж чанар өөрчлөгдөхөөс биш, аюулгүй байдлын түвшин дээшилж, доошлохгүй юм. Үүнтэй холбоотойгоор хэд хэдэн таамаглалыг дэвшүүлж болох юм.

Судлаач Р.Роузкрансын¹³⁹ үзэж байгаагаар хоёр туйлт системийн үед олон улсын түвшинд гарах хүчирхийллийн тоо нь цөөрч сөнөөх хүч чадал нь өсдөг бол тархмал системийн үед хүч хэрэглэх явдал олширч, хөнөөл нь багасдаг байна. Түүнээс гадна нэг төрлийн /өөрөөр хэлбэл нэгтгэн нягтруулах үзэл суртал нь өөр хооронд ялгаа бага/ системүүд нь үзэл суртлын хувьд ихээхэн ялгаатай системтэй харьцуулахад олон улсын мөргөлдөөнд өртөх нь бага ажээ. Гэхдээ томоохон асуудлаар ижил байр суурьтай байж чаддаггүй байна. Орчин үеийн гол асуудал болох хоёр туйлт бүтцийн үзүүлэх нөлөөний тухай санал ихээхэн зөрөлдөөнтэй байгаа юм.

Судлаач Р.Роузкрансын нотолж байгаа хатуу хоёр туйлт систем нь олон улсын маргааныг хянах чадварын хувьд “уян хатан биш” гэсэн үзэл бодол нь хоёр туйлт бүтэц бол аюулгүй байдлын асуудлаар хийх сонголтыг ихээхэн хатуу ширүүн болгодог тухай Жон Херцийн саналтай дүйж байгаа юм.

Судлаач Карл Дейч, судлаач Дэвид Сингер нар жишээлбэл, аюулгүй байдлын хувьд олон туйлт систем нь хоёр туйлт системээс илүү гэж үзэж байхад судлаач Майкл Хаас, аль ч хэлбэрийг нь ач холбогдол, үнэ цэнтэй гэж үзэхгүй гэжээ. Харин Уольц ийм үзэл санааг шүүмжлэн хоёр туйлт бүтэц бол нээлттэй бүтэцтэй харьцуулахад олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалахад илүү тул энгийн тогтвортой санамсаргүй зүйлд өртөх нь бага гэж үзэж байна. Судлаач Майкл Брешэр ба бусад судлаачид Уольцийн саналыг дэмжиж, дээрх сэдвээр маргаан өрнүүлснээр бүтцийн

¹³⁴ Kenneth Neal Waltz, Америкийн улс төрч, улс төрийн шинжлэх ухааны профессор

¹³⁵ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он. 190 дахь тал

¹³⁶ Morton Kaplan, АНУ, улс төрийн шинжлэх ухааны профессор, олон улсын харилцаа, геополитик судлаач

¹³⁷ Eino Rudolf Woldemar Holsti, Финляндын улс төрч, дипломатч

¹³⁸ Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он. 191 дэх тал

¹³⁹ Richard Rosecrance, Америкийн улс төрч, профессор

судалгаанаас гадна хүчин чадлын хуваарилалт ба шийдвэр гаргах төвүүд гэсэн үзэл бодлыг шинээр дэвшүүлэн тавьж байжээ.

Онолын ийм дээд түвшинд үндэсний аюулгүй байдлын асуудалд системийн бүтэц хэрхэн нөлөөлөх тухай нарийвчилсан заавар, зөвлөмж байхгүй юм. Системийн бүтцийн хандлага тусгаар байдлыг сонгож авч болох шинэ загварын тухай сэтгэлгээнд шинэ түлхэц өгөх учиртай. Мөн түүнчлэн системийн бүтэц нэг хэлбэрээс нөгөөд шилжихдээ ямар учир шалтгаанаар, яаж, хэзээ, ямар үр дагавартай зэрэг олон асуудлыг дэвшүүлдэг ч аль загвар нь илүү ач холбогдолтой талаар нэгдмэл байр суурь байхгүй учраас ихээхэн хийсвэр шинжтэй ажээ. Өөр өөр бүтцийг аюулгүй байдлын объект гэж үзэж болох юм. Уольцийн үзэж байгаа шиг хоёр туйлт бүтэц нь аюулгүй байдалд арай бага бэрхшээл учруулдаг гэж нотолбол нөхцөл байдлыг хэвээр үлдээсэн нь дээр гэсэн дүгнэлтэнд хүрэх юм. Үүнтэй нэгэн адил системийн бүтцийг өөрчилж, аюулгүй байдлын олон асуудлыг шинээр гаргаж болох юм. Яагаад гэвэл хуучин систем, улс орнуудын хууль ёсны эрх ашгийг тусгаж байгааг зөрчил тэмцэлгүй өөрчилж чадахгүй ажээ. Уольцийн тодорхойлж буй бүтэц бол Дэлхийн Хоёрдугаар дайны үр дүнд бий болж хүчин чадлын одоогийн хуваарилалтыг аюулгүй байдлын эрх ашгийн бодит нөхцөл байдлыг тусгаж байгаа гэж үзэн түүнд өөрчлөлт орох нь аюул занал нэмэгдэнэ гэж үздэг. Иймээс системийн тогтвортой байдлыг эрэлхийлэх нь аюулгүй байдлын судалгааны сэдэв болж байна.

Ийм учраас системийн бүтцүүдийг бүхэлд нь судалж, өөр хооронд нь харьцуулахад асар их хүчин чармайлт шаардана. Туйлт нөхцөл байдал нь олон улсын системийн үндсэн асуудлууд болох дайн, энх тайван, тогтвортой байдлын асуудалд хариулт өгнө гэж хүсэн хүлээж байсан учраас тодорхой үр дүнг дүгнэх, практик үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах талыг орхигдуулж байжээ.

Туйлт нөхцөл байдал бол нэгэн хэмжигдэхүүнээс бүтэх түүхэн хандлага биш юм. Тэр нь хүчин чадлын хуваарилалт хэмээх эгэл хүчин зүйлийг аюулгүй байдлыг бүрэлдүүлэх нөхцөл гэж үзэж түүхийн өөр өөр үеүдэд хандахдаа энэхүү хүчин чадлыг л цорын ганц тайлбар болгосоор иржээ. Асар хурдацтай өөрчлөгдөж байгаа асуудлуудад ганц үзүүлэлттэй хариулт өгнө гэдэг бол ухаалаг биш нь ойлгомжтой юм. Туйлт нөхцөл байдлыг түүхэн үеүдээр өөр хооронд нь харьцуулах нь явцуу үндэс суурьтай болно гэсэн үг юм.

Аюулгүй байдлын нөхцөлүүд хүчин чадлын хуваарилалтаас гадна олон хүчин зүйлээс хамаарах төдийгүй эдгээрийн ялгаатай тал нь түүхийн өөр өөр үеүдэд системийн бүтцийн дотор ижил төстэй зүйлээс урган гарах нэгэн төрөл байдлаас шалтгаална.

Түүхийн ялгаа, зөрөөтэй талууд эсрэг тэсрэг байдалд, улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлдөг. Тэдгээр нь:

- Цэргийн технологийн шинж чанар, юуны өмнө түүний устгах чадвар, түүнчлэн хүч хэрэглэх магадлал
- Системийн дотор эзгүй, эсвэл цөөн хүн амтай, томоохон улс гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх түвшинд улс төрийн хувьд зохион байгуулагдаагүй газар нутаг байгаа эсэх
- Системийг бүрэлдүүлэгч төрийн шинж чанар, түүнчлэн үзэл суртлын “нэг төрөл байдал” ба системийн дотор нөлөө бүхий том гүрний байр суурь, үндсэн чиглэлээ өөрчлөх гэж байгаа зэргийг нэрлэж болно.
- Системийн дотор дайн дажнаас ядарч сульдсан байдал байгаа эсэх, жишээлбэл, 30 жилийн дайны дараах Европын систем, эсвэл Вьетнамын дараах АНУ дахь дайн байлдааны сулруулагч мөн чанарыг гүнзгий ухамсарласан байдал зэрэг юм.
- Системийн түвшинд дайныг төрийн бодлогын хууль ёсны шинжтэй хэрэгсэл гэж үзэж байгаа эсэх,
- Системийн доторх улс орнууд өөр хоорондоо дайсагналцсан түвшин байгаа эсэх; энэхүү харьцаа Герман, Франц хоёрын туршлагаас харахад түүхэн нөхцөл байдлаас болоод ихээхэн өөрчлөгддөг байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзээд системийн бүтцээс үүдэн гарах аюулгүй байдлын асуудлуудын хил хязгаарыг тодорхойлж болох юм. Тэр нь юу гэсэн үг вэ? Ижил төстэй системийн бүтцийн дотор цөмийн зэвсэгтэй эсэх эсвэл дайн байлдаан явуулахад бэлэн болон зайлсхийж байгаа

зэрэг шинжээр илүү өргөн хүрээнд ижил төстэй байдлыг нь тодорхойлно гэсэн үг юм. Жишээлбэл, хоёр туйлт ертөнцийн тухай мэтгэлцээнд нэг талаас аюулгүй байдалд үзүүлэх нөлөө, нөгөө талаас цөмийн зэвсгийг хэрэглэсний үр дагавар хоёрыг цаг хугацааны хувьд давхцаж байгаагийн хувьд хэрхэн яаж бие биенээс нь салгаж ойлгох тухай асуудал чухал болж байна. Европ тив бол Дэлхийн нэгдүгээр дайн, түүнээс хойш ч гэсэн хүчний тэнцвэртэй систем байснаа хэрхэн өөрчлөгдсөнийг харж болно.

Өрнөдийн стратеги судлаачид үзэж буйгаар олон туйлт тогтолцоо эргээд олон улсын аюулгүй байдалд ноцтой занал учруулах боломжтой гэж дүгнэж байна. Дээрх судалгааны онолын үндэс нь “Balance of Power” буюу “хүчний тэнцвэр”-т тулгуурласан “Rebalance Power” буюу хүчний дахин тэнцвэржүүлэх үзэл баримтлал болно.¹⁴⁰

Хүчний тэнцвэржилтийн талаар бас онцгой анхаардаг, яагаад гэвэл тэр нь олон улсын харилцааны судалгаанд уламжлал ёсоор чухал байр эзэлдэгээс гадна гүн дэх болон хуваарилалтын бүтцийг өөр хооронд нь холбох гүүр болдог.

Нөгөө талаас хүчний тэнцвэр бол хүчин чадлын бүтцийн нэг загвар /гол төлөв олон туйлт загвар/ тул бас шүүмжлэлд өртдөг. Буллын тэмдэглэснээр “хүчний тэнцвэржилт” нь олон утга санааг илэрхийлдэг. Түүгээр хүчин чадлын бүтцийн нэгэн өвөрмөц хэв маягийг төдийгүй анархи систем дэх төрийн үйл ажиллагааны ерөнхий зарчмыг бас илэрхийлдэг. Түүний үзэж байгаагаар хүчин чадлын тэнцвэржилт хэмээх нэр томъёоны жинхэнэ утга санаа системийн түвшинд тод илэрдэг байна.

Системийн түвшин дэх хүчин чадлын тэнцвэржилт нь олон улсын анархи байдлыг хадгалан үлдээх гол зарчмуудыг тодорхойлж, тэдгээртэй салшгүй холбоотой байдаг. Анархи бүтэц нь нэг юмны эсрэг тэсрэг хоёр тал болох хүчин чадлыг тэнцвэржүүлж хадгалан барих боломжтой. “Хүчин чадлын тэнцвэржилт гэж бусдын үйл ажиллагааг хуульчлан тогтоодог аль ч улс гүрэн давуу эрх эдлэхгүй байхыг хэлнэ”¹⁴¹ гэсэн судлаач Ваттеллын сонгодог тодорхойлолтыг зөв зүйтэй гэж хүлээн зөвшөөрөл анархи байдлыг өөр талаас нь тодорхойлж байгаа хэрэг юм.

Дүгнэлт. Системийн бүтцийн судалгаа бол үзэл санааны гэхээсээ илүү яаж хэрэглэхээс их хамаарна. Системийн бүтцийг чадамгай хэрэглэж чадвал аюулгүй байдлын асуудлын олон тодорхой зүйлийг шийдвэрлэх үзэл бодлыг боловсруулах боломж олно.

Харин дангаараа аюулгүй байдлын нарийн төвөгтэй асуудлыг иж бүрнээр шийдвэрлэж чадахгүй. Эдгээр нь анархи байдлаас урган гарах аюулгүй байдлын асуудлыг хэлбэржүүлж, холбодог чухал боловч цөөн зарим үзүүлэлтийн л нэг юм байна.

Ашигласан материал

1. Д.Уламбаяр. Дэлхийн шинэ дэг журмын талаарх зарим эргэцүүлэл. УБ., 2014 он
2. Берри Бузан. (орчуулагч Л.Оюунгэрэл). Ард, түмэн, айх аюул. УБ., 1999 он
3. Morton A. Kaplan Morton. System and Process in International Politics. 1957 он
4. Barry Buzan Department of International Studies, University of Warwick. Peace, Power, and Security: Contending Concepts in the Study of International Relations.
5. Buzan Barry 1983. People, States and Fear: The National Security Problem in International Relations. Brighton: Harvester Press/Chapel Hill: North Carolina University Press.

¹⁴⁰ Д.Уламбаяр. Дэлхийн шинэ дэг журмын талаарх зарим эргэцүүлэл. УБ., 2014 он